



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 6



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 6

Улаанбаатар, 2022

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 6

СУДЛААЧИД:

1. Г.Буян, С.Нансалмаа, Юн Чанин, Д.Отгоннасан
2. Б.Амарсанаа, С.Батбаяр
3. Д.Гангабаатар, Б.Баттуул, Б.Гүнжидмаа, Б.Түвшинжаргал

Дугаар хариуцсан редактор А.Бямбажаргал

© Нээлттэй Нийгэм Форум, 2022.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9926-0-6

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 6



1

ДУУСГАВАР БОЛСОН АКТАД ХОЛБОГДУУЛАН
НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ
(ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА)

9

2

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ
МАРГААН ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН
ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙДАЛ
(ИРГЭН, ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХЭРГИЙН
ХАРЬЯАЛЛЫН ДАВХЦАЛ)

111

3

СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН
ШИНЖИЛГЭЭ

193

ӨМНӨХ ҮГ

Шүүхийн шийдвэрийн судалгааны цувралын хүрээнд захиргааны шүүхийн шийдвэртэй холбоотой анхны дугаарыг бэлтгэн уншигчдын хүртээл болгож байгаадаа баяртай байна. Энэхүү дугаарт багтсан гурван судалгааны тайлан нь хэргийн харьяалал болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, тэрчлэн сонгуулийн маргаан шийдвэрлэх зэрэг захиргааны шүүхэд нэн тулгамдаж буй асуудлуудыг хөндсөнөөрөө онцлогтой.

Дугаарыг ННФ-ын Шүүхийн судалгааны редакцын зөвлөлийн гишүүн хууль зүйн ухааны доктор, дэд профессор А.Бямбажаргал эрхлэн агуулга, арга зүйн хувьд шүүн тунгаасан юм. Тэрээр сонгуулийн маргааны шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн болон дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан гаргасан маргааныг шийдэж буй шийдвэрт хийсэн судалгааны тайланд шүүмж бичсэн бол редакцын зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг хуулийн этгээдийн бүртгэлийн маргаан шийдвэрлэсэн байдлыг судалсан судалгааны тайланд шүүмж бичиж хамтран ажиллалаа.

Захиргааны шүүхийн практикт тулгамдаж буй эдгээр сэдвийг сонгон судалсан нийт судлаачид, тайланг боловсронгуй болгоход оюунаа чилээн ажилласан агуулгын болон хэвлэлийн редактор нартаа гүн талархал илэрхийлье.

Энэхүү судалгааны тайлан нь хөндөгдсөн асуудлуудыг оновчтой шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд тодорхой хувь нэмэр оруулна хэмээн найдахын ялдамд уншигч Таныг холбогдох хэлэлцүүлэгт идэвхийлэн оролцож санал бодлоо сэтгэл харамгүй хуваалцахыг урьж байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

Шүүхийн шийдвэрийн судалгаа цувралын ээлжит дугаар Таны оюуны хүртээл болж байна. Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрх болох шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлэлт өгч буй утгаараа энэхүү цувралд багтсан судалгаанууд онцгой ач холбогдолтой юм.

Шүүх эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэгч шүүгчийн үйл ажиллагааны чанар нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, түүнийг гаргаж буй шүүгчийн хууль хэрэглээнээс шууд харагдаж байдаг. Чухамдаа нийгэмд шударга ёс тогтоож буй шүүхийн үйл ажиллагааг хэмжих хэмжүүр нь шүүгчийн гаргаж буй шийдвэрийн агуулга, хууль хэрэглээний үндэслэлээр тодорхойлогдоно. Иймд шүүхийн шийдвэрийн судалгааны цуврал нь шүүхэд тавьж буй хөндлөнгийн хяналтын нэг төрөл болох юм.

Энэ удаагийн цувралд багтсан судалгааны ажлууд нь нийтийн эрх зүй, ялангуяа захиргааны эрх зүйд холбогдох асуудлаар дагнан гарч буй гэдгээрээ өмнөх судалгааны цуврал бүтээлүүдээс ялгарч байгаа билээ.

Уншигч таны хүртээл болж буй судалгааны уг цувралд Г.Буян нарын “*Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн төрлийг өөрчлөхтэй холбоотой шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийх нь*”, Б.Амарсанаа, С.Батбаяр нарын “*Хуулийн этгээдийн*

бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал: Иргэний ба Захиргааны хэргийн шүүхийн зөрчилдөөн”, Хөгжлийн академи ТББ-ын судлаачдын багийн “УИХ-ын болон аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбоотой хэрэг, маргааныг анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн шийдвэрцүдийн харьцуулсан шинжилгээ” зэрэг судалгааны ажлууд багтлаа.

Дээрх судалгааны ажлууд нь Монгол Улсын шүүхийн практик дахь тулгамдсан асуудлуудыг судалж, хууль хэрэглээний нэгдмэл байдал, оновчтой шийдлийг судлаачдын хараат бус байр сууринаас хөндөн, олон нийтэд хүрч байна.

Судлаачдын тус бүтээлүүд нь Монголын эрх зүйн хөгжилд өөрийн бодит хувь нэмрийг оруулна гэдэгт гүнээ итгэнэ.

Редактор
А.Бямбажаргал

1

ДУУСГАВАР БОЛСОН АКТАД ХОЛБОГДУУЛАН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ

(ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА)

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



ГАНСҮХИЙН БУЯН (LL.M)

Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-ийн гүйцэтгэх захирал, хуульч, өмгөөлөгч Г.Буян нь 2002 онд “Их Засаг” Их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, 2006 онд Цагдаагийн академи (Хууль Сахиулахын Их сургууль)-д хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан, Одоогоор БНСУ-ын Күүкмин Их сургуульд докторын зэрэг хамгаалахаар судалгаа хийж байна. 2011 оноос хойш “Хил хязгааргүй хуульчид” ТББ-ын ТУЗ-ийн гишүүн болон даргаар, 2013 онд Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-г үүсгэн байгуулж, өнөөдрийг хүртэл гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байна. Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшин судалгаа, шинжилгээ хийдэг бөгөөд 2018 онд “Мөрөөдлийн хүч” орчуулгын номоо хэвлүүлэн гаргаж байсан.

Судалгааны
багийн ахлагч:

Г.Буян (LL.M)

Судлаачид:

С.Нансалмаа
Д.Отгоннасан
Ну Дун Хөг
Д.Мягмарсүрэн
Юн Чанин



СУМЬЯАГИЙН НАНСАЛМАА

Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-ийн хуульч, өмгөөлөгч тэрээр 2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, МУИС-ийн ХЗС-ийн Солонгосын эрх зүйн боловсролын төвийн эрх зүйн хөтөлбөрийг зэрэг дүүргэсэн. Гэрээний эрх зүй, гэр бүлийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг. 2020 онд Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-өөс хэвлэн гаргасан “Монгол Улс болон БНСУ-ын Захиргааны хууль тогтоомж” номын хуулийн орчуулгыг хийж гүйцэтгэсэн.



YUN CHANEUN (ЮН ЧАНИН)

Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-ийн эрх зүйч тэрээр 2020 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж, МУИС-ийн ХЗС-ийн Солонгосын эрх зүйн боловсролын төвийн эрх зүйн хөтөлбөрийг зэрэг дүүргэсэн. 2019 оноос Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-д эрх зүйчээр ажиллаж байгаа бөгөөд компанийн эрх зүйн чиглэлээр судалгаа хийдэг. 2020 онд Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-өөс хэвлэн гаргасан “Монгол Улс болон БНСУ-ын Захиргааны хууль тогтоомж” номын хуулийн орчуулгыг хийж гүйцэтгэсэн.



ДАВААЖАВЫН ОТГОННАСАН

2013 онд МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийг Монгол хэл, англи хэл судлалын мэргэжилтнээр, 2017 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн. 2013 оноос 2017 он хүртэл Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд гадаад харилцааны менежер, 2017 оноос 2021 оныг хүртэл Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-д хуульчаар, 2022 оноос Нийслэлийн тойргийн нотариатчаар тус тус ажиллаж байна.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	13
УДИРТГАЛ	14
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	17
1.1. Дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрх	17
1.2. Захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн шийдвэр дуусгавар болсон байх	21
ХОЁР. ШҮҮХЭЭС АНХААРВАЛ ЗОХИХ БУСАД АСУУДАЛ	35
2.1. Нэхэмжлэлийн шаардлага өөрчлөх шаардлагатай эсэх	35
2.2. Нэхэмжлэл гаргах эрхгүй болох нь тогтоогдвол түүнийг шийдвэрлэх хууль зүйн үндэслэл	40
2.3. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий акт дуусгавар болсон тохиолдолд шүүхээс гаргах шийдвэрийн төрөл	51

ГУРАВ. БНСУ-ЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	55
3.1. БНСУ-ын захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зорилго, үзэл санаа, онцлог	55
3.1.1. Дуусгавар болсон захиргааны акт зэрэгт холбогдуулан нэхэмжлэл гаргах, ашиг сонирхлын талаарх зохицуулалт	60
3.2. БНСУ-ын шүүхийн практик.....	68
ДҮГНЭЛТ.....	103
САНАЛ	106
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	108

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
АМтХ	Ашигт малтмалын тухай хууль
АШШ	Анхан шатны шүүх
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОАЖЯ	Байгаль орчин аялал, жуулчлалын яам
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх
ЕС	Ерөнхий сайд
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УДШ	Улсын дээд шүүх
ХтХ	Хөдөлмөрийн тухай хууль
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

УДИРТГАЛ

Монгол Улсын Их хурлаас 2016 онд баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэдийн шүүхэд хандах эрхийг олон талаас өргөжүүлсэн нь процессын эрх зүйн чухал шинэтгэл болсон юм. Уг шинэтгэлийн хүрээнд захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргааныг жагсаалтын зарчмаар тодорхойлсныг халж, нээлттэй зарчимд шилжсэн нь том дэвшил болсныг дурдах нь зүйтэй. Түүнчлэн уг хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь заалтаар үйлчлэл дуусгавар болсон захиргааны акт нэхэмжлэлийн зүйл болох зохицуулалтыг хуульчилжээ.

Манай улс 2002 онд анх Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баталснаар иргэд захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны эсрэг эрхээ хамгаалах, хуулийн хяналт хэрэгжүүлэх боломж бодитоор бүрдсэн билээ. Гэвч 2016 онд шинэчлэн найруулагдах хүртэлх хугацаанд хуулийн зохицуулалт, шүүхийн практик гагцхүү үйлчлэлтэй захиргааны актын хүрээгээр хязгаарлагдаж, иргэд дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан ашиг сонирхлоо хамгаалах үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй байв. 2002 оны ЗХШХШТХ-ийн зохицуулалтын үндсэн зорилго нь актын эрх зүйн үр дагаврын улмаас зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн байдаг. Гэтэл маргаан бүхий акт нэгэнт дуусгавар болсон байх тул тэр нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг

сонирхлыг хэрхэн хөндөх, түүний талаар маргах хэрэгцээ шаардлага байгаа эсэх асуудал тодорхой зохицуулалтгүй байв. Өөрөөр хэлбэл, үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхийн шалгуурыг хэрхэн тодорхойлох, улмаар иргэний шүүхэд хандах эрхийг хязгаарлах эсэх, нэхэмжлэлийн үүдийг нээх, үр ашиггүй шүүхийн шийдвэр гарах, түүнчлэн захиргааны хэргийн шүүх субъектив эрхийг хамгаалах үндсэн зорилгоос хальж, захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зөрчлийг хянах зэрэг асуудлуудыг хөндөх юм.

Түүнчлэн тус заалтын (106.3.3) утга агуулга нь манай улсын захиргааны процессын эрх зүйд шинэлэг төдийгүй бичвэрийн хувьд онол, үзэл баримтлалын тайлбар шаарддаг. Иймд захиргааны хэргийн шүүх, хуульч, судлаачид энэхүү зохицуулалтыг хууль зүйн шинжлэх ухааны ололт, онол, арга зүйд тулгуурлан, хамгийн сайн үзэл баримтлалаар хөгжүүлэх шаардлагатай.

Энэхүү судалгааны зорилго нь (1) хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийн утга агуулга, ач холбогдлыг тодруулах, (2) шүүхээс анхаарвал зохих зарим асуудлыг тодорхойлж, санал дэвшүүлэхэд оршино.

Судалгаанд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд гарсан 2057 шүүхийн шийдвэрээс хайлт хийн, хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлтэй холбоо бүхий анхан шатны шүүхийн 86 шийдвэр, давж заалдах шүүхийн 26 магадлал, хяналтын шатны шүүхийн 20 тогтоолыг авч үзлээ. Улмаар хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийн агуулга, ач холбогдлыг харуулахуйц хууль зүйн факт, анхаарал татахуйц дүгнэлт, хууль зүйн үндэслэлийг харгалзан, УДШ-ийн 6 тогтоол, АШШ-ийн 11 шийдвэрийг сонгон авч, нарийвчилсан дүн шинжилгээ хийсэн болно. Мөн зарим асуудалд тойм судалгаа хийх

зорилгоор 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл шийдвэрлэгдсэн 28 хэргийн шүүхийн шийдвэрийг ашигласан болно. Түүнчлэн БНСУ-ын анхан нэг, дээд шүүхийн гурав, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг шийдвэрийг харьцуулан авч үзлээ.

БНСУ-ын захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт, онол, үзэл баримтлал, шүүхийн практикийг харьцуулан судлах болсон нь дараах хэд хэдэн шалтгаантай. Үүнд:

- 1984 онд захиргааны процессын хуульдаа үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрх зүйн үндэслэлийг зохицуулсан бөгөөд өнөөдрийг хүртэл өөрчлөлт оруулаагүй, тогтвортой үйлчилж байна. Үүний шалтгаан нь Герман, Япон зэрэг өндөр хөгжилтэй орны эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик, онолыг судлах замаар өөрийн орны эрх зүйн зохицуулалтын утга агуулга, шүүхийн практикийг хөгжүүлсээр ирсэнтэй нь холбоотой юм.
- Уг зохицуулалт батлагдсанаас хойш шүүхийн практикт олон янзаар хэрэглэж, түүний утга агуулгыг сайжруулсаар ирсэн туршлагатай орон билээ. Тухайлбал, анх нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хэт явцуу байдлаар тайлбарлан хэрэглэж байсан боловч онол, үзэл баримтлалын нөлөөгөөр үүнийг өөрчилж чадсан байна.
- БНСУ-ын захиргааны процессын эрх зүйн зорилго, үзэл санаа нь манай улсын адил иргэний шүүхэд хандах эрхийг өргөжүүлж, улмаар субъектив эрхийн хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн байх тул харьцуулсан эрх зүйн хүрээнд сонгон судлахад тохиромжтой гэж үзлээ.

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1. ДУУСГАВАР БОЛСОН ЗАХИРГААНЫ АКТАД ХОЛБОГДУУЛАН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХ

ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага, урьдчилсан нөхцөлүүдийг заасан байх бөгөөд үүнд “нэхэмжлэгчийн ашиг сонирхол” байх нөхцөлийг тусгажээ. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчид тухайн дуусгавар болсон захиргааны актыг хууль зөрчсөн болохыг тогтоолгох ашиг сонирхол байх шаардлагатай бөгөөд энэ нь нэхэмжлэгчид тавигдах үндсэн шаардлага буюу нэхэмжлэл гаргах эрхийн гол шалгуур болдог.

Нэхэмжлэл гаргах ашиг сонирхол гэдэг нь маргаан бүхий актын улмаас нэхэмжлэгчийн ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, эсхүл хууль бус гэдгийг нь тогтоохгүй байснаар зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал хэрхэн бий болох, мөн яагаад заавал уг ашиг сонирхлыг шүүхээр хамгаалуулах болсон, шүүхээс тухайн шийдвэрийг гаргуулснаар нэхэмжлэгчийн ашиг сонирхол хэрхэн хамгаалагдах тухай ойлголт юм. Нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нь нэхэмжлэлийн төрлөөсөө хамаараад, харилцан адилгүй байдаг. Дийлэнх нэхэмжлэлийн хувьд хуулийн бичвэрээс тодорхой харагддаг бөгөөд тухайлбал, хүчингүй болгох нэхэмжлэлийн тухайд маргаан бүхий актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн

зөрчигдсөн, шүүхээс шийдвэр гарснаар зөрчигдсөн сэргэх тухай ойлголт юм¹. Гэвч уг хуулийн 106.3.3-д “зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй”, “эрх, хууль ёсны ашиг сонирхол” гэх томъёолол байдаггүй, харин “нэхэмжлэгчийн ашиг сонирхол” хэмээн ерөнхийлөн хуульчилжээ. Эндээс хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хэрхэн тодорхойлох вэ? гэсэн асуулт урган гарч ирнэ.

Шүүхийн шийдвэрүүдийг уншиж, судлахад дийлэнх хувь нь нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын талаар дүгнэлт хийгээгүй байхын сацуу, дүгнэлтийн агуулга хэт товч байна. Энэ нь уг ойлголтын утга агуулга, ач холбогдлыг багасгах төдийгүй хөгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс шүүх дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэхийг заавал дүгнэх бөгөөд үндэслэх хэсэгтээ дэлгэрэнгүй бичих шаардлагатай. Ингэснээр тэдгээр үндэслэлээр судалгаа, шинжилгээ хийж, хэлэлцүүлэг өрнүүлэн, хөгжүүлэх боломж бүрдэх юм.

Судалсан шүүхийн шийдвэрүүдээс харахад, нэхэмжлэгчийн ашиг сонирхол гэдэгт маргаан бүхий актын улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх (Хэрэг 2), мөн ирээдүйд болзошгүй эрсдэлээс сэргийлэх ашиг сонирхол байх явдлыг (Хэрэг 1) хамруулан үзэж байна.

Хэрэг 1

Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолын (1) заалтаар төвийн бүсийн хурдан морины “Дүнжингарав” хаврын уралдааныг 2017 оны 3 дугаар сарын 5-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын Цагаан хөтөлд, бүсийн хурдан морины уралдааныг 2017 оны 3 дугаар сарын

¹ ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.1-д “захиргааны акт, захиргааны гэрээ хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох” хэмээсэн байдаг.

12-ны өдөр Хөвсгөл, Говь-Алтай аймагт зохион байгуулахыг, мөн (2) (3) заалтаар Зуны зүүн бүсийн хурдан морины уралдааныг Сүхбаатар аймагт, Хойд бүсийн хурдан морины уралдааныг Сэлэнгэ аймагт, Говийн бүсийн хурдан морины уралдааныг Дундговь аймагт, Хангайн бүсийн хурдан морины уралдааныг Өвөрхангай аймагт, Баруун бүсийн хурдан морины уралдааныг Увс аймагт, Төвийн бүсийн хурдан морины уралдааныг Улаанбаатар хот, Хүй долоон худагт 2017 оны 7 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулахыг холбогдох аймаг болон Нийслэлийн Засаг дарга, Монголын морин спорт, уяачдын холбоонд тус тус даалгажээ. Энэ тогтоолын дагуу Төв аймгийн Аргалант сумд хурдан морины уралдаан зохион байгуулагдсаны дараа Засгийн газар 63 дугаар тогтоолоо хүчингүй болгожээ.

Нэр бүхий төрийн бус байгууллагууд хэдийгээр 63 тогтоол дуусгавар болсон боловч уг актыг хууль бус байсан болохыг тогтоолгох ашиг сонирхол байгаа буюу хариуцагчаас дахин ижил агуулга бүхий хууль бус захиргааны акт гаргуулахгүй байх хэмээн ашиг сонирхлоо тодорхойлж маргажээ.

Хяналтын шатны шүүхийн тогтоолын хянавал хэсэг:

...Нэхэмжлэгчдээс Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолыг хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага гаргасны дараа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч нь 2017 оны 224 дүгээр тогтоолоороо маргаан бүхий уг тогтоолыг хүчингүй болсонд тооцож шийдвэрлэсэн, мөн морин уралдаан Төв аймгийн Аргалант сумд болж, тогтоолын 1 дэх заалт бодитоор хэрэгжсэн байх боловч нэхэмжлэгчдийн хувьд уг актыг хууль бус байсан болохыг тогтоолгох ашиг сонирхол байгаа буюу хариуцагчаас дахин ижил агуулга бүхий хууль бус захиргааны акт гаргуулахгүй байх ашиг сонирхол

байх тул нэхэмжлэлийн уг шаардлагыг хангаж шийдвэрлэсэн хоёр шатны шүүхийн шүүхийн шийдвэр зөв байна².

Хэрэг 2

Э нь Сэлэнгэ аймгийн Мандал сумд ахлах шийдвэр гүйцэтгэгчээр ажиллаж байгаад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын Б/690 тоот тушаалаар 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдөр албан тушаалаасаа чөлөөлөгджээ. Шүүхэд хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа ШШГЕГ-ын дарга нь 2016 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Б/908 дугаар тушаалаар Э-г Чингэлтэй дүүргийн шийдвэр гүйцэтгэгчээр томилжээ. Гэхдээ энэ нь 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдрөөс хойш ажлаа хийгээгүй учраас ажлын цалин хөлсийг олгох боломжгүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд³ шүүхийн шийдвэрээр хэмээсэн учраас бидний зүгээс дур мэдэн цалин олгох үндэслэлгүй байна гэсэн байна. Иймд Э ажилгүй хугацааны цалинг (2016.06.06 - 2016.07.28) гаргуулж, нийгмийн даатгалын дэвтэрт нөхөн бичилт хийлгэх зорилгоор нэхэмжлэлийн шаардлагаа Б/690 тушаалыг хууль бус байсан болохыг тогтоох болгон өөрчилжээ.

Шүүх тус нэхэмжлэлийг хүлээн авч, хангаж шийдвэрлэсэн байна⁴.

² УДШ-ийн тогтоол (2018.01.15), дугаар 26, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1203/view>

³ Хөдөлмөрийн тухай хууль (1999)-ийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг “Энэ хуулийн 36.1.2-т заасны дагуу ажилтныг ажил, албан тушаалд нь эгүүлэн тогтоосон бол түүнд ажилгүй байсан бүх хугацаанд нь урьд авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор, хэрэв бага цалинтай ажил хийж байсан бол зөрүүтэй тэнцэх олговрыг олгоно”. 36.1.2. Ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтныг өмнө нь эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

⁴ АШШ-ийн шийдвэр (2016.11.07), дугаар 885.

Судлаачдын зүгээс шүүхийн эдгээр шийдвэртэй санал нийлж байна. Учир нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь заалтын “нэхэмжлэгчийн ашиг сонирхол” гэдэгт зөрчигдсөн төдийгүй зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамруулах нь ЗХШХШТХ-ийн үндсэн зорилгод нийцэх юм.

1.2. ЗАХИРГААНЫ АКТ ХҮЧИНГҮЙ БОЛГУУЛАХ НЭХЭМЖЛЭЛ ГАРГАСНЫ ДАРАА ТУХАЙН ШИЙДВЭР ДУУСГАВАР БОЛСОН БАЙХ

А. ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа дуусгавар болсон байх шаардлагыг заасан байна. Энэ нь уг нэхэмжлэлд тавигдах чухал шалгуур бөгөөд тухайн нэхэмжлэлийн зорилго, шинж чанарыг тодорхойлдог. Тодруулбал, хүчингүй болгох нэхэмжлэл нь захиргааны актын эрх зүйн үр дагаврыг буюу зохицуулалтыг шууд дуусгавар болгуулахад чиглэгддэг⁵. Тиймээс маргаан бүхий захиргааны акт дуусгавар болсноор уг нэхэмжлэлийн шаардлага ач холбогдолгүй болох юм. Гэвч бодит байдалд нэхэмжлэгч захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гарган, ашиг сонирхлоо хамгаалах хэрэгцээ, шаардлага байдаг учир дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхийг олгох шаардлагатай. Иймд уг нэхэмжлэлийн зорилгыг “*нэхэмжлэгчээс захиргааны актыг хүчингүй болгуулахыг зорьж байсан боловч тодорхой шалтгааны улмаас боломжгүй болсон тохиолдолд тухайн акт хууль бус байсан болохыг үргэлжлүүлэн тогтоолгоход оршино*”⁶ гэж тодорхойлсон нь оновчтой юм. Энэ утгаараа хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл нь хүчингүй болгуулах

⁵ Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019, 158 дахь тал.

⁶ Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019, 210 дахь тал.

нэхэмжлэл гаргах боломжгүй тохиолдолд нөхөн хэрэглэгдэх субсидарь шинжтэй юм. Гэвч дуусгавар болоогүй захиргааны актыг хууль бус байсан болохыг тогтоож, шийдвэрлэсэн тохиолдол шүүхийн практикт байгаа нь анхаарал татаж байна.

СТ ХХК нь БОАЖЯ-ны “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах тухай” 2020/04 дугаар дүгнэлт, АМГТГ КХД-ийн “тусгай зөвшөөрөл цуцлах тухай” 58 дугаар шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргажээ. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад БОАЖЯ 2020/04 дугаар дүгнэлтээ хүчингүй болгосон байна. Үүний дараа СТ ХХК нь нэхэмжлэлийн шаардлагаа БОАЖЯ-ны 2020/04 дугаар дүгнэлт, АМГТГ КХД-ийн 58 дугаар шийдвэрийг тус тус хууль бус байсан болохыг тогтоолгох болгож өөрчилжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

“...Гэвч дүгнэлт хүчингүй болсон эсэхийг үл хамаарч, Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга өөрийн гаргасан 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 58 дугаар шийдвэрийг цуцлаагүй.

Улмаар тус актын үйлчлэл бусад байдлаар хэрэгжиж, эрх зүйн нөлөөллөө бүрэн үзүүлсээр байсан тул шүүх нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг сэргээхээр Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 58 дугаар шийдвэрийг хууль бус байсан болохыг тогтоолгох”-оор гаргасан энэхүү нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ⁷.

⁷ АШШ-ийн шийдвэр (2020.09.14), 128/ШШ2020/0587.

Энэ хэргийн хувьд маргаан бүхий акт эрх зүйн үйлчлэлтэй байгаа бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн хэвээр байна. Тиймээс хүчингүй болгуулах нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэснээр зөрчигдсөн эрх сэргэх байтал хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэсэн нь учир дутагдалтай.

Энэ нь ЗХШХШТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.1-т “нэхэмжлэгч нэхэмжлэлээ өөрчлөх эрхтэй” гэж заасан боловч нэхэмжлэгчийн хувьд эрх зүйн үйлчлэл дуусгавар болоогүй актын хувьд хууль бус байсан болохыг тогтоолгох боломжгүй.

Харин шүүх ЗХШХШТХ-ийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 54.1-д заасан үндэслэл хэргийг хянан шийдвэрлэх явцад, эсхүл шүүх хуралдааны үед тогтоогдвол шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана”, мөн уг хуулийн 54.1.5-д “...нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан”⁸ гэж тус тус заасны дагуу нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн тохиолдолд тухайн нэхэмжлэлд тавигдах урьдчилсан нөхцөлийг шалгах ёстойг харуулж байна.

Тиймээс нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа АМГТГ-ын КХД-ын 58 дугаар шийдвэрийг хууль бус байсан болохыг тогтоолгох болгож өөрчлөх нь 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж үзвэл, дараах үндэслэл, шалтгаанаар нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх эрхгүй, харин өмнөх хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэргийг шийдвэрлүүлэх эрхтэй байна.

(1) Энэ хэргийн тухайд АМГТГ КХД-ийн 58 дугаар шийдвэр нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д “хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа дуусгавар болсон” байх

⁸ Нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг энэхүү зохицуулалттай холбож үзэх болсныг 2.2 дахь хэсгээс уншина уу.

шаардлагыг хангахгүй юм. Учир нь маргаан бүхий акт эрх зүйн үйлчлэлтэй хэвээр байх тул хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд үргэлжлүүлэн маргах боломжтой. Өөрөөр хэлбэл, 58 дугаар захирамжийн эрх зүйн үр дагавар (тусгай зөвшөөрөл цуцалсан) нь СТ ХХК-ийн ашигт малтмал ашиглах эрхийг зөрчиж буй бөгөөд хүчингүй болгуулснаар зөрчигдсөн эрх сэргэх эрх зүйн үйлчлэлтэй байна.

(2) СТ ХХК-ийн нэхэмжлэл гаргаж буй ашиг сонирхол нь ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлөө сэргээхэд чиглэсэн гэдэг нь хэргийн үйл баримтаас тодорхой харагддаг. Гэвч АМГТГ-ын КХД-ийн 58 дугаар шийдвэрийг хууль бус байсан болохыг тогтоосноор нэхэмжлэгч хүссэн эрх зүйн хамгаалалтаа авч чадахгүй юм. Учир нь хууль бус байсан болохыг тогтоох шийдвэр нь маргаан бүхий актыг хууль зөрчсөн болохыг тогтоох идэвхгүй эрх зүйн хамгаалалтын хэлбэр юм. Гэтэл нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа хууль бус байсан болохыг тогтоолгох болгож өөрчилснөөр нэхэмжлэгчийн ашиг сонирхол сэргээгдэхгүй юм.

Эдгээр үндэслэл, шалтгаан нь энэ хэргийн хувьд СТ ХХК нэхэмжлэлийн шаардлагаа АМГТГ-ын КХД-ийн 58 дугаар шийдвэрийг хууль бус байсан болохыг тогтоолгох болгож өөрчлөх эрхгүй болохыг харуулж байх тул шүүх ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3, 54 дүгээр зүйлийн 54.1.5 дахь заалтуудыг үндэслэн, 109 дүгээр зүйлийн 109.2-д заасны дагуу нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх хүсэлтийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байжээ.

Иймд цаашид шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх тохиолдолд тухайн нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг шалгах төдийгүй нэхэмжлэгчээс хүсэж буй эрх зүйн хамгаалалтыг тодруулж, шүүхийн шийдвэрийн үр дагаврыг танилцуулан,

ойлгуулах асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй юм.

Б. ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д “тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн” байх шаардлагыг заасан бөгөөд нэхэмжлэгч энэхүү шаардлагыг хангасан болохыг тодорхойлох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч хүчингүй болгуулах нэхэмжлэлийн хүрээнд маргах боломжгүй нөхцөл байдал бий болсныг тодорхойлох тухай ойлголт тул хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл болно.

Шүүхийн практикт захиргааны актын агуулгад өөрчлөлт огт ороогүй, зөвхөн баримт бичгийн хэлбэр буюу бланк зэрэг өөрчлөгдсөнийг тухайн захиргааны актын үйлчлэл дуусгавар болсон гэж үзсэн тохиолдол байна.

О нь Эрчим хүчний зохицуулах хорооны даргаар ажиллаж байгаад Монгол Улсын Ерөнхий сайдын 88 дугаар захирамжаар албан тушаалаасаа чөлөөлөгджээ. Үүнийг эс зөвшөөрч, уг захирамжийг хүчингүй болгуулах, хуучин ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна.

Гэтэл шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагч тал “О-ыг 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн, үүрэгт ажлаас чөлөөлөх” тухай 131 дугаар захирамж, мөн “маргаан бүхий 88 дугаар захирамжийг хүчингүй болгох” тухай 132 дугаар захирамжийг гаргажээ. Энэ үйлдлээ **Захиргааны ерөнхий** хуулийн 45.1-д⁹ заасны дагуу захиргааны актын бичгэн хэлбэрт

⁹ ЗЕХ-ийн 45 дугаар зүйлийн 45.1-д “Захиргааны актын бичилт болон тооцооны алдаа, түүнтэй адилтгаж болохоор өөр бусад илэрхий алдааг захиргааны актын үндсэн зохицуулалт, утга, агуулгыг өөрчлөхгүйгээр захиргааны байгууллага өөрөө, эсхүл оролцогчийн хүсэлтээр засах эрхтэй бөгөөд уг засварыг оролцогчид мэдэгдэх үүрэгтэй” хэмээжээ.

тавигдах шаардлага болох хуулийн үндэслэл бичээгүй алдаагаа засварласан хэмээн тайлбарласан байна.

Эндээс нэхэмжлэлийн зүйл болох 88 дугаар захирамжийн эрх зүйн үйлчлэл 132 дугаар захирамжийн дагуу дуусгавар болсон, эсхүл 131 дүгээр захирамжаар үргэлжилж байгаа эсэхийг шалгах шаардлагатай юм. Маргааныг шийдвэрлэсэн анхан шатны шүүх уг хоёр захирамжаар нэхэмжлэгчийн эрх зүйн байдал өөрчлөгдөөгүй гэж дүгнэсэн атлаа 88 дугаар захирамжийн эрх зүйн үйлчлэл дуусгавар болсон мэт шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “...*Ерөнхий сайдын 132 дугаар захирамжаар маргаан бүхий 88 дугаар захирамжийг хүчингүй болгосон хэдий ч 131 дүгээр захирамжид “О-ыг Эрчим хүчний зохицуулах хорооны даргын цэрэгт ажлаас 2016 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс чөлөөлсүгэй” гэсэн байх тул нэхэмжлэгчийн хувьд эрх зүйн байдал өөрчлөгдөөгүй байна.*

...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д зааснаар Захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн боловч нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа тул маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэв”.

ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт захиргааны актыг тодорхойлохдоо хэлбэр (бичиг баримт) бус, гагцхүү актын зорилго, агуулга, үр дагаварт тулгуурласан байдаг¹⁰. Иймд 131, 132 дугаар захирамж гарснаар маргаан бүхий 88

¹⁰ Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний эмхтгэл 3, Н.Отгончимэг, Засгийн газар хариуцагчаар оролцсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 2020.

дугаар захирамжид тавигдах дараах шинжүүд өөрчлөгдөөгүй юм. Үүнд: Захиргааны байгууллага (МУ-ын Ерөнхий сайд), тодорхой нэг тохиолдол (О-д хаяглагдсан), нийтийн эрх зүйн хүрээнд байх, гадагш чиглэсэн байх (О-ийн үндсэн эрхэд халдсан), эрх зүйн шууд үр дагавар үүсгэсэн (О-г 2016.11.04-ний өдрөөс ажлаас чөлөөлсөн), захирамжилсан шинжтэй (О-ийн хүсэл зоригоос үл хамаарсан) байна.

Харин 131, 132 дугаар захирамжийн агуулга болон хариуцагчийн тайлбараас үзвэл 88 дугаар захирамжийн алдааг засварласан шинжтэй буюу зөвхөн формаль эрх зүйн шаардлагад өөрчлөлт оруулжээ. Иймд ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтын тодорхойлолтын дагуу 88, 131, 132 дугаар захирамжуудыг өөр, өөр акт гэж үзэхгүй юм. Тиймээс шүүх маргаан бүхий актын үйлчлэл дуусгавар болсон эсэхийг дүгнэхдээ тухайн актын зохицуулалт болон агуулгыг анхаарах нь чухал билээ.

Түүнчлэн ЗХШХШтХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.1, мөн уг хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.1, 106.3.3 дахь заалтаас үзэхэд, нэхэмжлэлийн зүйл нь тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан, захирамжилсан шинжтэй захиргааны акт байхыг шаарддаг. Энэ утгаараа нэг агуулга бүхий захиргааны актын шинжийг хэд хэдэн захиргааны актад агуулсан тохиолдолд эрх зүйн нэг үйлчлэл үзүүлж буй нэг нэхэмжлэлийн зүйл болно.

Гэтэл нэхэмжлэгч дан ганц 88 дугаар захирамжийн талаар маргаж, шүүх нэг агуулгатай захирамжуудыг тусдаа нэхэмжлэлийн зүйл болно хэмээн үзэж, зөвхөн 88 дугаар захирамжийг хүчингүй болгосноор нэхэмжлэгчийн хүссэн эрх зүйн хамгаалалт буюу ажилдаа эгүүлэн томилогдож, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах шаардлага хангагдахгүй юм. Иймд тухайн нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэргийг шийдвэрлэх нь нэхэмжлэгчид эрх зүйн үр дагаврыг үүсгэхгүй болно.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг¹¹ “...Ерөнхий сайдын 131, 132 дугаар захирамжтай маргах эсэхийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс тодруулахад “...хэргийг урьд гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд шийдцүлье, ...эдгээр захирамжтай маргах эсэхээ дараа нь тусдаа шийднэ...” гэсэн тайлбар өгсөн учраас шүүх “Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 88 дугаар захирамжийг хүчингүй болгож, урьд эрхэлж байсан ажилд эгцүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах” шаардлага бүхий нэхэмжлэлийн хүрээнд хэргийг хэлэлцэж шийдвэрлэлээ...

...Хэрэв хожим нэхэмжлэгч Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131, 132 дугаар захирамжуудыг хүчингүй болгуулахаар маргах тохиолдолд “ажилд эгцүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх хэмжээний нөхөн олговор гаргуулах” нэхэмжлэлийн шаардлага гаргах эрхтэй болно. “Урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох гол үндэслэл нь Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131, 132 дугаар захирамжууд байсан бөгөөд эдгээр захирамжтай маргаж, шүүх хүчингүй болгосон тохиолдолд энэхүү шийдвэрийн хувьд шинээр илэрсэн нөхцөл байдал үүсэх буюу дээрх нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа гэх нөхцөл үгүйсгэгдэх болно.”

Нэхэмжлэгч хожим 131, 132 дугаар захирамжуудыг хүчингүй болгож, урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхэд дахин гаргажээ.

¹¹ АШШ-ийн шийдвэр (2017.01.04), дугаар 15.

Мөн гуравдагч этгээдийн “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах” тухай хүсэлтийн дагуу 88 дугаар захирамжийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хянан шийдвэрлэсэн байна. Түүнчлэн эдгээр хэргийг нэгтгэх хүсэлтийг шүүх хангаагүй бөгөөд тус бүр хяналтын шатны шүүхээр эцэслэгдэн шийдвэрлэгдсэн байдаг.

Иймээс цаашид шүүх маргаан бүхий актын үйлчлэл дуусгавар болох нөхцөлийг дүгнэхдээ анхаарал хандуулах шаардлагатай юм. Учир нь маргаан бүхий акт дуусгавар болсон эсэхийг алдаатай дүгнэвэл нэхэмжлэгч хүссэн эрх зүйн хамгаалалтаа авч чадахгүй байх, нэг агуулгатай захиргааны актад холбогдуулан тусдаа нэхэмжлэлийн шаардлага гаргах, цаашлаад тусдаа шүүхээр шийдвэрлүүлэх, шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх, хэргийн оролцогчдод хүндрэл учруулах үр дагаварт хүргэж болзошгүй юм.

В. ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д “хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа” байх шаардлагыг заасан байна. Энэ нь шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах эсэх, өөрөөр хэлбэл, шүүхэд хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргах эрх үүсэх эсэх асуудлыг үүтгэж байна.

Шүүхийн практикт урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад, эсхүл урьдчилан шийдвэрлэх ажиллагааны өмнө нь дуусгавар болсон актад холбогдуулан нэхэмжлэл гаргах тохиолдол цөөнгүй байна. 2019-2020 онд шийдвэрлэсэн нийт 28 хэргийн 8 нь буюу 26 хувь нь нэхэмжлэл гаргахаас өмнө дуусгавар болсон байна (Дараах графикийг харна уу). Өөрөөр

хэлбэл, “хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа” гэж заасан нь үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхэд нөлөөлөх юм.



УДШ-ийн практикийг авч үзвэл, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад дуусгавар болсон тохиолдолд дүгнэлт гаргаагүй бөгөөд анхнаасаа хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл шүүхэд гаргасан хэд хэдэн тохиолдлыг шийдвэрлэсэн байна. Тухайн тогтоолуудын дүгнэлт хэсгээс үзвэл, шүүхэд анхнаасаа хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргаж болохгүй, харин маргаан бүхий акт дуусгавар болохоос өмнө шүүхэд хүчингүй болгох нэхэмжлэл гаргасан байх шаардлагатай гэх утгаар тайлбарласан байна.

УДШ-ийн тогтоолын хянавал хэсэг:

...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь заалтын дагуу нэхэмжлэгчээс захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа

тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол шүүхээс маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох боломжтой. Гэтэл энэхүү маргааны хувьд нэхэмжлэгчдээс анхнаасаа “захиргааны акт хууль бус байсан болохыг тогтоолгох” нэхэмжлэл гаргасан байхад шүүх түүнийг хүлээн авч, хангаж шийдвэрлэсэн нь буруу юм¹².

...Гагцхүү Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т заасанчлан захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн тохиолдолд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох боломжтой. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч анхнаасаа захиргааны акт хууль бус байсан, эсхүл илт хууль бус байсан болохыг тогтоолгох шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргах боломжгүй¹³.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдийг авч үзвэл, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий акт дуусгавар болсон тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой гэж дүгнэсэн байхын зэрэгцээ, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад дуусгавар болсон тохиолдолд шүүхэд хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргах боломжгүй гэж харилцан адилгүй дүгнэлт гаргажээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын хянавал хэсэг:

...Захиргааны акт хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийн зорилго нь нэхэмжлэгчээс захиргааны актыг хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусахаас өмнө тодорхой шалтгааны улмаас тухайн акт хэрэгжээд дууссан тохиолдолд уг захиргааны актыг хууль

¹² УДШ-ийн тогтоол (2018.06.25) дугаар 288.

¹³ УДШ-ийн тогтоол (2017.11.06), дугаар 440.

бус байсан болохыг тогтоолгоход оршдог. Өөрөөр хэлбэл, актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг гаргаснаас хойш хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн зүйл болох захиргааны акт нь нэгэнт хэрэгжчихсэн тул түүнийг *хүчингүй болгох боломжгүй болсон учраас тогтоох нэхэмжлэлээр солигдож байна гэх агуулгаар ойлговол зохино.* Нэхэмжлэгч “Э” ХХК-ийн хувьд тухайн захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг анхлан гаргасан бөгөөд хүчингүй болгох нэхэмжлэлд тавигдах хуулийн нөхцөл шаардлагыг хангасан байна. Сангийн яамны 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 6-1/3420 дугаар албан бичиг нь нэхэмжлэгч уг актыг хүчингүй болгох нэхэмжлэлийг гаргасны дараа бус, харин тендерийн үнэлгээний хороо мөн оны 5 дугаар сарын 25-ны өдөр тендерийг дахин үнэлснээр, өөрөөр хэлбэл, тус албан бичигт заагдсан ажиллагааг хийснээр хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгч түүнээс хойш уг актыг хүчингүй болгох нэхэмжлэлээ гаргасан нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож байна. *Гэхдээ маргаан бүхий актад урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гарган шийдвэрлүүлж байх үед буюу шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө тухайн захиргааны актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болсон тохиолдолд захиргааны акт хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийг гаргах боломжтой.* Нэхэмжлэгч маргаан бүхий 6-1/3420 дугаар албан бичгийг хэрэгжсэний дараа түүнийг хүчингүй болгох нэхэмжлэлээ гаргасан байх боловч нэхэмжлэгч уг акт гарсныг мэдээгүй, Сангийн яам зөвхөн гомдол гаргагч “М.Х” ХХК болон захиалагчид мэдэгдсэн байх тул “Э” ХХК нь Сангийн яамны 6-1/3420 дугаар албан бичгийн талаар “ЭҮ” ТӨҮГ-ын мөн оны 05 дугаар сарын 25-ны өдрийн ДҮ-112-12/2995 дугаар албан бичгийг хүлээн авснаар мэджээ гэж дүгнэх боломжтой. *Иймд захиргааны акт нэхэмжлэл гаргахаас өмнө хэрэгжсэн байх гэх шаардлагыг нэхэмжлэгчийн буруугаас гомдол гаргах хугацаа дууссан байхыг бус, харин гомдол гаргах хугацаа дуусахаас*

өмнө болон урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн акт нь хэрэгжсэн байхаар ойлговол зохино.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

...Нэхэмжлэгчдээс дээрх нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан “хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох” нэхэмжлэлд хамааруулан гаргасан байх ба энэ нь урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад эсвэл урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хугацаа дуусгавар болсны дараа хэрэгжээд дууссан захиргааны акттай холбогдуулан гаргах нэхэмжлэлийн төрөл юм¹⁴.

Анхан шатны шатны шүүхийн шийдвэр:

...Шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хүчингүй болгосон захиргааны актыг хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага гаргасан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т “захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох” гэж заасантай нийцээгүй гэж үзнэ¹⁵.

¹⁴ АШШ-ийн шийдвэр (2019.04.15), дугаар 221/МА2019/0425, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/3010/view>

¹⁵ АШШ-ийн шийдвэр (2019.08.15), дугаар 221/МА2019/0424, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2905/view>

Шүүхийн шийдвэрүүдээс харахад, ЗХШХШтХ-ийн 106 дугаар 106.3.3-д “хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа” гэх урьдчилсан нөхцөлийг тайлбарлахдаа захиргааны акт дуусгавар болсон хугацааг чухалчлан үзэж буй нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны акт шүүхэд нэхэмжлэл гаргасны дараа, эсхүл урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны өмнө дуусгавар болсон эсэх нь гол хүчин зүйл болжээ. Судлаачдын зүгээс уг нөхцөлийг дүгнэхдээ захиргааны актын дуусгавар болсон хугацаанд бус, харин хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах эрхээ алдсан эсэхэд ач холбогдол өгч тайлбарлах нь хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн зорилгод нийцэх юм.

Практикт нэхэмжлэгч хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах эрхээ алдаагүй үед, тухайлбал, ЗЕХ-ийн 92 дугаар зүйл (захиргааны актад гомдол гаргах хугацаа), ЗХШХШтХ-ийн 14 дүгээр зүйл (захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах хугацаа)-д маргаан бүхий захиргааны акт дуусгавар болох тохиолдол (2.1 дэх хэсэг хэрэг-3) гарахыг үгүйсгэх аргагүй. Энэ тохиолдолд шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь иргэний шүүхэд хандах эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан хэрэг болох юм.

ХОЁР. ШҮҮХЭЭС АНХААРВАЛ ЗОХИХ БУСАД АСУУДАЛ

2.1 НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГА ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГАТАЙ ЭСЭХ

ЗХШХШТХ-ийн 52 дугаар зүйлийн 52.5.1-д заасан хүчингүй болгох нэхэмжлэлийн зүйл нь эрх зүйн үйлчлэлтэй захиргааны акт байхыг шаарддаг. Мөн тус хуулийн 106.5-д “шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй” хэмээн заажээ. Тиймээс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий акт дуусгавар болсноор хүчингүй болгуулах нэхэмжлэлийн зүйл мөн адил дуусгавар болох тул шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. Харин ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д зааснаар нэхэмжлэгчид хууль бус байсан болохыг тогтоолгох ашиг сонирхол байгаа бол хэргийг үргэлжлүүлэн шийдвэрлэх зохицуулалттай байна. Гэтэл шүүхүүд маргаан бүхий акт дуусгавар болсноор нэхэмжлэгч үргэлжлүүлэн маргаагүй, эсхүл маргах ашиг сонирхол байхгүй болохыг дүгнэсэн атлаа ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.14-д заалтыг үндэслэн, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж буй тохиолдол байна. Эндээс 106.3.14-д заасан шийдвэр нь процессын шийдвэр үү, эсхүл хэргийг эцэслэн шийдвэрлэх агуулгын шийдвэр үү? гэсэн асуулт үүдэж байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

...Гэвч нэхэмжлэгч нь нэгэнт хэрэгжиж дууссан Алтанширээ сумын Засаг даргын 2020 оны А/50 дугаар захирамжийг “хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөөгүй бөгөөд энэ тохиолдолд шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5-д “Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй” гэж заасныг зөрчин, “нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрч, маргаан бүхий 2020 оны А/50 дугаар актыг “хууль бус байсан болох” эсэх талаар дүгнэлт хийх замаар нэхэмжлэлийн шаардлагыг шууд өөрчлөн шийдвэр гаргах боломжгүй тул маргаан бүхий 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Газар албадан чөлөөлөх тухай” А/50 дугаар захирамжийг хүчингүй болгуулах шаардлагыг мөн хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ¹⁶ хэмээн дүгнэн, тогтоох хэсэгтээ ЗХШХШТХ-ийн 106.3.14-д заасныг үндэслэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, шийдвэрлэжээ¹⁷.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

...нэхэмжлэгч нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5.1 дахь “захиргааны акт хүчингүй болгуулах, ...захиргааны акт гаргуулахыг даалгах...” агуулгаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан байсан бөгөөд мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь “захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол

¹⁶ АШШ-ийн шийдвэр (2020.11.04), дугаар 115/ШШ2020/0020, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/7273/view>

¹⁷ АШШ-ийн шийдвэр (2020.11.04), дугаар 115/ШШ2020/0020, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/7273/view>

маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох” гэж заасны дагуу маргаан бүхий актаар тодорхойлсон захиргааны актуудыг дээр дурдсанаар хууль бус байсан болохыг тогтоолгох гэж нэхэмжлэлийн шаардлагаа тодорхойлсон, ингэхдээ нэгэнт маргаж буй актууд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэгэнт хэрэгжиж дууссан, цаашид үргэлжлэхгүй болсон гэх агуулгаар маргаж байгаа энэ тохиолдолд шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх үндэслэлгүй байна. ...Гэвч маргаан бүхий акт хэрэгжсэн гэх энэ тохиолдолд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа эсэхийг шүүх анхаарах шаардлагатай юм. Шүүх хуралдаанд нэхэмжлэгч Б.Ц нь ерөнхий боловсролын 18 дугаар дунд сургуульд суралцаж байгааг төлөөлөн нэхэмжлэгч тайлбартаа хэлсэн бөгөөд энэ талаар “...намайг маргах явцад манай хүүхдийг 18 дугаар сургуульд элсүүлж суралцуулсан” хэмээж буй нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй болохыг нотолж байна¹⁸.

Тогтоох хэсэгт ...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.1, 106.3, 106.3.14, 107 дугаар зүйлийн 107.5-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

Нийслэлийн боловсролын газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн А/44 тушаалын 8, Хан-Уул дүүрэг гэсэн хэсгийн 3 болон 4 дүгээр хэсэгт заасан хамран сургах тойрог тогтоосон нь илт хууль бус байсан болохыг тогтоолгох тухай” нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3-д “Анхан шатны шүүхээс “захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд” дараах шийдвэрийг гаргана”, 106.3.14-д

¹⁸ АШШ-ийн шийдвэр (2020.05.12), дугаар 128/ШШ2020/0314, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/6798/view>

“нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох” гэж заасан байгаа нь хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах процессын шийдвэр биш, харин нэгэнт хүлээн авсан нэхэмжлэлийг эцэслэн шийдвэрлэж буй агуулгын шийдвэр болох нь харагдаж байна.

Харин дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нэхэмжлэгчид байхгүй нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан “нэхэмжлэгчийн ашиг сонирхол” байх нөхцөл буюу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл юм. Иймд хэрэв шүүх нэхэмжлэгчид үргэлжлүүлэн маргах ашиг сонирхол байхгүй гэж дүгнэсэн бол 106.3.14-д заасан хэргийг эцэслэн хянан шийдвэрлэх агуулгын шийдвэрийг бус, харин 109 дүгээр зүйлийн 109.2-д заасны дагуу хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах процессын шийдвэр гаргах учиртай.

Улсын дээд шүүх нь “нэхэмжлэл гаргахаас өмнө дуусгавар болсон актад холбогдуулан нэхэмжлэл гаргах нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д нийцэхгүй буюу ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан татгалзах үндэслэл болно” хэмээн дүгнэж, ЗХШХШТХ-ийн 109 дүгээр зүйлийн 109.2-т зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзан, хэргийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэл бүхий байна.

Хяналтын шатны шүүхийн тогтоолын хянавал хэсэгт:

...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоохоор заажээ.

...өөрөөр хэлбэл нэхэмжлэгч “Х” ХХК-иас дээрх захиргааны

актуудыг хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргахаас өмнө, маргаан бүхий захиргааны актуудыг дараагийн эрх олгосон захирамжуудаар хүчингүй болгосон, иймд шүүхээс эрх зүйн үйлчлэлгүй болсон захиргааны актыг хууль бус байсан болохыг тогтоох үндэслэлгүй учир нэхэмжлэлийн эдгээр шаардлагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан үндэслэлээр шүүх хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх байжээ. Иймээс энэ үндэслэлээр шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэв.

Хяналтын шатны шүүхийн тогтоолын тогтоох хэсэгт: *...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2-т заасныг баримтлан “Багануур дүүргийн Засаг даргын 2005 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 442, 2008 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 512 дугаар захирамжуудаар “Д” ХХК-д, 2009 оны 12 дугаар барын 10-ны өдрийн 496 дугаар захирамжаар “Ж г” ХХК-д, 2011 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн А/222 дугаар захирамжаар “Ж а” ХХК-д “Х” ХК-ийн өмчлөлийн төмөр замын болон дундын ашиглалтын гол төмөр замын доорх газрыг оролцуулан эзэмшүүлсэн хэсгийг тус тус хууль бус байсан болохыг тогтоолгох”-ыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагуудыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчлөн...*¹⁹

¹⁹ УДШ-ийн тогтоол (2019.12.23), дугаар 02, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/2156/view>

2.2. НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХГҮЙ БОЛОХ НЬ ТОГТООГДВОЛ ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д “захиргааны акт *хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа* тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох” хэмээн, мөн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-д уг нэхэмжлэлийн төрөл байхгүй нь нэхэмжлэгч анх хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан байхад хангалттай, эсхүл нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа хууль бус байсан болохыг тогтоох болгож өөрчлөх шаардлагатай эсэх асуудлыг хөндөж болох юм.

Шүүхийн практикаас харахад, 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаарсарын 31-ний өдрийн хугацаанд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн нийт 28 хэргээс 25 хэргийн нэхэмжлэлийн зүйл нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дуусгавар болсон байна (Хүснэгтээс харна уу).

Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн эсэх	Нэхэмжлэлийн зүйлийн тоо	Хувь
Нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн	18	64%
Нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөөгүй	5	18%
Хүчингүй болгох нэхэмжлэл шаардлагын хүрээнд хэргийг шийдвэрлэсэн	2	7%

УДШ-ийн тогтоолоос үзвэл, нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх хүсэлт гаргаагүй тохиолдолд хэргийг эцэслэн шийдвэрлэх нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5-д заасан “нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэргийг шийдвэрлэх зарчим”-ыг зөрчинө хэмээн дүгнэж байна.

УДШ-ийн тогтоолын хянавал хэсэг:

..Сангийн яамны дээрх шийдвэр гарснаар түүний өмнөх 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 6-1/3064 тоот шийдвэр болон хариуцагч Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдөр зарласан тендерийн (Тендерийн урилгад тендерийг 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 10 цаг 30 минутад нээхээр заасан) эрх зүйн үйлчлэл нь дуусгавар болж, бодит байдалд биелэгдэх боломжгүй болсон тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон давж заалдах шатны шүүхийн шийдэл зөв байна.

Харин нэхэмжлэгчийн хувьд ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т зааснаар захиргааны акт хүчингүй болгох нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн боловч ашиг сонирхол байгаа гэж үзсэн бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоолгуулахаар нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх боломжтой байсныг дурдах нь зүйтэй²⁰.

УДШ-ийн тогтоолын хянавал хэсэг:

...анхан шатны шүүх 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр хэргийг хэлэлцэж, шийдвэр гаргахдаа нэхэмжлэлийн шаардлагыг өөрөө өөрчилж, шийдэлдээ нийцүүлсэн нь хэрэг хянан

²⁰ УДШ-ийн тогтоол (2020.07.24), дугаар 18, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1593/view>

шийдвэрлэх ажиллагааны журмын ноцтой зөрчил ба уг алдааг давж заалдах шатны шүүх засаагүй нь буруу болжээ. Тодруулбал, ЗХШХШтХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1, 52 дугаар зүйлийн 52.2.4-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа “2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.2-т заасан үүргээ биелүүлээгүй Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгох” гэж тодорхойлсон (анхан шатны шүүх хуралдаанд өөр байдлаар тодорхойлоогүй) байхад шүүх “өнгөрсөн цаг хугацаанд хэм хэмжээний актыг гаргаагүй эс үйлдэхүй хууль бус байсан” гэсэн агуулгаар нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын зөрчилд тооцогдоно. Учир нь ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5-д зааснаар шүүх “нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд” хэргийг шийдвэрлэх үүрэгтэй, өөрөөр хэлбэл, хуулиар нэхэмжлэлийн шаардлагыг өөрийн санаачилгаар өөрчлөн шийдвэрлэх эрх хэмжээг шүүхэд олгоогүй байна²¹.

УДШ-ээс нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх хүсэлтэд үндэслэн, хэргийг шийдвэрлэх шаардлагатай гэсэн байр суурьтай байх боловч анхан шатны шүүхүүд харилцан адилгүй байдлаар авч үзэж байна. Тухайлбал, нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөөгүй боловч шүүх хууль зүйн тодорхой дүгнэлтийн үндсэн дээр хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэсэн тохиолдол байна.

Хэрэг 1. Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг: ...Хэдийгээр нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Б/934 дүгээр тушаалын хувьд

²¹ УДШ-ийн тогтоол (2020.06.23), дугаар 241.

“хүчингүй болгуулах” хэмээн тодорхойлсон ч шүүхэд хандан нэхэмжлэл гаргах үед уг тушаалд өөрчлөлт оруулсан, тушаалыг өөрчилсөн ч нэхэмжлэгчийн “ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” нэхэмжлэлийн шаардлагаар тодорхойлогдсон ашиг сонирхол байгаа тул шүүх энэхүү хууль бус тушаалыг ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т зааснаар “хууль бус байсан болохыг тогтоож” шийдвэрлэлээ²².

Анхан шатны шүүх үндэслэл бүхий дүгнэлт хийжээ. Учир нь нэхэмжлэгч хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахдаа ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах ашиг сонирхлоо нэгэнт илэрхийлсэн байх бөгөөд маргаан бүхий акт дуусгавар болсонтой холбоотойгоор уг ашиг сонирхлоосоо татгалзаагүй юм. Тиймээс шүүх нэхэмжлэлийн шаардлагыг тодорхойлохдоо нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн төрлөөс гадна нэхэмжлэгчийн бодитоор авахыг хүссэн эрх зүйн хамгаалалтыг харгалзан үзэх нь чухал юм. Цаашид хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа маргаан бүхий актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болох тохиолдолд маргааныг шийдвэрлэсэн шүүхийн дүгнэлтийн арга зүй ихээхэн ач холбогдолтой болжээ.

Мөн нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөөгүй тохиолдолд шүүх маргаан бүхий актын үндсэн дээр байгуулагдсан гэрээ нэгэнт дуусгавар болсон тул нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрх сэргэхгүй гэж дүгнэсэн атлаа хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэсэн тохиолдол байна.

Хэрэг 2. Нэхэмжлэлийн шаардлага

“М” ХХК-ийг шалгаруулах тухай үнэлгээний хорооны зөвлөмжийг хүчингүй болгуулах болон “М” ХХК болон ИНЕГ-ын хооронд байгуулсан “Түлшний шүүрний

²² АШШ-ийн шийдвэр (2020.08.25), дугаар 527.

элемент нийлүүлэх” 160/19 тоот гэрээг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Ингэснээр тендерийн шаардлагад нийцсэн тендер илгээсэн “Х” ХХК нь уг тендер шалгаруулалтад шалгарсан нь тогтоогдох бөгөөд ИНЕГ-тай гэрээ байгуулах эрхтэй болж, зөрчигдсөн эрх ашиг нь хамгаалагдах боломжтой.

Анхан шатны шүүхийн үндэслэх хэсэг:

Хэдийгээр Түлшний шүүрний элемент нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан, “М” ХХК-ийг илт худал баримтыг тендерт гаргаж хүргүүлснийг тогтоосон аливаа шийдвэр гараагүйгээс хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт бичгүүдийг хуурамч эсэхийг тендерийн үнэлгээний хороо мэдэх боломжгүй” гэсэн тайлбарыг буруутгахааргүй боловч энэ нь оролцогчоос ирүүлсэн тендер нь тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхийг нягтлан шалгах, оролцогчоос ирүүлсэн баримт бичиг үнэн зөв эсэх, тэр дундаа өөр этгээдээс олгосон тодорхойлолт, зөвшөөрөл зэрэг нь хууль ёсны дагуу олгогдсон эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, түүнчлэн төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг шударгаар зохион байгуулах үүргээс чөлөөлөхгүй тул уг тендер шалгаруулалтад мөн шаардлагад нийцсэн тендер хүргүүлсэн боловч бага үнийн шалгуураар ялагдсан “Х” ХХК-ийн шударгаар өрсөлдөх, шалгарч, гэрээ байгуулах эрх зөрчигдсөн гэж үзэхээр байх тул нэхэмжлэл хангагдах үндэслэлтэй байна.

Гэвч ИНЕГ болон “М” ХХК-ийн хооронд байгуулагдсан “Түлшний шүүрийн элемент нийлүүлэх тухай” гэрээ ИНЕГУЗ/ТО/ТББ/Б-04/19 тоот гэрээ хэрэгжсэн, “М” ХХК нь ОХУ-ын “Э-2” компанийн үйлдвэрлэсэн ЭФК-300-5-М, ФЭ-700-15-

1-Е, ФЭ-170-5-1-В, ФЭ-2000-15-1-Б, ФЭ-1340-15-1-Б маркийн шүүлтүүрийн элементүүдийг “Иркутскнефтесервистрейд” хувьцаат нийгэмлэгийн захиалгаар дамжуулан худалдан авч нийлүүлснийг бараа, материал хүлээн авах комиссын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар актаар захиалагч хүлээн авсан байх тул нэхэмжлэлийн ““М” ХХК болон ИНЕГ-ын хооронд байгуулсан “Түлшний шүүрний элемент нийлүүлэх тухай” 1602/19 тоот гэрээг хүчингүй болгуулах” шаардлага хангагдсанаар нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол сэргэхгүй.

Иймд ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т “захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох” гэж заасны дагуу “ИНЕГ-ын даргын 2019 оны А/512 тоот тушаалаар байгуулагдсан Түлшний шүүрний элемент нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01 тоот дүгнэлт, зөвлөмжийг хууль бус байсан болохыг тогтоож, нэхэмжлэлийн үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй хэмээн шүүх дүгнэлээ²³.

Энэ хэргийн хувьд нэхэмжлэгч хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхлоо тендерт гэрээ байгуулах эрх олж авах гэж тодорхойлсон байдаг. Гэтэл тендер хэрэгжсэн байх тул нэхэмжлэгчийн тодорхойлсон ашиг сонирхол мөн дуусгавар болох юм. Өөрөөр хэлбэл, бодит байдалд тендер байхгүй болсон учраас түүнд оролцох, гэрээ байгуулах тухай ойлголт байх учиргүй. Тиймээс нэхэмжлэгчид Түлшний шүүрний элемент нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон

²³ АШШ-ийн шийдвэр (2020.03.26), дугаар 0201.

шалгаруулах үнэлгээний хорооны 01 тоот дүгнэлт, зөвлөмжийг хууль бус байсан болохыг тогтоох шийдвэрийг шүүхээс гаргуулах хэрэгцээ шаардлага байхгүй юм. Гэвч шүүхээс маргаан бүхий актыг хууль бус байсан болохыг тогтоох шийдвэр гаргасан нь учир дутагдалтай.

Энэхүү шүүхийн дүгнэлтийн агуулгаас харахад, шүүх маргаан бүхий актын үндсэн дээр байгуулагдсан гэрээ хэрэгжээд дуусгавар болсны дараа нэхэмжлэгчид үргэлжлүүлэн маргах ашиг сонирхол байгаа эсэхийг шалгахгүйгээр хуулийн зөрчлийг шалгасан байх (Хэрэг 3 мөн адил) бөгөөд тус актын алдааны улмаас нэхэмжлэгчийн гэрээ байгуулах эрх зөрчигдсөн болохыг дүгнэжээ. Энэ нь шүүхийг маргаан бүхий актыг хууль бус байсан болохыг тогтоох шийдвэр гаргахад хүргэсэн байхыг үгүйсгэх аргагүй. Учир нь хүчингүй болгуулах нэхэмжлэл ач холбогдлоо алдсан байх тул тус шийдвэрийг гаргах боломжгүй нөхцөл байдал үүсжээ. Гэвч шүүх нэгэнт маргаан бүхий акт хууль зөрчсөн, түүний улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдсөн болохыг дүгнэсэн атлаа хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйд нийцэхгүй юм.

Тиймээс цаашид шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий захиргааны акт дуусгавар болсон тохиолдолд актын хуулийн зөрчлийг шалгаххаас өмнө нь нэхэмжлэгчид үргэлжлүүлэн маргах ашиг сонирхол байгаа эсэх, өөрөөр хэлбэл, шүүхээс хууль бус байсан болохыг тогтоох шийдвэр гаргуулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг дүгнэх шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болсонтой холбоотойгоор нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн боловч нэхэмжлэгчид ийнхүү үргэлжлүүлэн маргах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг шүүх дүгнэлгүйгээр нэхэмжлэлийг хүлээн авч, хэргийг шийдвэрлэжээ.

Хэрэг 3. А нам нь жагсаал хийх тухай мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. Үүний дараа мэдэгдэлд дурдсан өдрөө жагсаал, цуглаан зохион байгуулсан бөгөөд нэхэмжлэлийн шаардлагаа хууль бус байсан болохыг тогтоох болгож өөрчилжээ.

АШШ-ийн үндэслэх хэсэг:

Маргаан бүхий захиргааны акт нь Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар нэхэмжлэгчийн Монгол Улсын Үндсэн хуульд заасан тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хөндсөн гэж үзээд маргаан бүхий захиргааны акт нь дээрх хуулийн заалтуудыг зөрчсөн, мөн *нэхэмжлэгчийн жагсаал, цуглаан хийх эрхийг хөндсөн*, нэгэнт нэхэмжлэгчээс зохион байгуулсан жагсаал, цуглаан хийх хугацаа өнгөрсөн учир А намаас 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр жагсаал хийх тухай мэдэгдлийг НЗД бүртгэхээс татгалзсан шийдвэр (амаар гаргасан захиргааны акт) болон НЗДТГ, ХЭЗХД-ын 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 07/1122 дугаар албан тоот хууль бус байсан болохыг тогтоох нь зүйтэй байна²⁴.

Энэ хэргийн тухайд А нам нь Нийслэлийн засаг даргын татгалзсан шийдвэрээс үл хамааран, жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу нэхэмжлэгчийн эрх зөрчигдөөгүй, мөн Нийслэлийн засаг даргын шийдвэрийг хууль зөрчсөн болохыг шүүхээр тогтоолгох хэрэгцээ, шаардлага байгаа гэдгээ илэрхийлээгүй аж. Гэтэл шүүх нэхэмжлэгчийн жагсаал, цуглаан хийх эрхийг хөндсөн гэх үндэслэлээр нэхэмжлэлийг шийдвэрлэсэн нь учир

²⁴ АШШ-ийн шийдвэр (2019.04.17), дугаар 242.

дутагдалтай. Учир нь хэргийг шийдвэрлэхэд нэхэмжлэгчийн эрхийг хөндсөн байх нь хангалтгүй, харин шүүхээр тухайн актыг хууль бус байсан болохыг тогтоосноор А намын зөрчигдсөн эрх сэргэх, эсхүл ирээдүйд бий болох ашиггүй нөхцөл байдлаас сэргийлэх үр дагавартай байх шаардлагатай.

Хэрэв ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан “нэхэмжлэгчийн ашиг сонирхол” гэдэгт маргаан бүхий актын улмаас эрх хөндөгдсөн байхыг хамааруулан авч үзвэл бүхий л эрх зүйн үйлчлэл нь дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан маргах боломжтой. Өөрөөр хэлбэл, “нэхэмжлэгчийн ашиг сонирхол” гэх нэхэмжлэл гаргах эрхийн шалгуурын ач холбогдлыг үгүйсгэж, маргах эрхийг хязгаарлалтгүйгээр нээж өгөх юм. Энэ нь шүүхийн ачаалал хийсвэрээр нэмэгдэх, үүний улмаас эрх зүйн хамгаалалт зайлшгүй шаардлагатай хэргүүдэд шүүхийн хамгаалалт дутагдах зэрэг үр дагаварт хүргэх эрсдэлтэй билээ.

Тиймээс энэ хэргийн хувьд шүүх А намын НЗД-ын татгалзсан шийдвэрийг хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагыг ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2-д заасны дагуу хүлээн авахаас татгалзаж, маргаан бүхий актыг хууль бус байсан болохыг тогтоолгох хэрэгцээ, шаардлага нэхэмжлэгчид байх шаардлагатайг тайлбарлаж, нэхэмжлэл гаргах боломжийг олгох нь зүйтэй юм.

Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... эрх бүхий байгууллагад бүртгүүлэлгүйгээр, ...жагсаал, цуглаан зохион байгуулсан, ...бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж зааснаас үзвэл, А намд НЗД-ын жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэхээс татгалзсан шийдвэрийг хууль зөрчсөн болохыг тогтоолгох хэрэгцээ, шаардлага байна. Өөрөөр хэлбэл, маргаан бүхий актын

эрх зүйн үйлчлэл хэдийгээр дуусгавар болсон боловч нэхэмжлэгчид зөрчлийн хариуцлага хүлээлгэх урьдчилсан нөхцөл болж байна. Иймээс А намд тухайн актыг хууль бус байсан болохыг тогтоолгохоор нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байна.

Иймд цаашид шүүхүүд дуусгавар болсон захиргааны актад нэхэмжлэл гаргах эрхийн шалгуурын (нэхэмжлэл гаргах ашиг сонирхол) ач холбогдол, түүнийг тодорхойлох арга зүйд анхаарал хандуулахгүй бол тус нэхэмжлэлийн утга агуулга, ач холбогдол багасах, улмаар үгүйсгэгдэх эрсдэлтэй байж болох юм.

Хэрэг 4. Г нь сумын Засаг даргын “Газар албадан чөлөөлөх тухай” А/50 дугаар захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад газрыг албадан чөлөөлснөөр уг захирамж хэрэгжжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэг:

..Өөрөөр хэлбэл, шүүхээс хүчингүй болгуулахаар шаардаж буй захиргааны акт нь эрх зүйн үйлчлэл нь дуусаагүй акт байх ёстой бөгөөд нэгэнт хэрэгжсэн буюу биелэгдэж дууссан актыг шүүх дахин хүчингүй болгож шийдвэрлэхгүй. Шүүхээс нэхэмжлэгч *Ц.Ганбат, түүний өмгөөлөгчид нэхэмжлэлийн шаардлагаа тодруулах, зөвтгөх боломжийг удаа дараа олгон, шүүхээс гаргах шийдвэрийн төрлийн талаар тайлбарлан өгсөн болохыг дурдах нь зүйтэй байна.* Гэвч нэхэмжлэгч нь нэгэнт хэрэгжиж дууссан Алтанширээ сумын Засаг даргын 2020 оны А/50 дугаар захирамжийг “хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөөгүй бөгөөд энэ тохиолдолд шүүх ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5-д “Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр

гаргаж болохгүй” гэж заасныг зөрчин, “нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрч, маргаан бүхий 2020 оны А/50 дугаар актыг “хууль бус байсан болох” эсэх талаар дүгнэлт хийх замаар нэхэмжлэлийн шаардлагыг шууд өөрчлөн, шийдвэр гаргах боломжгүй тул маргаан бүхий 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн “Газар албадан чөлөөлөх тухай” А/50 дугаар захирамжийг хүчингүй болгуулах шаардлагыг мөн хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ²⁵ гэж дүгнэн, ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.14-д заасныг үндэслэн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ.

Маргааныг шийдвэрлэсэн анхан шатны шүүх маргаан бүхий актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болсонтой холбоотойгоор нэхэмжлэгчид нэхэмжлэлийн шаардлага, шүүхийн шийдвэрийн үр дагаврыг тайлбарлаж, нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх боломжийг олгосон нь ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2-д “Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана” гэж заасанд нийцнэ. Учир нь уг зохицуулалтын зорилго нь нэхэмжлэгчийн хүссэн эрх зүйн хамгаалалтыг олгоход чиглэсэн байх бөгөөд шүүгчийн тодруулах үүргийг заасан байна. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болох нь нэхэмжлэгчийн хувьд шинэ нөхцөл байдлыг бий болгодог буюу хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлага үгүйсгэгдэх юм. Гэвч нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөөгүй бол хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэргийг шийдвэрлэх боломжгүй учир нь ЗХШХШТХ-ийн 109 дүгээр 109.2-д зааснаар *хэргийг хэрэгсэхгүй болгох* нь зүйтэй юм. Гэвч энэ хэргийн хувьд

²⁵ АШШ-ийн шийдвэр (2020.11.04), дугаар 115/ШШ2020/0020.

шүүх ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.14-д заасныг үндэслэн *нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож* шийдвэрлэсэн нь учир дутагдалтай байна (Энэ талаар 2.3 хэсэгт авч үзсэн болно).

2.3. ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД МАРГААН БҮХИЙ АКТ ДУУСГАВАР БОЛСОН ТОХИОЛДОЛД ШҮҮХЭЭС ГАРГАХ ШИЙДВЭРИЙН ТӨРӨЛ

ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1-д нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг хуульчилсан байна. Эдгээр нь адил эрх зүйн үр дагаврыг үүсгэх боловч ялгаж, оновчтой хэрэглэх нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг төлөвшүүлэх, талуудад хүлээн зөвшөөрөгдөх шинжийг олгох талаасаа арга зүйн хувьд ач холбогдолтой юм. Гэтэл УДШ-ийн тогтоолуудыг авч үзвэл, шүүхэд анхнаасаа хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргасан тохиолдолд харилцан адилгүй үндэслэлээр татгалзаж байна.

УДШ-ийн тогтоолын хянавал хэсэг:

...шүүх “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд”-ийн нэхэмжлэлийг хүлээн авч хэрэг цусгэн, улмаар анхан шатны шүүх нэхэмжлэлийн зарим шаардлагыг хангаж, харин давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Гагцхүү ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-т заасны дагуу захиргааны акт *хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа* тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн тохиолдолд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол маргаан бүхий акт хууль бус байсан

болохыг тогтоох боломжтой. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч анхнаасаа захиргааны акт хууль бус байсан, эсхүл илт хууль бус байсан болохыг тогтоолгох шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргах боломжгүй²⁶.

УДШ-ийн тогтоолын хянавал хэсэг:

...өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч “Х” ХХК-аас дээрх захиргааны актуудыг хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргахаас өмнө, маргаан бүхий захиргааны актуудыг дараагийн эрх олгосон захирамжуудаар хүчингүй болгосон, иймд шүүхээс эрх зүйн үйлчлэлгүй болсон захиргааны актыг хууль бус байсан болохыг тогтоох үндэслэлгүй учир нэхэмжлэлийн эдгээр шаардлагыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан үндэслэлээр шүүх хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэх байжээ²⁷.

УДШ-ийн тогтоолын хянавал хэсэг:

...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь заалтын дагуу нэхэмжлэгчээс захиргааны акт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн бөгөөд нэхэмжлэгчийн ашиг сонирхол байгаа бол шүүхээс маргаан бүхий акт хууль бус байсан болохыг тогтоох боломжтой. Гэтэл энэхүү маргааны хувьд нэхэмжлэгчдээс анхнаасаа “захиргааны акт хууль бус байсан болохыг тогтоолгох” нэхэмжлэл гаргасан байхад шүүх түүнийг хүлээн авч, хангаж шийдвэрлэсэн нь буруу юм.

²⁶ УДШ-ийн тогтоол (2017.11.06), дугаар 440.

²⁷ УДШ-ийн тогтоол (2019.12.23), дугаар 02.

Хэдийгээр энэ тохиолдолд хяналтын шатны шүүхээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан өөрчлөлт хийх боломжтой ч шүүхийн алдааны улмаас нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүй үүднээс нэхэмжлэлийн уг шаардлагыг анхан шатны шүүхээс дахин тодруулах нь зүйтэй гэж үзлээ²⁸.

Дээрх тогтоолуудын хянавал хэсгээс харвал, эхний тохиолдолд 54.1.5-ыг үндэслэсэн байхад дараагийн хоёр тохиолдолд 54.1.1 дэх заалтыг үндэслэж, нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзсан байна. Энэ нь ЗХШХШтХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан шаардлагыг бүрэн хангаагүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл нь 54.1.1 дэх зохицуулалт уу, эсхүл 54.1.5 дахь зохицуулалт уу гэсэн асуулт тавигдах юм.

Хуулийн зохицуулалтыг авч үзвэл, ЗХШХШтХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус”, 54.1.5 -д “нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй болон нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэж заажээ. Хэргийн харьяалал гэдэг нь тухайн хууль зүйн фактыг хянан шийдвэрлэх шүүхийн төрлийн тухай ойлголт юм. ЗХШХШтХ-ийн 13 дугаар зүйлээр захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааныг ерөнхий зарчмаар заасан байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц, өөр шүүхэд харьяалуулснаас бусад ЗЕХ-ийн 3.1-д заасан үйл ажиллагаанд хамаарахгүй нийтийн эрх зүйн хүрээнд үүсэх хууль зүйн фактыг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан

13.1. Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон

²⁸ УДШ-ийн тогтоол (2018.06.25), дугаар 288.

өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ.

13.2. Захиргааны ерөнхий хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй.

Харин нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэх ойлголт нь өмнө дурдсан нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэх асуудалтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч нь тухайн нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг бүрэн дүүрэн хангаж буй эсэх шалгуур юм. Энэ нь манай улсын ЗХШХШТХ-д 52 дугаар зүйлийн 52.5, 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсэгт хуульчлагджээ. Тиймээс ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5 дахь зохицуулалт нь 52.5, 106.3 дахь заалтуудтай хамт хэрэглэгдэх учиртай.

Иймд шүүхэд анхнаасаа хууль бус байсан болохыг тогтоолох нэхэмжлэл гаргах нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан урьдчилсан нөхцөлийг хангахгүй гэж үзэж байгаа бол мөн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5 заасныг үндэслэн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь оновчтой юм. Түүнчлэн Хэрэг 2-ын тухайд дүүргийн засаг даргын газар эзэмших эрх олгосон захирамж нь ЗХШХШТХ-ийн 13 дугаар зүйлд зааснаар захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх хууль зүйн факт байх нь маргаангүй юм. Хэрэв шүүх ЗХШХШТХ-ийн 13 дугаар зүйлд зааснаас өөр үндэслэлээр захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааныг хязгаарлан тайлбарлаж байгаа бол тухайн үндэслэлээ бичих зайлшгүй шаардлагатай.

ГУРАВ. БНСУ-ЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. БНСУ-ЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОРИЛГО, ҮЗЭЛ САНАА, ОНЦЛОГ

БНСУ нь 1951 онд анх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль нь захиргааны байгууллагын хууль бус акт болон төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйлдэл, эс үйлдэхүйн улмаас иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс хамгаалах, нийтийн эрх зүйн харилцаа болон хууль хэрэглээтэй холбогдсон маргааныг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар дамжуулан зохистойгоор шийдвэрлэх зорилготой²⁹. Ийнхүү манай улсын адил иргэний субъектив эрхийг хамгаалахын сацуу объектив эрхийн хамгаалалтыг тодорхой хэмжээнд нээж өгсөн байдаг.

БНСУ-ын Захиргааны процессын эрх зүйд “Нэхэмжлэл байхгүй бол шүүхийн шийдвэр байхгүй”³⁰ гэх зарчим үйлчилдэг. Энэ нь нэг талаас захиргааны процессын эрх зүйн субъектив эрхийг хамгаалах зорилготой холбоотой бөгөөд нөгөө талаас шүүхийн дур зоргыг хязгаарлах, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэхэд чиглэдэг хэмээн тайлбарладаг. Түүнчлэн “нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй бол нэхэмжлэл байхгүй”³¹

²⁹ БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (1951)-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

³⁰ 소 없으면 판결 없다.

³¹ 소의 이익 없으면 소가 없다 (이익이 없으면 소 없다)

гэх зарчим ч мөн үйлчилдэг. Тодруулбал, нэхэмжлэгч нь нэхэмжлэл гаргах ашиг сонирхолтой байх шаардлагатай.

Уг нэхэмжлэл гаргах ашиг сонирхол³² гэх ойлголт нь онолын хувьд өргөн болон явцуу утгаар хэрэглэгддэг. Өргөн утгаараа нэхэмжлэлийн зүйл (объект)-ийн шалгуур, нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуур, эрхээ хамгаалуулах шаардлага гэх ойлголтуудын уялдаа холбоог агуулсан цогц утгыг илэрхийлдэг бол явцуу утгаараа эрхээ хамгаалуулах шаардлага гэсэн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл нэхэмжлэл гаргах ашиг сонирхол гэдэг нь эрхээ хамгаалуулах шаардлагыг илэрхийлж буй ойлголт юм. Нэхэмжлэлд эрхээ хамгаалуулах шаардлагыг тавьж байгаа нь нэхэмжлэгч шүүхэд хандах эрхээ хэтрүүлэхгүй байх, шүүхийн шийдвэр нэхэмжлэгчид ач холбогдолтой байхад чиглэдэг гэж судлаачид дүгнэжээ³³.

Дээрх хоёр зарчмаас үүдэлтэйгээр шүүх аливаа хэргийг шийдвэрлэхдээ хоёр үндсэн зүйлийг шалгадаг байна. Нэгдүгээрт, нэхэмжлэл нь нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг хангасан эсэх, тухайлбал, нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэх, урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн эсэх, хөөн хэлэлцэх хугацааг баримталсан эсэх, уг асуудлаар өөр шүүхийн шийдвэр байгаа эсэх зэрэг урьдчилсан нөхцөлүүдийг шалгаж, хангагдсан тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авч, хэрэг үүсгэдэг. Хоёрдугаарт, хэрэг үүсгэсний дараа маргаан бүхий захиргааны актыг хууль зөрчсөн эсэхийг шалгаад, эцсийн шийдвэрийг гаргадаг³⁴. Түүнчлэн хэрэг үүсгэсний дараа буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг хангаагүй болох нь тогтоогдвол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг.

³² 소의 이익

³³ 김남진/김연태, 행정법, 법문사, 2013, 760면

³⁴ 홍정선, 행정법 입문, 396

БНСУ-ын үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан гаргах нэхэмжлэлийг явцуу утга бүхий нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын хүрээнд дийлэнх судлаач тайлбарладаг³⁵ тул энэ талаарх онолын зохицуулалт, онцлогийг тодруулан авч үзье.

Өмнө дурдсанчлан нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нь нэхэмжлэлийн зүйл (объект)-ийн шалгуур, нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуур, эрхээ хамгаалуулах шаардлагын уялдаа холбоог илэрхийлсэн цогц ойлголт тул доорх хэсэгт эдгээр ойлголтыг авч үзсэн болно. Түүнчлэн эдгээр ойлголт нь хоорондоо ялгаатай боловч хуулийн зохицуулалт, онол, шүүхийн практикт төдийлөн ялгаж хэрэглэдэггүй болохыг дурдах нь зүйтэй.

³⁵ 김철용, 『행정법』, 고시계사, 2014, 583면.

Нэхэмжлэл гаргах ашиг сонирхол	
Нэхэмжлэ- лийн зүйл	<p>Захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар гаргасан хуулийн хэрэгжилтийн хувьд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйлдэл, татгалзал, түүнтэй адилтгах захиргааны үйл ажиллагаа болон захиргааны хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанаас гарсан шийдвэрийг хэлнэ³⁶.</p> <p>Захиргааны байгууллага холбогдох эгтээдийн хүсэлтэд хууль тогтоомжид заасны дагуу акт гаргах үүрэг хүлээсэн боловч тодорхой хугацааны дотор үүргээ биелүүлээгүй байхыг хэлнэ³⁷.</p> <p>1984 онд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн найруулж, уг шинэчилсэн найруулгаар нэхэмжлэлийн төрлийг анх удаа хуульчилсан ба тус хуулийн 3 дугаар зүйлд захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлийг³⁸ гомдлын, оролцогч талуудын, нийтийн эрх ашгийг хамгаалах, захиргааны байгууллага хоорондын нэхэмжлэл гэж ангилсан байдаг. Дээр дурдсан гомдлын нэхэмжлэлд хүчингүй болгуулах, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолох, эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолох нэхэмжлэлийн төрлийг хуульчилсан байна³⁹. Харин бусад төрлийн нэхэмжлэлийг онол болон шүүхийн практикаар хөгжүүлж, хүлээн зөвшөөрдөг.</p>
Нэхэмжлэл гаргах эрх- тэй эгтгээд	<p>Нэхэмжлэ- лийн төрөл</p>
	<p>Дээрх гомдлын нэхэмжлэлд хамаарах гурван төрлийн нэхэмжлэлийн хувьд субъектив эрхийн зөрчлөөр нэхэмжлэл гаргах эрх (ашиг сонирхол) үүснэ.</p>
	<p>Субъектив эрх</p>

³⁶ 행정소송법 제2조 제1항.

³⁷ 행정소송법 제2조 제2항.

³⁸ 행정소송법 제3조.

³⁹ 행정소송법 제4조, 제12조, 제35조, 제36조.

	Объектив эрх	Харин нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нэхэмжлэл болон захиргааны байгууллага хоорондын нэхэмжлэлийн хувьд хууль тогтоомжид заасан тохиолдолд нэхэмжлэл гаргах эрх (ашиг сонирхол) үүснэ ⁴⁰ .
	Онол ба шүүхийн жишиг	Эрхээ хамгаалуулах шаардлагыг хууль тогтоомжид тодорхой хуульчлаагүй боловч онол болон шүүхийн практикаар хүлээн зөвшөөрдөг. Уг урьдчилсан нөхцөл нь ашиггүй шүүхийн шийдвэр хүсэх, шүүхэд хандах эрхээ хэтрүүлэхийг хязгаарлах зарчмаас үүдэлтэй гэж судлаачид тайлбарладаг ⁴¹ .
<p>Эрхээ хамгаалуулах шаардлага</p>	<p>Эрхээ хамгаалах шаардлага үгүйсгэгдэх тохиолдол</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр өөр аргаар зорилгодоо илүү амархан хүрэх боломжтой бол нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй гэж үзэх бөгөөд үүнд шүүхийн харьяаллыг буруу сонгож, нэхэмжлэл гаргах эсхүл нэхэмжлэлийн төрлийг буруу сонгох зэрэг хамаарна. 2. Нэхэмжлэлийн шаардлагыг хангасан ч зорилгодоо хүрэх боломжгүй буюу нэхэмжлэл гаргах нь бодит байдалд ямар ч ашиггүй байх тохиолдолд эрхээ хамгаалуулах шаардлага үгүйсгэгдэнэ. 3. Зохисгүй зорилгоор гаргаж буй нэхэмжлэл. Жишээлбэл, өөрийн эрхийг хамгаалуулах зорилгоор бус, зөвхөн бусдад хохирол учруулах зорилгоор гаргаж буй нэхэмжлэлийн хувьд эрхээ хамгаалуулах шаардлага байхгүй гэж үзнэ⁴².

40 행정소송법 제12조, 제35조, 제36조.

41 홍정신, 행정법 입문, 424.

42 홍정신, 행정법 입문, 425.



3.1.1 ДУУСГАВАР БОЛСОН ЗАХИРГААНЫ АКТ ЗЭРЭГТ ХОЛБОГДУУЛАН НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь 1984 оны 12 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэн найруулагдаж, 1985 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэхүү шинэчилсэн найруулгын хүрээнд үйлчлэл дуусгавар болсон захиргааны акт зэрэгт холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын эрх зүйн үндэслэлийг анх удаа нэмж хуульчилжээ.

Ингэснээр БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд 2 дахь өгүүлбэрийг нэмж, “үйлчлэл дуусгавар болсон захиргааны акт зэрэгт” холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргах талаар дараах байдлаар зохицуулжээ.

제12조(원고적격)

취소소송은 처분등의 취소를 구할 법률상 이익이 있는 자가 제기할 수 있다. 처분등의 효과가 기간의 경과, 처분등의 집행 그 밖의 사유로 인하여 소멸된 뒤에도 그 처분등의 취소로 인하여 회복되는 법률상 이익이 있는 자의 경우에는 또한 같다.

12 дугаар зүйл (Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд)

Хүчингүй болгуулах нэхэмжлэлийг тухайн акт зэргийг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол бүхий этгээд гаргана. Акт зэргийн үр дагавар нь хугацаа өнгөрөх, акт зэрэг хэрэгжсэн, бусад шалтгааны улмаас дуусгавар болсон ч тухайн акт зэргийг хүчингүй болгосноор сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол бүхий этгээд мөн адил хамаарна.

Уг нэмэлтийг хуульчлах болсон үндэслэлийг шүүхийн практикт өмнө нь үйлчлэл дуусгавар болсон захиргааны акт зэрэгт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж⁴³, иргэдийн шүүхэд хандах эрхийг хязгаарладаг байсан явдлыг өөрчлөн, уг эрхийг өргөжүүлэх зорилготой гэж судлаачид тайлбарладаг⁴⁴. Тухайлбал, захиргааны актын үйлчлэл дуусгавар болсон хэдий ч иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн хэвээр үлдэх боломжтой бөгөөд тэр нь туслах шинжтэй ашиг сонирхол байсан ч түүний талаар шүүхэд хандах эрхийг хүлээн зөвшөөрөх зорилгоор тус зохицуулалтыг бий болгосон гэж үздэг⁴⁵.

Тус зохицуулалтын талаарх судлаачдын байр суурийг авч үзвэл, эхний өгүүлбэр нь нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуурын талаарх зохицуулалт гэх тухайд маргаан байдаггүй. Харин хоёр дахь өгүүлбэр нь хүчингүй болгуулах нэхэмжлэл дэх эрхээ хамгаалуулах шаардлагын талаарх зохицуулалт уу, эсхүл нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн талаарх зохицуулалт уу гэдэг талаар онолын хувьд маргаантай байдаг⁴⁶.

Дийлэнх судлаачийн хувьд уг зохицуулалт нь нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн талаарх зохицуулалт биш, харин эрхээ хамгаалуулах шаардлагын талаарх зохицуулалт хэмээн үзэж, уг эрхээ хамгаалуулах шаардлагыг өргөжүүлэхийн тулд Германы үргэлжлүүлэн тогтоох нэхэмжлэлтэй холбож судалдаг⁴⁷.

⁴³ 대법원, 1982.3.9 선고 81누 326 판결.

⁴⁴ 김남진/김연태, "행정법'1" 법무사, 2013, 770면. 홍준형, "행정법" 법무사, 2011, "879면 이하, 이 규정은 일본의 행정시건소송법 제9조 괄호규정을 거의 그대로 반영한 것이라고 한다.

⁴⁵ 박운흔, 최신행정법강의 (상), 제29판, 934면.

⁴⁶ 최선웅, 행정소송법 제12조 제2문의 해석, 87 면.

⁴⁷ 최선웅, 행정소송법 제12조 제2문의 해석, 사단법인 행정법이론실무학회 행정법연구 제41호 2015년 2월, 2015년, 85면.

А. ЗХШХШтХ-ийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийн зохицуулалтын чиг үүрэг

Энэхүү зохицуулалтын ойлголт болон чиг үүргийн талаар тайлбарласан олон онол, судлаачдын үзэл баримтлал байдаг бөгөөд нэхэмжлэлийн ямар төрөл болохыг уг зохицуулалтыг хэрхэн авч үзэхээс хамаарч тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалтын чиг үүргийг эрхээ хамгаалуулах шаардлага хэмээн тодорхойлбол үйлчлэл дуусгавар болсон захиргааны акт зэрэгт холбогдуулан гаргах нэхэмжлэл нь тогтоох нэхэмжлэлийн шинжтэй болно. Харин нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуур гэж тодорхойлбол хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шинжтэй болно.

Тогтоох нэхэмжлэл болон хүчингүй болгуулах нэхэмжлэл нь харилцан адилгүй урьдчилсан нөхцөлийг шаардах бөгөөд мөн харилцан адилгүй эрх зүйн хамгаалалтыг үзүүлдэг. Тодруулбал, хүчингүй болгуулах нэхэмжлэл нь эрх зүйн идэвхтэй хамгаалалт үзүүлдэг сайн талтай боловч тогтоох нэхэмжлэлтэй харьцуулахад урьдчилсан нөхцөлийг илүү өргөн хүрээнд шаарддаг. Тухайлбал, маргаан бүхий акт үйлчлэлтэй байх, түүний улмаас нэхэмжлэгчийн хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байх, улмаар шүүхээс хүчингүй болгуулах шийдвэр гаргасан тохиолдолд нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрх сэргэх үр дагавартай байхыг урьдчилсан нөхцөлөө болгодог. Харин тогтоох нэхэмжлэлийн үндсэн урьдчилсан нөхцөл нь тухайн шийдвэрийг гаргуулах онцгой ашиг сонирхлоо илэрхийлсэн байх юм.

Эрхээ хамгаалуулах шаардлагын талаарх онол:

Энэхүү онолоор БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийг нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын талаарх зохицуулалт хэмээн тайлбарлаж, нэхэмжлэл

гаргах ашиг сонирхол гэдгийг нэхэмжлэгч шүүхэд хандан эрхээ хамгаалуулах бодит ашиг сонирхол буюу эрхээ хамгаалуулах шаардлага гэж дийлэнх судлаач үздэг. Өөрөөр хэлбэл, захиргааны акт зэргийн үйлчлэл дуусгавар болсон тохиолдолд түүнийг хүчингүй болгох шийдвэрийг шүүхээс гаргуулах ашиг сонирхол (эрхээ хамгаалуулах шаардлага) байгаа эсэх талаарх зохицуулалт хэмээн тайлбарладаг⁴⁸. Тийм учраас “нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд” гэх гарчиг бүхий нэг зүйлд нэгдүгээр өгүүлбэрт нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн талаар, хоёрдугаар өгүүлбэрт эрхээ хамгаалуулах шаардлагын талаарх зохицуулалтыг хамт хуульчилсан нь хууль тогтоомжийн алдаа гэж үздэг⁴⁹.

Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн талаарх онол

Энэхүү онолоор хүчингүй болгуулах нэхэмжлэл нь захиргааны акт зэргийг үйлчлэлтэй байхыг урьдчилсан нөхцөлөө болгодог учраас акт зэргийн үйлчлэл дуусгавар болсон тохиолдолд хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах боломжгүй болох хэдий ч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр нь дуусгавар болсон захиргааны акт зэрэгт холбогдуулан маргах боломжтой онцгой нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг зохицуулсан зохицуулалт гэж үздэг⁵⁰. Тийм учраас 2 дахь өгүүлбэр нь дуусгавар болсон актыг үйлчлэлтэй актын адил нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуур болох хууль ёсны ашиг сонирхлыг

⁴⁸ 김철용, 행정법, 고시계사, 2014년, 583면.

⁴⁹ 홍준형, 행정법, 법문사, 2011년, 873면.

⁵⁰ 홍정선, 행정법원론, 박영사, 2007년, 961면- 962면.

агуулж байгаа гэж үзэх ёстой хэмээн тайлбарладаг⁵¹. Ийнхүү хоёр дахь өгүүлбэрийг эрхээ хамгаалуулах шаардлага бус, нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн талаарх зохицуулалт хэмээн тайлбарладаг учир тус зохицуулалт нь алдаагүй гэж үздэг⁵².

Б. ЗХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэлийн шинж чанар

Энэхүү зохицуулалтын нэхэмжлэлийн төрлийн талаар хэд хэдэн онол үүсэж хөгжсөн бөгөөд үндсэн гурван онолыг энд танилцуулъя. Уг өгүүлбэр дэх нэхэмжлэлийн төрөл болон “хууль ёсны ашиг сонирхол”-ын хүрээ хязгаарын талаар олон онол, үзэл баримтлал байдаг хэдий ч тэдгээр нь бүгд иргэдийн шүүхэд хандах эрхийг өргөжүүлэхэд чиглэсэн бөгөөд гагцхүү хууль хэрэглээний арга зүй, онолын хувьд аль нь илүү оновчтой байх талаарх өрсөлдөөн байдаг.

Түүнчлэн нэхэмжлэлийн төрлийн шинж чанараас хамааран маргаан бүхий актын агуулга, нэхэмжлэгчийн ашиг сонирхол, шүүхийн шийдвэр хоорондын хамаарал харилцан адилгүй байдлаар тодорхойлогддог. Тиймээс нэхэмжлэлийн төрлийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

⁵¹ 홍정선, 위의 책, 1014면-1015면.

⁵² 홍정선, 위의 책, 1014면.

12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийн нэхэмжлэлийн шинж чанар

<p>Тогтоох нэхэмжлэлийн онол</p>	<p>Уг зохицуулалт нь хэдийгээр хүчингүй болгуулах нэхэмжлэлийн хэлбэртэй боловч тус нэхэмжлэлийн шинж чанар нь ирээдүйд гарч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргадаг урьдчилан сэргийлэх зорилго бүхий тогтоох нэхэмжлэл гэж үзэх бөгөөд энэ тохиолдолд тогтоолгох зүйл нь хүчин төгөлдөр бус болохыг тогтоох бус, харин хууль бус байсан болохыг тогтооход чиглэгддэг⁵³. Иймд акт зэргийн үйлчлэл дуусгавар болсноор тухайн актыг хүчингүй болгуулах нь ямар ч үр нөлөөгүй⁵⁴ бөгөөд хуулийн зохицуулалтад “хүчингүй болгуулах” гэсэн нэр томъёог хэрэглэсэн ч нэгэнт дуусгавар болсон акт зэргийг хууль бус байсан болохыг тогтоохоос өөр үр дагавар гарахгүй тул⁵⁵ ХБНГУ-ын үргэлжлүүлэн тогтоох нэхэмжлэлтэй төстэй нэхэмжлэлийн шинжтэй гэж үздэг⁵⁶.</p>
<p>Хүчингүй болгуулах нэхэмжлэлийн онол</p>	<p>Акт зэргийн үйлчлэл дуусгавар болсон хэдий ч шүүхээс хүчингүй болгуулах шийдвэр гаргуулахгүйгээр зөрчигдсэн хууль ёсны ашиг сонирхол бүрэн дүүрэн сэргээгдэх боломжгүй тохиолдолд хүчингүй болгуулах ашиг сонирхол байна гэдгийг хүлээн зөвшөөрч, тус шийдвэрийг гаргадаг гэдэг утгаараа хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шинжтэй хэмээн үздэг⁵⁷.</p>
<p>Хосолмол шинжтэй өвөрмөц нэхэмжлэлийн онол</p>	<p>Энэхүү онол нь дээрх хоёр онолын агуулгыг огт үгүйсгэдэггүй боловч хүчингүй болгуулах нэхэмжлэл, эсхүл тогтоох нэхэмжлэлийн аль нэгийг сонгох ёстой гэсэн хатуу шаардлага тавьдаг талыг нь шүүмжилдэг. Өөрөөр хэлбэл, 12 дугаар зүйлийн 2 дэх өгүүлбэр нь уг хоёр онолын агуулгыг хамтад нь агуулсан гэж тайлбарлагдах бүрэн боломжтой хэмээн үздэг⁵⁸.</p>

⁵³ 류지태/ 박종수, 행정법신론, 박영사, 654면.

⁵⁴ 김유환, 취소소송에 있어서의 권리보호의 필요, 고시연구 1995.11, 61면 이하, 홍준형, 행정구제법 제4판 한울아카데미, 590면.

⁵⁵ 홍정선, 『행정법원론(상)』, 2002, 962-963면.

⁵⁶ 김남진, 김연태, 『행정법 I』, 법문사, 2013, 709면 이하.

⁵⁷ 김유환, 앞의 책 71면.

⁵⁸ 최선웅, 행정소송법 제12조 제2문의 해석, 2015년, 103 - 108면.

В. БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх “хууль ёсны ашиг сонирхол” гэх ойлголтын хүрээ хязгаар

12 дугаар зүйл (Нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд)

Хүчингүй болгуулах нэхэмжлэлийг тухайн акт зэргийг хүчингүй болгуулах “хууль ёсны ашиг сонирхол” бүхий этгээд гаргана. Акт зэргийн үр дагавар нь хугацаа өнгөрөх, акт зэрэг хэрэгжсэн, бусад шалтгааны улмаас дуусгавар болсон ч тухайн акт зэргийг хүчингүй болгосноор сэргээгдэх “хууль ёсны ашиг сонирхол” бүхий этгээд мөн адил хамаарна.

Дараах онолуудын эхний хоёр нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх “хууль ёсны ашиг сонирхол”-ыг нэг дэх өгүүлбэр дэх “хууль ёсны ашиг сонирхол” гэх ойлголттой адил хэмээн үздэг бол сүүлийн хоёр онол нь илүү өргөн хүрээг хамааруулна гэж үздэг.

12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх хууль ёсны ашиг сонирхол гэж ойлголтын хүрээ хязгаар

<p>Онол 1</p>	<p>Хүчингүй болгуулах нэхэмжлэл дэх ашиг сонирхолтой адил ойлголт гэж үздэг.</p>	<p>Энэхүү онолоор Хууль ёсны ашиг сонирхлыг “Тухайн актын үндэслэл болсон хуулиар хамгаалагдах шууд болон тодорхой ашиг сонирхол” гэж үздэг⁵⁹. Учир нь БНСУ-ын шүүхийн практикт 12 дугаар зүйлийн 1 дэх өгүүлбэр дэх хууль ёсны ашиг сонирхол гэж ойлголтын хүрээ хязгаарыг “эрх зүйн ашиг сонирхлыг хамгаалах” онолд тулгуурлан тодорхойлдог. Тус онол нь хэд хэдэн үзэл баримтлалаар хөгжиж буй бөгөөд тэдгээрийн дотроос захиргааны актын үндэслэл болсон хууль тогтоомжоор хамгаалагдах шууд, тодорхой хувийн ашиг сонирхол гэх үзэл баримтлал давамгайлдаг. Түүнчлэн сүүлийн үеийн шүүхийн шийдвэрүүд уг ойлголтын хүрээг өргөжүүлэх чиг хандлагатай байна⁶⁰.</p>
<p>Онол 2</p>	<p>Үздэг.</p>	<p>Актын үндэслэл болсон хэм хэмжээгээр хамгаалагдах ашиг сонирхлоос илүү өргөн хүрээний буюу онол, шүүхийн жишгээр хүлээн зөвшөөрөгдсөн ашиг сонирхол гэж үздэг⁶¹.</p>
<p>Онол 3</p>	<p>Хүчингүй болгуулах нэхэмжлэл дэх ашиг сонирхлоос</p>	<p>Энэхүү онол нь 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийг нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын талаарх зохицуулалт гэж үздэг учраас нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг зохицуулсан 1 дэх өгүүлбэрийн хууль ёсны ашиг сонирхолтой адилхан тайлбарлаж болохгүй хэмээн үздэг. Иймээс хууль ёсны ашиг сонирхолд хамаарахгүй нэр хүнд зэрэг эдийн бус, нийгмийн, мөн эдийн засгийн ашиг сонирхол зэргийг хамааруулдаг зүй ёсны ашиг сонирхлоор тайлбарлах ёстой гэж үздэг⁶².</p>
<p>Онол 4</p>	<p>ялгаатай ойлголт хэмээн үздэг.</p>	<p>12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх хууль ёсны ашиг сонирхлыг 1 дэх өгүүлбэр дэх хууль ёсны ашиг сонирхлоос илүү өргөнөөр тайлбарлах ёстой гэж үздэг. Гэвч 12 дугаар зүйлийн 1 болон 2 дахь өгүүлбэрт “Хууль ёсны ашиг сонирхол” гэж адилхан хуульчилсан байгааг харгалзан үзвэл 3 дахь онолын адил зүй ёсны ашиг сонирхол гэж өргөжүүлэх нь зохисгүй хэмээдэг⁶³.</p>

⁵⁹ 대법원 1995.10.17. 선고 94누14148.

⁶⁰ 박근서, 행정법강의, 2018년, 747 면

⁶¹ 법원행정처, 행정소송법 개정자료집 1, 2017년, 334면334

⁶² 김남진, 『행정법1』, 2001, 760면

⁶³ 김유환, 취소소송에 있어서 권리보호 필요, 고시연구, 1995, 70면



3.2. БНСУ-ЫН ШҮҮХИЙН ПРАКТИК

1. Шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэг	Агуулга	Судлаачдын тайлбар
Хэргийн оролцогч	<p>Нэхэмжлэгч: Худалдааны “А” Хувьцаат компани Хариуцагч: Татварын газрын дарга</p>	<p>Шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө үйлчлэл нь дуусгавар болсон захиргааны актыг нэхэмжлэлийн зүйл болгожээ. Өөрөөр хэлбэл, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий актад заасан хугацаа өнгөрснөөр актын үйлчлэл дуусгавар болсон байна.</p>
Маргаан бүхий акт	<p>Согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрлийг гурван сараар түдгэлзүүлсэн акт</p>	<p>2006 оноос өмнөх үеийн шүүхийн практикт үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах тохиолдолд нэхэмжлэгчид нэгэнт дуусгавар болсон актыг хүчингүй болгуулснаар сэргээгдэх ямар нэгэн ашиг сонирхол байхыг шаарддаг байсан бол 2007 оноос хойших шүүхийн практикт нэхэмжлэгчид холбогдуулан ирээдүйд сөрөг нөлөөлөл бүхий акт гарах боломжтой тохиолдлыг сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхолд хамааруулан авч үзсэнээрээ энэхүү шүүхийн шийдвэр онцлог юм.</p>
Хэргийн агуулга	<p>Худалдааны “А” Хувьцаат компанийн “Согтууруулах ундааны татварын тухай хууль”-ийн 15.1.4-ийг зөрчсөн” гэх үндэслэлээр согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрлийг гурван сар (2018.09.01-2018.11.30-ыг хүртэл)-аар түдгэлзүүлсэн актыг Татварын газрын дарга 2018 оны 08 дугаар сарын 16-нд гаргажээ. Худалдааны “А” Хувьцаат компани нь дээрх актыг эс зөвшөөрч, 2018 сарын 9 дүгээр сарын 13-ны өдөр урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гаргасан боловч 2018 оны 12 сарын 6-ны өдрийн шийдвэрээр гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна.</p>	

<p><i>Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл</i></p>	<p>Нэхэмжлэлийн шаардлага: Татварын газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 16-нд гаргасан согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрлийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлсэн захиргааны актыг хүчингүй болгуулах</p> <p>Нэхэмжлэлийн үндэслэл: Татварын газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 16-нд гаргасан согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрлийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлсэн захиргааны актыг үйлчлэл дуусгавар болсон боловч Татварын ерөнхий газраас баталсан “Согтууруулах ундаанд татвар ногдуулахтай холбоотой маргааныг шийдвэрлэх журам”-д заасны дагуу Захиргааны актыг гарснаас хойш нэг жилийн дотор Татварын зөрчилд шийтгэл оногдуулах хуульд заасан ижил төрлийн зөрчлийг дахин гаргасан тохиолдолд үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгохоор заасан байна. Иймд Татварын газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 16-нд гаргасан актыг үйлчлэл нь дуусгавар болсон ч ирээдүйд нэхэмжлэгчид сөрөг үр дагавар үзүүлж болзошгүй тул нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг зөвшөөрөх боломжтой гэж тайлбарлажээ.</p>	<p>Нэхэмжлэгч нь маргаан бүхий үйлчлэл дуусгавар болсон захиргааны актыг хүчингүй болгуулах ашиг сонирхлоо тухайн актын улмаас зөрчигдсэн эрхээ сэргээх бус, харин ирээдүйд гарч болох сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гаргахаас сэргийлэх ашиг сонирхол байна гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, үйлчлэл дуусгавар болсон захиргааны актыг хүчингүй болгуулснаар өнгөрсөн цаг хугацаанд буюу тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн үеийн цаг хугацаанд эргэн очиж, үйл ажиллагаа явуулах боломжгүй боловч ирээдүйд гарч болох сөрөг нөлөөлөл бүхий актыг гаргуулахгүй байх ашиг сонирхолтой болохоо илэрхийлжээ.</p>
--	---	--



Анхан шатны шүүхийн шийдвэр⁶⁴	
<p>1. Захиргааны актад актын үйлчлэл хугацааг заасан байгаа тохиолдолд тухайн актын биелэлтийг түдгэлзүүлээгүй бол тухайн актад заасан хугацаа өнгөрснөөр актын үйлчлэл дуусгавар болох тул хугацаа өнгөрсний дараа тухайн акт хэлбэр төдий үлдсэн нь нэхэмжлэгчид ямар нэгэн хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байна гэж үзэхээр онцгой нөхцөл байдлыг үзсээгүй л бол тухайн актыг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол байхгүй (Дээд шүүхийн 1995.10.17. 선고 94-14148 전원합의체 шийдвэрийг эшлэв).</p> <p>2. Гагцхүч хязгаарласан захиргааны актад заасан хязгаарлалтын хугацаа өнгөрснөөр актын үйлчлэл дуусгавар болох боловч өмнө гарсан хязгаарласан акт нь ирээдүйд гарах актын хүндрүүцлэх нөхцөл болж, эсгүл урьдчилсан нөхцөл болж гарахаар байгаа тохиолдолд, эсгүл гарч болзошгүй тохиолдолд хязгаарласан захиргааны актын үйлчлэл чиглэж буй этгээд нь тухайн актад заасан хугацаа өнгөрсөн хэдий ч актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлээр дамжуулан, тэрхүү ашиггүй байдлаа ариггуулах эрхээ хамгаалуулах шаардлага хангалттай байна гэж хцлээн зөвшөөрөөдөх тул хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол байна хэмээн үзэх ёстой (Дээд шүүх 2007.01.11. 선고 2006-13312 шийдвэр зэргийг эшлэв).</p>	<p>1995 оны шүүхийн жишгээр дуусгавар болсон захиргааны актын улмаас зөрчигдсөн хууль ёсны ашиг сонирхол байх тохиолдолд нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрдөг байсан бол 2007 оны шүүхийн жишгээр ирээдүйд гарч болзошгүй ашиггүй, сөрөг нөлөөлөл бүхий актаас урьдчилан сэргийлэх явдлыг нэхэмжлэл гаргах хууль ёсны ашиг сонирхолд хамруулж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүх хүчингүй болгох шийдвэрийг гаргаснаар зөрчигдсэн эрх сөргэхгүй хэдий ч нэхэмжлэгчид тус шийдвэрийг гаргуулах хууль ёсны ашиг сонирхол байгаа тохиолдолд нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх чиг хандлагатай болсон байна.</p>
<p>Үндэслэл болгосон шүүхийн шийдвэр</p>	

64 창원지방법원 2019구단 10574 영업정지처분취소.

<p>Нэхэмжлэл гаргах ашиг сонирхол буюу эрхээ хамгаалуулах шаардлагын дүгнэсэн байдал</p>	<p>1. Энэ хэргийн хувьд тухайн актад заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаа өнгөрснөөр актын <u>цэцэглэл дуусгавар болж буй тухайн акттай холбогдуулан маргах шүүд ашиг сонирхол нь дуусгавар болсон</u> байна.</p> <p>2. <u>Мөн энэ хэргийн акт гарсны дараа ирээдүйд сөрөг нөлөөлөл бүхий акт дахин гарах боломжтой эсэхийг хянахад</u>, “Сог-тууруулах ундаанд татвар ногдуулахтай холбоотой маргааныг шийдвэрлэх журам”-ын 24.3-г “Зөвшөөрөлгүйгээр худалдаа эрхэлсэн болон борлуулалтаа нуун дарагдуулсан татварын зөрчилд ногдуулах хариуцлагын тухай хууль”-ийн дагуу хариуцлага хүлээсэн эсхүл захиргааны акт авснаас хойш <u>1 жилийн дотор ижил төрлийн зөрчилд дахин хариуцлага хүлээсэн эсхүл захиргааны акт авсан тохиолдолд зөвшөөрлийг цуцална</u>” гэж заажээ. <u>Иймд нэхэмжлэгчийн маргаж буй акт гарсан хугацаа болох 2018 оны 8 сарын 16-ны өдрөөс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн тухай нэхэмжлэгчид холбогдуулан ирээдүйд сөрөг нөлөөлөл бүхий акт гаралад маргаан бүхий энэхүү акт нь түүний үндэслэл болохгүй буюу ирээдүйд сөрөг нөлөөлөл бүхий акт дахин гарах боломжгүй гэж үзнэ.</u></p> <p><u>Иймд нэхэмжлэл гаргах ашиг сонирхол (эрхээ хамгаалуулах шаардлага) байхгүй байна.</u></p>	<p>Шүүхээс “өмнөх акт нь ирээдүйд бий болох ашиггүй актын хүндрүүлэх нөхцөл болох тохиолдолд маргаан бүхий актын талаар маргах ашиг сонирхол байна гэж үзэх боловч цаг хугацааны хувьд маргаан бүхий актыг үндэслэн ирээдүйд сөрөг нөлөөлөл бүхий акт гарах нөхцөл байдал арилсан тул нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй” гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, шүүхээс нэхэмжлэлийг хангасан шийдвэр гаргах нь ач холбогдолгүй буюу эрхээ хамгаалуулах шаардлаггүй гэж үзсэн байна.</p>
--	---	---

<p>Эцсийн шийдвэр</p>	<p>Дээрх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.</p>	
<p>БНСУ-ын шүүхийн шийдвэр гаргах онцлог</p> <p>БНСУ-ын шүүх аливаа хэргийг шийдвэрлэхдээ “Урьдчилсан нөхцөлийг шалгах”, “Үндсэн асуудлыг шалгах” гэсэн хоёр үндсэн үе шатыг дамждаг. Урьдчилсан нөхцөлийг шалгах шатанд нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг хангасан эсэхийг шалгадаг бөгөөд үүнд <u>нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэх</u>, урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн эсэх, хөөн хэлэлцэх хугацааг баримталсан эсэх, уг асуудлаар өөр шүүхийн шийдвэр байгаа эсэх зэрэг урьдчилсан нөхцөлүүдийг шалган, хангагдсан тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авч, хэрэг үүсгэдэг бол хангагдаагүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэдэг. Харин Үндсэн асуудлыг шалгах шатанд хэрэг үүсгэсний дараа маргаан бүхий акт зэргийн хууль зөрчсөн эсэхийг шалгаж, нэхэмжлэлийг хангах эсхүл хэрэгсэхгүй болгох эсэхийг шийдвэрлэн, эцсийн шийдвэр гаргадаг. Гэхдээ хэрэг үүсгэсний дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл хангагдаагүй болох нь тогтоогдвол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг байна.</p> <p>Нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл болох <u>Нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нь өргөн утгаараа нэхэмжлэлийн зүйл (объект)-ийн шалгуур</u>, нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуур, <u>эрхээ хамгаалуулах шаардлагын талаарх ойлголтыг багтаасан цогц ойлголт</u> байдаг.</p> <p>Энэхүү хэргийн хувьд нэхэмжлэгч нь нэхэмжлэлийн зүйлийн болон нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийн шалгуурыг хангасан боловч нэхэмжлэлийн шаардлагыг хангах нь ач холбогдолгүй буюу эрхээ хамгаалуулах шаардлага байхгүй гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, шүүхийн “Урьдчилсан нөхцөлийг шалгах” үе шатанд буюу нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл болох нэхэмжлэл гаргах ашиг сонирхолд хамаарах эрхээ хамгаалуулах шаардлагыг хангаагүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.</p>		

Үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан гаргасан хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шийдвэрлэж буй БНСУ-ын шүүхийн шийдвэрийн онцлог	
Захиргааны хэрэг шүү-хэд хянан шийдвэрлэх тухай хуу-лийн 12 дугаар зүй-лийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэ-лийн шинж	БНСУ-ын шүүхийн жишиг эхэн үедээ (1995 оноос өмнө) Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шинжтэй хэмээн үзэж, нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын шалгуурыг эрх зөрчигдсөн байх, улмаар шүүхээс нэхэмжлэлийг хангаснаар зөрчигдсэн эрх сэргээгдэх үр дагаварт хүрсэн байх хэмээн хатуу тодорхойлж байсан бол 2007 оноос эхлэн шүүхийн чиг хандлага өөрчлөгдөж, нэгэнт үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах боломжгүй бөгөөд актыг үйлчлэл дуусгавар болсны дараа ч зөрчигдсэн эрхтэй холбогдуулан маргах шаардлага байгаа тохиолдолд үүнийг тогтоох нэхэмжлэлээр шийдвэрлэхээс өөр аргагүй гэж үзэн, үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шинжийг тогтоох нэхэмжлэл хэмээн үзэх чиг хандлагатай болсон байна.
2. Шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэг	Судлаачдын тайлбар
Хэргийн оролцогч	<p>Нэхэмжлэгч: ТУЗ-ийн үндсэн гишүүд Хариуцагч: Боловсролын хүний нөөцийн дэд сайд</p> <p>“Төнгү их сургуулийн захирлын ТУЗ-ийн гишүүдийг томилж шийдвэр”-ийг хүчингүй болгох тухай акт ТУЗ-ийн түр гишүүдийг томилж тухай акт</p>
Маргаан бичгийг акт	<p>Маргаан бүхий акт болох ТУЗ-ийн түр гишүүдийг томилсон захиргааны актад заасан ТУЗ-ийн түр гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноор дахин өөр ТУЗ-ийн түр гишүүнийг томилж дараагийн захиргааны акт гарсан байна. Өөрөөр хэлбэл, маргаан бүхий актад заасан ТУЗ-ийн түр гишүүний бүрэн эрхийн хугацаа өнгөрснөөр актыг үйлчлэл дуусгавар болсон боловч үргэлжилсэн шинжтэй маргаан бүхий дараагийн акт давтагдан гарчээ.</p>

<p>Хэргийн агуулга</p>	<p>Боловсролын хүний нөөцийн дэд сайд Гэнги Их сургуульд нэгдсэн хяналт, шалгалт хийжээ.</p> <p>Уг хяналт, шалгалтаар Гэнги Их сургуулийн ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай захирлын шийдвэр нь хувийн сургуулийн тухай хуулийг зөрчсөн хэмээн үзэж, зөрчлийг арилгаагүй тохиолдолд уг шийдвэрийг хүчингүй болгох талаар мэдэгдсэн байна. Гэтэл уг зөрчлөө арилгаагүй байсан тул ТУЗ-ийн гишүүдийг томилсон захирлын тушаалыг хүчингүй болгож, түр ТУЗ-ийн гишүүдийг томилжээ.</p>	<p>Энэ хэргийн хувьд маргаан бүхий акт талуудын хооронд адил үндэслэлээр дахин давтагдах боломжтой, мөн түүний улмаас нэхэмжлэгч ашиггүй байдлаар дахин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж болзошгүй нөхцөл байдлыг үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах шийдвэрийг гаргуулах ашиг сонирхолд хамруулж үзсэнээрээ онцлог шүүхийн шийдвэр юм.</p> <p>Нэхэмжлэгчид анх нэхэмжлэл гаргах ашиг сонирхлоо уг албан тушаалд өргүүлэн томилогдох буюу зөрчигдсэн эрхээ сэргээх гэж тодорхойлжээ.</p>
<p>Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл</p>	<p>Нэхэмжлэлийн шаардлага:</p> <p>Гэнги их сургуулийн ТУЗ-ийн үндсэн гишүүдээс “Гэнги Их сургуулийн захирлын ТУЗ-ийн гишүүдийг томилсон шийдвэр” - ийг хүчингүй болгох тухай акт болон ТУЗ-ийн түр гишүүдийг томилох тухай актыг тус тус хүчингүй болгуулах нэхэмжлэлийг Боловсролын хүний нөөцийн дэд сайдад холбогдуулан гаргасан байна.</p> <p>Нэхэмжлэлийн үндэслэл:</p> <p>Боловсролын хүний нөөцийн дэд сайдын тодорхойлсон зөрчлийг бүрэн арилгасан бөгөөд ажилдаа эргэн томилогдох сонирхолтой байна гэж маргажээ.</p>	

Дээд шүүхийн шийдвэр⁶⁵

<p>Үндэслэл болгосон шүүхийн шийдвэр</p>	<p>1. ТУЗ-ийн үндсэн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд тэдэнд дараагийн ТУЗ-ийн түр гишүүнийг томилсон актыг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол байхгүй учраас хуульд нийцэхгүй хэмээн дүгнэж ирсэн байна (да법원 1995.03.10. 선고 94누 8914 판결, 대법원 1997.04.25. 선고 96누 9171 판결, 대법원 1999.06.11. 선고 96누 10614 판결, 대법원 2003.03.14. 자 2002무 56 결정, 대법원 2003.03.14. 선고 2002무 10568 판결, 대법원 2003.10.24. 선고 2003무 5877 판결 등).</p> <p>2. Нэхэмжлэл гаргасны дараа ТУЗ-ийн түр гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, ТУЗ-ийн түр гишүүн дахин шинээр томилогдсон бол актыг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол байхгүй гэж дүгнэдэг байжээ (대법원 2002.11.26. 선고 2001 무 2874 판결).</p>	<p>Дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч болох ТУЗ-ийн үндсэн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул шүүхээс тус хэргийг шийдвэрлэхдээ өмнө нь шүүхээр шийдвэрийг байсантай адил хэргийн шийдвэрийг ашигласан байна.</p>
	<p>Дээрх шүүхийн жишүүдээс үзвэл энэхүү хэрэгт хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол байхгүй гэж үзэн, нэхэмжлэлийг хүлээн авахаас тагталзаж шийдвэрлэх боломжтой боловч шүүхээс шударга ёсонд нийцсэн шийдвэр гаргахын тулд Нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх зарчмын талаар дараах байдлаар тайлбарлажээ.</p>	

⁶⁵ 대법원 2007.07.19 선고 2006무 19297 전원합의체 판결.



- Захиргааны актын үйлчлэл нь хутагаа өнгөрөх зэргийн шалтгааны улмаас дуусгавар болсон хэдий ч уг акт зэргийг хүчингүй болгосноор сэргээгдэх тохиолдолд
 - Захиргааны актын үйлчлэл нь хутагаа өнгөрөх зэргийн шалтгааны улмаас дуусгавар болсон боловч уг акт зэргийг хүчингүй болгосноор сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол хүлээн зөвшөөрөгдөх тохиолдолд нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байна.
1. Өмнө гарсан акт болон дараагийн акт нь үргэлжилсэн үе шаттай даван гарсан бөгөөд дараагийн акт нь өмнөх актаа хууль ёсных эзэмээн үзэж гардаг учраас өмнөх актын хууль бус шинэж нь дараагийн актад давагдах боломжтой учраас нэхэмжлэл гаргах замаар маргаан бүхий өмнө гарсан актын хууль бус шинэжийг тогтоох шаардлагатай тохиолдолд
 2. Захиргааны байгууллагаас өмнө нь гаргасан хууль бус захиргааны акттай адил үндэслэлээр дахин акт гаргах боломжтой учраас тухайн захиргааны актын хууль бус шинэжийг тогтоолох болон тодорхой бус эрх зүйн асуудалтай холбоотойгоор иргэдийн эрхээ хамгаалуулах хүрээг өргөжүүлэх үүднээс тухайн актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч болно.

БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 зүйлийн 2 дахь өгүүлбэр нь үйлчлэл дуусгавар болсон захиргааны актыг хүчингүй болгуулах тохиолдолд “Сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол” байхыг гол урьдчилсан нөхцөлөө болгодог.

Энэхүү “сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол”-д актын үйлчлэл нэгэнт дуусгавар болсон учраас зөрчилдсөн эрхийг бүрэн сэргээх боломжгүй боловч сэргээгдэж болох ямар нэгэн эрх, ашиг сонирхол, мөн үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах шийдвэрийг гаргуулах ашиг сонирхол хамаардаг.

Энэхүү маргааны хувьд шүүхээс нэхэмжлэгчид үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах шийдвэрийг гаргуулах ашиг сонирхол байгаа буюу тодорхой зөрчил давагдахаас урьдчилан сэргийлэх, дараагийн актад холбогдуулан маргаанаас сэргийлэх ашиг сонирхлууд байна гэж үзжээ. Иймд сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол байна хэмээн үзээд, эрхээ хамгаалуулах шаардлага буюу нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн байна.

Нэхэмжлэл гаргах ашиг сонирхол буюу эрхээ хамгаалуулах шаардлагын талаар дүгнэсэн байдал

Энэ хэргийн хувьд ТУЗ-ийн түр гишүүдийг томилсон актыг хүчингүй болгуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ТУЗ-ийн түр гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, шинээр дахин ТУЗ-ийн түр гишүүд томилогдсон бөгөөд өмнө нь гарсан ТУЗ-ийн түр гишүүнийг томилсон захиргааны актын үйлчлэл дуусгавар болсон гэх үндэслэлээр уг актыг хүчингүй болуулах хууль ёсны ашиг сонирхол байхгүй гэж үзвэл ТУЗ-ийн үндсэн гишүүд (нэгэмжлэгчид) нь хэрэг үүсгэн хянагдаж байсан нэгэмжлэлээсээ татгалзаж, дараа нь гарсан ТУЗ-ийн түр гишүүнийг томилсон акттай холбогдуулан, нэгэмжлэл гаргахаас өөр аргагүй болох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин өөр ТУЗ-ийн түр гишүүдийг томилбол дахиад шинээр нэгэмжлэл гаргах зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал давтагдах боломжтой. Иймд илүүх үйлчлэл нь дуусгавар болсон өмнө гарсан ТУЗ-ийн түр гишүүнийг томилсон актыг хүчингүй болгуулах нэгэмжлэл гаргах хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх нь тодорхой зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх төдийгүй дараагийн ТУЗ-ийн түр гишүүнийг томилсон акттай холбогдуулан маргах шаардлагагүй болох тул иргэдийн эрхийг хамгаалах ач холбогдолтой.

<p><i>Эцсийн шийдвэр</i></p>	<p>Шүүхээс нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрсөн боловч маргаан бүхий акт нь хууль тогтоомж зөрчөөгүй гэдэг үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.</p>	<p>Энэхүү маргааны хувьд шүүх нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг хангасан гэж үзэн, нэхэмжлэлийг хүлээн авч, хэрэг үүсгэсэн боловч үндсэн асуудлыг шалгах шатанд маргаан бүхий акт хууль зөрчөөгүй байсан тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.</p> <p>Үндэслэл болгосон шүүхийн шийдвэрүүдээс үзвэл нэхэмжлэл гаргах хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрдөггүй байсан бол энэ хэргийн тухайд хууль ёсны ашиг сонирхлын хүрээг өргөжүүлэн, эрхээ хамгаалуулах шаардлагыг хүлээн зөвшөөрч дүгнэсэн байна.</p>
<p>3. Шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэг</p>	<p>Агуулга</p>	<p>Судлаачдын тайлбар</p>
<p><i>Хэргийн оролцогч</i></p>	<p>Нэхэмжлэгч: “Ёховагийн гэрчүүд” гэх шашныг шүтдэг нэр бүхий иргэд Хариуцагч: Цэргийн ерөнхий газрын дарга</p>	<p>Энэхүү шүүхийн шийдвэр нь БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх “хууль ёсны ашиг сонирхол” гэх ойлголтын хамрах хүрээ болон БНСУ-ын гомдлын нэхэмжлэлийн зүйл болох “Акт”-ын талаар тайлбарласнаараа онцлог шүүхийн шийдвэр юм.</p>
<p><i>Маргаан бүхий акт</i></p>	<p>Нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг Цэргийн ерөнхий газрын цахим сайтад нийтэлсэн үйлдэл</p>	

<p><i>Хэргийн агуулга</i></p>	<p>Нэхэмжлэгчид нь “Ёховагийн гэрчүүд” гэх шашныг шүтдэг бөгөөд уг шашны номлолоор буу зэрэг хүйтэн зэвсэгт хүрэх нь нүгэл хэмээн тооцогддог. Иймээс нэхэмжлэгчид нь шашны итгэл үнэмшлийнхээ дагуу цэргийн алба хаахаас татгалзсан байна.</p> <p>Хариуцагч болох Цэргийн ерөнхий газрын дарга нь БНСУ-ын Цэргийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 2-ын 1 дэх хэсгийн 4 дүгээр тоотыг үндэслэн, нэхэмжлэгчдийг цэргийн алба хаахаас санаатайгаар зайлсхийсэн хэмээн үзэж, цахим сайтад тэдний хувийн мэдээллүүдийг нийтэлжээ.</p> <p>БНСУ-ын Цэргийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 2-т Цэргийн албанаас зайлсхийсэн этгээдийн хувийн мэдээлэл зэргийг нийтлэх талаар заасан байдаг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цэргийн ерөнхий газрын дарга нь дараах этгээдүүдийн хувийн мэдээлэл болон цэргийн үүрэг гүйцэтгээгүй талаарх мэдээллийг цахим сайт зэрэгт нийтэлж болно. 4. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цэрэгт талагдаагүй, цэргийн зарлан дуудах мэдэгдлийг хүлээн аваагүй этгээд 	
-------------------------------	--	--

<p><i>Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл</i></p>	<p>Нэхэмжлэлийн шаардлага:</p> <ol style="list-style-type: none"> 1. Үндсэн нэхэмжлэлийн шаардлага: Цэргийн албанаас зайлсхийсэн этгээдийн хувийн мэдээллийг нийтэлсэн хариуцагчийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн үйлдлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолох 2. Туслах нэхэмжлэлийн шаардлага: Цэргийн албанаас зайлсхийсэн этгээдийн хувийн мэдээллийг нийтэлсэн хариуцагчийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн үйлдлийг хүчингүй болгуулах <p>Нэхэмжлэлийн үндэслэл:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шийдвэр гаргах ажиллагааны алдааны тухайд: Хариуцагч нь Цэргийн албанаас зайлсхийсэн этгээдийн хувийн мэдээллийг нийтлэхээс өмнө эрх нь зөрчигдөж болзошгүй этгээдүүдэд мэдэгдээгүй нь Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хуулийн 23, 24, 26 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна. 2. Материаллаг эрх зүйн алдааны тухайд: Нэхэмжлэгчид нь шашны итгэл үнэмшлийн хэе дагуу цэргийн алба хаахаас татгалзсан нь БНСУ-ын Үндсэн хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан хүний мөн чанар болон шашны эрх чөлөөнд хамаарагдах эрх учраас хүндэтгэн үзэх шалтгаанд хамаарна. Мөн энэхүү үйлдэл нь цэргийн алба хаах үүргийг биелүүлэх зорилгод нийцээгүй, нэхэмжлэгчдэд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс өөр зүйлгүй учраас Үндсэн хуулийн тэнцвэртэй байх зарчмыг зөрчиж, захиргааны байгууллага шийдвэр гаргах эрхээ хэтрүүлсэн хууль бус үйлдэл юм. 	<p>Судалгаанд шууд хамааралгүй хэдий ч БНСУ-ын захиргааны процесст үндсэн болон туслах шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргаж болдог онцлогтой байна.</p> <p>주위적 청구 (Үндсэн нэхэмжлэлийн шаардлага) – Энэ нь нэхэмжлэгчийн юун түрүүнд шүүхээр шийдвэрлүүлэхийг хүсэж буй нэхэмжлэлийн шаардлага</p> <p>예비적 청구 (Туслах нэхэмжлэлийн шаардлага) – Үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох тохиолдолд дараа нь хангуулахаар гаргаж буй нэхэмжлэлийн шаардлага.</p> <p>Өөрөөр хэлбэл, шүүхэд гаргаж буй нэхэмжлэлдээ нэг л нэхэмжлэлийн шаардлагыг дурдаж, тухайн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх болзошгүй тохиолдолд өөр бусад нэхэмжлэлийн шаардлагыг хамтад нь дурдан, нэхэмжлэл гаргаж болно.</p> <p>Шүүхээс нэхэмжлэгчийн үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг анхлан хэлэлцэх бөгөөд үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд туслах нэхэмжлэлийн шаардлагыг хэлэлцдэггүй.</p> <p>Харин үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд туслах нэхэмжлэлийн шаардлагыг хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>
--	---	--

Шүүхийн шийдвэр

Үндсэн нэхэмжлэлийн шаардлагын тухайд: Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт захиргааны байгууллага хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд актыг бичгээр гаргах ёстой бөгөөд гацхүү захиргааны актыг хойшлуулшгүй гаргах шаардлагатай өсхүл эрх зүйн ялимгүй үр дагавар бүхий асуудлыг шийдвэрлэх бол амаар гаргаж болно.

Бусад тохиолдолд захиргааны актыг бичгээр гаргахаар заасан нь актын агуулга тодорхой байх, акт бодитоор гарсан эсэх талаар маргахаас сэргийлэх зорилготой төдийгүй захиргааны байгууллагын үйл ажиллагаа шударга, ил тод нээлттэй байх, итгэл хамгаалах зарчмыг багатган, иргэдийн эрхийг хамгаалах зорилготой тул энэхүү шаардлагыг зөрчсөн захиргааны акт ноцтой, илэрхий алдаатай тул хүчин төгөлдөр бус байна.

Харин энэхүү хэргийн хувьд харууцагч цэргийн албанаас зайлсхийсэн этгээдийн мэдээллийг нийтлэхдээ урьдчилсан байдлаар цэргийн албанаас зайлсхийсэн этгээдээр тогтоож, холбогдох мэдэгдлийг нэхэмжлэгчдэд хүргүүлсэн, нэхэмжлэгчдээс тайлбар авсан, үүний дараа эцсийн шийдвэр гаргаж, цэргийн албанаас зайлсхийсэн этгээдээр тогтоон,

*Анхан
шатны
шүүхийн
шийдвэр*⁶⁶

Анхан шатны шүүхээс үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, туслах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Цэргийн ерөнхий газрын даргын нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг нийтэлсэн үйлдлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Анхан шатны шүүхийн шийдвэр гарах үед маргаан бүхий үйлдэл нь үйлчлэлтэй байжээ.

⁶⁶ 서울행정법원 2018.2.9 선고 2017구합 59581 판결.

нэхэмжлэгчдийн овог нэр, нас, хаяг, цэргийн албанаас зайлсхийсэн өдөр, шалтгаан, зөрчиж буй хуулийн зүйл заалтыг цэргийн ерөнхий газрын цахим сайтад нийтэлсэн нь актын агуулга тодорхой байх, акт бодитоор гарсан эсэх тухайд маргах боломжгүйгээр гаргасан учраас Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзнэ. Иймд нэхэмжлэгчийн үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

Туслах нэхэмжлэлийн шаардлагын тухайд: Нэхэмжлэгчдийн шашны итгэл үнэмшлийн дагуу цэргийн алба хаахаас татгалзсан үйлдлийг цэргийн үүргийг биелүүлэхгүй байх “хүндэтгэн үзэх шалтгаан”-д хамаарахгүй хэмээн үзсэн боловч цэргийн албанаас зайлсхийсэн этгээдийн хувийн мэдээллийг нийтэлсэн үйлдэл нь захиргааны үүргийг гүйцэтгүүлэх зорилгодоо хүрч чадахгүй зөвхөн нэхэмжлэгчдийн нэр хүндэд халдахаас өөр үр дагаваргүй байх тул захиргааны байгууллага шийдвэр гаргах эрхээ хэтрүүлсэн гэж үзэхээр байна. Иймээс нэхэмжлэгчийн туслах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

<p>Давж заалдах шатны шүүхэс хариуцагчийн үйлдэл нь эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, иргэний эрхэд шууд нөлөө үзүүлэхгүй тул захиргааны акт биш гэж дүгнэжээ.</p> <p>Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэл нь нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл болох <u>нэгэмжлэлийн зүйл (объект)-ийн шалгуур</u> хангаагүй тул нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй хэмээн үзээд, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.</p>	<p>1. Нэхэмжлэгчдийн давж заалдах гомдлыг хариуцагч эс зөвшөөрч, дараах тайлбарыг давж заалдах шатны шүүхэд гаргасан байна: Нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг цахим сайтад нийтэлсэн үйлдэл нь нэхэмжлэгчдэд эрх, үүрэг үүсгээгүй, захирамжилсан шинжгүй учраас гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйл болох захиргааны актад хамаарахгүй гэж маргажээ.</p> <p>2. Нэхэмжлэгчид нь хариуцагчийн үйлдлийг захиргааны акт болох талаар дараах тайлбарыг гаргасан байна. Үүнд:</p> <p>Олон нийтэд нийтэлсэн үйлдэл нь мэдээлэл технологийн нийгэмд хувь хүний нэр хүндэд халдах замаар захиргааны үүргийг шууд бусаар гүйцэтгүүлэх зорилготой байдаг учраас</p> <ol style="list-style-type: none"> ①. <u>Хариуцагчийн үйлдэл нь нэгэмжлэгчдийн нэр хүндэд халдсан.</u> ②. Нэг удаагийн үйлдлээр биш, тодорхой хугацааны туршид нийтлэн, нэхэмжлэгчдээр хүлээн зөвшөөрүүлэх аргыг хэрэглэж буй захирамжилсан шинжтэй. ③. <u>Энэхүү иргэлжилж буй бодит үйлдлийг хүчингүй болгуулснаар ирээдүйд үүсэх үүрний салшгүй эргийн зөрчлөөс сэргийлэх нэхэмжлэгчдийн эргийг хамгаалах бодит ашиг сонирхол байгаа эргийг үндэслэн нэхэмжлэгчдийн эрх, үүрэгт шууд өөрчлөлт бий болгосон нийтийн эрх зүйн үйлдэл учраас гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйл болох актад хамаарна гэж тайлбарлажээ.</u>
--	--

Давж заалдах шатны шүүхийн магадлал⁶⁷

⁶⁷ 서울고등법원 2018.6.5 선고 2018누 38217 판결.



Давж заалдах шатны шүүхийн дүгнэлт:
Нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг цахим сайтад нийтэлсэн үйлдэл нь бодит үйлдлийн хувьд аливаа эрх зүйн үр дагавар үүсгэхгүйгээс гадна нийтэлснээр тухайн үйлдэл дуусгавар болох бөгөөд иргэний эрх, үүрэгт шууд нөлөө үзүүлэхгүй. Түүнчлэн Цэргийн тухай хуульд хувийн мэдээллийг нийтлэхийн тулд цэргийн ерөнхий газраас холбогдох асуудлыг шийдвэрлэх хороог байгуулж, хорооноос урьдчилсан байдлаар цэргийн албанаас зайлсхийсэн этгээдээр тогтоогдсон тохиолдолд тэдэнд мэдэгдэн, тайлбар гаргах боломж олгох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш зургаан сарын дараа цэргийн үүргээ биелүүлэх нөхцөл байдлыг харгалзан нийтлэх эсэхийг дахин хэлэлцсэний дараа эцсийн байдлаар цэргийн албанаас зайлсхийсэн этгээдээр тогтоож шийдвэрлэхээр заасан байдаг. Энэхүү цэргийн албанаас зайлсхийсэн этгээдээр тогтоосон шийдвэр нь захиргааны акт учраас нэхэмжлэгчид нь хувийн мэдээлэл цахим сайтад нийтлэгдэхээс өмнө энэхүү акттай холбогдуулан маргаж, хувийн мэдээлэл нийтлэгдэх үйлдлийг гаргуулахгүй байх боломжтой байв. Харин хувийн мэдээллийг цахим сайтад нийтэлсэн хариуцагчийн үйлдэл нь захиргааны актад хамаарахгүй гэж дүгнэлээ. Иймд нэхэмжлэгчдийн үндсэн болон туслах нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хүлээн авахаас тагталзаж шийдвэрлэв.

<p>Дээд шүүхийн шүүхний тогтоол⁶⁸</p>	<p>1. Нэхэмжлэлийн зүйлийн шалгуурыг хангасан эсэх (захиргааны акт мөн эсэх) Нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг Цэргийн ерөнхий газрын цахим сайтad нийтэлсэн тус газрын даргын үйлдэл нь дараах үндэслэлээр гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйл болох захиргааны актад хамаарна.</p> <p>① <u>Нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг нийтэлж буй үйлдэл нь тодорхой этгээдийг цэргийн албанаас зайлсхийсэн этгээдээр тогтоож, түүний талаар нийтэд мэдээлсэнээр нэхэмжлэгчдийн нэр хүндийг гутаан, цэргийн алба хаах цэргийг шууд бусаар гүйцэтгүүлэх арга хэмжээ учраас төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй үйлдэлд хамаарна.</u></p> <p>② <u>Нийтэлсэн үйлдэл нь тодорхой этгээдэд ашиггүй байдлыг цэсгэж буй үйлдэл юм.</u></p> <p>③ <u>Нийтэлсэн үйлдэл нь тухайн этгээдийн нэр хүндэд халдаж буй учраас тухайн этгээд энгэцүү нийтэлсэн шийдвэрийг цэргийн тухай хууль тогтоомжийн үрбдчилсэн нөхцөл, процессыг мөрдсөн эсэхийг шүүхээр дамжуулж хянуулах хууль ёсны ашиг сонирхол байна гэж үзнэ.</u></p>	<p>Дээд шүүхээс давж заалдах шатны шүүхийн адил нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй гэж шийдвэрлэсэн боловч илүү үндэслэл бүхий дүгнэлт гаргажээ. Гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйл болох “Акт” гэдэг нь захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар гаргасан хуулийн хэрэг-жилтийн хувьд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйлдэл, тагталал, түүнтэй адилтгах захиргааны үйл ажиллагааг хэлнэ. (БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.1.1) Захиргааны байгууллагын үйлдэл нь гомдлын нэхэмжлэл (захиргааны байгууллагын акт, эс үйлдэхүйтэй холбоотой нэхэмжлэл)-ийн зүйл болох эсэхийг хийсвэрлэх болон ерөнхий байдлаар шийдвэрлэх боломжгүй бөгөөд тодорхой тохиолдолд холбогдох хуулийн зорилго, агуулга, захиргааны үйлдлийн субьект, агуулга, хэлбэр, үе шат, захиргааны үйлдэл болон үйлдлийн үйлчлэл чиглэж буй этгээд хоорондын харилцан хамаарал, хуульд захирагдах зарчим, захиргааны байгууллага болон захиргааны үйлдлийн үйлчлэл чиглэж буй этгээдийн хандлага зэргийг харгалзан нэг бүрчлэн шийдвэрлэх ёстой (Дээд шүүх 2010.11.18 шngo 2008ду 167 전원합의체 판결).</p>
--	--	--

⁶⁸ 대법원 2019.6.27 선고 2018두 49130 판결.



- ④ Мөн нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг Цэргийн ерөнхий газрын цахим сайтad нийтэлсэн үйлдэл нь гадагш чиглэсэн байна.
2. Үйлчлэл дуусгавар болсон захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэх
- ① Захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах үед нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад захиргааны байгууллагаас маргаан бүхий актыг өөрийн санаачилгаар хүчингүй болгосон тохиолдолд тухайн актын үйлчлэл дуусгавар болсон тул нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нь дуусгавар болсон гэж дүгнэх ёстой. (Пээд шүүх 2006.9.28 선고 2004두 5317 판결 эшлэв).
- Гагцхүү акт гаргасан захиргааны байгууллагаас өөрийн санаачилгаар маргаан бүхий актыг хүчингүй болгосон хэдий ч өмнөх байдлыг бүрэн сэргээх боломжгүй учраас маргаан бүхий актыг хүчингүй болгуулснаар сэргээгдэх бусад эрх, ашиг сонирхол үлдсэн байгаа, мөн хэргийн оролцогчдын хооронд тухайн захиргааны акттай адил үндэслэлээр хууль бус акт давамгайлсан боломжтой учраас Захиргааны актын хууль бус шинжийг тогтоох болон тодорхой бус

Энэхүү хэргийн хувьд дээрх дээд шүүхийн жишиг шийдвэрийг үндэслэн нэхэмжлэгчийн хувийн мэдээллийг Цэргийн ерөнхий газрын цахим сайтad нийтэлсэн үйлдлийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйлдэл гэж дүгнээд захиргааны акт гэж үзжээ. Хэдийгээр нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэл нь нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл болох нэхэмжлэл гаргах эрхэд хамаарах нэхэмжлэлийн зүйлийн шалгуурыг хангасан боловч эрхээ хамгаалуулах шаардлагын шалгуурыг хангаагүй тул шүүхээс нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй гэж үзжээ.

Учир нь хариуцагч нь нэхэмжлэгчийн шашны итгэл үнэмшлийг цэргийн үүргийг биелүүлэхгүй байх “Хүндэтгэн үзэх шалтгаан”-д хамаарна хэмээн үзсэн дээд шүүхийн жишиг шийдвэрийг үндэслэн, нэхэмжлэгчдийн хувийн мэдээллийг устгасан тул дахин маргаан бүхий акттай адил үндэслэлээр буюу хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цэргийн албанаас зайлсхийсэн гэж үзсэн энэ хэргийн акт дахин давтагдах боломжгүй тул нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй хэмээн үзсэн байна.

эрх зүйн асуудлын талаар тайлбар шаардлагатай тохиолдолд захиргааны хууль ёсны байдлыг хангах, түүнд хяналт тавих, иргэдийн эргээ хамгаалуулах хүрээг өргөжүүлэх үүднээс тухайн актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч болно (Дээд шүүх 2007.7.19 선고 2066-ду 19297 전원합의체 판결, Дээд шүүх 2016.6.10. 선고 2013-두 1638 판결 эшлэл).

② Дээд шүүхээс шашины итгэл үнэмшилгүйнхээ дагуу цэргийн алба хаахаас татгалзсан үйлдлийг Цэргийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн үүргийг биелүүлэхгүй байх “Хүндэтгэн үзэх шалтгаан”-д хамаарна гэсэн шүүхийн жишиг шийдвэр гарсан байна (Дээд шүүх 2018.11.1. 선고 2016-도 10912 전원합의체 판결 эшлэл).

Харуулагч болох Цэргийн ерөнхий газрын дарга нь дээрх Дээд шүүхийн 2018.11.1. 선고 2016-도 10912 전원합의체 판결 шийдвэрийг үндэслэн, Дээд шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажчлалагааны явцад тухайн нийтэлсэн үйлдлээ өөрийн санаачилгаар хүчингүй болгож, цахим сайтаас нэхэмжлэгчдийн мэдээллийг устгасан байна.

	<p>③ <u>Иймээс энэ хэргийн нэхэмжлэл нь үйлчлэл нь дуусгавар болсон актыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох болон хүчингүй болгуулах учраас зарчмын хувьд нэхэмжлэл гаргах ашиг сонирхол дуусгавар болжээ. Гэвч харууцагч нь шашны итгэл үнэмлэлийнхээ “Ёховагийн гэрчүүд” гэх шашныг иштдэг нэхэмжлэгчидтэй холбогдуулан, Дээд шүүхийн жишиг шийдвэрийн үндэслэлийг хүндэтгэж, өөрийн санаачилгаар маргаан бүхий актыг хүчингүй болгосон тул хэргийн оролцогчдын хооронд тухайн захиргааны акттай адил үндэслэлээр хууль бус акт давамгайлх боломжтой учраас Захиргааны актын хууль бус шинжийг тогтоох болон тодорхой бус эрх зүйн асуудлын талаар тайлбар шаардлагатай гэж үзэх боломжгүй тул нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.</u></p>	<p>Хариуцагчийн нийтэлсэн үйлдлийг гомдлын нэхэмжлэлийн зүйл болох актад хамаарахгүй гэж шийдвэрлэсэн давж заалдах шагны шүүхийн шийдвэр буруу байх боловч энэ хэргийн үндсэн болон туслах нэхэмжлэлд нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй тул хүлээн авахаас тагталзаж шийдвэрлэх нь зохистой байна. Иймээс нэхэмжлэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.</p>
<p><i>Эцсийн шийдвэр</i></p>		

4. Шийдвэрийн холбогдох хэсэг	Агуулга	Судлаачдын тайлбар
Хэргийн оролцогч	<p>Нэхэмжлэгч: “Ханрил” Хувьцааг Компани Хариуцагч: Инчоны далайн цагдаагийн газрын дарга</p>	<p>Энэхүү шүүхийн шийдвэр нь захиргааны байгууллагаас өмнөх актын агуулгыг өөрчилж, дараагийн акт гаргасан тохиолдолд, өмнөх актын үйлчлэл дуусгавар болох эсэхийг дүгнэсэн онцлог шийдвэр юм.</p>
Маргаан бичгий акт	<p>Хуучин хөлөг онгоц (319 тонн, 394 хүн)-ны зөвшөөрлийг шинэ том хөлөг онгоц (715 тонн, 504 хүн) болгож өөрчилсөн акт (Цеееаашид “1 дүгээр захиргааны акт” буюу 1 дүгээр ЗА гэх) “1 дүгээр захиргааны акт”-д заасан бусад агуулгыг хэвээр үлдээж, хүний тоог 393 болгон өөрчилсөн акт (Цаашид “2 дугаар захиргааны акт” буюу 2 дугаар ЗА гэх)</p>	<p>2 дугаар ЗА-аар 1 дүгээр ЗА-д заасан хөлөг онгоцны хүний тоог л өөрчилсөн тул 1 дүгээр захиргааны актад заасан хүний тоотой агуулга нь дуусгавар болсон гэж үзнэ. Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хариуцагчаас 2 дугаар ЗА-ыг гаргасан байна.</p>
Хэргийн агуулга	<p>Сэжүн ХК 1999 оны 03 дугаар сарын 04-нд Инчоны далайн цагдаагийн газрын даргаас хөлөг онгоцны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (тодорхой чиглэлд хөлөг онгоцоор зорчих эрх) авчээ. Зөвшөөрөл авсан хөлөг онгоц (319 тонн, 394 хүн) 20 жил болж хуучирсны улмаас хуучин хөлөг онгоцны зөвшөөрлийг шинэ том хөлөг онгоц (715 тонн, 504 хүн) болгож өөрчлүүлэх хүсэлтийг 2017 оны 04 дүгээр сарын 06-нд хариуцагчид гаргасан бөгөөд хариуцагч хүсэлтийг хүлээн авч 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хөлөг онгоцны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг том хөлөг онгоцоор өөрчилсөн акт гаргасан байна (Цаашид “1 дүгээр ЗА” гэх).</p>	<p>Хариуцагч нь Сэжүн ХК-ийн 319 тонн, 394 хүний багтаамжтай хуучин хөлөг онгоцны зөвшөөрлийг 715 тонн, 504 хүний багтаамж бүхий шинэ хөлөг онгоцоор өөрчилсөн акт гаргажээ.</p>



	<p>Нэхэмжлэгч нь Сэжүн ХК-тай холбоотой 1 дүгээр ЗА гарсныг хожим мэдэж, 2017 оны 12 дугаар сарын 14-нд шүүхэд нэхэмжлэл гаргажээ.</p>	
<p><i>Нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл</i></p>	<p>1. Анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага: 1 дүгээр ЗА-г хүчингүй болгуулах Нэхэмжлэлийн үндэслэл: Нэхэмжлэгч нь Сэжүн ХК-ийн хөлөг онгоцтой адил чиглэлд далайд зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж, Сэжүн ХК-тай өрсөлдөөний харилцаатай байдаг учраас 1 дүгээр ЗА нь нэхэмжлэгчийн хөлөг онгоцоор зорчигч тээвэрлэх үйл ажиллагааны эрхийг зөрчиж байна гэж тайлбарлажээ.</p> <p>2. Давж заалдах шатны шүүхэд гаргасан нэмэгдүүлсэн нэхэмжлэлийн шаардлага: Давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад (2019.02.26) 1 дүгээр ЗА-ыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагаа 2 дугаар ЗА-ыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох үндсэн болоод хүчингүй болгуулах туслах нэхэмжлэлийн шаардлагын агуулгаар тус тус нэмэгдүүлсэн байна.</p>	<p>Сэжүн ХК нь анхан шатны шүүхийн шийдвэр гарсны (2018.08.16) дараа том хөлөг онгоцонд авсан зөвшөөрлийг хэвээр үлдээх зорилгоор 2018 оны 8 дугаар сарын 31-нд хариуцагчид дахин хандаж, 1 дүгээр ЗА-ын бусад агуулгыг хэвээр үлдээн, харин хүний тоог 1 дүгээр ЗА-д заасан 504 хүн байснаас өмнөх буюу хуучин хөлөг онгоцны хүний тоо болох 394 хүнээс 393 хүнд үйлчлэхээр өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан бөгөөд хариуцагч нь үүнийг хүлээн зөвшөөрч, 2018 оны 9 дүгээр сарын 3-нд хөлөг онгоцны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг өөрчлөх акт гаргасан байна (Цаашид “2 дугаар захиргааны акт” гэх).</p>

<p>Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хариуцагчаас 2 дугаар ЗА-ыг гаргасан тул анхан шатны шүүхээс зөвхөн 1 дүгээр ЗА-тай холбогдуулан шийдвэр гаргасан болно.</p>	<p>Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, 1 дүгээр ЗА-д заасан тодорхой чиглэлд хөлөг онгоцоор зорчих шугамыг хэвээр үлдээж, илүү олон хүнийг суулгах боломжтой том хөлөг онгоцонд зөвшөөрөл олгосон нь нэхэмжлэгчийн хөлөг онгоцоор зорчигч тээвэрлэх үйл ажиллагааны эрхийг зөрчсөн хууль бус шийдвэр гэж дүгнэн, 1 дүгээр ЗА-ыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.</p>	<p>Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа хариуцагчаас 2 дугаар ЗА-ыг гаргасан тул анхан шатны шүүхээс зөвхөн 1 дүгээр ЗА-тай холбогдуулан шийдвэр гаргасан болно.</p>
<p>Давж заалдах шүүхийн шүүхээс 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-д заасан хүний тоо 504 байсныг л 393 болгож өөрчилсөн, бусад агуулга болох тээврийн жин (719 тонн)-г өөрчлөөгүй тул 1 дүгээр ЗА дуусгавар болоогүй бөгөөд урьдын адил нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөөр байгаа тул 1 дүгээр ЗА-ыг хууль бус гэж дүгнэсэн байна.</p> <p>Харин 2 дугаар ЗА-ыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох үндсэн нэхэмжлэл нь нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл (нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэх, УША хийгдсэн эсэх, хөөн хэлэлцэх хугацааг баримталсан эсэх зэрэг)-ийг хангасан боловч үндсэн асуудлыг хэлэлцэх шатанд маргаан бүхий акт нь алдаагүй байсан тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол туслах нэхэмжлэлийн шаардлагын тухайд нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын шалгуурыг хангасан боловч хөөн</p>	<p>① <u>2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-д заасан агуулгаас хүний тоог л өөрчилсөн тул 1 дүгээр ЗА-ыг дуусгавар болсон гэж үзэх боломжгүй ба 1 болон 2 дугаар ЗА нь хоёулаа захиргааны хэргийн гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйл учраас нэхэмжлэгчид нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байна гэж үзсэн байна.</u></p> <p>② <u>Хэдийгээр 2 дугаар ЗА-аар 1 дүгээр ЗА-д заасан хүний тоог багасгасан боловч өмнөх хуулийн хөлөг онгоцны хүний тоог нэгээр багасгасан ч 1 дүгээр ЗА-аар хөлөг онгоцны тээврийн жин нэмэгдсэн тул нэхэмжлэгчийн хөлөг онгоцоор зорчигч тээвэрлэх үйл ажиллагааны эрх зөрчигдөж байгаа нь хэвээрээ тул 1 дүгээр ЗА-ыг хууль бус гэж үзсэн, улмаар хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй холбогдуулан гаргасан хариуцагчийн давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.</u></p>	<p>Давж заалдах шатны шүүхээс 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-д заасан хүний тоо 504 байсныг л 393 болгож өөрчилсөн, бусад агуулга болох тээврийн жин (719 тонн)-г өөрчлөөгүй тул 1 дүгээр ЗА дуусгавар болоогүй бөгөөд урьдын адил нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөөр байгаа тул 1 дүгээр ЗА-ыг хууль бус гэж дүгнэсэн байна.</p> <p>Харин 2 дугаар ЗА-ыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох үндсэн нэхэмжлэл нь нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөл (нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэх, УША хийгдсэн эсэх, хөөн хэлэлцэх хугацааг баримталсан эсэх зэрэг)-ийг хангасан боловч үндсэн асуудлыг хэлэлцэх шатанд маргаан бүхий акт нь алдаагүй байсан тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол туслах нэхэмжлэлийн шаардлагын тухайд нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын шалгуурыг хангасан боловч хөөн</p>

69 인천지방법원 2018.8.16 선고 2017구 합 55194 판결.

70 서울고등법원 2019.6.27 선고 2018누 63312 판결.



	<p>③ 2 дугаар ЗА-ыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолох үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг уг ЗА нь ноцтой болон илэрхий алдаагүй гэсэн шалтгаанаар хэрэгсэхгүй болгож, 2 дугаар ЗА-ыг хүчингүй болгуулах туслах нэхэмжлэлийн шаардлагын хувьд нэхэмжлэгч нь 2 дугаар ЗА-ыг гарсныг мэдсэнээс хойш 90 хоногийн дотор нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.</p>	<p>хэлэлцэх хугацааны урьдчилсан нөхцөлийг хангаагүй тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.</p>
<p>Дээд шүүхийн шүүхтөвлөл⁷¹</p>	<p>1. Дээд шатны шүүхээс үндэслэл болгосон шүүхийн шийдвэр: <u>① Захиргааны акттай холбоотой маргах нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг тухайн тохиолдол болон тодорхой нөхцөл байдлыг харгалзан дүгнэх ёстой.</u> <u>Захиргааны актыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолох эсгүүл хүчингүй болгуулах нэхэмжлэл нь нэхэмжлэл гаргах тухайн үед нэхэмжлэл гаргах ашиг сонирхол буй учраас зүй ёны байсан боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад акт гаргасан байгууллага маргааны зүйл болсон захиргааны актыг өөрийн санаачилгаар хүчингүй болгосон тохиолдолд тухайн актын үйлчлэл дуусгавар болж, цаашид байхгүй болсонтой ижил тул байхгүй</u></p>	<p>Дээд шүүхээс энэхүү хэргийг шийдвэрлэхдээ 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-ын гол агуулгыг өөрчилж гараагүй тохиолдолд 1 дүгээр ЗА нь дуусгавар болоогүй гэж дүгнээд, 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-ын хүний тоог л өөрчилсөн агуулаар гарсан тул 1 дүгээр ЗА-д заасан өөрчлөгдөөгүй хэсэг болох хөлөг онгоцны тээврийн хэмжээ (719 тонн)-тэй холбоотой хэсгийг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг нэхэмжлэгчид байна гэж дүгнэсэн байна. <u>Харин 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА дахь 504 хүүнийг 393 хүн болгон багасгасан агуулгаар гарсан учраас нэхэмжлэгчид ашигтай тул нэхэмжлэгчид 1 дүгээр ЗА-ын дуусгавар болсон хэсэгт холбогдуулан нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй хэмээн үзэж шийдвэрлэжээ.</u></p>

⁷¹ 대법원 2020.4.9 선고 2019두 49953 판결 (도선사업면허변경분취소).

байгаа актыг маргааны зүйлээ болгосон захираганы хэргийн гомдлын нэхэмжлэл нь зарчмын хувьд нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нь дуусгавар болсон хэмээн үзэж зүй бус гэж дүгнэх ёстой (Дээд шүүх, 대법원 2006.09.28. 선고 2004두 5317 шийдвэр).

Гагцхүү акт гаргасан байгууллагаас өөрийн санаачилгаар маргаан бүхий актыг хүчингүй болгосон хэдий ч өмнөх байдлыг бүрэн сэргээх боломжгүй учраас маргаан бүхий актыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоох эсхүл хүчингүй болгуулснаар сэргээгдэх бусад эрх, ашиг сонирхол үлдсэн байгаа, мөн адил маргааны талуудын хооронд тухайн захираганы акттай адил үндэслэлээр хууль бус акт давтагдах боломжтой учраас захираганы актын хууль бус шинжийг тогтоолох, тодорхой бус эрх зүйн асуудлын талаар тайлбар шаардлагатай тохиолдолд захираганы хууль ёсны байдлыг хангах, түүнд хяналт тавих, иргэдийн эрхээ хамгаалуулах хүрээг өргөжүүлэх үүднээс тухайн актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч болно (Дээд шүүх, 대법원 2007.07.19. 선고 2006두 19297 전원합의체 판결, 대법원 2016.06.10. 선고 2013두 1638 шийдвэр).

- ② Өмнөх актын гол агуулгыг бодитоор өөрчилсөн дараагийн акт гарсан тохиолдолд өмнөх акт нь тусгайлсан нөхцөл байгаагаас бусад тохиолдолд үйлчлэл нь дуусгавар болох боловч дараагийн акт нь өмнөх актын агуулгын зарим хэсгийг ялимгүй өөрчилсөн тохиолдолд өмнөх актын үйлчлэл дуусгавар болохгүй бөгөөд дараагийн актаар өөрчлөгдсөн хэсгээс бусад хэсэг нь үйлчлэлтэй хэвээр байна (Дээд шүүх, 대법원 2012.12.13. 선고 2010두20782, 20799 шийдвэр).
2. Дээд шүүхийн дүгнэлт:
- ① 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-ыг бүхэлд нь буруу түүний гол хэсгийн агуулгыг бодит байдалд өөрчлөөгүй, гагцхүү хүний тоог багасгасан бөгөөд 2 дугаар ЗА-аар өөрчлөгдөөгүй 1 дүгээр ЗА-д байгаа агуулга болох хуучин хөлөө онгоцны тээврийн хэмжээ болох 319 тоннныг шинэ хөлөө онгоцонд 715 тонн болгож өөрчилсөн нь өрсөлдөөний харилцаа бүхий нэхэмжлэгчид ачаа тээврийн салбарт сөрөг нөлөө үзүүлсээр байгаа тул 1 дүгээр ЗА-ын үйлчлэлтэй хэвээр байгаа үлдсэн хэсэг нь гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйл болох учраас тэр хэсэгт холбогдуулан хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нэхэмжлэгчид байна.

- ② 2 дугаар ЗА нь 1 дүгээр ЗА-д заасан хүнийг тоог хариуцагч өөрийн санаачилгаар хүчингүй болгосон захиргааны акт тул гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйлд хамаарна. Гэвч 1 дүгээр ЗА-аар хөлөг онгоцны хүний тоог хуучин хөлөг онгоцны хүний тоо болох 394 хүнээс 504 хүн болгон нэмэгдүүлсэн агуулгатай байсан тул нэхэмжлэгчид ашиггүй боловч 2 дугаар ЗА нь 504 хүнээс 393 хүн болгож цөөрүүлсэн нь нэхэмжлэгчид ашигтай хэмээн үзэхээр байгаа учраас нэхэмжлэгч нь 2 дугаар ЗА-ыг хүчингүй болгуулах, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй.
- ③ Гэвч давж заалдах шатны шүүх 2 дугаар ЗА-ыг хүчингүй болгуулах болон хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэл гаргах ашиг сонирхол нэхэмжлэгчид байна гэж үзээд 2 дугаар ЗА-ыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хуралдаанаар хэлэлцэж, хэрэгсэхгүй болгосон байна. Ингэж шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь гомдлын маргааны нэхэмжлэлийн нэхэмжлэл гаргах ашиг сонирхолтой холбоотой хууль зүйн ойлголтыг буруу хэрэглэн, шүүхийн шийдвэр алдаатай гарахад нөлөөлсөн байна.

- ④ Давж заалдах шатны шүүхээс 2 дугаар ЗА-ыг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй холбоотойгоор нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон гэх шалтгаанаар татгалзсан нь үндэслэлтэй байна. 2 дугаар ЗА нь хариуцагчийн 1 дүгээр ЗА-д заасан хүнийг тоог өөрийн санаачилгаар хүчингүй болгосон захиргааны акт тул гомдлын маргааны нэхэмжлэлийн зүйлд хамаарна. Гэвч 1 дүгээр ЗА-аар хөлөө онгоцны хүний тоог хуучин хөлөө онгоцны хүний тоо болох 394 хүнээс 504 хүн болгон нэмэгдүүлсэн агуулгатай байсан тул өрсөлдөөний харилцаа бүтгий нэхэмжлэгчид ашиггүй боловч 2 дугаар ЗА нь 504 хүнээс 393 хүн болгож цөөрүүлсэн нь нэхэмжлэгчид ашигтай гэж үзэхээр байгаа учраас нэхэмжлэгч нь 2 дугаар ЗА-ыг хүчингүй болгуулах, хүчин төгөлдөр бус болохыг тогтоолох нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй. Давж заалдах шатны шүүхээс 2 дугаар ЗА-ыг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй холбоотойгоор нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон гэх шалтгаанаар татгалзсан нь үндэслэлтэй байна. Улмаар хөөн хэлэлцэх хугацааг баримталсан ч нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй тул татгалзаж шийдвэрлэх ёстой байсан тул энэ нь шүүхийн шийдвэрт нөлөөлөхгүй.

<i>Эцсийн шийдвэр</i>	<p>Давж заалдах шатны шүүхийн 2 дугаар Заа- ыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоох үндсэн нэхэмжлэлийн шаардлагын хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэсгийг хүчингүй болгон, тус нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас тагталгаж, туслах нэхэмжлэлийн шаардлагыг хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн гэдэг үндэс- лэлээр хүлээн авахаас тагталгаж шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн холбогдох хэсгийг хэвээр үлдээж шийдвэрлэв.</p>	
5. Шийдвэ- рийн хол- богдох хэсэг	Агуулга	Судлаачдын тайлбар
<i>Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа- ны оролцогч</i>	<p>Гомдол гаргагч: Иргэн А Гомдолд холбогдогч: Дэжон хотын Б дүүргийн Засаг дарга</p>	
<i>Хэргийн агуулга</i>	<p>Дэжон хотын Б дүүрэг В хороо Г тоотын Д вилла зогсоолд иргэн А-ийн тавьсан мото- циклттой холбогдуулан, тус газрын ойролцоо амьдардаг иргэнээс мэдээлэл өгсөн байна. Дээрх мэдээлэлтэй холбогдуулан, Дэжон хотын Б дүүрэг В хорооны Засаг дарга тухайн газарт очиж шалгаад, иргэн А-д мотоциклоо холдуулах талаар шаардлага тавьсан боловч иргэн А нь мотоциклоо холдуулах ямар нэгэн арга хэмжээ аваагүй тул Дэжон хотын Б дүүрэг В хорооны Засаг дарга 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр иргэн А-ын мотоциклыг хадгалах агуула руу зөөж, шилжүүлэх арга хэмжээг авсан байна.</p>	<p>Энэхүү маргааны хувьд дуусгавар болсон захиргааны үйл ажиллагаанд холбогдуулан, Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хүчингүй болуулах гомдол гаргаж байгаагаар онцлогтой юм.</p>

<p>Гомдлын шаардлага</p>	<p>Иргэн А нь Дэжон хотын Б дүүрэг В хорооны Засаг даргын мотоциклыг нь хадгалах агуулга руу зөөж шилжүүлэх арга хэмжээнд холбогдуулж, 2020 оны 12 дугаар сарын 30-нд Захиргааны хэргийн урьдчилан шийдвэрлэх ажиллагааны (наашид УША гэх) хороонд дараах гомдлыг гаргажээ.</p> <ul style="list-style-type: none"> - Мотоциклоо буцаан авах; - Зөөж шилжүүлсний төлбөр болон хадгалалтын төлбөр ногдуулсан актыг хүчингүй болгуулах; - <u>Зөөж шилжүүлсэн арга хэмжээг хүчингүй болгуулах;</u> 	<p>БНСУ-ын Захиргааны урьдчилан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд үйлчлэл дуусгавар болсон актад холбогдуулан, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гаргах дараах зохицуулалтыг хуульчилсан байдаг.</p> <p>13 дугаар зүйл (Урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргах эрхтэй этгээд)</p> <p>Хүчингүй болгуулах урьдчилан шийдвэрлэх ажиллагааны гомдлын актыг хүчингүй болгуулах болон өөрчлүүлэх хууль ёсны ашиг сонирхол бүхий этгээд гаргана. Акт зэргийн үр дагавар нь хутацаа өнгөрөх, акт зэрэг хэрэгжсэн, бусад шалтгааны улмаас дуусгавар болсон ч тухайн акт зэргийг хүчингүй болгосноор сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол бүхий этгээд мөн адил хамаарна.</p>
<p>Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр⁷²</p>	<p>УША-ны хорооноос 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдөр шийдвэр гарчээ. <u>Зөөж шилжүүлсэн арга хэмжээг хүчингүй болгуулах гомдлын шаардлагыг дараах байдлаар шийдвэрлэв.</u></p> <p><u>Гомдол гаргагч нь 2019 оны 11 дүгээр сарын 22-нд мотоциклыг зөөж шилжүүлсэн арга хэмжээтэй холбоотойгоор процесс ажиллагааны журам зөрчсөн гэх үндэслэлээр хүчингүй болгуулах гомдлыг гаргасан бөгөөд энэ хэргийн хувьд зөөж шилжүүлэх арга хэмжээ нь аль хэдийн хэрэгжиж дуусгавар</u></p>	<p>Энэхүү хэргийн хувьд гомдол гаргагчаас урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар гомдол гаргахаас өмнө (2020.12.30) маргаан бүхий захиргааны үйлдэл аль хэдийн хэрэгжиж дуусгавар болсон байна (2019.11.22).</p> <p>Шүүхээс энэхүү дуусгавар болсон захиргааны арга хэмжээг хүчингүй болгосноор нэхэмжлэгчид сэргээгдэх аливаа ашиг сонирхол байхгүй гэж үзэн, гомдлыг хүлээн авахаас татгалзсан байна.</p>

⁷² <https://daecjeon.go.kr/drh/administration/AppealView.do?menuSeq=1878&appealSeq=1095&fbclid=IwAR3wldIb8KmK9shgAn23yMFP-PPDQ496zX9FXFwxе-0JURkhyj64bGrFXN0E>

	<p>болсон тул гомдолд холбогдогч талын арга хэмжээг хүчингүй болгосноор гомдол гаргагчид сэргээгдэх ашиг сонирхол байггүй гэж үзээд тухайн арга хэмжээг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол байхгүй байна хэмээн дүгнэсэн байна. Иймд дээрх үндэслэлээр гомдол гаргагчийн гаргасан гомдол нь үндэслэлгүй байх тул гомдлыг хцлээн авахаас татгалзаж шийдвэрлэв.</p>	
<p>Үйлчлэл дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан гаргасан хүчингүй болгуулах нэхэмжлэлийг шийдвэрлэж буй БНСУ-ын шүүхийн шийдвэрийн онцлог</p>		
<p>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дэх хэсэгт хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шинжтэй хэмээн үзэж, нэхэмжлэл гаргах ашиг сонирхлын шалгуурыг эрх зөрчигдсөн байх, улмаар шүүхээс нэхэмжлэлийг хангаснаар зөрчигдсөн эрх сэргээгдэх үр дагаварт хүрсэн байх хэмээн хатуу тодорхойлж байсан бол 2007 оноос эхлэн шүүхийн чиг хандлага өөрчлөгдөж, нэгэнт үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах боломжгүй бөгөөд актыг үйлчлэл дуусгавар болсны дараа ч зөрчигдсөн эрхтэй холбогдуулан маргах шаардлага байгаа тохиолдолд үүнийг тогтоох нэхэмжлэлээр шийдвэрлэхээс өөр аргагүй гэж үзэн, үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шинжийг тогтоох нэхэмжлэл хэмээн үзэх чиг хандлагагай болсон байна.</p>		



<p>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх “хууль ёсны ашиг сонирхол” гэх ойлголтын хүрээ хязгаар</p>	<p>Дээд шүүхийн 1995 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрээр хууль ёсны ашиг сонирхлыг “Тухайн актын үндэслэл болсон хуулиар хамгаалагдах шууд болон готорхой ашиг сонирхол” гэж тодорхойлдог байсан шүүхийн чиг хандлага 2007 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэр-ээр өөрчлөгдөж, хууль ёсны ашиг сонирхлын хүрээг Германы Үргэлжлүүлэн тогтоох нэхэмжлэл дэх “тогтоох зүй ёсны ашиг сонирхол (ein berechtigtes Interesse an dieser Feststellung)”-ын хүрээгээр өргөжүүлэн тайлбарлах чиг хандлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, өмнөх шүүхийн практик дахь “хууль ёсны ашиг сонирхол”-д хамаарахгүй нэр хүнд зэрэг эдийн бус ашиг сонирхол, цалин хөлс гаргуулах зэрэг эдийн засгийн ашиг сонирхол, ашиггүй нөхцөл байдлыг арилгуулах нийгмийн ашиг сонирхол зэргийг хамааруулдаг зүй ёсны ашиг сонирхлыг хүртэл энэхүү хууль ёсны ашиг сонирхолд багтаан ойлгож байна. Цаашлаад оюун санааны ашиг сонирхлыг хүртэл хүлээн зөвшөөрөх чиг хандлагатай болж байна.</p> <p>Тухайлбал, Шүүхээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх “хууль ёсны ашиг сонирхол”-д дараах ашиг сонирхлуудыг хамааруулж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Зөрчилдсөн эрхийг сэргээх • Талуудын хооронд адил үндэслэлээр адил агуулгатай сөрөг нөлөөлөл бүхий акт давтагдахаас урьдчилан сэргийлэх ашиг сонирхол • Өмнө гарсан акт нь ирээдүйд гарах актын урьдчилсан нөхцөл, эсхүл хүндрүүлэх нөхцөл болон гарах тохиолдолд • Ирээдүйд бий болох ашиггүй байдлаас урьдчилан сэргийлэх ашиг сонирхол • Хохирол арилгуулах ашиг сонирхол • Нэр хүнд зэрэг эдийн бус ашиг сонирхол • Ирээдүйд бий болох аливаа эрхийн зөрчлөөс сэргийлэх ашиг сонирхол
--	--

1. Өмнөх шүүхийн практикт хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахаас өмнө захиргааны актын үйлчлэл дуусгавар болсон бол нэгэнт дуусгавар болсон акттай маргах боломжгүй гэж үздэг байсан бол үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлээр дамжуулж, ашиггүй байдлыг арилгуулах эрхээ хамгаалуулах шаардлагыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэсэн Дээд шүүхийн 2006 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн шийдвэрээс хойш хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахаас өмнө үйлчлэл дуусгавар болсон акттай холбоотойгоор нэхэмжлэл гаргах боломжтой хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл, БНСУ-ын шүүхийн практик нь манай улсын адил “хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа” гэж хязгаарлахгүйгээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэлийн зүйл болох актын үйлчлэл дуусгавар болох цаг хугацааг хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахаас өмнө болон хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараахыг хамтад нь багтаадаг онцлогтой.
2. БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэл нь “хууль ёсны ашиг сонирхол” гэдгийг гол урьдчилсан нөхцөлөө болгодог учраас дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах “хууль ёсны ашиг сонирхол” байгаа тохиолдолд нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, үүний дараа маргаан бүхий актыг хууль зөрчсөн эсэхийг шалгаж, шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангасан, эсхүл хэрэгсэхгүй болгосон үндсэн хоёр шийдвэрийг гаргадаг. Хэрэв дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол нэхэмжлэгчид байхгүй тохиолдолд нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байхгүй хэмээн үзээд, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, МУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.3.3-ын адилаар актыг хууль бус байсан болохыг тогтоох агуулгаар шүүхийн шийдвэр гардаггүй, харин дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах сөргээгдэх ашиг сонирхол байгаа гэж үзвэл нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч хэрэг үүсгэх бөгөөд үүний дараа шүүх хуралдаанаар дуусгавар болсон акт нь хууль бус болох нь тогтоогдвол нэхэмжлэлийг хангах, хууль зөрчөөгүй болох нь тогтоогдвол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг онцлогтой.

БНСУ-ын
шүүхийн
шийдвэрийн
онцлог

3. БНСУ-ын шүүхийн практик нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр дэх нэхэмжлэлийн шинжийг тогтоох нэхэмжлэлийн шинжтэй хэмээн үзэж байгаа боловч тогтоох нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг заавал хангасан байхыг шаарддаггүй. Харин хэлбэрийн хувьд тус нэхэмжлэл нь хүчингүй болгуулах нэхэмжлэл учраас “Үйлчлэл дуусгавар болсон акт”-д холбогдуулан хүчингүй болгуулах нэхэмжлэлийг гаргах тохиолдолд ерөнхийдөө “Үйлчлэлтэй акт”-д холбогдуулан гаргах хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хангасан байхыг шаарддаг.
4. БНСУ-ын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд “Хүчингүй болгуулах нэхэмжлэлийг тухайн акт зэргийг хүчингүй болгуулах “хууль ёсны ашиг сонирхол” бүхий эгтгээд гаргана. Акт зэргийн үр дагавар нь хугацаа өнгөрөх, акт зэрэг хэрэгжсэн, бусад шалтгааны улмаас дуусгавар болсон ч тухайн акт зэргийг хүчингүй болгосноор сэргээгдэх “хууль ёсны ашиг сонирхол” бүхий эгтгээд мөн адил хамаарна” гэж үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах гэсэн агуулгаар зохицуулсан тул нэхэмжлэлийн шаардлага нэхэмжлэгчээс заавал өөрчилсөн байхыг шаарддаггүй. Өөрөөр хэлбэл, үйлчлэлтэй захиргааны актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл нь дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах нэхэмжлэлээр хэвээр үргэлжилж байгаа учраас тэр юм. Гэхдээ үйлчлэлтэй актыг хүчингүй болгуулах хууль ёсны ашиг сонирхол нь үйлчлэл дуусгавар болсон актыг хүчингүй болгуулах сэргээгдэх хууль ёсны ашиг сонирхол болж өөрчлөгддөг.

ДҮГНЭЛТ

Судлаачдын зүгээс дуусгавар болсон захиргааны актад холбогдох хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг ашиглан, ЗХШХШТ хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3 дахь зохицуулалтын утга агуулга, хууль хэрэглээний зарим асуудлын талаар дүгнэж, БНСУ-ын хууль тогтоомж, онолын ойлголт, шүүхийн практиктай харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Уг судалгааны ажлыг үндэслэн, дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хоёр улсын шүүхийн практикаас үзэхэд, маргаан бүхий акт нэгэнт дуусгавар болсон хэдий ч түүнийг хууль бус байсан болохыг тогтоох хэрэгцээ шаардлага байх тохиолдол цөөнгүй байна. Тиймээс дуусгавар болсон актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхийг олгохоос өөр аргагүй. Гэхдээ энэхүү эрхийн шалгуурыг оновчтой утгажуулж хэрэглэхгүй бол захиргааны хэргийн шүүх иргэний субъектив эрхийг хамгаалах зорилгоосоо хальж, захиргааг хянах, эсхүл иргэний шүүхэд хандах эрхийг⁷³ зохисгүйгээр хязгаарлах эрсдэлтэй байна. Тийм учраас БНСУ-ын захиргааны хэргийн шүүх дуусгавар болсон захиргааны актад холбогдох нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ нэхэмжлэл гаргах ашиг сонирхол байгаа эсэхийг онцгойлон анхаарч, дэлгэрэнгүй дүгнэлт хийдэг болох нь ажиглагдаж байна.
2. Харин манай улсын хувьд дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг дүгнээгүй, эсхүл дүгнэлт нь тодорхой биш тохиолдол олон

⁷³ Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14 дэх хэсэг, 1992 он.

байгаа нь хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийн утга агуулга, ач холбогдлыг үгүйсгэх төдийгүй захиргааны хэргийн шүүх захиргааг хянадаг дээд шатны байгууллага хэмээн буруу ойлголт төрүүлэх эрсдэлтэй юм. Энэ нь улмаар тус асуудлыг судалгааны объект болгож, хөгжүүлэх боломжийг хаах юм.

3. Маргаан бүхий захиргааны акт дуусгавар болоогүй байхад хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэх, мөн захиргааны актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болсон байдлыг баримт бичигт тулгуурлан дүгнэж буй нь нэхэмжлэгчийн хүссэн эрх зүйн хамгаалалтыг хангалтгүй эдлүүлэх, цаашлаад дахин нэхэмжлэл гаргах, шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх, оролцогчдыг хүндрүүлэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.
4. 106.3.3 дахь заалтын “...хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа...” гэх томъёоллыг тайлбарлахдаа захиргааны акт дуусгавар болсон цаг хугацааг чухалчлан үзэж байгаа нь дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхийг зохисгүйгээр хязгаарлах шалтгаан болж байна. Энэ нь тус нэхэмжлэлийн зорилгыг үгүйсгэх юм. Учир нь хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийн зорилго нь маргаан бүхий актыг хүчингүй болгуулахыг зорьж байсан боловч дуусгавар болсны улмаас уг нэхэмжлэлийн шаардлагаар маргах боломжгүй болсон тохиолдолд нөхөж маргах боломжийг олгох зорилготой юм.
5. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий акт дуусгавар болсноор хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд маргах эрх үгүйсгэгдэх учир хэргийн хувьд шинэ нөхцөл байдал үүсэх юм. Өөрөөр хэлбэл, хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн

шаардлагаар эцэслэн шийдвэрлэх асуудал хөндөгдөнө. Манай улсын ЗХШХШТ хуульд нэхэмжлэлийн зүйл өөрчлөгдсөнөөр нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн өөрчлөх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй. Гэхдээ ЗХШХШТ хуулийн (20.1.1, 54.1, 54.2, 106.5, 109.2) заалтуудаар уг асуудлыг бүрэн зохицуулжээ. Гэвч шүүх тэдгээр заалтын дагуу өөрчлөгдсөн нөхцөл байдалтай холбогдуулан шүүхээс гаргах шийдвэр, нэхэмжлэлийн төрөл эрх зүйн үр дагаврыг нэхэмжлэгчид тайлбарлаж, нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх боломж олгосон нь шүүхийн шийдвэрээс харагдах тохиолдол маш цөөхөн байна.

6. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэл гаргах эрхгүй болох нь тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгож, татгалзах хууль зүйн үндэслэлийг ЗХШХШТ хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2-д заасан байтал хэргийг эцэслэн шийдвэрлэх шийдвэр болох 106.3.3/4 дэх заалтыг үндэслэх тохиолдол байгаа нь хууль хэрэглээний төдийгүй агуулгын хувьд учир дутагдалтай юм.
7. Нэхэмжлэлийн урьдчилсан нөхцөлийг хангаагүй байх нь 54.1.5-д заасан “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд” гэх ойлголтын агуулгад илүү хамааралтай байхад УДШ-ийн зүгээс 54.1.1 дэх заалтыг үндэслэн татгалзах болсон нь анхаарал татууштай.

САНАЛ

1. Дуусгавар болсон захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргах ашиг сонирхлыг дүгнээгүй тохиолдол олон байгаа нь хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийн утга агуулга, ач холбогдлыг үгүйсгэх төдийгүй захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагыг хянадаг дээд шатны байгууллага гэх буруу ойлголт төрүүлэх эрсдэлтэй тул шүүх “нэхэмжлэгчийн ашиг сонирхол”-ыг зайлшгүй дүгнэж, шийдвэртээ дэлгэрэнгүй тусгах;
2. “...хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа тухайн актыг цуцалсан болон хүчингүй болгосон, эсхүл бусад байдлаар хэрэгжсэн...” гэдэг нь хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн субсидарь шинжийг илэрхийлэх учир хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагаар маргах боломжтой тохиолдолд хууль бус байсан болохыг тогтоох нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах;
3. “...хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасны дараа...” гэх бичвэрийг маргаан бүхий акт дуусгавар болсон цаг хугацааны хязгаарлалт бус, хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргах эрхээ алдаагүй байх хязгаарлалт хэмээн тус нэхэмжлэлийн зорилгын дагуу тайлбарлаж хэрэглэх;
4. Захиргааны актын эрх зүйн үйлчлэл дуусгавар болсон эсэхийг дүгнэхдээ хэлбэр бус, агуулгыг чухалчлан үзэх;
5. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад маргаан бүхий акт дуусгавар болсон тохиолдолд өөрчлөгдсөн

нөхцөл байдалтай холбогдуулан, нэхэмжлэгчид хүссэн эрх зүйн хамгаалалтаа авах боломжийг олгох үүднээс нэхэмжлэлийн төрөл, урьдчилсан нөхцөл, үр дагаврыг тайлбарлах, тодруулах ажиллагааг хийх;

6. ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3-д заасан хэргийг эцэслэн хянан магадлах шийдвэрийг бусад процессын шийдвэрээс ялгаж хэрэглэх;
7. Энэхүү харьцуулсан эрх зүйн судалгаанаас үзэхэд, ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5 дахь заалтын “нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд” гэх томьёолол нь БНСУ-ын ЗХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн малгай гарчигтай, мөн ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасан хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэл нь БНСУ-ын ЗХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэртэй адилтгаж болох зохицуулалт байгаа учраас ЗХШХШТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-ыг мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-аар тайлбарлан хэрэглэж болохоор байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ДОТООДЫН ЭХ СУРВАЛЖ

Ном, сурах бичиг судалгаа

1. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019.
2. Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019.
3. А.Эрдэнцогт, Монгол улсын захиргааны процессын эрх зүй, УБ., 2014.
4. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний эмхтгэл 3, Н.Отгончимэг, Засгийн газар хариуцагчаар оролцсон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, УБ., 2020.
5. П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, УБ., 2016.

Хууль тогтоомж:

1. Үндсэн хууль, 1992.
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016.
3. Захиргааны ерөнхий хууль, 2016.
4. Ашигт малтмалын тухай хууль, 2006.
5. Хөдөлмөрийн тухай хууль, 1999.

Шүүхийн шийдвэр

1. УДШ-ийн тогтоол (2020.07.24), дугаар 18.
2. УДШ-ийн тогтоол (2020.06.23), дугаар 241.
3. УДШ-ийн тогтоол (2019.12.23), дугаар 02.

4. УДШ-ийн тогтоол (2018.06.25), дугаар 288.
5. УДШ-ийн тогтоол (2018.01.15), дугаар 26.
6. УДШ-ийн тогтоол (2017.11.06), дугаар 440.
7. АШШ-ийн шийдвэр (2020.08.25), дугаар 527.
8. АШШ-ийн шийдвэр (2020.11.04), дугаар 115/
ШШ2020/0020.
9. АШШ-ийн шийдвэр (2019.04.15), дугаар 221/
МА2019/0425.
10. АШШ-ийн шийдвэр (2019.08.15), дугаар 221/
МА2019/0424.
11. АШШ-ийн шийдвэр (2020.03.26), дугаар 0201.
12. АШШ-ийн шийдвэр (2019.04.17), дугаар 242.
13. АШШ-ийн шийдвэр (2020.05.12), дугаар 128/
ШШ2020/0314.
14. АШШ-ийн шийдвэр (2017.01.04), дугаар 15.
15. АШШ-ийн шийдвэр (2016.11.07), дугаар 885.

ГАДААД ЭХ СУРВАЛЖ

Ном, сурах бичиг, судалгаа:

1. 김남진, 김연태, 『행정법 I』, 법문사, 2013, 709면 이하.
2. 김남진/김연태, “행정법’1” 법무사, 2013, 770면. 홍준형, “행정법” 법무사, 2011.
3. 김유환, “취소소송에 있어서의 권리보호의 필요”, 『고시연구』, 고시계사, 1995.11, 64면 참조.
4. 김유환, 취소소송에 있어서의 권리보호의 필요, 고시연구 1995.11, 61면 이하, 홍준형, 행정구제법 제4판.
5. 김철용, 『행정법』, 고시계사, 2014,
6. 류지태/박종수 『행정법신론』, 654면, 박정훈 『행정소송의 구조와 기능』 319면 이하 참조.
7. 박윤흔, 최신행정법강의 (상), 제29판,
8. 최선응, 행정소송법 제12조 제2문의 해석 논문. 대법원, 1982.3.9 선고 81누 326 판결.

9. 한울아카데미, 590면.
10. 홍정선, 『행정법원론(상)』, 2002, 962-963면.
11. 홍준형, 『행정법』, 법문사, 2011.
12. <https://law.go.kr/LSW/precInfoP.do?evtNo=93%EB%88%848139>
13. <https://www.law.go.kr/LSW/precInfoP.do?evtNo=2006%EB%91%9019297>

БНСУ-ын шүүхийн шийдвэр:

1. 대법원, 1982.3.9 선고 81누 326 판결.
2. 대법원 1995.10.17. 선고 94누 14148 전원합의체 판결.
3. 대법원 2006.06.22. 선고 2003두 14148 전원합의체 판결.
4. 대법원 2007.07.19. 선고 2006두 19297 전원합의체 판결.
5. 서울행정법원 2018.2.9 선고 2017구합 59581 판결.
6. 서울고등법원 2018.6.5 선고 2018누 38217 판결.
7. 인천지방법원 2018.8.16 선고 2017구합 55194 판결.
8. 서울고등법원 2019.6.27 선고 2018누 63312 판결.
9. 창원지방법원 2019구단 10574 영업정지처분취소 판결.
10. 대법원 2019.6.27 선고 2018두 49130 판결.
11. 대법원 2020.4.9 선고 2019두 49953 판결 (도선사업면허변경처분취소).

2

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭР- ЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ҮНДЭСЛЭЛТЭЙ БАЙДАЛ (ИРГЭН, ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХЭРГИЙН ХАРЬАЛЛЫН ДАВХЦАЛ)

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



БАТБОЛДЫН АМАРСАНАА (LL.D)

МУИС-ын Хууль зүйн сургуулийн захирал, хууль зүйн доктор, профессор Б.Амарсанаа нь 1999 оноос хойш МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш, дэд профессор, Хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, 2021 оноос тус сургуулийн захирлаар тус тус ажиллаж байна. Б.Амарсанаа нь хувийн эрх зүйн салбар, тэр дундаа арилжааны эрх зүй, компанийн эрх зүй, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Монгол Улсад арилжааны эрх зүйг хөгжүүлэхэд голлон анхаарч судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж байна.



САРАНГЭРЭЛИЙН БАТБАЯР (LL.M)

МУИС-ын Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш, Япон Улсын Кюүшүгийн Их сургуулийн судлаач, докторант С.Батбаяр нь Хууль зүйн үндэсний хүрээлэнд бодлогын судлаач ажиллаж байсан туршлагатай. С.Батбаяр нь Арилжааны эрх зүй, Компанийн эрх зүй, Үнэт цаасны эрх зүйн чиглэлээр дагнан судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг бөгөөд дангаар болон хамтарсан 30 гаруй эрдэм шинжилгээний судалгаа, 20 гаруй эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийг дотоодын болон гадаадын сэтгүүлд хэвлүүлжээ.

Судлаачид:

Б.Амарсанаа (LL.D)

С.Батбаяр (LL.M)

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	114
УДИРТГАЛ	115

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ ЧИГ ХАНДЛАГА БА ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	122
1.1. Монгол Улсын бүртгэлийн эрх зүйн үндэс ба бүртгэлээс үүсэх маргаан	122
1.2. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиг хандлага	124
1.3. Улсын бүртгэгчийн эрх буюу хэлбэр ба агуулгын хяналт	125
1.4. Япон Улс	130
1.5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	137

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛЭЭС ҮҮДЭХ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ	140
2.1. Улсын бүртгэгчийн хяналтын эрх ба бүртгэхээс татгалзах	140
2.2. Улсын бүртгэгчийн хэлбэрийн хяналт ба захиргааны хэргийн шүүхийн агуулгын хяналт	146
2.3. Захиргааны шүүх хувийн эрх зүйн харилцаанд дүгнэлт өгөх нь	149

2.4. Захиргааны хэргийн шүүх хувийн эрх зүйн материаллаг хуулийг хэрэглэх нь	152
2.5. Захиргааны хэргийн шүүхийн хяналт ба Иргэний хэргийн шүүхийн харьяаллын давхцал	167
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	181
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	188



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗХШ	Захиргааны хэргийн шүүх
ИХШ	Иргэний хэргийн шүүх
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ХЭБ	Хуулийн этгээдийн бүртгэл
ХЭУБтХ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
ХЭЭБХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
КтХ	Компанийн тухай хууль

УДИРТГАЛ¹

Ардчилал, чөлөөт зах зээлийн нийгмийн үндэс суурь нь аж ахуй эрхлэх замаар ашиг олж, капитал буюу хөрөнгө бий болгох замаар өмчлөх эрхээ баталгаажуулах явдал юм. Манай улсын хувьд ч 1990-ээд оноос хойш чөлөөт зах зээлийн энэхүү замаар замнан, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн хөгжлийг чиг баримжаагаа болгож, энэ тухай Үндсэн хуульдаа тунхаглан баталгаажуулсан билээ.

Үүний тод илрэл нь ашгийн төлөө хуулийн этгээд байгуулах замаар бизнесийн үйл ажиллагаа эрхлэх хэлбэр юм. 2019 оны байдлаар Монгол Улсад нийт 194.741 хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас 152.737 компани буюу 80 орчим хувь нь компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна². Ийнхүү компанийн хэлбэрээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэх нь бизнес эрхлэгчдийн хувьд хөрөнгө оруулалт татах, санхүүжилт босгох, хязгаарлагдмал хариуцлага хүлээх зэрэг давуу талыг олгох боловч нөгөө талдаа компанийг удирдах, хөрөнгө болон хувьцаа шилжүүлэх, бизнесээ өөрчлөн байгуулах замаар өргөжүүлэх зэрэг нарийн төвөгтэй асар олон харилцааг дагуулдаг.

Тухайлбал, хуулийн этгээдийн буюу компанийн бүртгэлээс

¹ Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Форум ТББ-ын шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийх судалгааны төслийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд тус байгууллагын хамт олонд талархал илэрхийлье. Зохиогчид

² Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 1 дүгээр улирлын тоон мэдээ, <http://burtgel.gov.mn/post/38421> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов).

үүдэх маргааныг хувийн эрх зүйн маргааны хүрээнд иргэний хэргийн шүүхээр (ИХШ) шийдвэрлэх үү, эсхүл бүртгэл хийсэн төрийн байгууллагын чиг үүргийн хүрээнд үүссэн захиргааны акттай холбоотой захиргааны эрх зүйн маргаан хэмээн үзэж, захиргааны хэргийн шүүхээр (ЗХШ) шийдвэрлэх үү гэсэн асуудал хөндөгддөг.

Эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудын хувьд хуулийн этгээд буюу компанийн бүртгэлийг ямар байгууллага хариуцан гүйцэтгэж байгаагаас хамаараад, бүртгэлтэй холбоо бүхий маргааныг ямар шүүх харьяалан шийдвэрлэх тухай хоёр төрлийн хандлага түгээмэл байна. Үүнд: 1. Япон Улс болон манай улсын загвар болох төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага буюу бүртгэлийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага бүртгэлийг хариуцах загвар; 2. ХБНГУ-ын загвар болох шүүхийн байгууллага бүртгэлийг хариуцах юм³.

Манай улсын хувьд Япон Улстай адилаар хуулийн этгээдийн бүртгэлийг (ХЭБ) Засгийн газрын харьяа төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлдэг боловч бүртгэлийн байгууллага агуулгын хяналт (substantive examination) хийх үү, хэлбэрийн хяналт (formal examination) хийх үү гэдэг талаар эрх зүйн тодорхой зохицуулалт хийгээд онолын ойлголт бүрэн төлөвшин тогтоогүй билээ. Үүний улмаас компаниуд улсын бүртгэлд хадгалагдаж буй мэдээлэлд өөрчлөлт оруулах, шинээр үүсгэн байгуулах зэрэг ХЭБ хийлгэхэд тодорхойгүй асуудалтай алхам тутамдаа тулгарах, улмаар бүртгэл хийгдээгүйн улмаас бизнесийн үйл ажиллагаанд саад учрах, доголдол гарах зэрэг эрсдэл бий болж байна.

Өөрөөр хэлбэл, бүртгэлийн байгууллагын гаргасан шийдвэр болон шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаанаас үзвэл бүртгэл нь зөвхөн тодорхой эрхийг гэрчлэх зорилготой төрийн

³ 海老澤 毅 (2010) 「商業登記法」 法学書院、37頁.

байгууллагын эрх мэдэл хэмээн үздэг болохоос бизнесийн үйл ажиллагааг саадгүй, найдвартай явуулах хөшүүрэг гэж үздэггүйтэй шууд холбоотой. Тухайлбал, хуулийн этгээдийн болоод өмчийн эрхийн бүртгэл нь нийтийн эрх зүйн бус хувийн эрх зүйн суурьтай харилцаа гэдэг нэгдсэн ойлголтод хүрээгүй явж ирсэнтэй холбоотой хэмээн дүгнэж болно. Улмаар уг асуудал цаашид үргэлжилбэл эрх зүйн онолын хийгээд шүүхийн харьяалал хоорондын зөрчил үүсгэж, үүний үр дүнд иргэн, хуулийн этгээд, бизнес эрхлэгчийн эрх ашиг зөрчигдөхөд хүргэж болзошгүй.

Иймд ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяалал болон бүртгэлийн хяналтын чиг үүргийг оновчтой тодорхойлсноор ХЭБ-тэй холбоотойгоор ЗХШ-ээс ХЭБ-ийн маргааныг хууль зүйн үндэслэлтэйгээр шийдвэрлэх болон хувийн эрх зүйд хамаарах асуудлыг ЗХШ шийдвэрлэснээр гарч болох сөрөг үр дагаврыг арилгах замаар компанийн эрх зүйн маргааны харьяаллыг тодорхой болгож, бизнесийн маргааныг хоёр тусдаа шүүхээр шийдвэрлэн, талуудын хувьд нэмэлт хугацаа, зардлын чирэгдэл гаргахаас сэргийлэх боломж бүрдүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн, уг сэдвийн хүрээнд ХЭБ-ийн хүрээ дэх зөвхөн компанийн бүртгэлтэй холбогдох маргааныг авч үзэх бөгөөд бүртгэлтэй холбоо бүхий маргааныг шийдвэрлэж буй ЗХШ-ийн шийдвэрт дүн шинжилгээ хийнэ.

Энэхүү судалгааны зорилго нь ХЭБ, тухайлбал, компанийн бүртгэлтэй холбоо бүхий маргааныг шийдвэрлэж буй ЗХШ-ийн шийдвэр, магадлал, тогтоолд компанийн эрх зүйн үүднээс дүн шинжилгээ хийж, ЗХШ (дагнасан шүүх) болон ИХШ (ерөнхий харьяаллын шүүх)-ийн харьяаллын асуудал, өргөн утгаараа хувийн болон нийтийн эрх зүйн зөрчил компанийн эрх зүйн харилцаанд хэрхэн үүсэж байгааг тогтооход оршино.

Тухайлбал, олон нийтэд танил болсон нэг жишээ болох “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ОХУ-ын Роснефт компанийн эзэмшиж байсан 49 хувийн хувьцааг худалдсантай холбоо бүхий маргааныг дурдаж болно. Тодруулбал, тус маргаан нь ЗХШ, ИХШ, ЭХШ гэсэн гурван өөр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаа явагдсан бөгөөд 49 хувийн хувьцааг төрд шилжүүлэн авах тухай УИХ-ын тогтоолын талаар Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн цэцээр шийдвэрлэгдэж байсан билээ⁴.

Өөрөөр хэлбэл, бизнесийн үйл ажиллагааны нэг төрөл болох хувьцаа худалдах, худалдан авах харилцаа нь иргэн, захиргаа, эрүү, Үндсэн хууль гэх үндсэн дөрвөн салбар эрх зүйн маргааны шинжийг агуулах боломжтой юу, эсхүл үүнд ямар нэгэн салбар эрх зүй дундын холимог шинж бүхий харилцаа үүсээд байна уу гэдэгт эрх зүйн онолын үүднээс хариулах зайлшгүй шаардлагатай юм.

Тиймээс энэхүү судалгааны хүрээнд ЗХШ-ээр шийдвэрлэсэн ХЭБ-тэй холбоотой дараах төрлийн маргааныг гүнзгийрүүлэн судална. Үүнд:

- Компанийн тухай хуулийг хэрэглэж шийдвэрлэсэн маргаан;
- Компанийн дүрэм болон эрх олгосон бусад баримт бичгээр зохицуулсан харилцааг хуульд нийцсэн эсэхийг дүгнэсэн бүртгэгчийн үйлдэлтэй холбоо бүхий маргаан;
- Бичиг баримтын агуулгын зөрчлөөс үүдэн, бүртгэл хийхээс татгалзсан бүртгэгчийн татгалзалтай холбоо бүхий маргаан;

Харьцуулсан судалгааны хувьд манай улстай адил загвар

⁴ Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаартай “Монгол Улсын Их хурлын 2017 оны 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааны хянан шийдвэрлэсэн тухай” дүгнэлтээс дэлгэрүүлэн үзнэ үү. Тус хэрэгтэй холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэн явагдаж буй.

болох, бүртгэлийн чиг үүргийг төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлдэг Япон Улсын шүүхийн шийдвэр болон эрх зүйн зохицуулалтыг судаллаа. Тухайлбал, Япон Улсад компанитай холбоотой бүртгэлийг Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хуулиар⁵ зохицуулдаг бөгөөд тус хууль нь Арилжааны хуулийн тусгай хууль буюу хувийн эрх зүйн харилцаа дахь бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилго бүхий хууль гэж үздэг. Өөрөөр хэлбэл, дээр дурдсанчлан манай улсын хувьд ХЭБ-ийг төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг талаас нь нийтийн эрх зүйн харилцаанд хамааруулан авч үздэг бол угтаа бүртгэлийн асуудал (Үүнд: эд хөрөнгийн бүртгэл нэгэн адил хамаарна) нь өмчийн эрхийг баталгаажуулах, эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх хувийн эрх зүйн хэм хэмжээ гэж үздэг байна.

Энэхүү судалгааны хүрээнд зөвхөн ЗХШ-ийн шийдвэрт дүн шинжилгээ хийхээс гадна ХЭБ-ийн чиг үүрэг, онолын үндэслэлийг судлах бөгөөд харьцуулалтын хувьд ойлгомжтой байх үүднээс тухайн маргааныг шийдвэрлэсэн ерөнхий харьяаллын шүүх буюу ИХШ-ийн шийдвэрийг авч үзсэн болно.

Гэвч уг судалгаа нь ЗХШ-ээр шийдвэрлэгдсэн маргаанд дүн шинжилгээ хийхэд чиглэгдэж байгаа тул бүх маргааны ИХШ-ээр хэрхэн шийдвэрлэгдсэн талаар авч үзээгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Судалгааны арга зүйн хувьд тус судалгааг гүйцэтгэхдээ: 1. Баримт бичигт дүн шинжилгээ хийх буюу ЗХШ-ийн болон ИХШ-ийн тогтоол, магадлал, шийдвэрт дүн шинжилгээ хийх; 2. Харьцуулсан судалгааны арга буюу Япон Улс, ХБНГУ-ын компанийн бүртгэлтэй холбогдох хууль тогтоомж, шүүхийн шийдвэрийг харьцуулах арга замаар судаллаа.

⁵ 商業登記法 (Япон Улсын Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль), https://elaws.e-gov.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=338AC0000000125 (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 15-ны өдөр зочлов)

①. Баримт бичигт дүн шинжилгээ хийх буюу шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ shuukh.mn сайтаас 2015-2020 он хүртэлх сүүлийн таван жилийн хугацаанд шийдвэрлэсэн ЗХШ-ийн шийдвэрээс ХЭБ-тэй холбоотой компанийн эрх зүйн маргааныг шийдвэрлэсэн нийт долоон хэргийн шүүхийн шийдвэрийг сонгон авч, дүн шинжилгээ хийлээ. Өөрөөр хэлбэл, долоон хэрэгт холбогдох гурван шатны шүүхийн шийдвэр гэж үзвэл нийт 21 шүүхийн шийдвэр болох бөгөөд мөн Эрдэнэт үйлдвэрийн маргаантай холбогдох ИХШ-ийн гурван шатны шүүхийн шийдвэрийг оролцуулаад, нийт 24 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн болно.

Ингэхдээ 2015 онд Захиргааны ерөнхий хууль⁶, 2016 онд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)⁷, 2018 онд Улсын бүртгэлийн ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)⁸ болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (шинэчилсэн найруулга)⁹ батлагдсан хугацааг хамруулан, тус хуулиуд батлагдахаас өмнөх болон хойших хугацааны шүүхийн шийдвэрийг харьцуулан үзэхийг зорьж, 2015-2020 оны хоорондох шүүхийн шийдвэрээс сонголт хийсэн болно.

Түүнчлэн shuukh.mn нээлттэй цахим хаягаас 2015.01.01-2020.07.30-ны өдөр хүртэлх хугацаанд захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн “хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан” гэх түлхүүр үгээр хайлт хийвэл шүүхийн нийт 83 шийдвэр байна. Гэвч энэхүү тоо нь

⁶ <https://www.legalinfo.mn/law/details/11259?lawid=11259> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)

⁷ <https://www.legalinfo.mn/law/details/11703?lawid=11703> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)

⁸ <https://www.legalinfo.mn/law/details/13537?lawid=13537> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)

⁹ <https://www.legalinfo.mn/law/details/13591?lawid=13591> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)

100 хувь бүрэн гүйцэд, үнэн бодитой тоо баримт хэмээн үзэх боломжгүй болохыг дурдах нь зүйтэй бөгөөд shuukh.mn хаягийн хайлт нь тодорхой хэмжээний алдаатай болохыг харгалзан үзсэн болно. Нөгөөтээгүүр, дээрх 83 шүүхийн шийдвэрээс долоон шийдвэр, мөн ИХШ-ээр шийдвэрлэгдсэн шүүхийн нэг шийдвэрийг сонгон авч, дүн шинжилгээ хийсэн нь ХЭУБ-тэй холбоотой маргааны 10 орчим хувь болох юм.

②. Харьцуулсан судалгааны хүрээнд дээр дурдсан Япон Улсын Арилжааны бүртгэлийн тухай хууль болон Япон Улсын Дээд шүүхээс гаргасан Арилжааны бүртгэлийн 100 шийдвэрийн эмхэтгэл (商業登記先例判例百選)-ээс холбогдох шүүхийн шийдвэрийг сонгон авч судалсан бөгөөд мөн ХБНГУ-ын Арилжааны хууль болон компанийн бүртгэлтэй холбоотой зохицуулалтад дүн шинжилгээ хийв.



НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААРХ ЧИГ ХАНДЛАГА БА ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1.1 МОНГОЛ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС БА БҮРТГЭЛЭЭС ҮҮДЭХ МАРГААН

Өдгөө манай улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх нэгдсэн тогтолцоо байхгүй бөгөөд зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлээр хязгаарлагдаж байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан ашгийн төлөө хуулийн этгээд болох компани, нөхөрлөлийн хэлбэрээр бизнесийн буюу аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэдэг байна. Тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн (УБЕХ) 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо нь иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлээс бүрдэнэ” гэж заажээ.

Үүнээс үзэхэд иргэний бүртгэл нь иргэний төрсөн, нас барсан, шилжсэн, үрчилсэн, гэрлэсэн зэрэг хувь иргэнд чиглэсэн бол ХЭБ нь зөвхөн хуулийн этгээд хэлбэрээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотой бүртгэл хийдэг. Харин эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэл нь иргэн, хуулийн этгээд харгалзахгүйгээр бүртгүүлэх шаардлага хуулиар тавигдсан эд хөрөнгийг бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулдаг.

Манай орны хувьд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн

тухай анхны хууль (ХЭУБтХ) 2003 онд батлагдсанаас хойш нийт есөн удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, 2018 онд шинэчилсэн найруулгыг баталсан юм. Уг хууль нь найман бүлэг, 28 зүйлтэй бөгөөд Монгол Улсад хуулийн этгээд шинээр үүсэн байгуулагдсан, өөрчлөн байгуулагдсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бичгээр болон цахим хэлбэрээр бүртгэх, иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгох, улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Өөрөөр хэлбэл, манай улсын ХЭБ-ийн тогтолцоо нь төрийн байгууллагын бүртгэл хөтлөх үндсэн чиг үүргийг хуульчилсан нийтийн эрх зүйн шинж бүхий хууль юм. Угтаа хувийн эрх зүйн үүднээс бүртгэлийн асуудал бол бүртгэл хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналтын чиг үүргээс илүүтэй арилжааны эрх зүй дэх хэлцлийн баталгаатай байдал, шударга гуравдагч этгээдийн хэлцэлд итгэх итгэлийг хамгаалах зорилготой бөгөөд аж ахуй эрхлэгчийн бүртгэлээр дамжин, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгосноор аж ахуй эрхлэгчдийн хэлцэл баталгаат, түргэн шуурхай, найдвартай хийгдэх боломжийг олгодог ач холбогдолтой¹⁰.

Харин эсрэгээр нь ХЭБ-ийг хувийн эрх зүйгээс салган, дан ганц төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг мэтээр хэт явцууруулан ойлгож, бүртгэл хийх төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг хуульчлах замаар эрх зүйн зохицуулалтыг бий болгохыг оролдох нь бизнес эрхлэгчийн бүртгэлийн үндсэн зорилгыг гажуудуулан, зөвхөн хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулагдсанд тооцдог зарчмыг хэрэгжүүлэх механизм болж, түүнээс үүдэн гарах маргаан нь бизнесийг түргэн шуурхай, найдвартай явуулахад нь саад болох нөхцөлийг бүрдүүлдэг.

¹⁰ Ханс Зайделийн сан, Арилжаа (Худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны тайлан, 2018, 10 дахь тал.

1.2 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Онолын хувьд компанийн бүртгэлээс үүдэх маргааныг хувийн эрх зүйн маргааны хүрээнд ИХШ-ээр шийдвэрлэх үү, эсхүл төрийн байгууллагын чиг үүргийн хүрээнд үүссэн захиргааны акттай холбоо бүхий захиргааны эрх зүйн маргаан хэмээн үзэж, ЗХШ-ээр шийдвэрлэх үү гэсэн асуудал хөндөгддөг боловч үүнийг ямар байгууллага бүртгэлийг хариуцаж байгаагаас хамааран, бүртгэлийн хяналтын чиг үүргээр нь шүүхийн харьяаллыг тогтоох бөгөөд бүртгэлийн эрх зүйн үндэс суурь нь хувийн эрх зүй байхыг хүлээн зөвшөөрдөг.

Өөрөөр хэлбэл, зөвхөн хуулийн этгээдээр үл хязгаарлагдах аливаа эрх үүсгэх бүртгэл нь нэг талаас талуудын хоорондын хэлцэлд суурилсан буюу өмчлөх эрх үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгдсэн хэлцэл суурьтай харилцаа, нөгөө талаас тухайн хэлцлийг бүртгэх замаар хүчин төгөлдөр болгох зорилго бүхий бүртгэлийн байгууллагын оролцоо буюу төрийн захиргааны байгууллагын оролцоо гэсэн хоёр талт харилцааны огтлолцолд бий болдог онцлогтой харилцаа юм.

ХБНГУ-ын хувьд аж ахуйн нэгжийн бүртгэлийг шүүх хариуцдаг учраас бүртгэл хийх үедээ агуулгын хяналт болох маргаанаас урьдчилан сэргийлэх хяналтыг (ex-ante) хэрэгжүүлдэг бол Япон Улсын хувьд манайхтай адил гүйцэтгэх эрх мэдлийн харьяа бүртгэлийн байгууллага бүртгэдэг нь бичиг баримтын хэлбэрийн хяналтыг (ex-post) хийж, харин агуулгыг хянадаггүй. Өөрөөр хэлбэл, бүртгэхдээ бичиг баримт нь хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангасан эсэх, бүрдүүлбэр бүрэн гүйцэд эсэх, эрх бүхий этгээдийн шийдвэрээр баталгаажсан эсэх, гарын үсэг, тамга тэмдэг үнэн зөв эсэхийг шалгахад хангалттай бөгөөд агуулгын зөрчилдөөнөөс үүдэх маргаан нь нэгэнт хувьцаа эзэмшигч хоорондын маргаан болж хувирах тул

шүүхийн харьяаллын ямар нэгэн маргаан гардаггүй.

Манай улсын хувьд Япон Улстай адил тогтолцоотой боловч бүртгэлийн байгууллага агуулгын хяналт хийх үү, хэлбэрийн хяналт хийх үү гэдэгт тодорхой эрх зүйн зохицуулалт хийгээд онолын суурь ойлголт тогтоогүй юм. Өөрөөр хэлбэл, бүртгэлийн байгууллага болон шүүхийн шийдвэрээс үзвэл бүртгэл нь зөвхөн тодорхой эрхийг гэрчлэх зорилготой төрийн байгууллагын эрх мэдэл хэмээн үздэг болохоос бизнесийн үйл ажиллагааг саадгүй, найдвартай явуулах хөшүүрэг гэж үздэггүйтэй шууд холбоотой. Тухайлбал, хуулийн этгээдийн төдийгүй өмчийн эрхийн бүртгэл нь нийтийн эрх зүйн бус, хувийн эрх зүйн харилцаа гэдэг нэгдсэн ойлголтод хүрэлгүй явж ирсэнтэй холбоотой хэмээн дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, тодорхой эрх үүсгэх шинжтэй өмчлөх эрхийн болон хуулийн этгээдийн бүртгэл нь тухайн эрхийг үүсгэж буй үйлдэл бус, харин тухайн эрх нь хүчинтэй болохыг гэрчилж буй үйлдэл тул хувийн эрх зүйн харилцаа гэж үзнэ.

Үүний улмаас Улсын бүртгэлийн ерөнхий хуульд “бүртгэл нь үнэн зөв байх” гэсэн зарчмыг бүртгэлийн байгууллага болон шүүх хэт өргөжүүлэн тайлбарласнаар агуулга болон хэлбэрийн хяналтыг хийх болсноор компанийн бүртгэлтэй холбоотой гэсэн нэрийдлээр компанийн хувьцаа эзэмшигч хоорондын шинжтэй хувийн эрх зүйн маргааныг ч захиргааны хэргийн шүүх шийдвэрлэсэн тохиолдлууд гарч байна.

1.3 УЛСЫН БҮРТГЭГЧИЙН ЭРХ БУЮУ ХЭЛБЭР БА АГУУЛГЫН ХЯНАЛТ

ХЭБ-тэй холбоотойгоор ямар байгууллага тус бүртгэлийг хариуцан бүртгэдгээс хамаарч, улсын бүртгэгчийн хяналтын

эрх нь ялгамжтай байдаг. Эдгээрийг 1. Улсын бүртгэгчийн хэлбэрийн хяналт (formal examination) буюу процессын хяналт; 2. Агуулгын хяналт (substantive examination) буюу бодит хяналт хийх эрх гэж ангилдаг бөгөөд үүнээс хамаарч, тухайн бүртгэлийг хийх улсын бүртгэгчийн бүртгэлийн эрх хэмжээг тогтоодог.¹¹ Өөрөөр хэлбэл, улсын бүртгэгч бүртгүүлэхээр өргөдөл гаргасан иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийн материалыг хүлээн авч, бүртгэхдээ хэлбэрийн хяналт хийх үү, агуулгын хяналт хийх үү гэдгээс хамаарч, маргааны агуулга өөрчлөгддөг.

Тухайлбал, иргэн А болон Б нар хамтран, компани үүсгэн байгуулахаар тохиролцож, Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулан, компани бүртгүүлэхээр улсын бүртгэлд өргөдөл гаргажээ. Энэ тохиолдолд улсын бүртгэгч компани үүсгэн байгуулах материалыг хүлээн авч бүртгэхдээ хуульд заагдсан бичиг баримтууд бүрэн гүйцэд бөгөөд тэдгээрийг баталгаажуулсан гарын үсэг, тамга, тэмдэг нь үнэн зөв үү гэдгийг хянан бүртгэх нь хангалттай юу эсхүл А, Б нарын байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээ нь Иргэний хуульд заасан гэрээнд тавигдах шаардлагыг хангасан уу, компанийн дүрэм нь Компанийн тухай хуульд заасан зохицуулалтад харшлаагүй эсэхийг шалгасны үндсэн дээр бүртгэх ёстой юу гэдгийг дээрх улсын бүртгэгчийн хяналтын эрхээр тодорхойлдог.

Ийнхүү улсын бүртгэгчийн эрх хэмжээг тогтоосноор бүртгэгч ямар тохиолдолд бүртгэхээс татгалзах ёстой, бүртгэснээр эрх зүйн ямар үр дагавар үүсгэх вэ гэдгийг нарийвчлан тогтоож, тухайн хэрэг маргааныг хэргийн харьяаллын хувьд ерөнхий харьяаллын ба дагнасан шүүхийн аль нь шийдвэрлэх вэ гэдгийг тогтоодог. Тиймээс манай улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд улсын бүртгэгч агуулгын

¹¹ 松本 (2018年) 「会社法・商業登記全対象」、(Commercial Registration) 34頁.

хяналт хийх үү, эсхүл хэлбэрийн хяналт хийх үү гэдгийг хэрхэн зохицуулсныг авч үзье.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль (цаашид “УБЕХ” гэх)-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо нь улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүний орон нутаг дахь газар, хэлтэс, тасаг, улсын бүртгэлийн ажилтан, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газрын консулын ажилтнаас бүрдэнэ” гэж зааснаас үзвэл манай улсад бүртгэлийн үйл ажиллагааг Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага хэрэгжүүлдэг гэдэг нь тодорхой юм. Харин улс төрийн нам зэрэг тусгай шаардлагатай бүртгэлийг Улсын дээд шүүх бүртгэдэг боловч ХЭБ нь УБЕГ-т хамаарах бүртгэл юм. Бусад улс орнуудад бүртгэлийг гүйцэтгэх эрх мэдэл эсвэл шүүх эрх мэдэл хариуцдаг хэлбэрээс манай улс гүйцэтгэх эрх мэдэл хариуцдаг тогтолцоотой гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, энэ нь шууд утгаараа улсын бүртгэгч агуулгын хяналт хийх эрхгүй буюу шууд хэлбэрийн буюу процессын хяналтын эрхтэй байна гэдгийг илэрхийлнэ.

Үүнийг дэлгэрүүлэн үзвэл, УБЕХ-ийн 19 дүгээр зүйлд улсын бүртгэгчийн бүрэн эрхийг заасан бөгөөд үүний 19.4.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийн үнэн зөвийг холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас нотлох баримт, тайлбар, лавлагааг гаргуулан авч тогтоох”;

19.4.2-т “энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн төрлийн хүрээнд иргэн, хуулийн этгээдээс улсын бүртгэл хийлгэх тухай хүсэлт, нотлох баримтыг хүлээн авч хянан, улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах”;

19.4.3-т “энэ хуулийн 19.4.2-т заасан нотлох баримт нь зөрчилтэй, бүрэн бус, холбогдох хуулийн заалтыг зөрчсөн бол улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах” хэмээн заасан



нь ямартаа ч улсын бүртгэгч нотлох баримтад тулгуурлан, бүртгэлийг хийх эрхтэй болохыг тодорхойлжээ. ХЭБ-тэй холбоотойгоор нарийвчилсан хууль болох Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (ХЭУБтХ)-ийг үзвэл тус хуульд шинээр байгуулагдах хуулийн этгээд, өөрчлөн байгуулагдах хуулийн этгээд, татан буугдах хуулийн этгээд гэх мэт улсын бүртгэлд бүртгэлтэй мэдээлэлд өөрчлөлт орох зэрэгт ямар баримт бичиг бүрдүүлэх талаар нэг бүрчлэн заажээ. Уг хуульд нэг бүрчлэн бүртгэл хийхэд шаардлагатай материалыг ийнхүү заасан нь бүртгэл заавал нотлох баримтад үндэслэж хийгдэх зарчимд суурилсан гэдгийг илэрхийлнэ.

Харин тус хуулийн 18 дугаар зүйлд улсын бүртгэгч ямар тохиолдолд бүртгэл хийхээс татгалзах тохиолдлыг заасан бөгөөд 18.1.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу”;

18.1.2-т “үүсгэн байгуулах баримт бичиг энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй”;

18.1.3-т “өргөдөл гаргагч хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн” гэсэн гурван тохиолдлыг тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, дээрх гурван тохиолдлоос 18.1.1 болон 18.1.3-т заасан үндэслэл нь шууд хэлбэрийн хяналт буюу зөвхөн бичиг баримтын бүрдлийг хянан, бүртгэл хийх ёстой болохыг зааж буй бөгөөд харин 18.1.2-т заасныг хэрхэн ойлгохоос хамаарч, улсын бүртгэгч агуулгын хяналт хийх эрхтэй юү гэдгийг тодруулах шаардлагатай юм. Гэвч дээр дурдсанчлан бүртгэлийг захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэх тохиолдолд улсын бүртгэгч нь агуулгын буюу бодит хяналт хийх эрх байхгүйн зэрэгцээ тийм боломж ч байдаггүй.

Тухайлбал, ХЭУБтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 16.1, 16.2, 16.3-т заасан баримт бичгийг бүрэн гүйцэд

хүлээн авснаас хойш гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар ажлын 5 өдрийн дотор, бусад хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар ажлын 2 өдрийн дотор шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ” хэмээн бүртгэх тодорхой хугацаа заасан нь бүртгэлийг аль болох түргэн шуурхай гүйцэтгэх зарчимд үндэслэдэгтэй холбоотой.

Практик түвшинд авч үзвэл нэг бүртгэгчид өдөрт олон тооны бүртгэлийн өргөдөл ирсэн тохиолдолд бүртгэгч өргөдлийн тооноос үл хамаарч, бүх бүртгэлийг хуульд заасан хугацаанд бүртгэх шаардлагатай тул агуулгын хяналт хийх бодит боломж байхгүй юм. Харин шүүх бүртгэлийг хариуцах тохиолдолд агуулгын хяналт хийх боломжтой байдаг ба тухайн бүртгэлээс үүдэлтэй маргаан гарсан тохиолдолд мөн шүүх шийдвэрлэх буюу бүртгэл хийх субъект болон маргаан шийдвэрлэх субъект нь адил байдаг тул маргаан гарахаас урьдчилан сэргийлэх буюу ex-ante хяналт хийх боломжтой байдаг ажээ.

Иймд ХЭУБтХ-ийн 18.1.2-т заасан үүсгэн байгуулах баримт бичиг нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй гэдэг нь үүсгэн байгуулах баримт бичиг болох дүрэмд заавал тусгах ёстой шаардлагыг илэрхийлэх болохоос баримт бичгийн бүхий л агуулгыг хянан үзэх тухай зохицуулалт биш гэж тайлбарлах боломжтой байна. Үүнээс манай улсын ХЭУБ-тэй холбоотой улсын бүртгэгч нь зөвхөн хэлбэрийн хяналтыг хийх эрхтэй хэмээн үзэх нь улсын бүртгэлийн байгууллагын хувьд ч бүртгэлийн чиг үүргийг зохистой хэрэгжүүлэх, шүүхээс ХЭБ-тэй холбоотой маргааныг оновчтой шийдвэрлэх талаасаа ач холбогдолтой юм.

Иймд ХЭБ-ийг хийхдээ дээрх хоёр хандлагыг баримтлагч улсууд болох Япон, ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтын талаар дараах хэсэгт дэлгэрүүлэн авч үзье.

1.4. ЯПОН УЛС

Өмнө дурдсанчлан Япон Улсын хувьд хуулийн этгээдийн бүртгэлийг ашгийн төлөө этгээд болох компани, хувиараа арилжаа эрхлэгчийг Арилжааны хууль, Компанийн тухай хууль, Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хуулиар зохицуулдаг. Түүнчлэн эрх зүйн онолын хувьд хууль тогтоомж нь нийтийн эрх зүйн хэм хэмжээнд хамаарах уу, хувийн эрх зүйн хэм хэмжээнд хамаарах уу гэдгийг ерөнхий ба тусгай хуулийн харилцаагаар тогтоодог. Тухайлбал, хувийн эрх зүйн харилцааны суурь хууль (general law) Иргэний хууль бол түүний тусгай хууль (special law) нь Арилжааны хууль юм. Харин Арилжааны хууль нь арилжаа эрхлэгчид зориулсан ерөнхий хууль бол Компанийн тухай хууль болон Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль нь Арилжааны хуулийн тусгай хууль хэмээн үздэг.

Өөрөөр хэлбэл, дээрх хууль хоорондын эрэмбийн дарааллаас дүгнэвэл Арилжааны бүртгэл буюу компанийн бүртгэлийн хууль тогтоомж нь хувийн эрх зүйн тусгай хэм хэмжээ гэж үздэг байна. Тиймээс ч Арилжааны бүртгэлийн хуулийн зорилго буюу 1 дүгээр зүйлд “Тус хууль нь Арилжааны хууль, Компанийн тухай хууль болон бусад хуулийн заалтад үндэслэн, заавал бүртгүүлэх нөхцөлийг нээлттэй болгохтой холбоо бүхий бүртгэлийн системийг хуульчилснаар арилжааны нэр, компанитай харилцах итгэлийг хадгалах, мөн бизнесийн үйл ажиллагааг аюулгүй бөгөөд саадгүй явуулах зорилготой” хэмээснээс бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд зориулагдсан хууль гэдгийг нь тодорхой мэдэж болно.

Үүнээс үзэхэд манай улсын Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь

хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх, иргэн, хуулийн этгээд болон эрх бүхий байгууллага, албан тушаалтанд лавлагаа олгох, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан буюу илүү бүртгэлийн чиг үүрэг нь захиргааны шинжтэй болохыг тодорхой харж болно.

Япон Улсад арилжаа эрхлэгч гэдэгт хуульд зааснаар компани болон хувь этгээд хамаарах тул Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн систем нь бүх төрлийн үйл ажиллагаа явуулж буй компани болон хувиар бизнес эрхлэгчдийн бизнес эрхлэхэд чухал шаардлагатай нөхцөлийг бүртгэлд бүртгэж, нийтэд ил болгох зорилготой тогтолцоо бөгөөд ингэснээр арилжааны нэр, холбогдох мэдээллээр дамжин, арилжаа эрхлэгч хоорондын болон бусад этгээдийн итгэлцлийг хадгалах, хэлцэл аюулгүй бөгөөд саад бэрхшээлгүй явагдахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой.

Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн гол үүрэг нь “Нээлттэй, ил тод байх үүрэг” юм. Жишээ нь, хувьцаат компани бол худалдааны үйл ажиллагааны бүртгэлд компанийн нэр, үндсэн салбарын байршил, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хувьцааны нийт тоо хэмжээ, үндсэн хөрөнгийн дүн зэрэг олон мэдээллийг бүртгэдэг. Ерөнхийдөө шинээр худалдаа арилжаа эрхлэх гэж буй бол хамтрагч тань танай хуулийн этгээдийн бүртгэлийг үзээд, үйл ажиллагаагаа тогтвортой явуулж буй эсэх, компанийн эрх бүхий этгээд нь хэн болох, үндсэн салбар нь хаана байдаг зэрэг мэдээллийг олж авах боломжийг олгодог¹².

¹² 大塚英明（2008年）「商法総則 商行為法」第2版、91-94頁.

Хэрэв Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн тогтолцоо байдаггүй бол компани болон хувиараа бизнес эрхлэгчтэй хэлцэл хийх гэж буй этгээд нь худалдаа хийхийн өмнө тухайн этгээд үйл ажиллагаагаа бодитоор явуулж буй эсэх, эрх бүхий этгээд нь хэн болох, үйл ажиллагаагаа хаана явуулж буй зэрэг мэдээллийг судлах боломжгүй болж, ихээхэн хэмжээний зардал, цаг хугацаа зарцуулах шаардлага гарах учир шуурхай хэлцэл хийхэд хүндрэлтэй болдог.

Иймд Японд хэлцлийн аюулгүй байдал болон түргэн шуурхай байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн системийг бий болгож, бүртгэх ажиллагааг төрийн байгууллага болох улсын бүртгэлийн газар явуулж, хураамж төлсөн хэн бүхэн бүртгэлтэй холбоо бүхий мэдээллийг олж авахад нээлттэй болгосон байна.

Түүнчлэн Япон Улсын Арилжааны бүртгэлийн тухай хуульд компанийн бүртгэлтэй холбоо бүхий маш олон төрлийн бүртгэлийг нэг бүрчлэн заасан байхаас гадна бүртгэл тус бүрд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг нарийвчлан гаргасан байдаг. Харин бүртгэгчийн хяналтын эрхийг хуульд шууд тодорхой заагаагүй ч шүүхийн жишгээр бүртгэгч нь зөвхөн хэлбэрийн буюу бичиг баримтын бүрдүүлбэрийг хянан бүртгэх онолын ойлголт хэвшсэн байдаг.

Нөгөө талаар бүртгэлтэй холбоо бүхий процессын маргааны талаар хуульд нарийвчлан заагаагүй бөгөөд харин Арилжааны хууль болон Компанийн тухай хуульд бүртгэлийн эрх зүйн үр дагаврын талаар тодорхой зохицуулсан байдаг.

Арилжааны бүртгэлийн эрх зүйн үр дагаврын хувьд бүртгэл үнэн зөв байх зарчим үйлчлэх бөгөөд бүртгэлийн хүчинтэй байдлын талаар Арилжааны хууль, Компанийн тухай хуулиудад дараах байдлаар тусгажээ.

- Арилжааны хуулийн 9.1-д “Энэ бүлгийн заалтад үндэслэн бүртгэлд заавал бүртгүүлэх мэдээллийг бүртгүүлээгүй бол шударга гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах боломжгүй болно. Бүртгэл хийгдсэний дараа ч гуравдагч этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүртгэл байсныг мэдээгүй тохиолдолд мөн адил үйлчилнэ”.
- Компанийн тухай хуулийн 908.1-д “Энэ хуулийн заалтад үндэслэн бүртгэлд тусгах ёстой мэдээллийг бүртгүүлээгүй бол шударга гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах боломжгүй болно. Бүртгэлийн дараа ч гуравдагч этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүртгэл байсныг мэдээгүй тохиолдолд мөн адил үйлчилнэ” хэмээжээ.

Дээрх зохицуулалт нь бүртгэлд бүртгүүлэх ёстой мэдээллийг бүртгүүлэхгүй бол шударга гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргахгүй боломжгүй болох бөгөөд бүртгүүлсний дараа бол шударга гуравдагч этгээдэд ч гэсэн шаардлага гаргах боломжтой гэсэн үг юм. Үүнийг “Ил тод байх чадварын зарчим” хэмээн нэрлэдэг. Үүгээр арилжаа эрхлэгчтэй хэлцэл хийж буй гуравдагч этгээдийг хамгаалж буй хэрэг юм. Гэвч үүнд онцгой тохиолдол гэж байх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүртгэлийн талаар мэдээгүй гуравдагч этгээдэд хамаарахгүй. Энд заасан хүндэтгэн үзэх шалтгаан гэдэг нь газар хөдлөлт, уулын гал түймэр, салхи шуурга, усны аюул зэргийн улмаас бүртгүүлэх ажиллагаа хийгдсэн эсэхийг мэдэхийг хүсэвч мэдэх боломжгүй об’ектив нөхцөл байдлыг хэлнэ.

Тухайлбал, гүйцэтгэх захирал байсан этгээд уг албан тушаалаас буусныхаа дараа чөлөөлөгдсөн талаарх бүртгэл хийгдсэн байсныг үл харгалзан, гүйцэтгэх удирдлага хэмээн гуравдагч этгээдтэй хэлцэл хийсэн бөгөөд тус гуравдагч этгээд компанид хандан, хэлцэл хүчин төгөлдөр гэж маргасан хэрэг байдаг. Тус гуравдагч этгээд нь байнгын түншийн харилцаатай байсан тул хэлцэл хийх бүрд бүртгэлийг шалгадаггүй байснаас

гүйцэтгэх захирал мөн хэмээн итгэж, хэлцэл хийсэн маргаан юм. Тиймээс анх хэлцэл хийж буй этгээдийн хувьд эсрэг талынхаа бүртгэлд итгэж болохуйц байх боловч үргэлжилсэн буюу байнгын харилцаатай байх этгээдийн хувьд шинээр хэлцэл хийх бүрдээ бүртгэлийг нь нягтлах гэсэн төвөг чирэгдэл учруулах үр дүнг дагуулж байв.

Иймд сүүлийн үед бүртгэлтэй холбоо бүхий мэдээллийг цахим санд байршуулж, компанийн бүртгэлийн мэдээллийг харах бололцоотой болсноор өмнөх шиг бүртгэлтэй холбоотой төвөг чирэгдэл багассан гэж хэлж болох юм. Түүнчлэн, Арилжааны хууль, Компанийн тухай хуулийн бүртгэлийн хүчин төгөлдөр байдлын талаар дараах байдлаар заажээ.

- Арилжааны хуулийн 9.2-т “Санаатай болон болгоомжгүйгээр бодит бус мэдээллийг бүртгүүлсэн этгээд тус бүртгэлийг бодит бус гэдэг үндэслэлээр шударга гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах эрхгүй болно”; Компанийн тухай хуулийн 908.2-т “Санаатай болон болгоомжгүйгээр бодит бус мэдээллийг бүртгүүлсэн этгээд тус бүртгэлийн бодит бус гэдэг үндэслэлээр шударга гуравдагч этгээдийн эсрэг шаардлага гаргах эрхгүй болно” гэж заажээ.

Энэ нь бодит бус мэдээллийн бүртгэлд итгэсэн шударга гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах талаарх зохицуулалт бөгөөд жишээ нь, компани А-г гүйцэтгэх удирдлагаар бүртгэсэн боловч бодит байдалд А гэгч этгээд нь гүйцэтгэх захирал биш байсан тохиолдолд ч компани түүнтэй хэлцэл хийсэн шударга гуравдагч этгээдэд хандан, А нь гүйцэтгэх удирдлага биш хэмээн маргах боломжгүй болно гэсэн үг. Үүнийг “Итгэлцлийн зарчим” гэнэ.

Үүнээс гадна арилжааны үйл ажиллагааны бүртгэл нь эрх зүйн олон үр дагавар үүсгэх бөгөөд тухайлбал, дээр дурдсан Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд “Хувьцаат компани

нь үндсэн салбарынхаа байрших газар үүсгэн байгуулагдсан бүртгэлээ хийлгэснээр албан ёсоор үүсгэн байгуулагдсанд тооцогдоно” гэж заасан нь бүртгэл хийлгэх эрх зүйн харилцаа үүсгэх нөхцөл болсон бөгөөд ийм бүртгэлийг “Үүсгэн байгуулах чадвар бүхий бүртгэл” хэмээн нэрлэдэг.

Дээр дурдсан ёсоор Япон Улсын хувьд арилжааны бүртгэл нь хувийн эрх зүйн харилцаа гэж тооцогдох бөгөөд захиргааны байгууллага болох Хууль зүйн яам бүртгэлийг хариуцдаг байсан ч бүртгэгчийн хэлбэрийн хяналтын эрхийн зарчмаар бүртгэл хийхтэй холбоо бүхий маргаан бус, бүртгэл хийгдсэний дараах бүртгэлийн эрх зүйн үр дагаврыг хувийн эрх зүйн “ил тод байдлын зарчим” ба “итгэлцлийг хамгаалах зарчим”-ыг баримтлан шийдвэрлэдэг.

Харин бүртгэгчийн бүртгэл хийхээс татгалзсан татгалзалтай холбогдох маргааныг ИХШ нь захиргааны маргааны журмаар хянан шийдвэрлэдэг. Учир нь бүртгэгч хэлбэрийн хяналт хийх эрхийн хүрээнд үнэн зөв хэмээн итгээд, бүртгэл хийсэн бол түүнээс хойших маргаан нь бүртгэлтэй холбоотой бус, бүртгэлд бүртгүүлсэн мэдээлэл, баримт бичгийн агуулгатай холбоотой хувьцаа эзэмшигч, компани хоорондын маргаан болдог бөгөөд бүртгэл хийхээс татгалзах үйлдэл нь бүртгэгчийн үйлдэлтэй шууд холбоотой учраас захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчилдэг. Иймд Япон Улсад гарсан бүртгэлийн маргааны шүүхийн харьяалал болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар жишиг болсон шүүхийн шийдвэрийг танилцуулъя.

Тохиолдол 1¹³

“А” ХХК-ийн дүрэмд зааснаар “Компанийн гишүүн нь компаниас гарах тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчийн олонхын саналаар шийдвэрлэнэ” гэсний дагуу компанийн бүх гишүүдийн хурлаар компанийн гишүүн Б-г компаниас хассан шийдвэр гаргаж, шийдвэр, дүрмийн хамт бүртгэлийн газарт хүсэлтээ өгч, улсын бүртгэгч бүртгэсэн шийдвэр гаргажээ.

Гэтэл компанийн гишүүн Б нь өөрийг нь компанийн гишүүнээс хассан шийдвэр болон компанийн дүрмийн заалт нь Арилжааны хууль 147 дугаар зүйлд үндэслэн, тус хуулийн 86 дугаар зүйлийн 86.1-д заасан “Компанийн бүртгэлээс хасах үндэслэл, журам”-ын тухай заалтыг зөрчсөн тул бүртгэлийг хүчингүй болгуулахаар захиргааны хэргийн журмаар нэхэмжлэл гаргаж, шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэжээ.

Ингээд “А” ХХК-ийн гишүүн Д-ийн гаргасан гомдлын дагуу Токио хотын орон нутгийн шүүх хэлэлцээд, дараах шийдвэрийг гаргажээ.

1. Улсын бүртгэгч зөвхөн хуульд заасан бичиг баримтыг шалгаж үзээд, бүртгэл хийх буюу хэлбэрийн хяналтын эрх эдлэх бөгөөд бичиг баримтын агуулга хуульд нийцсэн эсэх талаар аливаа агуулгын хяналт хийх эрх эдлэхгүй.
2. Тиймээс улсын бүртгэгч нь дээр дурдсан компанийн гишүүнээс хассан бүртгэл хийсэн нь хуульд нийцсэн байна.
3. Шүүх Б-ийн нэхэмжлэлээр бүртгэлийг хүчингүй

¹³ 高野 修 (2002) 「行政判例研究」 『アルテスリバラレス 岩手大学人文社会科学部紀要』 127-137頁.

болгосон нь буруу бөгөөд энэ нь шүүхээс улсын бүртгэгчийг агуулгын хяналт хийж татгалзах ёстой байсан мэтээр дүгнэлт хийсэн нь бүртгэгчийг агуулгын хяналт хий гэснээс ялгаагүй юм.

4. Хэрэв дүрэм нь хуульд нийцээгүй гэж үзвэл компанийн гишүүд компанийн эсрэг нэхэмжлэл гаргаж, дүрмийг хүчингүй болгуулах ёстой болохоос захиргааны журмаар шийдвэрлэх маргааны тухайд шүүх дүгнэлт өгөх эрхгүй.

Токио хотын орон нутгийн шүүх. Хэйсэй 10 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн шийдвэр.

Дээрх шүүхийн жишгээс харахад, компанийн буюу хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоо бүхий маргааныг захиргааны хэргийн журмаар шийдвэрлэхдээ зөвхөн улсын бүртгэгчийн хэлбэрийн хяналт хийсэн үйлдэл нь хууль ёсны эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх ёстой гэж үзсэн байна. Харин бүртгэлийн дараах эрх зүйн үр дагаврыг үндэслэж, эрх ашиг нь зөрчигдсөн бол тухайн дүрэм, компанийн гаргасан шийдвэрийг хүчингүй болгуулах замаар иргэний журмаар маргааныг шийдвэрлэх тухай заажээ. Өөрөөр хэлбэл, эрх ашгийг зөрчсөн болон эрх ашиг нь зөрчигдсөн тал ижил тэгш эрхтэйгээр иргэний шүүхэд тухайн маргаанаа таслуулснаар тухайлбал, шүүхээс дүрэм нь хууль зөрчсөн гэж үзвэл түүнд үндэслэн, бүртгэлд өөрчлөлт оруулах процесс ажиллагаа явагдах ёстой.

1.5. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Герман Улсын хувьд анхны арилжааны бүртгэлийн тогтолцоо нь 1861 оны Арилжааны хуулийн 12-14 дүгээр зүйлд заас-

наар зохицуулагдаж байжээ. Тус зүйлүүд нь арилжааны бүртгэлийг шүүх хариуцан бүртгэх, арилжааны бүртгэлд бүртгэгдсэн мэдээллийг нийтэд ил болгохтой холбоо бүхий суурь зохицуулалтыг агуулж байсан бөгөөд харин нарийвчилсан процессын асуудлыг мужийн хуулиудаар зохицуулж байв. Одоогийн арилжааны бүртгэлийн зохицуулалт нь ч Арилжааны хуулийн 8 дугаар зүйлээс хойших заалтуудад тусгагдсан бөгөөд ерөнхий зохицуулалтуудыг агуулах ба Компанийн тухай хуулийн тусгай зохицуулалт зэргээр зохицуулдаг.

Арилжааны хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар арилжааны бүртгэлийг шүүхийн байгууллага хариуцан хөтлөх бөгөөд үүнийг Шүүхийн тухай хуулийн (Gerichtsverfassungsgesetz) 23 дугаар зүйлд зааснаар мужийн болон дүүргийн шүүхүүд холбогдох харьяаллын дагуу хөтлөн явуулдаг.

Арилжааны бүртгэлийн эрх зүйн үр дагаврын талаар Арилжааны хуулийн 15 дугаар зүйлд зохицуулжээ. Тус зүйлийн 1 дүгээр хэсэгт “Бүртгүүлээгүй болон нийтэд мэдээлээгүй нөхцөлийн талаар бүртгүүлэх үүрэгтэй этгээд нь шударга гуравдагч этгээдийн эсрэг эсэргүүцэх боломжгүй”; 2 дугаар хэсэгт “Хэрэв арилжааны бүртгэлд бүртгүүлсэн, нийтэд мэдээлсэн бол тухайн үйл баримтын талаар хэний ч эсрэг эсэргүүцэх зарчим”; 3 дугаар хэсэгт “хэрэв худал мэдээлэл бүртгүүлсэн бол гуравдагч этгээд тухайн мэдээлэлд үндэслэн эсэргүүцэх эрхтэй” байхаар тусгасан байна. Ерөнхийдөө бүртгэлийн эрх зүйн үр дагавар нь Япон Улстай адил ямар ч бодит мэдээллийг бүртгүүлээгүй бол гуравдагч этгээдийн эсрэг эсэргүүцэх боломжгүй, харин бүртгүүлсэн бол бүртгэлээр эрхээ хамгаалах боломжтой зарчмуудыг тусгажээ.

Түүнчлэн шүүхээс бүртгэлийг цахим хэлбэрээр хийдэг болсноор бүртгэлийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй ил тод, танилцах боломжтой байдлаар байршуулдаг.

Харин бүртгэлийн талаар шүүхээс хийх хяналтын эрхийн талаар Хувьцаат компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд “Компани хуульд заасныг дагуу үүсгэн байгуулагдсан, өргөдөл гаргасан талаар шалгах үүрэгтэй. Хуульд нийцээгүй бол шүүх бүртгэхээс татгалзах ёстой” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, Германы шүүхийн жишиг болон эрх зүйн онолын тайлбараар бүртгэл хариуцсан шүүгч (Registerrichter) нь зөвхөн хэлбэрийн хяналтаас гадна агуулгын хяналт хийх эрхтэй хэмээн үздэг бөгөөд тус агуулгын хяналт нь бодит байдлыг тогтоох, эрх зүйн харилцаа үүссэн эсэх, хүчин төгөлдөр байдал зэрэг өргөн хүрээтэй хяналт хийх эрхтэй гэсэн үг юм¹⁴.

Өөрөөр хэлбэл, агуулгын хяналт хийх дээрх эрх нь манай улсын болон Япон Улсын бүртгэлийн тогтолцооноос ялгарах гол онцлог шинж бөгөөд шүүх агуулгын хяналт хийснээрээ бүртгэлтэй холбоо бүхий маргаан гарахаас урьдчилан сэргийлэх хяналт буюу ex-ante хяналтыг хэрэгжүүлдэг гэж үздэг.

Гэхдээ шүүх бүртгэлийн үйл ажиллагааг хариуцах нь хэт хуучирсан буюу орчин үед нийцэхгүй хэмээн үздэг судлаачид байдаг бөгөөд арилжааны бүртгэлийн чиг үүргийг Худалдаа, аж үйлдвэрийн танхимд шилжүүлэх ёстой гэсэн шүүмжлэлүүд гарах нь бий.

¹⁴ 公益財団法人商事法務研究会（平成28年1月） 「外国法制等の調査研究業務の報告書」 『ドイツの商業登記制度』、184頁.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛЭЭС ҮҮДЭХ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны багийн зүгээс энэхүү судалгааны хүрээнд 2015-2020 оны хооронд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой ЗХШ-ээс шийдвэрлэгдсэн нийт долоон хэрэгт хамаарах 21 шийдвэр, магадлал, тогтоол, ИХШ-ийн нэг хэрэгт хамаарах шийдвэр, магадлал, тогтоол нийт 24 шүүхийн шийдвэрийг сонгон судаллаа. Ингэхдээ хэргийн нэн төвөгтэй байдал болон маргааны агуулга ойролцоо боловч шийдвэрийн үндэслэл, дүгнэлт ялгаатай, түүнчлэн маргааны талаар олон нийтийн анхаарал татсан томоохон компаниудад холбогдох хэргийг түүвэрлэн, дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

Ингээд дээр дурдсан шүүхийн 24 шийдвэрийн хүрээнд ХЭБ-ийн маргааныг ЗХШ-ээр шийдвэрлэхэд үүсэж буй нийтлэг асуудлуудыг дэд сэдэв болгон тус бүрд нь задлан үзэв.

2.1. УЛСЫН БҮРТГЭГЧИЙН ХЯНАЛТЫН ЭРХ БА БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ

Өмнөх хэсэгт ХЭБ-тэй холбоотой улсын бүртгэгч нь зөвхөн хэлбэрийн хяналтыг хийх эрхтэй байж болох талаар тодорхой тайлбарласан билээ.

Харин улсын бүртгэлийн болон шүүхийн практикт улсын бүртгэгч бүртгэл хийх хяналтын эрхээ хэт өргөжүүлэн тайлбарлах замаар агуулгын хяналтыг хийх гэж оролдох, нөгөө талаар шүүхээс улсын бүртгэгчийг бүртгэл хийхдээ агуулгын хяналтыг давхар хийх ёстой зэргээр дүгнэж шийдвэрлэх тохиолдол гарсаар байна. Тухайлбал, Тохиолдол 1-д энэ талаар хэрхэн шийдвэрлэснийг авч үзье.

Тохиолдол 1¹⁵

Нэхэмжлэгч Л.Б нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгчийн 2017 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 31 дүгээр “Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан мэдэгдэл” хууль бус болохыг тогтоож, “И” ХХК-ийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 16/02 тоот хувьцаа эзэмшигчдийн тогтоолын дагуу Ч.Б-г гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, Ч.М-г гүйцэтгэх захирлаар томилон, компанитай холбогдох утасны дугаарыг 99005482 болгосон хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээнд бичилт хийхийг УБЕГ-т даалгах шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Учир нь нэхэмжлэгч Компанийн тухай хуулийн 61.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд ХЭЭБХ-ийг зарлан хуралдуулж, компанийн гүйцэтгэх захирлыг өөрчлөх шийдвэр гарган, ХЭУБтХ-д заасан шаардлагатай бичиг баримтын хамт бүртгүүлэхээр өгсөн боловч улсын бүртгэгч КтХ-

¹⁵ Л.Б нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 128/ШШ2019/0033 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 221/МА2019/0166 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 163 дугаар тогтоолтой захиргааны маргаан.

ийн 60-63 дугаар зүйлд заасан шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр бүртгэл хийхээс татгалзаж шийдвэрлэжээ. Энэ нь “...Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн (2009) 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6-д заасныг зөрчиж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2015)-ийн 23 дугаар зүйлийн 23.1-д зааснаас өөр ямар бичиг баримт шаардаад буй нь ойлгомжгүй, үүгээрээ тус хуулийн 23.2-д заасныг зөрчиж байна. Мөн Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4.2-т зааснаас бусад баримт бичгийг шаардах үндэслэлгүй” гэснийг зөрчиж байна хэмээн нэхэмжлэгч үзжээ.

Анхан шатны шүүх:

Шүүхээс “захиргааны байгууллагаас уг асуудлаар дахин шинэ акт гаргах хүртэл Улсын бүртгэгчийн 2017 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 31 дүгээр “Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан мэдэгдэл”-ийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэх нь зүйтэй байна” хэмээн үзэж, улсын бүртгэгчийн татгалзлыг түдгэлзүүлж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүх:

Хэрэгт авагдсан баримтууд болон хэргийн оролцогчдын тайлбараас үзвэл “И Н” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн ээлжит бус хурлыг хуралдуулах мэдэгдлийг гуравдагч этгээд Ч.Б хүлээн авсан эсэхийг тогтоосноор хариуцагчийн татгалзсан мэдэгдэл хуульд нийцсэн эсэхийг хянах боломж бүрдэхээр байна.

Гэтэл анхан шатны шүүхээс маргаан бүхий татгалзлын гол үндэслэл болсон дээрх мэдэгдлийг гуравдагч этгээд Ч.Б хүлээн авсан эсэх үйл баримтыг хөдөлбөргүй

тогтоогоогүй нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй...”; 32 дугаар зүйлийн 32.1-д “Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчсөн байна хэмээн үзээд, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хянуулахаар анхан шатны шүүхэд буцаахаар шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүцх:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (2015) хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг... (улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, ...үүсгэн байгуулах баримт бичиг энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй, ...өргөдөл гаргагч хууль тогтоомжид заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлснийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон) тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах”-аар заасан, тухайн тохиолдолд, нэхэмжлэгчээс “И Н” ХХК-ийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр өргөдөл гаргахдаа Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (2015) хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д тусгайлан заасан баримт бичгүүдийг бүрэн бүрдүүлсэн, өргөдөл гаргагчийн бүрдүүлэн ирүүлсэн баримт бичгүүд нь “хуурамч, эсхүл хуурамчаар бүрдүүлснийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон” гэх асуудлаар маргаагүй,

түүнчлэн тус компанийн “үүсгэн байгуулах баримт бичиг нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй” гэж үзэх үндэслэлгүй байна хэмээх үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

Түүнчлэн Хяналтын шатны шүүхийн тогтоолд: “И н” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хурал, уг хурлаар хэлэлцсэн асуудлууд, гаргасан шийдвэр нь “компанийн тухай хуульд нийцсэн эсэх”, хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх асуудлыг захиргааны хэргийн шүүх дүгнэхгүй, уг асуудлаар хувьцаа эзэмшигч Ч.Б иргэний шүүхэд хандаж, гомдол нэхэмжлэл гаргах эрхтэй, ийнхүү иргэний шүүхэд маргасан талаарх болон эрх бүхий этгээдээс тогтоосон “...баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн” талаарх баримтгүй байхад уг асуудлыг “хянах”, “дүгнэлт хийх” эрхийг улсын бүртгэлийн байгууллагад хуулиар олгоогүй, өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг “хүчин төгөлдөр эсэх” талаар аливаа сонирхогч этгээдээс иргэний шүүхэд маргаагүй, уг тогтоол хүчин төгөлдөр байхад хариуцагч улсын бүртгэгч хувьцаа эзэмшигчдийн хурлын уг тогтоолыг “...хуульд нийцээгүй, хүчин төгөлдөр бус” гэх үндэслэлээр бүртгэхээс татгалзсан нь хууль бус гэж үзнэ” гэсэн маш чухал дүгнэлтийг хийсэн байна.

Хяналтын шатны шүүхийн дээрх дүгнэлт нь улсын бүртгэгч нь зөвхөн хуульд заасан баримт бичгийн хүрээнд хяналт хийх буюу хэлбэрийн хяналтыг хийх эрхтэй бөгөөд аливаа байдлаар агуулгын хяналт хийх боломжгүй гэдгийг тодотгосон ач холбогдолтой шийдвэр болжээ.

Харин агуулгын хяналт хийх замаар бүртгэл хийхээс татгалзсан улсын бүртгэгчийн үйлдлийг анхан шатны болон давж заалдах шатны шүүхүүд буруутгаагүйгээс гадна давж заалдах шатны шүүх Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмыг баримталсан эсэхийг буюу хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүрсэн эсэх, зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулсан байх ёстой хэмээн дүгнэсэн нь улсын бүртгэгч хэлбэрийн бус, агуулгын хяналтыг хийх ёстой гэсэнтэй адил утга бүхий дүгнэлт болсон байна.

Түүнчлэн хяналтын шатны шүүхийн тогтоолд заасан *“хувьцаа эзэмшигчдийн ...хурал, уг хурлаар хэлэлцсэн асуудлууд, гаргасан шийдвэр нь “компанийн тухай хуульд нийцсэн эсэх”, хувьцаа эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн эсэх асуудлыг захиргааны хэргийн шүүх дүгнэхгүй”* гэсэн дүгнэлт нь ХЭБ-тэй холбоотой маргааныг ИХШ шийдвэрлэх үү, ЗХШ шийдвэрлэх үү гэдэгт чухал хариулт өгсөн дүгнэлт юм. Тодруулбал, ерөнхий харьяаллын шүүх буюу ИХШ нь иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн хувийн эрх зүйн шинжтэй маргааныг харьяалан шийдвэрлэх бол дагнасан шүүх буюу ЗХШ нь захиргааны байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдсэнтэй холбоо бүхий маргааныг харьяалан шийдвэрлэдэг.

Гэтэл ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд дээр дурдсанчлан ерөнхий харьяаллын шүүх болон дагнасан шүүхийн харьяаллын асуудал үүсдэг шалтгаан нь улсын бүртгэгчийн бүртгэл хийхээс татгалзсан татгалзал, эсхүл хийсэн бүртгэлийн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг хохирсон гэж үзэх үү, эсрэгээрээ тухайн бүртгэлээс үл хамаарч, компанийн дүрэм болон үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт оруулсан хувьцаа эзэмшигчийн үйлдлийн

улмаас бусад иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдөж байна уу гэдгийг нарийвчлан ялган зааглах нь дээрх маргаанд хариулт өгөх гол үндэслэл болно.

Тиймээс хяналтын шатны шүүхийн дээрх дүгнэлтийг багцлан үзвэл 1. Улсын бүртгэгч зөвхөн хэлбэрийн буюу процессын хяналт хийх эрхтэй; 2. Хэлбэрийн хяналт хийсний үндсэн дээр бүртгэлтэй холбоо бүхий маргаан гарвал ЗХШ зөвхөн тухайн бүртгэгчийн үйлдэл, эс үйлдэлтэй холбогдох хэсгийг хянана; 3. ЗХШ бичиг баримтын агуулга нь бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дүгнэхгүй бөгөөд тухайн асуудал нь хувьцаа эзэмшигч хоорондын иргэний эрх зүйн шинжтэй маргаан тул иргэний шүүхэд харьяалагдана гэсэн дүгнэлт хийсэн нь ХЭБ-ийн маргааны харьяаллын асуудалд хариулт өгсөн чухал ач холбогдолтой хэмээн дүгнэх үндэслэл юм.

Гэвч хяналтын шатны шүүхийн дээрх дүгнэлт нь бусад хэрэг маргааны хувьд жишиг болоогүй буюу ижил төсөөтэй бусад маргаанд өөр өөр байдлаар шийдвэрлэгдэх тохиолдол цөөнгүй гарсаар байна. Тиймээс дараа дараагийн тохиолдолд шүүх ямар байдлаар дүгнэлт гаргасныг авч үзэх болно.

2.2. УЛСЫН БҮРТГЭГЧИЙН ХЭЛБЭРИЙН ХЯНАЛТ БА ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АГУУЛГЫН ХЯНАЛТ

Тохиолдол 2¹⁶

Нэхэмжлэгч “АМ” ХХК-ийн шинээр гаргасан хувьцааны бүртгэлийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан УБЕГ-

¹⁶ “АМ” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 767 дугаар тогтоол бүхий захиргааны маргаан.

ын ХЭБГ-ын улсын бүртгэгчийн шийдвэрийг хүчингүй болгож, улмаар холбогдох бүртгэл хийхийг УБЕГ-ын ХЭБГ-т даалгах тухай нэхэмжлэлтэй маргаан байна.

Маргааны үйл баримтын хувьд “АМ” ХХК-ийн 49 хувийн хувьцаа эзэмшигч бөгөөд гүйцэтгэх захирал З.Н нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, компани хувьцаа нэмж гаргах замаар хөрөнгө оруулалт хийсэнтэй холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр өргөдөл гаргасан ч улсын бүртгэгчийн зүгээс бусад хувьцаа эзэмшигч хуралд оролцоогүй тул хурлын зар хүлээн авсан баримт байхгүй, нэмж гаргасан хувьцааг худалдан авах бусад хувьцаа эзэмшигчийн давуу эрхийг нь эдлүүлээгүй гэсэн үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан байна.

Харин Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс маргааныг шийдвэрлэхдээ шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “нэхэмжлэгч “АМ” ХХК-ийн гүйцэтгэх удирдлагын зүгээс КтХ-ийн 61.9, 65.1, 65.2, 69.3, 69.6, 69.5 зэрэг холбогдох заалтуудад үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулсан, мөн КтХ-ийн 38.2, 38.3-т заасны дагуу хувьцаа шинээр нэмж гаргасан учир улсын бүртгэлд бүртгэх үндэслэлтэй байна” гэж дүгнэж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна.

Тохиолдол 2-т заасан шүүхийн шийдвэрийн хувьд Тохиолдол 1-д заасан шүүхийн шийдвэртэй адил улсын бүртгэгчийн бүртгэл хийхээс татгалзсантай холбогдох маргааныг шийдвэрлэсэн захиргааны маргаан юм. Улсын бүртгэгчийн хувьд өмнөхтэй адилаар бүртгэл хийлгэхээр өргөдөл гаргагч нь ХЭБТХ-д заасан бүхий л шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн өгсөн хэдий ч хувьцаа эзэмшигчдийн хурал зохих

журмын дагуу хийгдсэн эсэх, нэмж хувьцаа гаргахдаа бусад хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлсэн эсэх гэх мэт хуульд заагдаагүй баримт бичгийг шаардаж, бүртгэл хийхээс татгалзжээ. Өөрөөр хэлбэл, улсын бүртгэгчдийн хувьд зөвхөн бүртгэл хийхдээ хэлбэрийн хяналт хийх эрхээс гадна агуулгын хяналт хийх эрхтэй хэмээн ойлгож, бүртгэл хийхээс татгалзах явдал түгээмэл байдаг нь дээрх шийдвэрүүдээс харагдаж байна. Харин Тохиолдол 2-ыг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг дүгнэн үзвэл бүртгэгчийн татгалзал нь хууль бус болохыг тогтоож, бүртгэл хийлгэхийг даалгаснаараа улсын бүртгэгчийн буруутай үйлдлийг залруулан, нэхэмжлэгчийн эрх ашгийг сэргээн тогтоосон ач холбогдолтой.

Гэвч шүүхийн шийдвэрээс анхаарал татаж буй асуудал нь ЗХШ-ээс ХЭБ-тэй холбогдох маргааныг шийдвэрлэхдээ улсын бүртгэгчийн хэлбэрийн хяналт хийх эрхийн хүрээнд маргааныг шийдвэрлэх үү, эсхүл шүүх өөрөө агуулгын хяналтыг хийж, маргааныг шийдвэрлэх үү гэдэгт оршино. Өөрөөр хэлбэл, хэрэв ЗХШ хэлбэрийн хяналт хийнэ гэж үзвэл улсын бүртгэгчийн захиргааны акт гаргах үйл явц болон эс үйлдэхүй нь нэхэмжлэгчийн эрх ашгийг зөрчсөн хүрээнд хянах бол агуулгын хяналт хийнэ гэж үзвэл нэхэмжлэгчийн үйлдэл яагаад хуульд нийцсэн буюу бүртгэгчийн үйлдэл хуульд нийцээгүй болохыг материаллаг хуулийн хэм хэмжээг хэрэглэн тогтоох шаардлагатай.

Тиймээс Тохиолдол 2-ыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг задлан үзвэл шүүх нь улсын бүртгэгчийн татгалзлыг үгүйсгэхдээ КтХ хуулийн материаллаг хэм хэмжээг баримтлан, нэхэмжлэгчийн үйлдлийг зөвтгөсний үндсэн дээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна. Тодруулбал, ЗХШ-ээс нэхэмжлэгч нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахдаа КтХ-ийг ягштал дагаж

мөрдсөн, хувьцаа нэмж гаргахдаа бусад хувьцаа эзэмшигчид мэдэгдсэн боловч бусад хувьцаа эзэмшигч ямар нэгэн хариу ирүүлээгүй тул нэхэмжлэгчийн шийдвэр хуульд нийцсэн гэж үзжээ. Зарчмын хувьд КтХ нь хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага зэрэг компанийн удирдлага, өмчлөгчийн хоорондын эрх зүйн харилцааг зохицуулдаг хувийн эрх зүйн шинжтэй хууль тул ЗХШ буюу дагнасан шүүх ийнхүү хувьцаа эзэмшигчийн үйлдэл хуульд нийцсэн гэдгийг тогтоож, улсын бүртгэгчийн үйлдлийг буруутгах боломжгүй ба харин шүүхээс нэхэмжлэгч нь УБЕХ болон ХЭУБтХ-д заасан бүрдүүлбэр хангаад байхад агуулгын хяналт хийх замаар татгалзаж буй улсын бүртгэгчийн үйлдэл хууль бус болохыг тогтоох ёстой.

Өөрөөр хэлбэл, компанийн доторх шийдвэр хуульд заасан журмын дагуу гарсан эсэх, бусад хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг хөндсөн эсэх нь хувьцаа эзэмшигч ба хувьцаа эзэмшигч, компани ба хувьцаа эзэмшигч гэсэн иргэн, хуулийн этгээдийн хоорондын шинжтэй хувийн эрх зүйн харилцаа тул ерөнхий харьяаллын шүүхийн шийдвэрлэх маргаанд хамаарах ёстой.

2.3. ЗАХИРГААНЫ ШҮҮХ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААНД ДҮГНЭЛТ ӨГӨХ НЬ

Дараагийн тохиолдолд улсын бүртгэгч ХЭБ хийсэнтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг авч үзье. Тус маргаан нь мөн л анхан, давж заалдах, хяналтын шат гэсэн гурван шатны шүүхээр шийдвэрлэгдсэн маргаан бөгөөд эдгээрээс хамгийн сонирхол татсан хэсэг болох Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг тодруулан үзье.

Тохиолдол 3¹⁷

Нэхэмжлэгч “ГГ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Б-ийн УБЕГ-ын ХЭБГ-т холбогдуулан гаргасан Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэсэн улсын бүртгэл болон Компанийн хувьцаа шилжүүлсэнтэй холбоотой бүртгэлийг хүчингүй болгох нэхэмжлэлтэй маргаан байна.

Анхан шатны шүүх:

Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэсэн улсын бүртгэл хуульд нийцсэн боловч хувьцаа шилжүүлэхтэй холбоотой улсын бүртгэл хүчингүй байна гэсэн шийдвэр гаргажээ.

Давж заалдах шатны шүүх:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ. Ийнхүү шийдвэрлэсэн хууль зүйн үндэслэлийг тодруулбал:

- Хэдийгээр ХЭУБтХ-д заасан баримт материалуудыг гуравдагч этгээд хүсэлтдээ хавсарган өгсөн боловч бүртгэлийн байгууллага нь зөвхөн дурдсан бичиг баримт байна гэж хэлбэр талаас нь хандах биш, уг хавсаргасан материалууд хуульд нийцсэн эсэх, бүртгэлийн болон Захиргааны ерөнхий хууль зөрчсөн эсэхийг нягталж үзсэний үндсэн дээр шийдвэр гаргах ёстой.
- Компанийн дүрмийн холбогдох заалтууд нь Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн эрхийг

¹⁷ Б.Б-н нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2018/0413 тоот шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 221/МА2018/0491 тоот магадлал, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 476 тоот тогтоолтой захиргааны хэрэг.

зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. Тухайлбал, “Г” ХХК-ийн дүрмийн 6.3, Компанийн тухай хуулийн 59.4, 59.5, 77.2 дахь хэсэгт заасны дагуу тус компани хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулсан эсэх, ТУЗ-ийн гишүүд шинээр сонгогдсон эсэх, мөн тус бүртгэлийн улмаас хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигч Б.Б-ын эрх зөрчигдөх эсэхэд анхаарал хандуулаагүй, эдгээрийг хянаагүй нь хууль бус, тус бүртгэлийн улмаас хувьцаа эзэмшигч нэхэмжлэгч Б.Б-ын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Хяналтын шатны шүцх:

Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, гуравдагч этгээдийн гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэжээ.

Дээрх Тохиолдол 3-ыг шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн магадлал нь улсын бүртгэгчийг хэлбэрийн хяналт бус, агуулгын хяналтыг хийх ёстой байсан гэсэн үндэслэлээр бүртгэлийг хүчингүй болгосон шийдвэр юм. Энэ нь өмнөх Тохиолдол 1, 2-той харьцуулахад эсрэгээрээ гарсан шийдвэр бөгөөд улсын бүртгэгч нь хуульд заасан бичиг баримтын бүрдүүлбэрээс гадна доторх агуулгыг материаллаг хуульд нийцсэн эсэхийг нэг бүрчлэн хянах тухай заасан нь ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэх практик захиргааны хэргийн шүүхэд тогтоогүй болохыг илтгэж буй нэг жишээ юм.

Гэтэл онолын болон практик нөхцөлийг харгалзан үзсэн ч улсын бүртгэгч бүртгэл хийхдээ тухайн бичиг баримтыг материаллаг хуульд нийцсэн эсэхийг хянах ямар ч боломжгүй гэдгийг дээр дурдсан билээ. Улмаар тус магадлалд шүүх захиргааны актыг хянах бус, материаллаг хуулийг хэрэглэн, агуулгын хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд компанийн дүрэм нь хуульд нийцээгүй, бусад хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг

зөрчиж буй талаар магадлалын үндэслэх хэсэгтээ тодорхой дурдсан байна. Угтаа компанийн дүрэм нь хуульд нийцсэн эсэх, бусад хувьцаа эзэмшигчийн эрх ашигт нийцэж байгаа эсэх нь ЗХШ буюу дагнасан шүүхийн харьяалах маргаан биш, харин хувийн эрх зүйн маргаан болохыг дээр тэмдэглэсэн бөгөөд энэ мэтчилэн ЗХШ-ээс ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэх явцдаа хувийн эрх зүйн харилцаа буюу ИХШ-ийн харьяаллын маргааныг шийдвэрлэх оролдлого хийж буй нь энэхүү ерөнхий харьяаллын шүүх болон дагнасан шүүхийн маргааны харьяаллын зөрчилдөөнийг үүсгэх нөхцөл болж байгаа юм.

Хэдийгээр дээрх Тохиолдол 3 магадлалыг хяналтын шатны шүүхээс хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн ч шат шатны шүүх илэрхий алдаа гаргаж буй нь анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай асуудал гэдгийг илэрхийлж байна. Түүнчлэн, улсын бүртгэгчдийн хувьд хэлбэрийн хяналт хийх үү, агуулгын хяналт хийх үү гэдэгт нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байгаа нь тэдгээрийн хийсэн бүртгэлтэй холбогдох маргааны захиргааны шүүхээс шийдвэрлэхдээ нэг бол зөвхөн хэлбэрийн хяналт хийх эрхтэй, эсхүл давхар агуулгын хяналтыг ёстой гэсэн өөр өөр шийдвэр гаргаж байгаатай холбогдож байна гэж үзэх үндэслэл ч бий болно.

2.4. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН МАТЕРИАЛЛАГ ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ

ЗХШ-ээс ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэх явцад гарч буй бас нэг асуудал нь хэрэг хянан шийдвэрлэхдээ ямар хуулийг хэрэглэж, маргааныг шийдвэрлэх вэ гэдэг асуудал юм. Өөрөөр хэлбэл, ЗХШ улсын бүртгэгчийн гаргасан захиргааны актыг хуульд нийцсэн эсэхийг хянахдаа хувийн эрх зүйн харилцаанд хамаарах Иргэний хууль болон Компанийн хуулийн

материаллаг хэм хэмжээг тайлбарлан хэрэглэж, маргааныг шийдвэрлэх боломжтой юу гэдгээс хамаарч, дээрх асуултад хариулах боломжтой болно.

Эрх зүйн онолын үүднээс үзвэл нэгэнт ЗХШ-ийн харьяалах маргаан нь захиргааны үйл ажиллагаатай холбогдох маргаан гэдэг нь тодорхой бөгөөд тухайн захиргааны үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх нь хувийн эрх зүй дэх материаллаг хэм хэмжээ бүхий хуультай ямар холбоотой вэ гэдэг логик холбоо гарах ба тухайлбал, улсын бүртгэгч бүртгэл хийхдээ Иргэний хууль болон Компанийн тухай хуулийн материаллаг хэм хэмжээг үндэслэж бүртгэсэн үү, эсхүл УБЕХ болон ХЭУБтХ-ийн процессын хэм хэмжээг үндэслэн бүртгэсэн үү гэдэг асуудал юм.

Тодруулбал, УБЕХ болон ХЭУБтХ-д улсын бүртгэгчийн эрх хэмжээ, бүртгэл хийх процесс болон бүртгэл хийхэд шаардлагатай материалыг нарийвчлан зохицуулсан байдгаас улсын бүртгэгч бүртгэл хийхдээ нарийвчилсан хууль тогтоомж буюу бүртгэлийн хуулийг баримтлан шийдвэр гаргадаг. Гэтэл ЗХШ дээрх бүртгэгчийн шийдвэртэй холбоо бүхий маргааныг шийдвэрлэхдээ иргэн, хуулийн этгээдийн хоорондын харилцааг зохицуулж буй материаллаг хуулийн хэм хэмжээг хэрэглэн, маргааныг шийдвэрлэж буй тохиолдлуудыг энэ хэсэгт авч үзье.

Тохиолдол 4¹⁸

Нэхэмжлэгч “КБ” ХХК-ийн нэхэмжлэлтэй Б.Ч-г “М” ХХК-ийн захирлаар томилсон шийдвэрийг компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэсэн бүртгэлийг илт хууль бус болгохыг тогтоолгох; “М”

¹⁸ “КБ” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 128/ШШ2017/0756 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 221/МА2017/0864 дүгээр магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 53 дугаар тогтоолтой захиргааны хэрэг.

ХХК-ийн үүсгэн байгуулагчийн 2016 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан “Дүрэм”-ийг бүртгэсэн бүртгэлийг илт хууль бус болгохыг тогтоолгох; Б.Ч-г “М” ХХК-ийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчээр бүртгэсэн бүртгэлийг илт хууль бус болохыг тогтоолгох шаардлага бүхий ОӨУБЕГ-т холбогдуулан гаргасан захиргааны маргаан байна.

Хэргийн үйл баримтын талаар дурдвал “М” ХХК нь 2007 онд “КБ” ХХК-аас 1.4 сая ам.долларыг зээлийн гэрээ байгуулан зээлсэн бөгөөд тухайн үед компанийн хувьцаа эзэмшигч, захирлаар Б.Б бүртгэлтэй байсан байна. Зээлийн гэрээний хугацаа дуусахад “М” ХХК гэрээний үүргээ биелүүлж чадаагүй тул Иргэний хэргийн шүүхээс “М” ХХК-аас 1.9 тэрбум төгрөгийг гаргуулж, “КБ” ХХК-д олгохоор шийдвэрлэсэн бөгөөд 2016 онд “М” ХХК-ийн захирал, хувьцаа эзэмшигч Б.Б нь өөрийн эзэмшлийн 100 хувийн хувьцаагаа иргэн Ч.Б-д Хувьцаа худалдан авах гэрээ болон Компанийн эрх шилжүүлэх гэрээг үндэслэн шилжүүлж, улсын холбогдох бүртгэлийг хийлгэсэн байна. Ингээд зээлдүүлэгч “КБ” ХХК нь “М” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Б.Б нь компанийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор өөрийн эзэмшлийн хувьцааг Ч.Б-д шилжүүлж, дүр үзүүлэн хэлцэл хийсэн тул түүнийг бүртгэсэн улсын бүртгэгчийн бүртгэл нь илт хууль бус болно хэмээн маргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

Шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд тус шийдвэрийн үндэслэх хэсэгтээ дор дурдсан үндэслэлийг дурджээ.

- Компанийн бүртгэлд орсон өөрчлөлт оруулах өргөдөл түүнд хавсаргасан баримтуудыг шүүхээс судлан

үзээд, ХЭУБтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан болох нь тогтоогдож байна.

- Дүр үзүүлэн хийсэн хэлцлийн хувьд “М” ХХК болон “КБ” ХХК-ийн хооронд 2007 оны 8 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан Зээлийн гэрээний 12.7-д “Гэрээнд оролцогч тал нөгөө талаас бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ ямарваа нэгэн хэлбэрээр гуравдагч этгээдэд шилжүүлж эсхүл залгамжлуулж үл болно” гэжээ. Зээлийн гэрээний энэхүү заалт нь зээлийн гэрээгээр хүлээсэн төлбөр төлөх үүргийг аливаа гуравдагч этгээдэд банкны зөвшөөрөлгүйгээр шилжүүлэхийг хориглосон бөгөөд харин зээлдэгч компанийн хувьцаа эзэмшигч өөрчлөгдөх, гүйцэтгэх удирдлага солигдох зэрэг өөрчлөлтүүдийг хязгаарласан зохицуулалт биш болно.
- КтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ”; 9.3-т “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэж заасны дагуу “М” ХХК тус төлбөрийг барагдуулах үүрэгтэй бөгөөд “М” ХХК-ийн хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирал нь Б.Б, Б.Ч нарын хэн байхаас үл хамааран, зайлшгүй биелэгдэх ёстой шийдвэр юм.
- Тогтоох хэсэгтээ: Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6, Компанийн тухай хуулийн 9.1, 9.3... дэх хэсгүүдэд заасныг тус тус баримтлан... ОӨУБЕГ-т холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

Анхан шатны шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх тул хэвээр үлдээж, давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.

Хяналтын шатны шүүхийн тогтоол:

Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

Тохиолдол 4-ийн хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрээс хоёр зүйлд анхаарал хандуулах шаардлагатай. Эхний зүйл нь Тохиолдол 1, 2-т тайлбарласанчлан улсын бүртгэгч нь зөвхөн хэлбэрийн буюу процессын хяналт хийнэ гэдгийг шүүхээс баталгаажуулсан байна. Учир нь шүүхээс дүгнэхдээ улсын бүртгэгч ХЭУБтХ-ийн 23 дугаар зүйлд заасан бичиг баримтын бүрдүүлбэр хангасан байхад бүртгэл хийхээс татгалзах эрхгүй гэж дүгнэсэн нь үүний нотолгоо бөгөөд энэ утгаараа нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь оновчтой байсан хэмээн үзэж байна.

Харин 2 дахь зүйлийн хувьд хэдийгээр гурван шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн ч шүүх маргааныг шийдвэрлэхдээ нэхэмжлэгч болон гуравдагч этгээдийн хооронд байгуулсан Зээлийн гэрээнд үнэлэлт дүгнэлт өгөхөөс гадна Компанийн тухай хуулийн хувьцаа эзэмшигчийн хүлээх хариуцлагын талаарх материаллаг эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэж, улмаар шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсгийн үндэслэл болгосонд оршино.

Өөрөөр хэлбэл, дээр дурдсанчлан ЗХШ хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэх хуулийн тухай асуудлыг энэхүү шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар хөндөж буй явдал юм.

Тэгвэл эрх зүйн зохицуулалтыг нь үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжийг хэрэглэнэ” гэж зааснаас үзвэл захиргааны шүүх нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүхий л хуулийг хэрэглэж хэрэг, маргааныг шийдвэрлэнэ гэж ойлгогдож байна.

Гэтэл тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ” хэмээн зааснаас үзвэл зөвхөн нийтийн эрх зүйн хүрээнд гарсан маргааныг шийдвэрлэх ёстой бөгөөд нийтийн эрх зүйн харилцааг зохицуулж буй тухайн хууль тогтоомжийг хэрэглэх ёстой. Тодруулбал, ямар хуулийг нийтийн эрх зүйн харилцааг зохицуулж буй хууль, хувийн эрх зүйн харилцааг зохицуулж буй хууль гэж үзэх тухайд хуулийн зорилго, хэм хэмжээ нь иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцаа буюу диспозитив харилцааг зохицуулсан шинжтэй юү, эсхүл захиргааны байгууллагаас иргэн хуулийн этгээдтэй харилцах харилцааг зохицуулж буй захиргаа ба иргэн, хуулийн этгээдийн хоорондын императив шинжтэй харилцааг зохицуулсан хууль уу гэдгээр нь төвөггүй ялгаж болно.

Тухайлбал, Иргэний хууль нь ямарваа нэг захиргааны байгууллагын эрх, үүргийн талаарх зохицуулалт агуулахгүй, зөвхөн иргэн, хуулийн этгээдийн эдийн болон эдийн бус баялагтай холбогдох харилцааг зохицуулах тул хувийн эрх зүйн харилцааг зохицуулж буй суурь хууль гэж үздэг. Харин холимог зохицуулалт агуулсан хууль байхыг үгүйсгэхгүй бөгөөд тухайлбал, Компанийн тухай хууль нь хувьцаа эзэмшигч, тэдгээрээс эрх олгогдсон бусад бизнесийн институцийн харилцааг зохицуулдаг хувийн эрх зүйн хууль боловч компани үүсгэн байгуулах бүртгэл, дүрэмд орсон өөрчлөлтийн бүртгэл

зэрэг бүртгэлтэй холбоотой процессын шинжтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээг агуулдаг.

Дээрх агуулгаас дүгнэж үзвэл Захиргааны шүүх нь захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхдээ бүхий л хууль тогтоомжийг хамаатуулж хэрэглэх бус, зөвхөн захиргаанд эрх, үүрэг олгосон, иргэн хуулийн этгээдээс захиргаатай харилцах харилцааг зохицуулж буй хууль болон холбогдох хэм хэмжээг хэрэглэх ёстой. Гэтэл Тохиолдол 4-т дүн шинжилгээ хийж үзвэл, ЗХШ-ээс хоёр хуулийн этгээд хооронд байгуулсан Зээлийн гэрээнд дүгнэлт хийх ёсгүй бөгөөд тийм шаардлага байхгүй гэдэг нь ойлгомжтой байна. Өөрөөр хэлбэл, талуудын хооронд гэрээний харилцаанаас үүсэх маргаан нь иргэн, хуулийн этгээдийн харилцаа тул иргэний эрх зүйн маргаан юм.

Нөгөө талаар Компанийн тухай хуулийн хувьцаа эзэмшигчийн компанийн өмнө хүлээх хязгаарлагдмал хариуцлагын тухай зохицуулалтыг Үндэслэх хэсэгтээ тайлбарлан хэрэглэж, хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн нь компанийн бусдын өмнө хүлээх хариуцлагыг үгүйсгэхгүй гэж дүгнээд, түүнийгээ шийдвэрийн Тогтоох хэсгийн үндэслэл болгосон нь хууль хэрэглээний алдааг гаргасан байна. Учир нь КтХ-ийн 9 дүгээр зүйл нь захиргааны байгууллагатай аливаа хамааралгүй зүйл бөгөөд зөвхөн компани, хувьцаа эзэмшигч хоорондын харилцааг зохицуулж буй зарчмын шинжтэй материаллаг хэм хэмжээ гэдгийг шүүх анхаарч үзээгүйн дээр давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхээс ч энэ талаар дүгнэлт огт хийлгүй, шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

Ийнхүү Захиргааны шүүх зөвхөн Компанийн тухай хуулиар хязгаарлагдахгүй Иргэний хуулийг хэрэглэн, маргаан шийдвэрлэж буй нийтлэг тохиолдол нь хуулийн этгээдийн оноосон нэртэй холбоотой маргаан юм. Тиймээс дээрх Тохиолдол 4-т тайлбарласан Захиргааны шүүх маргаан шийд-

вэрлэхдээ хэрэглэх хуультай холбоотойгоор Иргэний хуулийг хэрэглэн, маргааныг шийдвэрлэж буй хоёр өөр шүүхийн шийдвэрийг авч үзье.

Тохиолдол 5¹⁹

Нэхэмжлэгч “Аэрмаркет” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Эйрмаркет Говь” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулах, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээдэд бүртгэхгүй байхыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын ХЭБГ-т даалгуулах нэхэмжлэлтэй захиргааны маргаан.

Хэргийн үйл баримтыг авч үзвэл “Аэрмаркет” ХХК нь 2000 онд үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, олон улсын болон орон нутгийн тийз борлуулалт, аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг компани бөгөөд 2015 онд тус компанитай адил үйлчилгээ эрхэлдэг “Эйрмаркет Говь” ХХК гэх ижил нэртэй хуулийн этгээдийг үүсгэн байгуулж, улсын бүртгэлийн байгууллага Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, Өрсөлдөөний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсгийг зөрчиж, нэр олгосон гэсэн үндэслэлээр хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулан, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байхыг даалгуулах нэхэмжлэл гаргасан байна.

Анхан шатны шүүх:

Нэхэмжлэлийн шаардлагаас “Эйрмаркет Говь” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй

¹⁹ “АМ” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 471 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 221/МА2016/0585 дугаар магадлалтай, хяналтын шатны захиргааны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 403 дугаар тогтоолтой захиргааны хэрэг.



болгож, дахин энэ нэрээр өөр хуулийн этгээд бүртгэхгүй байх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ. Тус шийдвэрийн үндэслэлдээ:

“Эйрмаркет Говь” гэх нэр нь бусдад “Аэрмаркет” ХХК-ийн говь дахь салбар хэмээн ойлгогдож, Өмнөговь аймагт олон улсын болон орон нутгийн тийз борлуулалт, аялал жуулчлалын үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг эрхлэн, улмаар хүрээгээ тэлж, Улаанбаатар хотод адил үйл ажиллагааг явуулж байгаа нь Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-д “Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй”; Хууль зүйн сайдын тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-д “Хуулийн этгээдийн нэр нь Иргэний хуулийн 27 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу бусад хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй байхыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003) 16 дугаар зүйлийн 16.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2015) 14 дүгээр зүйлийн 14.2.1, Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасныг баримтлан, нэхэмжлэгч нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003) 16 дугаар зүйлийн 16.8-д “Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэхийг холбогдох бүртгэх байгууллага цахим хэлбэрээр шалгаж

баталгаажуулна” гэсний дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн газар цахим сангаас “Эйрмаркет Говь” нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхцаж байгаа эсэхийг шалган баталгаажуулсан боловч ижил төсөөтэй нэр гарч ирээгүй гэсэн үндэслэл заажээ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн (2003) 2 дугаар зүйлийн 2.1-д “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасны дагуу хуулийн этгээд байгуулах, түүнийг улсын бүртгэлд бүртгэх, улсын бүртгэл хөтлөхтэй холбоо бүхий харилцаанд Иргэний хууль эрх зүйн эх сурвалж болох бөгөөд Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т зааснаар хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан байж болохгүйгээс гадна бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байхыг хориглосон (зөвшөөрөөгүй) байна.

Тухайн тохиолдолд, “Airmarket” гэх гадаад үгийг кирилл үсгээр хэрхэн (“Эйрмаркет”, “Аэрмаркет” гэж) илэрхийлснээс үл хамааран, тухайн нэрийг ижил (адил) гэж үзэх бөгөөд энэхүү нэрийн өмнө болон хойно өөр оноосон нэрийг нэмснээр ялгагдах боломжтой боловч “говь” гэсэн бүс нутаг, байршил заасан үгийг оруулснаар нэг салбарт үйл ажиллагаа явуулах компаниудын хувьд бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй хэмээн үзэхээр болжээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газар нь “Эйрмаркет Говь” нэр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн өөр хуулийн этгээдийн нэртэй давхцаагүй боловч “бусдыг төөрөгдөлд оруулахаар ижил төсөөтэй” байгааг анхаарч

үзэлгүй нэрийн баталгаажуулалтын хуудас олгож, тухайн нэрээр хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэн нь Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасантай нийцээгүй, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байна.

Нөгөөтээгүүр, Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцын 8 дугаар зүйлд “аж ахуйн нэгжийн нэрийг барааны тэмдгийн бүрдэлд орсон эсэхээс үл хамааран, түүнийг мэдүүлэг гаргахыг шаардахгүйгээр эсхүл бүртгэлгүйгээр хамгаална” гэж заасан ба тус конвенцод Монгол Улс нэгдэн орж, 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталж, Монгол улсын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөгдөхөөр байх тул анхан шатны шүүх маргааны үйл баримтад дээрх конвенцын холбогдох заалтыг хэрэглэсэн нь үндэслэлтэй болжээ.

Тохиолдол 6²⁰

“Таун Компорт” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-ын ХЭБГ-т холбогдох “Комфорт Таун Инвест” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй захиргааны маргаан.

Хэргийн үйл баримтын хувьд “Таун Компорт” ХХК нь 2007 онд үүсгэн байгуулагдсан орон сууцны ашиглалт, нийтийн аж ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компани юм. 2015 онд “Комфорт Таун” ХХК байгуулагдаж, ижил төрлийн үйл ажиллагаа

²⁰ “ТК” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 128/ШШ2019/0039 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 221/МА2019/0219 магадлалтай, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн тогтоолтой захиргааны хэрэг.

эрхлэх болсон бөгөөд улмаар 2018 онд нэрээ “Комфорт таун Инвест” ХХК болгон өөрчилсөн нь Иргэний хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн нэр олгох журмыг зөрчиж, хуулийн этгээдийн ижил төстэй нэр олгосон гэж бүртгэлийг хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан маргаан байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

Хэргийн оролцогчдын тайлбар, хэрэгт авагдсан “тооцооны үлдэгдлийн баталгаа, нэхэмжлэх, тусгай зөвшөөрөлтэй холбогдох баримтууд зэрэг нотлох баримтуудыг үнэлж, “Таун Компорт” ХХК, “Комфорт Таун Инвест” ХХК-уудын үйлчилгээг авч буй иргэд, харилцагч байгууллагууд тэдгээрийг нэг компани гэж төөрөгдөх нөхцөл байдал үүссэн хэмээн дүгнэж, “Комфорт Таун Инвест” ХХК-ийн хуулийн этгээдийн нэрийн бүртгэлийг хүчингүй болгон, хуулийн этгээдийн нэр олгохдоо Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 хэсгийг зөрчсөн байна гэж дүгнэн, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гуравдагч этгээдийн гаргасан гомдлыг хангахгүй орхисугай гэжээ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр магадлалыг хэвээр үлдээж, хяналтын журмаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Тохиолдол 5 болон Тохиолдол 6-д дурдагдсан хэргүүд нь маргааны агуулга болон шүүх маргааныг шийдвэрлэсэн шийдвэр, шийдвэрийн үндэслэлүүд адил байна. Энэ нь

хуулийн этгээдийн нэрийн бүртгэлтэй холбоо бүхий маргааныг ЗХШ шийдвэрлэхдээ нийтлэг байр суурьтай байгаагаас гадна шийдвэр гаргах үндэслэлээ Иргэний хуульд үндэслэж байгаа гэсэн ерөнхий дүгнэлт гаргаж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Улсын бүртгэлийн байгууллага нь Иргэний хуулийн 27 дугаар зүйл, энэ хуулийн 13.7-д заасан журмаар тогтоосноос гадна дараах ерөнхий шаардлагыг хангасан хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулна”; Хууль зүйн сайдын баталсан 2015 оны А/41 тоот “Хуулийн этгээдийн оноосон нэр олгох, баталгаажуулах журам”-ын 3.1-д “Хуулийн этгээдийн нэр нь Иргэний хуулийн 27 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу бусад хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил төсөөтэй байхыг хориглоно” гэсэн заалтуудад Иргэний хуулийн 27 дугаар зүйлийг эшилсэн байх тул ЗХШ ийнхүү шийдвэрийн үндэслэлээ Иргэний хуулийг хэрэглэж буйг буруутгах аргагүй байна.

Тодруулбал, нийтийн эрх зүйд хамаарах хууль тогтоомжид хувийн эрх зүйн шинжтэй хуулийн материаллаг хэм хэмжээг хэрэглэж болохоор шууд эшлэн заасан бол тухайн хэм хэмжээг захиргааны шүүх эш татан хэрэглэх боломжтой.

Гэхдээ өөр нэгэн жишээ нь “Бодь” ХХК болон “Бодь Интернэшнл” ХХК-ийн хооронд үүссэн Бодь нэрийг аль нь давуу эрхтэйгээр ашиглах тухай маргаан юм. Гэтэл “Бодь” ХХК-ийн нэхэмжлэлтэй “Бодь Интернэшнл” ХХК-ийн маргааныг захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхээс захиргааны маргаан хэмээн үзэж шийдвэрлэснийг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн шүүхээс тус маргаан нь захиргааны эрх зүйн маргаан бус, иргэний эрх зүйн маргаан гэдэг үндэслэлээр Иргэний хэргийн шүүхийн харьяалалд шилжүүлсэн нь сонирхол татаж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн нэртэй холбогдох маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэх нь зохистой юу гэсэн асуулт урган гарч байна. Зарчмын хувьд хуулийн этгээдийн нэр нь тухайн хуулийн этгээдийг бусад хуулийн этгээдээс ялган таних, компанийн хувьд тухайн нэрээ бизнесийн үнэ цэн болгох замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиг олох үйл ажиллагааны нэг хэлбэр болгодог. Үүнээс үзэхэд хуулийн этгээдийн нэр нь зөвхөн захиргааны байгууллагын нэр олгох бүртгэл бус, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагын бизнесийн үйл ажиллагааны гол илэрхийлэл болох хувийн эрх зүйн элемент юм.

Тодруулбал, улсын бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийн нэр олгохдоо хуульд заасны дагуу цахим шүүлт хийх замаар ижил төсөөтэй нэр байгаа эсэхийг шалган тогтоосны үндсэн дээр нэр олгох шийдвэр гаргана. Гэтэл Тохиолдол 5, 6-ийн хувьд аль ч тохиолдолд цахимаар шүүж үзэхэд тухайн нэртэй шууд давхцах ижил нэр олдоогүй гэсэн үндэслэлээр нэр олгож шийдвэрлэснийг шүүхээс хүчингүй болгожээ. Нөгөө талаар шүүхийн шийдвэр нь улсын бүртгэгчийг зөвхөн цахим шүүлтээр хязгаарлагдахгүй, тухайн нэртэй ижил төсөөтэй өөр нэр байгаа эсэхийг мэдэх ёстой байсан гэсэн хийсвэр дүгнэлт хийж буй юм. Угтаа Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасан “хуулийн этгээдийн нэр нь бусад хуулийн этгээдийн нэртэй ижил буюу бусдыг төөрөгдүүлэхүйц ойролцоо утгатай байж болохгүй” гэсэн хязгаарлалт нь нэр олгож буй бүртгэлийн байгууллагад бус, хуулийн этгээд байгуулж буй иргэн, хуулийн этгээдэд оногдуулсан үүрэг юм.

Хэрэв хоёр компанийн нэр хоорондоо төсөөтэй байна гэж үзвэл тухайн компани нь ИХШ-д хандах замаар тухайн ижил төсөөтэй нэртэй компанийн улмаас компанид нь ямар хор уршиг учирсан, ямар байдлаар бусдыг төөрөгдүүлээд байгаа

гэдгийг өөрөө нотлох замаар маргааныг шийдвэрлүүлэх нь зохистой. Гэтэл ЗХШ-ийн онцлог нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна” гэсэн заалт буюу шүүх өөрөө нотлох зарчмын дагуу үнэхээр ижил төсөөтэй нэр олгосон байна уу гэдгийг шүүх өөрөө тогтоож, шийдвэрлэх ёстой болно. Улмаар шүүх ийнхүү хуулийн этгээдийн нэр ижил төсөөтэй байгаа гэдгийг абстракт буюу хийсвэр хяналт хийх замаар тогтооно.

Харин ИХШ-ээр шийдвэрлэгдэх тохиолдолд бодит байдалд тухайн нэр нь ижил төсөөтэй байгаа эсэх, бусдыг төөрөгдүүлж буй эсэх гэдгийг талуудын гаргасан нотлох баримтад суурилж дүгнэх бөгөөд энэ нь хуулийн этгээдийн нэртэй холбогдох маргаанд шүүх объектив дүгнэлт буюу талуудын гаргасан нотолгоонд суурилсан бодитой дүгнэлт гаргаж, хэргийг шийдвэрлэх боломжтой болгоно. Тодруулбал, Тохиолдол 5-ыг үзвэл “Эйрмаркет Говь” ХХК байгуулагдсанаар “Аэрмаркет” ХХК-ийн зах зээл дэх нэр хүндэд яаж халдсан, тухайн нэрийн улмаас хэдэн үйлчлүүлэгч бодитоор төөрөгдөж, “Аэрмаркет” ХХК-д хохирол учруулсан зэргийг шүүх бус нэхэмжлэгч өөрөө нотлон тогтоох ёстой бөгөөд ийнхүү нотолж чадвал шүүх түүнийг үндэслэн объектив дүгнэлт хийж шийдвэрлэнэ.

Гэвч ЗХШ-ээс Захиргааны ерөнхий хуулийн 58 дугаар зүйлд заасан захиргааны гэрээнд Иргэний хуулийг нөхөн тохируулан хэрэглэх тухай асуудалд хамааралгүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

2.5. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ХЯНАЛТ БА ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ХАРЬААЛЛЫН ДАВХЦАЛ



ХЭБ-тэй холбоотой маргааны хувьд ЗХШ болон ИХШ-ээр давхар шийдвэрлүүлэх тохиолдол цөөнгүй бөгөөд өмнө дурдагдсан тохиолдлуудад ч мөн давхар иргэний шүүхээр шийдвэрлэгдсэн маргаанууд байгаа боловч захиргааны шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээнд төвлөрсөн тул иргэний шүүхийн шийдвэрийн талаар авч үзээгүй болно.

Харин энэ хэсэгт ЗХШ ба ИХШ-ийн хяналтын давхцал үүссэн тохиолдлыг авч үзэх бөгөөд энэхүү хэрэг нь олон нийтийн анхаарлыг татсан “Эрдэнэт үйлдвэр” ХХК (“Э Ү” ХХК)-ийн 49 хувийн хувьцааг худалдан авсантай холбогдох маргаан юм. Гэхдээ тус хэргийн хувьд ИХШ, ЗХШ, ЭХШ, эцэстээ Үндсэн хуулийн цэцээр хүртэл хянан шийдвэрлэгдэж байсан бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа одоо ч үргэлжилж байгаа гэдгийг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн тус хэрэг нь ЗХШ-ийн зургаан удаагийн шийдвэр тогтоолтой бөгөөд эхэндээ анхан шатнаас хяналтын шатны шүүх хүртэл үргэлжлээд, хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан байдаг. Тиймээс энэ судалгааны хүрээнд дүн шинжилгээ хийх шийдвэр нь хяналтын шатаас анхан шатны шүүх рүү буцаах хүртэлх гурван шатны шүүхийн шийдвэрийг хамаарахгүй бөгөөд харин анхан шатны шүүхэд дахин хэлэлцэгдээд, хяналтын шатны шүүхээр эцэслэгдэн шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийг авч үзсэн болно. Мөн тус шүүхийн шийдвэрийн хувьд өмнөх тохиолдлуудтай адил Компанийн тухай хуулийг хэрэглэж шийдвэрлэсэн, улсын бүртгэгчийн агуулга болон хэлбэрийн хяналттай холбоо бүхий агуулгууд хөндөгдсөн боловч өмнөх тохиолдлуудад дэлгэрэнгүй тайлбарласан гэж үзээд, тухайн

хэсгүүдэд дүн шинжилгээ хийхгүй зөвхөн ЗХШ ба ИХШ-ийн хяналт давхацсан хэсэгт дүн шинжилгээ хийсэн болно.

Тохиолдол 7²¹

Нэхэмжлэгч “МКК” ХХК-аас Монгол Улсын Засгийн газар, ТӨБЗГ, ОӨУБЕГ-т хандсан нийт 13 нэхэмжлэлийн шаардлага бүхий захиргааны хэрэг.

Хэргийн үйл баримтын хувьд “МКК” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 330 тоот тогтоолыг үндэслэн, ОХУ-ын төрийн өмчит “Ростех” улсын корпорацтай гэрээ байгуулж, “Э Ү” ХХК болон “МРЦ” ХХК-ийн 49 хувийн хувьцааг худалдан авсан байна.

Товчоор, “Э Ү” ХХК болон “МРЦ” ХХК-ийн 51 хувийн хувьцааг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, 49 хувийн хувьцааг “МКК” ХХК хууль ёсоор эзэмшиж байна. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар “Э Ү” ХХК болон “МРЦ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг зуун хувь төрийн төлөөллөөс бүрдүүлж, цаашдаа тус компанийн засаглал, удирдлагын бүрэлдэхүүнд ажиллах төрийн төлөөллийн тоог нэмэгдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ж.М, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Н нарт Засгийн газар үүрэг болгож, даалгавар өгчээ.

Энэхүү даалгаврын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга холбогдох шийдвэрүүдийг

²¹ “МКК” ХХК-ийн нэхэмжлэлтэй ТӨБЗГ, ОӨУБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2018/0272 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 221/МА2018/0415 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолтой захиргааны маргаан.

гаргасныг хууль бус хэмээн үзэж, хүчингүй болгуулах, тухайн шийдвэр тогтоолыг үндэслэж хийсэн улсын бүртгэлийг хүчингүй болгох гол агуулгатай.

Анхан шатны шүцхийн шийдвэр:

Нэхэмжлэгч “МКК” ХХК-иас Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт тус тус холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, **...Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 6, 7 дугаар тогтоолууд...** “МРЦ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэсэн үйлдлийг тус тус илт хууль бус болохыг тогтоож, **...нэхэмжлэгчийн “ЭҮ” ХХК, “МРЦ” ХХК-ийн 49 хувийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг сэргээн бүртгэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр олгохыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт даалгах** тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүцх:

(Дүн шинжилгээнд хамааралтай хэсгийг авав)... Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 2-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ. Дарга орон тооны бус гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө”, 11 дүгээр зүйлийн 6-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,

түүний үйл ажиллагаанд хяналт тавина” гэж заасан байна.

Хуулийн энэхүү заалтаар төрийн өмчийн төлөөлөгчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлж томилохоор хуульчилсан байхад тус газрын дарга өөрөө тушаал гаргаж, нэр бүхий хүмүүсийг “ЭҮ” ХХК болон “М” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд төрийн өмчийг төлөөлөн оролцох төлөөлөгчөөр томилсон нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3-т зааснаар өөрийн чиг үүрэгт үл хамаарах асуудлаар захиргааны акт гаргасан байх тул уг захиргааны актыг илт хууль бус гэж үзнэ. Иймд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаалыг илт хууль бус болохыг тогтоох нь зүйтэй гэж үзэв.

Анхан шатны шүүх уг тушаалыг илт хууль бус болохыг тогтоосон боловч Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасныг баримталсан нь үндэслэлтэй биш байна. Өөрөөр хэлбэл, уг тушаал нь иргэн хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гэдэгт хамаарахгүй гээд холбогдох хуулийн заалтуудад өөрчлөлт оруулж, анхан шатны шүүхийн шийдвэрийн үндсэн хэсгүүдийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүх:

(Дүн шинжилгээнд хамааралтай хэсгийг авав)... Түүнчлэн, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн “Удирдамж өгөх тухай” А-1/666 тоот албан бичигт тухайлан заасан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодыг

байгуулах, компанийн ерөнхий захиралтай контрактын гэрээ байгуулах, компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай “удирдамж” нь “ЭҮ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосон, заавал биелэгдэх шинжийг агуулсан, эрх зүйн үр дагаврыг шууд бий болгосон гадагш чиглэсэн захиргааны акт байхад давж заалдах шатны шүүхээс уг албан бичигтэй холбогдох шаардлагыг хүлээн авахаас татгалзсан нь буруу болжээ.

Анхан шатны шүүхээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн “Удирдамж өгөх тухай” А-1/666 тоот албан бичгийг хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагыг “хууль бус байсан болохыг тогтоож шийдвэрлэсэн” нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.3-д заасантай нийцсэн байна. Тухайн тохиолдолд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн “Удирдамж өгөх тухай” А-1/666 тоот албан бичигт заасан удирдамж нэгэнт хэрэгжсэн боловч нэхэмжлэгчийн ашиг сонирхол байсан гэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт буруу биш болно гэж дүгнэжээ.

Эцэст нь давж заалдах шатны шүүхийн магадлалд холбогдох өөрчлөлтийг оруулж, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалын үндсэн агуулга болох нэхэмжлэлийн шаардлагын дийлэнх хэсгийг хангаж шийдвэрлэжээ.

Тохиолдол 7-д заасан маргааны хувьд энэхүү судалгааны хүрээнд хөндөх асуудал нь дээрх хэргийн шийдвэрт дурдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаал, тус

өдрийн “ЭҮ” ХХК-ийн ХЭЭБХ-ын тогтоолууд юм. Өөрөөр хэлбэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн “ЭҮ” ХХК, “МРЦ” ХХК-ийн ТУЗ-ийг 100 хувь төрөөс бүрдүүлэх тухай” асуудлыг хэлэлцэж өгсөн даалгаврын дагуу “ЭҮ” ХХК, “МРЦ” ХХК-ийн 49 хувийг эзэмшигч компанийг оролцуулалгүйгээр хийсэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан “ЭҮ” ХХК, “МРЦ” ХХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлт, хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Хуулийн этгээдийн бүртгэлийн газар 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авч 2017 оны 4 дүгээр сарын 3-ны бүртгэлүүдийг хийж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр олгосон явдал юм.

Иймд захиргааны хэргийн гурван шатны шүүхээс дээрх Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаал нь илт хууль бус захиргааны акт гэж дүгнэсэн байна. Тус актын талаарх шүүхийн дүгнэлтийг товчилбол:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1-д “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн”; Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д “Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга тушаал гаргах бүрэн эрхтэй байна.

Гэвч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ. Дарга, орон тооны бус гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө”; 11 дүгээр зүйлийн 11.6-д “төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих” гэж тус тус зааснаас үзэхэд Төрийн өмчийн төлөөлөгчийг томилох бүрэн эрх нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, найман гишүүний хамтын хуралдааны шийдвэрээр (тушаал биш тогтоолоор) томилогдохоор байх бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэхээр тус газрын хуралдаанаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад тусгайлан эрх олгоогүй байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга болон тус газрын орон тооны бус найман гишүүний хамтаар батлан гаргадаг шийдвэрийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тусгайлан зааглан тогтоосон байх бөгөөд хуулиар эсхүл тодорхой шийдвэрээр эрх олгосон тохиолдолд тус газрын дарга дангаараа шийдвэрлэх боломжтой.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаалаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга нь дангаараа төрийн өмчийн төлөөлөгч томилсон нь эрх зүйн үндэслэлгүй байх тул илт хууль бус захиргааны акт гэж үзэхээр байна.

Эндээс гол анхаарал татаж буй асуудал нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/50 дугаар тушаал нь “ЭҮ” ХХК болон “МРЦ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, шинээр томилох тухай тушаал бөгөөд энэхүү тушаалыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувьд гаргасан уу, эсхүл төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн хүрээнд гаргасан уу гэдэгт оршино. Дээрх захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд тус тушаалыг захиргааны акт буюу төрийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд гаргасан уу, үгүй юү гэдэгт үнэлэлт дүгнэлт өгөх замаар маргааныг шийдвэрлэсэн байна.

Гэтэл дээрх маргаан ЗХШ-ээр шийдвэрлэхтэй зэрэгцээд тус маргаантай холбоо бүхий нэхэмжлэгч “МКК” ХХК-ийн нэхэмжлэлтэй Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “ЭҮ” ХХК, ОӨУБЕГ-т хамаарах иргэний хэрэг ИХШ-д хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаа явагдаж байжээ. Иймд иргэний хэргийн шүүхэд ямар асуудал хэлэлцэгдэж, шүүхээс хэрхэн шийдвэрлэсэн шийдвэрийн талаар авч үзээд ЗХШ ба ИХШ-ийн хяналтын давхцалын талаар харьцуулан үзье.

Тохиолдол 8²²

Нэхэмжлэгч “МКК” ХХК-ийн нэхэмжлэлтэй Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “ЭҮ” ХХК, ОӨУБЕГ-т хандсан доорх таван шаардлага бүхий нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

1. “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус

²² “МКК” ХХК-ийн нэхэмжлэлтэй ТӨБЗГ, ЭҮ, ОӨУБЕГ-т холбогдох Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 181/ШШ2017/01956 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 2092 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 001/ХТ2017/01562 дугаар тогтоолтой иргэний маргаан.

- хурлын 2016 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 06/2016 тоот “ЭҮ” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, шинээр томилох тухай тогтоолыг хүчин төгөлдөр болохыг тогтоолгох;
2. ТӨБЗГ-ын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулан хуралдуулсан “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар “МКК” ХХК-ийн эзэмшлийн 49 хувийн хувьцааг хууль бусаар төрийн өмчид шилжүүлсэн болохыг тогтоолгох;
 3. ОӨУБЕГ-ын ХЭБГ-т 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр “ЭҮ” ХХК-ийн “МРЦ” ХХК-ийн эзэмшлийн 49 хувийн хувьцааг шилжүүлсэн бүртгэлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох;
 4. ТӨБЗГ-ын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулан хуралдуулсан “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох;
 5. ТӨБЗГ-ын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулан хуралдуулсан “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан 01, 02 тоот тогтоолуудыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох;

Хэргийн үйл баримтын хувьд “МКК” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 330 тоот тогтоолыг үндэслэн, ОХУ-ын төрийн өмчит “Ростех” улсын корпорацитай гэрээ байгуулан, “ЭҮ” ХХК болон “МРЦ” ХХК-ийн 49 хувийн хувьцааг худалдан авчээ.

“ЭҮ” ХХК болон “МРЦ” ХХК-ийн 51 хувийн хувьцааг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, 49 хувийн хувьцааг “МКК” ХХК хууль ёсоор эзэмшиж байна. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаан 2017

оны 3 дугаар сарын 31-ний өдөр ТӨБЗГ-аас зарласан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар “ЭҮ” ХХК болон “МРЦ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг зуун хувь төрийн төлөөллөөс бүрдүүлж, холбогдох өөрчлөлийг улсын бүртгэлийн газар бүртгүүлсэн байна.

Иймд дээрх хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулсан шийдвэрүүд хууль бус хэмээн үзэж, хүчингүй болгуулах, тухайн шийдвэр тогтоолыг үндэслэж хийсэн улсын бүртгэлийг хүчингүй болгох гол агуулгатай.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

Нэхэмжлэлийн шаардлагын гурав дахь хэсэг буюу Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хүчингүй болгох нь захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байгаа тул тус нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, бусад шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн шаардах эрхийн үндэслэлд хамааралгүй компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хурал хүчин төгөлдөр болох харилцааг зохицуулсан Компанийн тухай хуулийн 63.5, 69.2, 69.3 дахь хэсгүүдийг тогтоох хэсэгт баримталсан нь буруу байх тул энэ үндэслэлээр шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, хариуцагч ТӨБЗГ-ын төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, шийдвэрийн агуулгын хувьд анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт ороогүй байна.

Хяналтын шатны шүүхийн тогтоол:

Хоёр шатны шүүх үндсэндээ нэхэмжлэлийн шаардлага, агуулга, хүрээг зөв тодорхойлсон ба Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн

ээлжит бус хурал, уг хурлаас гаргасан хоёр тогтоолыг хүчингүй болгосон нь хуульд нийцсэн, энэ талаарх шүүхийн шийдвэр, магадлалыг үгүйсгэх үндэслэл тогтоогдсонгүй. Харин давж заалдах шатны шүүх... нэхэмжлэлд байхгүй асуудлаар шийдвэр гаргасан, ТУЗ-ийн өмнөх тогтоол хүчинтэй болохыг тогтоосон нь хуульд нийцээгүй тул зөвтгөж, магадлалд өөрчлөлт оруулан шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, шийдвэрийн агуулгын хувьд анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт ороогүй байна.

Өмнө дурдсанчлан Тохиолдол 8 нь Тохиолдол 7-д заасан хэрэгтэй ижил цаг хугацаанд шийдвэрлэгдсэн нэг хэрэгт хамаарах ерөнхий харьяаллын буюу ИХШ-ийн шийдвэр юм. Өөрөөр хэлбэл, ХЭБ-тэй холбоотой маргааны хувьд ИХШ болон ЗХШ-ийн аль алианаар маргах боломжтой гэдэг нь дээрх шийдвэрээс тодорхой харагдана.

Гагцхүү нэг хэргийн талаар шийдвэрлэж буй ерөнхий харьяаллын шүүх болон дагнасан шүүх нь тухайн хэргийн аль хэсэг нь хувийн эрх зүйд хамаарах, аль хэсэг нь нийтийн эрх зүйд хамаарах маргаан бэ гэдгийг сайтар шалгаж тогтоох шаардлагатай гэдэг нь тодорхой байна. Тэгвэл “Эрдэнэт Үйлдвэр” ХХК-тай холбоотой ЗХШ болон ИХШ-ийн шийдвэрт харьцуулан дүгнэлт хийх боломжтой нэг ижил зүйл нь дээр ЗХШ-ийн шийдвэрийг танилцуулах үед дурдагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн тушаал юм.

Учир нь тус тушаалаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлж, шинээр томилох шийдвэр гаргасан байна. Гэтэл захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт тус тушаалыг

захиргааны акт хэмээн тодорхойлж, илт хууль бус захиргааны акт болохыг тогтоожээ.

Гэтэл ИХШ-ээс тус тушаалтай холбоо бүхий дүгнэлт гаргахдаа тухайн шийдвэр нь захиргааны акт биш бөгөөд харин ТӨБЗГ нь “ЭҮ” ХХК-ийн 51 хувийн хувьцааг эзэмшигч этгээдийн хувиар гаргасан шийдвэр тул иргэний шүүхийн маргааныг объект байна хэмээн дүгнээд, шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн юм. Энэ талаарх Иргэний шүүхийн шийдвэрийн холбогдох хэсгийг хүргэе.

Хариуцагч ТӨБЗГ-ийн давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол:

ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлд иргэний хэрэг үүсгэх 5 үндэслэлийг заасан бөгөөд 12.1.4-т “Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол” гэж заасан байна. ТӨБЗГ нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасан “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн байгууллагад хамаарна. ...Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт... ИХШХШТХ-ийн 3.1, Компанийн тухай хуулийн 70.1-д заасны дагуу нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн 1, 2, 4, 5 дугаар шаардлагууд нь “ЭҮ” ХХК-ийн хувьцааг тухайн компанид хөрөнгө оруулах замаар олж аван эзэмшиж байсан нэхэмжлэгч “МКК” ХХК-ийн Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуулиар хамгаалагдсан хувьцаа эзэмших эрх зөрчигдсөн нь хувийн эрх зүйн хүрээнд хамаарах тул энэхүү маргаан нь ердийн харьяаллын шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан мөн болно” гэсэн нь хууль зөрчсөн гэжээ.

Давж заалдах болон хяналтын шатны шүүх энэ талаар дүгнэхдээ:

Иргэний хуулийн 7.3-т “төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно” гэж заасан тул “ЭҮ” ХХК-ийн 51 хувийг эзэмшигч болох хариуцагч ТӨБЗГ-ын хувьд Компанийн тухай хуулиар зохицуулагдах хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбоотой үүссэн харилцаанд бусад хувьцаа эзэмшигчтэй ижил буюу бусад хуулийн этгээдийн адил тэгш эрхтэй оролцоно. Иймд “ЭҮ” ХХК-ийн хувьцаа эзэмшигч ТӨБЗГ, “МКК” ХХК-ийн хооронд иргэний эрх зүйн харилцаанаас үүсэлтэй маргаан гарсан байна. Өөрөөр хэлбэл, “МКК” ХХК нь төрийн эрх бүхий байгууллагын хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан захиргааны актад холбогдуулан нэхэмжлэл гаргаагүй, харин Компанийн тухай хуульд заасан адил тэгш эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хоорондын эрхийн зөрчилтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэснийг буруутгах үндэслэлгүй байна.

Өөрөөр хэлбэл, ИХШ-ийн дээрх дүгнэлтээс үзэхэд ТӨБЗГ-ын шийдвэр, тушаал нь компанийн хувьцаа эзэмшигчийн хувиар гаргасан шийдвэр байх тул хувьцаа эзэмшигчдийн хооронд үүссэн иргэний эрх зүйн маргаан гэж үзсэн бол ЗХШ-ээс ТӨБЗГ нь хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд гаргасан захиргааны акт боловч илт хууль бус захиргааны акт болохыг тогтоон шийдвэрлэжээ.

Үүнээс дүгнэн үзвэл ИХШ, ЗХШ-ээс ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ нэг хэргийг хоёр шүүх зэрэг шийдвэрлэх, цаашлаад нэг үйл баримтын талаар хоёр тусдаа шүүх хоёр өөр дүгнэлт гарган шийдвэрлэж буй зөрчилдөөнтэй

байдлыг бий болгож байгаа тухай тодорхой жишээ юм.

Дээрх “ЭҮ” ХХК-тай холбоотой маргаанд ТӨБЗГ-ын шийдвэрийг захиргааны акт гэж үзээд, илт хууль бус болохыг тогтоосон, ИХШ-ээс хувьцаа эзэмшигч хоорондын маргаан хэмээн үзээд, тус шийдвэрийг хүчингүй болгосон үйлдэл аль аль нь хүчингүй буюу эрх зүйн үйлчлэлгүй болгоход чиглэсэн тул шүүхийн шийдвэрийн зөрчилдөөн үүсгээгүй байна.

Гэтэл дараа дараагийн тохиолдолд хоёр өөр шүүх хоёр тусдаа шийдвэр гаргахдаа нэг үйл баримтын талаар хоорондоо зөрчилдсөн шийдвэр гаргахыг үгүйсгэх аргагүй бөгөөд энэ тохиолдолд аль шүүхийн шийдвэрийг хүчинтэй хэмээн үзэх вэ гэдэг нь ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй ЗХШ-ээс ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ хувийн эрх зүйн маргаан буюу ИХШ-ийн харьяаллын маргааныг хянаж болохгүй тухай гол үндэслэл юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны “Иргэний зарим хэргийн харьяаллыг захиргааны хэргийн харьяаллаас ялгах тухай” 32 дугаар тогтоолд “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах нь иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрх тул дагнасан болон ерөнхий харьяаллын шүүхүүд хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэд, хуулийн этгээдийн гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ тухайн шүүхүүдийн хянан шийдвэрлэх маргааны харьяаллын талаар нэгдсэн ойлголттой байж, бусдыг чирэгдүүлэхгүй, шүүн таслах ажиллагааны чиглэл тус бүрээр үйл ажиллагаа явуулахыг онцгой анхаарах нь зүйтэй юм. ...Захиргааны хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүх байгуулагдсан явдал нь иргэдийн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгаа болох шүүхийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн тул хэргийн харьяаллын талаар шүүхүүд үл ойлголцох, хэрэг, маргааныг шийдвэрлэх шат, дамжлагыг нэмэгдүүлэх, бусдыг чирэгдүүлэх үндэслэл, шалтгааныг үүсгэж болохгүй” гэж заажээ.

Ерөнхий харьяаллын шүүх болон дагнасан шүүх аль аль нь иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалах зорилготой бөгөөд шүүх тус бүр өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд тодорхой төрлийн маргааныг харьяалан шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл, ИХШ нь иргэн,

хуулийн этгээдийн хоорондын диспозитив харилцаанаас үүдсэн иргэний эрх зүйн маргаан, ЗХШ нь захиргаа ба иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн императив шинжтэй нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ гэдэг нь эрх зүйн онолын хувьд нэгэнт тогтсон ойлголт бөгөөд манай улсын эрх зүйн тогтолцоо ч үүнтэй ижил билээ.

Гэвч бодит байдалд буюу шүүхийн практикт ИХШ болон ЗХШ-ийн харьяаллын маргаанд хамаарах хэрэг маргааны төрлийг яг цав тогтооход хүндрэлтэй бөгөөд ялангуяа, бүртгэлийн болон өрсөлдөөний эрх зүй, төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа зэрэг нийтийн болон хувийн эрх зүйн аль алины шинжийг агуулдаг салбар дундын шинжтэй харилцаанаас үүссэн маргааны тухайд шүүхийн харьяаллын асуудал хөндөгддөг.

Тиймээс энэхүү шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний судалгааны хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоо бүхий маргааныг захиргааны хэргийн шүүх хэрхэн шийдвэрлэж буй талаар болон тухайн бүртгэлтэй холбогдох маргаан дахь нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн маргааны агуулгыг зөв тодорхойлон шийдвэрлэж чадаж байна уу гэдэгт дүн шинжилгээ хийсний үр дүнг дараах байдлаар нэгтгэн дүгнэв.

1. БҮРТГЭГЧИЙН ХЯНАЛТЫН ЭРХИЙН ТАЛААР

Бүртгэлийн тогтолцооны үндсэн хоёр төрөл байдгаас манай улс гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага бүртгэлийг хөтөлдөг тогтолцоонд хамаарч байна. Манай улстай ижил тогтолцоо бүхий бусад улсад төрийн захиргааны байгууллага бүртгэлийг хөтлөн явуулах тохиолдолд улсын бүртгэгч бүртгэл хийхдээ зөвхөн хэлбэрийн буюу процессын хяналт хийх эрхтэй байхаар зохицуулсан байдаг. Харин манай улсын бүртгэлийн хууль

тогтоомжид бүртгэгчийн хяналтын эрхийн тухайд ямар төрлийн хяналт хийх эрхтэй талаар хуульд шууд тодорхойлон заагаагүйгээс улсын бүртгэгч ХЭБ хийхдээ бүртгэх эсэхээ өөрийн үзэмжээр шийдвэрлэх боломжтой байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Түүнчлэн, дүн шинжилгээ хийсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс үзэхэд улсын бүртгэгч хэлбэрийн хяналт хийх эрхтэй гэж шийдвэрлэсэн тохиолдол давамгайлах боловч цөөн тохиолдолд агуулгын хяналт хийх байхаар дүгнэж, хэргийг шийдвэрлэсэн нь захиргааны шүүхийн хүрээнд хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоо бүхий маргааныг шийдвэрлэхэд улсын бүртгэгчийн хяналтын эрхийн талаар нэгдсэн ойлголт тогтоогүй гэж дүгнэж байна.

Өөрөөр хэлбэл, дээр дурдсанчлан улсын бүртгэгч ХЭБ хийхдээ хэлбэрийн хяналт хийх үү, агуулгын хяналт хийх эрхтэй байх уу гэдэг асуудлыг эрх зүйн хэм хэмжээний хувьд тодорхой болгохгүй бол ЗХШ ХЭБ-тэй холбоотой маргааныг өөр өөр байдлаар шийдвэрлэсэн хэвээр, тухайн асуудлыг нэг мөр шийдвэрлэх боломжгүй байдал үргэлжилнэ.

2. ХЭБ-ТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХЭД ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХАРЬАЛЛЫН ХҮРЭЭ

Дээр дурдсанчлан ЗХШ нь маргааныг зөвхөн захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон түүнээс гарах актын хүрээнд хянан шийдвэрлэх бөгөөд хэргийн агуулгын хүрээнд хамаарах хувийн эрх зүйн шинжтэй харилцаанд үнэлэлт, дүгнэлт өгөхгүй байх ёстой. Харин ХЭБ-тэй холбоотой маргааныг шийдвэрлэх явцад ЗХШ-ийн хяналтын хүрээнд хамаарахгүй асуудалд дүгнэлт өгч, шийдвэр гаргах тохиолдол гарч байна.

Өөрөөр хэлбэл, ЗХШ-ээс ХЭБ-ийн маргааныг шийдвэрлэхдээ компанийн дүрэм журам хуульд нийцэж буй эсэх, улмаар бусад хувьцаа эзэмшигчийн эрхийг зөрчиж байгаа эсэх, хуулийн этгээд хооронд байгуулсан гэрээг тайлбарлах зэргээр дүгнэлт өгч, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгож байгаа нь ИХШ-ийн харьяаллын маргааныг ЗХШ шийдвэрлэж буй буруу жишиг юм.

Улмаар энэ асуудал нь зөвхөн шүүхийн харьяаллын асуудлаар үл хязгаарлагдах бөгөөд салбар эрх зүйн зөрчилдөөн бий болгох эрсдэлтэй тул нэг асуудлаар хоёр шүүх тус тусдаа шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ. Тодруулбал, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ авч үзсэн тохиолдолд нэг хэргийн ижил асуудалд ИХШ, ЗХШ тус тусдаа шийдвэр гаргасан явдал бөгөөд ИХШ болон ЗХШ ижил асуудлаар өөр шийдвэр гаргасан тохиолдолд аль шүүхийн шийдвэрийг хүчинтэй хэмээн үзэх вэ гэдэг дараагийн асуудал тулгарах болно.

Өөрөөр хэлбэл, нэг маргааны талаар хэд хэдэн шүүхэд хандах боломжтой байх нь нэг талаар иргэн, хуулийн этгээдийн эрхээ хамгаалах бололцоог нээсэн мэт боловч эсрэгээрээ цаг хугацаа их зарцуулах, үүний улмаас бизнесийн үйл ажиллагаанд саад болох зэргээр тус эрхээ буруугаар ашиглаж, бусдын эрхэд халдах нөхцөлийг бүрдүүлэх шалтгаан болж буйг үгүйсгэх аргагүй юм.

3. ЗАХИРГААНЫ ШҮҮХИЙН ХЭРЭГЛЭХ ХЭМ ХЭМЖЭЭ

Хэдийгээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар ЗХШ нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг хэрэглэж, хэрэг, маргааныг шийдвэрлэхээр заасан боловч шүүхийн шийдвэрийн үндэслэл

хэсэг, улмаар тогтоох хэсэгт хэрэглэх хууль нь нийтийн эрх зүйн харилцааг зохицуулсан хууль тогтоомж байх ёстой. Гэтэл шүүхийн шийдвэрийн үндэслэлээ бичихдээ дээр дурдсанчлан хувийн эрх зүйн хууль тогтоомжийн материаллаг хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн үндэслэл болгож байгаа нь шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдалд сөргөөр нөлөөлөх, шүүх хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэн, шийдвэр гаргаж буйг илтгэж байна.

Мөн манай улстай адил эрх зүйн болон бүртгэлийн тогтолцоо бүхий улсуудад бүртгэлийн чиг үүргийг захиргааны чиг үүрэг бус хувь хүн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийг баталгаажуулах, хэлцлийн найдвартай баталгаат байдлыг хангах зорилго бүхий хувийн эрх зүйн харилцаа хэмээн үзэж, түүнд зориулсан эрх зүйн хэм хэмжээг бүрдүүлснийг анхааран судлах шаардлагатай.

4. ХЭБ-ИЙН МАРГААНЫ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ БА ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХАМААРАЛ

Харьцуулсан судалгаанаас үзэхэд Япон болон ХБНГУ-ын аль алинд нь арилжааны бүртгэл нь хувийн эрх зүйн салбарын тусгай хууль болох нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, арилжааны буюу манай улсын хувьд ХЭБ нь шүүх болон захиргааны байгууллага бүртгэл хийхээс үл хамаарч, хувийн эрх зүйн суурьтай харилцаа гэдэг шалгуурыг чухалчлан, бүртгэлийн процессоос гадна бүртгэлийн эрх зүйн үр дагаврыг нарийвчлан зохицуулсан байна.

Үүнээс үзэхэд хэдийгээр арилжааны бүртгэлийн маргаан нь бүртгэл хөтлөх байгууллагын маргаан бус, бүртгэл хийгдсэний дараах эрх ашиг нь хөндөгдөж буй хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, гэрээний нөгөө талын хэлцлийн баталгаат байдал, итгэлийг хамгаалах маргаан болдог онцлогтой байна.

Манай улсын хувьд эсрэгээрээ талууд ИХШ-ээр эрх ашиг нь зөрчигдсөн талаар мэтгэлцэж, маргаанаа шийдвэрлүүлэхээс илүүтэйгээр төрийн байгууллагын шийдвэр нь хууль бус гэх үндэслэлээр ХЭБ-ийн бүхий л маргааныг ЗХШ-ийн маргаан болгон хувиргаж байна.

Тиймээс энэхүү судалгааны хүрээнд хөндөгдсөн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар дараах саналыг гаргаж байна.

1. Хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотойгоор улсын бүртгэгч хэлбэрийн хяналт уу, эсвэл агуулгын хяналт хийх үү гэдгийг эрх зүйн хэм хэмжээний түвшинд тодорхой болгох шаардлагатай байна.
2. Хэрэв улсын бүртгэгч агуулгын хяналт хийх эрхтэй гэх онолыг баримтлан, эрх зүйн зохицуулалтыг тайлбарлавал одоогийн бүртгэлийн хууль тогтоомжийг агуулгын хяналтад зориулсан байдлаар өөрчлөх шаардлагатай. Тухайлбал, улсын бүртгэгчийн ур чадвар, бүртгэл хийгдэх хугацаа, буруу бүртгэлийн улмаас бизнест учирч буй хохирлыг нөхөн төлөх тухай асуудал гэх мэт. Судлаачийн хувийн байр суурь бол одоогийн улсын бүртгэлийн тогтолцоонд нийцсэн буюу улсын бүртгэгч зөвхөн хэлбэрийн хяналт хийх эрхтэй болохыг хуульд тодорхойлон заах нь зүйтэй.
3. Хэрэв улсын бүртгэгч хэлбэрийн хяналт хийх эрхтэй байх онолыг баримталбал, ЗХШ-ээс маргааныг шийдвэрлэхдээ ХЭБ хийсэн улсын бүртгэгч хуульд заасан процессын дагуу бүртгэлийг хийсэн үү гэдэгт хэлбэрийн буюу процессын хяналт тавих бөгөөд ЗХШ өөрөө агуулгын хяналт хийхгүй байх ёстой. Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн хууль тогтоомжийн материаллаг хэм хэмжээг тайлбарлан хэрэглэхгүй ба харин бүртгэлд бүртгэгдсэн баримт бичгийн агуулга нь хуульд нийцээгүй, бусад

этгээдийн эрх ашгийг зөрчсөн гэж үзвэл тухайн маргааныг ИХШ хянан шийдвэрлэнэ гэдгийг тодорхой болгох шаардлагатай.

4. ХЭБ-тэй холбоотой ИХШ болон ЗХШ-д давхар нэхэмжлэл гаргах тохиолдолд нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн харилцааг ялган зааглаж, бусад шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааны агуулгад дүгнэлт өгөхгүй байх ёстой бөгөөд хоёр шүүхэд маргаан зэрэг хянан шийдвэрлэгдэж буй тохиолдолд дээрх зарчмын дагуу ЗХШ процессын буюу хэлбэрийн хяналт, ИХШ агуулгын хяналт тавих зарчмыг баримтлах нь зүйтэй.
5. Эцэст нь зөвхөн хуулийн этгээдийн бүртгэл бус, эд хөрөнгийн эрхийн бүртгэл нь өмчийн эрх баталгаажуулах, бизнесийн харилцааг түргэн шуурхай, баталгаатай явагдахад чиглэгдсэн хувийн эрх зүй суурьтай харилцаа гэдгийг хүлээн зөвшөөрч, бизнест холбогдох аливаа маргааныг талуудын оролцоо бүхий диспозитив зарчимд суурилан шийдвэрлэх нь оновчтой арга зам болохыг тэмдэглэх нь зүйтэй бөгөөд энэ талаарх бусад орны эрх зүйн зохицуулалт, шүүхийн практикийг дэлгэрүүлэн судлах шаардлагатай гэж үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Захиргааны ерөнхий хууль, <https://www.legalinfo.mn/law/details/11259?lawid=11259> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)
2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/11703?lawid=11703> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)
3. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаартай “Монгол Улсын Их хурлын 2017 оны 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааны хянан шийдвэрлэсэн тухай” дүгнэлт.
4. Ханс Зайделийн сан, Арилжаа (Худалдаа)-ны хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааны тайлан, 2018.
5. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/13591?lawid=13591> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)
6. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 1 дүгээр улирлын тоон мэдээ, <http://burtgel.gov.mn/post/38421> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)
7. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, <https://www.legalinfo.mn/law/details/13537?lawid=13537> (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 10-ны өдөр зочлов)
8. “АМ” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл

дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 767 дугаар тогтоолтой захиргааны маргаан.

9. “АМ” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 471 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 221/МА2016/0585 дугаар магадлалтай, хяналтын шатны захиргааны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 403 дугаар тогтоолтой захиргааны хэрэг.
10. Б.Б-н нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2018/0413 тоот шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 221/МА2018/0491 тоот магадлал, Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 476 тоот тогтоолтой захиргааны хэрэг.
11. “КБ” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 128/ШШ2017/0756 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 221/МА2017/0864 дүгээр магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 53 дугаар тогтоолтой захиргааны хэрэг.
12. Л.Б нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 128/ШШ2019/0033 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны

шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 221/МА2019/0166 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 163 дугаар тогтоолтой захиргааны маргаан.

13. “МКК” ХХК-ийн нэхэмжлэлтэй ТӨБЗГ, ОӨУБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 128/ШШ2018/0272 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 221/МА2018/0415 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолтой захиргааны маргаан.
14. “МКК” ХХК-ийн нэхэмжлэлтэй ТӨБЗГ, ЭҮ, ОӨУБЕГ-т холбогдох Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 181/ШШ2017/01956 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 2092 дугаар магадлал, Улсын дээд шүүхийн иргэний хэргийн шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 001/ХТ2017/01562 дугаар тогтоолтой иргэний маргаан.
15. “ТК” ХХК-ийн нэхэмжлэлтэй УБЕГ-т холбогдох Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 128/ШШ2019/0039 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 221/МА2019/0219 магадлалтай, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2019 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн тогтоолтой захиргааны хэрэг.
16. 海老澤 毅 (2010) 「商業登記法」 法学書院、 37頁.

17. 松本 (2018年)「会社法・商業登記全対象」、(Commercial Registration) 34頁.
18. 大塚英明(2008年)「商法総則・商行為法」第2版、91-94頁.
19. 高野 修(2002)「行政判例研究」『アルテスリバラレス 岩手大学人文社会科学部紀要』127-137頁.
20. 公益財団法人商事法務研究会(平成28年1月)「外国法制等の調査研究業務の報告書」『ドイツの商業登記制度』、184頁.
21. 商業登記法 (Япон Улсын Арилжааны үйл ажиллагааны бүртгэлийн тухай хууль), https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=338AC0000000125 (Хамгийн сүүлд 2020 оны 8 дугаар сарын 15-ны өдөр зочлов)



З

СОНГУУЛИЙН МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШБАЛБАРЫН ГАНГАБААТАР (LL.D)

Хууль зүйн ухааны доктор, Хууль зүйн сургуулийн профессор Д.Гангабаатар нь 1998 онд Гадаад хэлний дээд сургуулийг орчуулагч мэргэжлээр, 2002 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн. 2005 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд хууль зүйн ухааны магистр, 2011 онд Нагоягийн Их сургуулийн Хууль зүйн сургуульд хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2007 онд Нидерланд Улсын Утрехтын Их сургуульд зочин судлаач, 2008 онд Их Британийн Бэлфастын Хатан Хааны Их сургуульд зочин судлаач, 2012 онд Америкийн Нэгдсэн Улсын Жон Маршаллын хуулийн сургуульд зочин судлаачаар ажиллаж байсан. Мөн 2014 онд Япон Улсын Нагоягийн Их сургуулийн дэд профессор, профессор цол хүртсэн ажээ.

Судалгааны
багийн ахлагч:

Д.Гангабаатар
(LL.D) профессор

Судлаачид:

Б.Баттуул (LL.M,
MBA)

Б.Гүнжидмаа
(Ph.D.)

Б.Түвшинжаргал
(LL.M)



БАТ-ЭРДЭНИЙН БАТТУУЛ (LL.M, MBA)

Хуульч, судлаач Б.Баттуул нь Нээлттэй Нийгэм Форумын засаглалын хөтөлбөрийн менежер, International IDEA олон улсын байгууллагын төслийн зохицуулагчаар ажиллаж байсан. Үүнээс өмнө АНУ-ын Азийн Сангийн "Авлигатай тэмцэх" хөтөлбөрийн ажилтан, ЗГХЭГ-ийн дэргэдэх ТЗҮААЭГ-ийн хуулийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан.

Б.Баттуул нь МУИС-ийн Хууль зүйн сургууль, Япон улсын Бодлогын Судалгааны Үндэсний Институт, АНУ-ын Флорида мужийн Сэнт Томасийн Их сургуулийг тус тус төгсөж, мэргэжил дээшлүүлсэн, Хууль зүйн ухааны докторант, Олон улсын бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.



БАТСУУРИЙН ГҮНЖИДМАА (PH.D)

2004 онд Хан-Уул дээд сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр, 2007 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын магистр, 2021 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйн бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. 2016 онд Тайландын Үндэсний хөгжлийн удирдлагын институтэд Гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийн үр нөлөө сэдвээр Удирдахуйн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалсан.

Монголын Менежментийн холбоо, Удирдлагын академи, Хөгжлийн академи ТББ, Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институтэд ажилласан туршлагатай.



БАТСАЙХАНЫ ТҮВШИНЖАРГАЛ (LL.M)

2012 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгсөж 2018 онд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. “Арвайн-Үндэс” ХХК, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд ажилласан туршлагатай. 2017 оноос өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ГАРЧИГ

УДИРТГАЛ.....	197
НЭГ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	199
1.1. Сонгуулийн маргаан	199
1.2. Сонгуулийн тогтолцоо	200
1.3. Сонгуулийн эрх зүйн шинэтгэл	202
1.4. Үндсэн хуулийн зохицуулалт	204
1.5. Эрх зүйн зохицуулалт ба сонгуулийн маргаан	205
1.6. Шүүхийн харьяалал	210
1.7. Нэр дэвшигчийн баталгаа	214
ХОЁР. СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТООН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ	216
2.1 Бүртгэлтэй холбоотой маргаан.....	220
2.2 Сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбоотой маргаан	228
2.3 Санал хураалт дууссаны дараах маргаан.....	229
2.4. Саналын хуудас, санал авахтай холбоотой маргаан .	230
2.5. Шүүхээс маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн байдал	230

ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР:	
ХУГАЦАА, ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР	234
3.1. Сонгуулийн маргааныг шийдвэрлэх хугацаа	234
3.2. Шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагавар	244
ДӨРӨВ. СОНГУУЛИЙН МАРГААНЫ ТӨРӨЛ, АГУУЛГА	250
4.1. Бүртгэлтэй холбоотой маргаан	250
4.2. Хууль бус сурталчилгаатай холбоотой маргаан	267
4.3. Саналын хуудас, санал тоолохтой холбоотой маргаан	269
ТАВ. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА	271
5.1. Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах зарчмууд	273
5.2. Бүртгэлтэй холбоотой сайн туршлага	277
5.3. Гарын үсгийн тоо	278
5.4. Гарын үсгийн маягт	280
5.5. Гарын үсгийн маягт баталгаажуулах	282
5.6. Сонгуулийн мөрийн хөтөлбөртэй холбоотой олон улсын туршлага	284
ДҮГНЭЛТ	286
ХАВСРАЛТ	292
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	295

УДИРТГАЛ

Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөж байхад сонгуулийн хууль бус сурталчилгаа, сонгуулийн өмнөх иргэдийн шилжилт, хөдөлгөөнтэй холбоо бүхий маргаан шийдвэрээ хүлээж байдаг¹ нь сонгуулийн дараах танил дүр зураг болжээ. Иргэд сонгох, сонгогдох эрхээ хуулиар хамгаалуулж чадахгүй байгаа², сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээд УИХ-д сонгогддог, хариуцлага хүлээдэггүй байдал газар авсаар буй³ талаар хэвлэл мэдээлэл, улс төрийн нам, судлаачдын зүгээс хөндсөөр байна. Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагаас сонгуулийн үйл явцыг ажиглахаар томилогдсон Олон улсын ажиглагчдын багийн хийсэн дүгнэлтэд манай улсын хувьд сонгуулийн маргааныг цаг тухайд нь шийдвэрлэх баталгаа алга байна гэжээ⁴. Тийм учраас сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх нь холбогдох хууль тогтоомжийг сайжруулах, үр нөлөөг нэмэгдүүлэх, сонгуулийн маргааныг бууруулах,

¹ Холбогдох маргааныг эндээс үзнэ үү. (2021 оны 3 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <http://new.shuukh.mn/zahirgaanhan/2577/view>

² “Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт” Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэгт зориулсан Монголын төрийн бус байгууллагын форумын илтгэл, х.4, <https://www.gic.mn/images/upld/right%20to%20elect%20and%20to%20be%20elected%20-final.pdf>

³ “Хулгайлагдсан сонгох, сонгогдох эрх буюу Монголын сонгууль”, (2021 оны 3 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <http://www.jargaldefacto.com/article/khulgailagdsan-songokh-songogdokh-erkh-buyuu-mongoliin-songuuli>

⁴ (2021 оны 3 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

тулгамдсан асуудлыг тодорхойлох, зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, цаашлаад ардчиллыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэсэн сонгуулийн маргааны тоо, төрлийг шинжлэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийснээр шүүхийн практикт тулгамдсан асуудлыг тодорхойлох, олон улсын сайн туршлагыг судлах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар дүгнэлт хийх нь судалгааны ажлын үндсэн зорилго болно.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ харьцуулсан судалгаа, ярилцлага болон анкетын аргыг ашиглалаа. Шүүхээр шийдвэрлэсэн сонгуулийн маргааны тоо, төрөл⁵, хугацаа, шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагавар зэрэг асуудлыг судалгааны хүрээнд авч үзэв. 2012-2020 онд Монгол Улсын шүүхийн цахим санд бүртгэгдсэн сонгуультай холбоо бүхий нийт 857 шүүхийн шийдвэрээс УИХ-ын болон Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргаантай холбогдох захиргааны хэргийн шүүхийн 265 шийдвэрийг судалгаанд хамрууллаа. Харин сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргаантай холбоотой шүүхийн шийдвэр, Үндсэн хуулийн цэц болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг энэ судалгааны хүрээнд хамруулж үзээгүй болно.

⁵ Нэр дэвшигчийн бүртгэл, мөрийн хөтөлбөр, хууль бус сурталчилгаа зэрэг сонгуулийн маргааны нийтлэг төрлийг судалгаанд хамрууллаа.

НЭГ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

1.1. СОНГУУЛИЙН МАРГААН

Манай улсын сонгуулийн хууль тогтоомжид “сонгуулийн маргаан” гэсэн нэр томъёоны тодорхойлолт тусгагдаагүй байна. Харин сонгуультай холбоо бүхий маргааныг шийдвэрлэж байгаа шүүх өөрийн харьяаллын маргаан мөн эсэх талаар дүгнэлт хийсний үндсэн дээр хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэж байна. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд “... Монгол Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар⁶, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргааныг захиргааны хэргийн анхан шатны шүүх⁷ анхан шатны журмаар 30 хоногт хянан шийдвэрлэнэ” гэсэн боловч сонгуулийн маргааныг тодорхойлоогүй орхижээ.

Сонгуулийн үр дүнд нөлөөлөхүйц тооны сонгогчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоо бүхий Увс аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хамаарах маргааныг (Кэйс 1) сонгуулийн маргаан хэмээн үзээгүйн улмаас дөрвөн жил үргэлжилсэн жишээ бий. Хэрэв шүүх сонгуулийн маргаан гэж үзсэн бол тусгай журмаар, богиносгосон хугацаанд шийдвэрлэх байлаа. Захиргааны хэргийн шүүхээс зөвхөн Сонгуулийн ерөнхий хороо

⁶ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)-ийн 112 дугаар зүйлийн 112.1.3.

⁷ Мөн тэнд, 112.4.1.

болон сонгуулийн хороодод холбогдох маргааныг сонгуулийн маргаан гэж үзээд, тусгай журмаар шийдвэрлэж буй нь ийм үр дүнд хүргэжээ.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс сонгуулийн үйл явцтай холбогдох аливаа маргаан, саад бэрхшээл, шаардлага, санал зөрөлдөөнийг “сонгуулийн маргаан” гэж тодорхойлжээ⁸. Энэ тодорхойлолтын дагуу Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх сонгуулийн маргаан гэдгийг сонгууль зохион байгуулах болон сонгуулийн үйл явцтай холбоотой гарсан захиргааны байгууллагын шийдвэрт хамаарах маргаан хэмээн үзвэл зөрчигдсөн эрхээ богино хугацаанд шүүхээр хамгаалуулах, сэргээн тогтоолгох боломж бүрдэнэ⁹.

1.2. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Тогтмол зохион байгуулагддаг УИХ, Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн харилцааг Монгол Улсын Үндсэн хууль (1992), УИХ-ын Сонгуулийн тухай хууль (2019), Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2020), Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020), Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006), Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (2012), Төрийн аудитын тухай хууль (2020), Аудитын тухай хууль (2015) болон бусад холбогдох хууль эрх зүйн актаар зохицуулж байна.

1992 оноос хойших сонгуулиудаас 2012 оны УИХ-ын

⁸ “Electoral Justice” гарын авлага, АСДҮОУХ, 2010, 36 дахь тал, <https://www.idea.int/sites/default/files/publications/chapters/electoral-justice-handbook/electoral-justice-handbook-overview.pdf>

⁹ “Electoral Justice” гарын авлага, АСДҮОУХ, 2010, 9 дэх тал, <https://www.idea.int/sites/default/files/publications/chapters/electoral-justice-handbook/electoral-justice-handbook-overview.pdf>

сонгууль хувь тэнцүүлэх тогтолцоогоор, бусад нь олонхын тогтолцоогоор явагдсан билээ. Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн шийдвэрээр сонгуулийн хувь тэнцүүлэх тогтолцооны холбогдох хувилбар нь “шууд” сонгох зарчмыг зөрчсөн гэж үзсэнээр 2016, 2020 оны УИХ-ын сонгууль мөн олонхын тогтолцоогоор зохион байгуулагдав. Ийнхүү 1996, 2000, 2004, 2016 онд сонгуулийн нэг мандаттай тойрог бүхий олонхын тогтолцоогоор, 1992, 2008, 2020 онд олон мандаттай том тойрог бүхий олонхын тогтолцоогоор сонгууль явагджээ. 2020 оны УИХ-ын сонгуулийг сонгуулийн 29 тойрогт хувааж, 2-3 нэр дэвшигчид санал өгөх замаар олон мандаттай томсгосон тойргоор явуулав.

Сонгуулийн олонхын тогтолцоо нь сонгогчид нэр дэвшигчтэй нүүр тулан уулзах, таних, хариуцлага тооцох зэрэг сайн талтай хэдий ч олон сул талтай болох нь өмнөх сонгуулиудаар ажиглагдсан билээ. Мажоритар тогтолцооны хамгийн том сул тал нь сонгогчдын санал гээгдэх юм. Нэг тойрогт сонгогчдын 40 гаруй хувийн санал авсан нэр дэвшигч ялагдал хүлээж байхад өөр нэг тойрогт сонгогчдын 30 гаруй хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдох тохиолдол манай улсад гарч байлаа¹⁰. Санал гээгдэх сөрөг үр нөлөөг багасгах зорилгоор ХБНГУ, Франц, Япон, БНСУ зэрэг улс олонхын болон хувь тэнцүүлэх систем хосолсон холимог тогтолцоогоор сонгуулиа явуулдаг. Ийнхүү олонхын тогтолцоогоор сонгууль явуулдаг улс сонгуулийн холимог тогтолцоонд, холимог тогтолцооноос хувь тэнцүүлсэн тогтолцоонд шилжих чиг хандлага бусад улсад ажиглагдаж¹¹ байна.

¹⁰ Ч.Содномцэрэн, Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь, (2021 оны 3 дугаар сарын 29-ний өдөр нэвтрэв): <https://www.gec.gov.mn/post/887?n=%D0%9C%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D,%20%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB>

¹¹ (2021 оны 3 дугаар сарын 29-ний өдөр нэвтрэв): <https://www.gec.gov.mn/blog/2363>

1.3. СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

УИХ-ын 2012 оны сонгуулиас өмнө сонгогчдын бүртгэл будилаантах, гараар санал тоолох ажиллагаанд цаг хугацаа алддагаас сонгуулийн дүнг зарлах ажиллагаа удааширдаг, сонгуулийн доод шатны хороо нь дээд шатны сонгуулийн хорооноос гаргасан шийдвэр болон үүрэг даалгаврыг биелүүлдэггүй, сонгуулийн хороодын бүрэлдэхүүн улс төрийн намуудын төлөөллөөс бүрддэг зэргээс үүдэлтэй зөрчил, дутагдлууд нийтлэг ажиглагдаж байлаа¹². Жишээ нь, 2008 оны УИХ-ын ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн хороодын үйл ажиллагаанд улс төржиж талцах, санал хураалтын дүн гаргахгүй удах зэрэг алдаа дутагдал гарч, улмаар иргэдийн эсэргүүцэл даамжран, нийтийг хамарсан үймээн болж, таван хүний амьнас эрсдэн, онц байдал зарлах нөхцөл бүрдсэн юм¹³.

2008 оны сонгуулиар сонгогчдын санал хураалт 15 цаг, санал тоолох ажил дунджаар 72 цаг үргэлжилсэн байна. Энэ явцад нэг нэр дэвшигчид өгсөн саналыг өөр нэр дэвшигчийн саналд нэмж тоолох зөрчил гарсан талаар олон маргаан гарч, зарим нь олон сар шийдэгдэлгүй сунжирсан билээ¹⁴. 2008 он хүртэл сонгогчдын бүртгэл сул, санал тоолох ажиллагаа будилаантай, санал худалдаж авах явдал түгээмэл байсан бөгөөд хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах шийтгэл бага, жендерийн квотгүйн улмаас УИХ-д гуравхан эмэгтэй сонгогдсон дүр зурагтай явж иржээ¹⁵.

¹² Ч.Содномцэрэн, Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь, (2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр нэвтрэв): <https://www.gec.gov.mn/post/887?n=%D0%9C%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D,%20%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB>

¹³ Мөн тэнд.

¹⁴ Д.Энхцэцэг, Сонгуульд санал автоматаар тоолоход зайлшгүй анхаарах асуудлууд, Нээлтэй Нийгэм Форум, Бодлогын асуудал, 2011, (2021 оны 3 дугаар сарын 15-ны өдөр нэвтрэв): https://sanal.mn/files/attachments/bodlogiin_asuudal_tsuvral_VIII.pdf?fbclid=IwAR1oM0cJlOgANJpp7XhIEBVFeO-CHQwhyF1SHuGEFSMQBY34Az8vmT15Ik

¹⁵ НҮБХХ, Монгол Улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж, 2013, 6 дахь тал.

Ийнхүү 2008 оны сонгуулийн дараах жагсаал, цуглаанаас үүдэлтэй үймээний улмаас сонгуулийн тогтолцоо, сонгуулийн эрх зүйн зохицуулалтад шинэтгэл хийх улс төрийн хүсэл зориг бий болсон юм. Сонгуулийн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд 2012 оны УИХ-ын сонгуулиар анх удаа сонгуулийн холимог системийг хэрэглэх, гадаадад оршин суугаа иргэдийн сонгуульд оролцох эрхийг хангах, эмэгтэйчүүдийн квотыг нэмэгдүүлэх, жижиг намууд УИХ-д суудалтай болж төлөвших нөхцөл бүрдүүлэх, сонгуулийн дүн гаргах ажиллагаанд автомат тоолох хэрэгсэл ашиглах зэрэг олон шинэлэг эрх зүйн зохицуулалт бий болсон билээ¹⁶.

2011 онд Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль батлагдсанаар сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах ажиллагаанд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж ашиглах болов. Эдгээр эрх зүйн томоохон шинэтгэлийн үр дүнд санал тоолохтой холбогдох маргааны тоо цөөрч, 2012 оноос хойших сонгуулийн маргааны төрөл өөрчлөгдөхөд нөлөөлсөн байна.¹⁷

2020 оны сонгуулиар УИХ дахь эмэгтэйчүүдийн тоо 17 хувь буюу дэлхийн дунджаас доогуур хэвээр байна. Парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нийт нэр дэвшигчдийн 20 хувиас багагүй хувь нь эмэгтэйчүүд байх квоттой хэдий ч энэхүү зохицуулалт нь үр дүнгээ төдийлөн өгөхгүй байсаар байна. Тиймээс 20 хувийг 30 хувь болгож нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд эмэгтэйчүүдтэйгээ өрсөлдөх олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх зэргээр УИХ дахь эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.

¹⁶ Э.Гэрэлт-Од, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо: Сонголт, туршлага, <http://www.academy.edu.mn/content/legislative-election-gereltod/>

¹⁷ Гуравдугаар бүлгийг үз.

1.4. ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Сонгуулийн журмыг хуулиар тогтоохоор Үндсэн хуульд заасны дагуу УИХ хууль батлах замаар сонгуулийн харилцааг зохицуулсаар ирсэн билээ. “УИХ ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж үл болно”¹⁸ гэж Үндсэн хуульд заажээ. Энэ нь ардчилал, үндсэн хуульд ёсны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохицуулалт юм. Түүнчлэн 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор УИХ-ын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглохоор¹⁹ заасан нь ардчилсан сонгуулийн тогтолцоог тогтворжуулах, бэхжүүлэхэд чиглэсэн байна.

2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Цэц дүгнэлт гаргаж, сонгуулийн хувь тэнцүүлэх систем нь шууд сонгох эрхийг зөрчсөн гэж үзсэн юм. Үүнийг нь УИХ хүлээн авч, 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав. Цэцийн дүгнэлтээр сонгуулийн хувь тэнцүүлэх системийн холбогдох хувилбар нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэнээр 2012 оны сонгуульд хэрэглэсэн холимог тогтолцоог халж, эрх зүйн шинэтгэлээсээ ухарсан явдал болсон юм. Ийнхүү сонгууль зохион байгуулагдахаас сар гаруйхны өмнө сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, сонгуулийн системээ өөрчилсөн нь олон улсын сайн туршлагад нийцэхгүй байсан тул 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн өмнө сонгуулийн хуульд өөрчлөлт оруулахад энэхүү хязгаарлалтыг тогтоосон билээ. Үүнтэй нийцүүлж, ээлжит сонгуулийн өмнөхөн Сонгуулийн тухай хуулийн тодорхой зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргасан тохиолдолд Сонгуулийн тухай

¹⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 69.3 дугаар зүйл.

¹⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 21.4 дүгээр зүйл.

хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх, Үндсэн хуулийн дээрх зүйл заалтыг хэрхэн ойлгож, тайлбарлах асуудлыг тодорхой болгох шаардлагатай байна.

1.5. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА СОНГУУЛИЙН МАРГААН

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиудыг нэгтгэн, 2015 онд Сонгуулийн тухай хууль нэрээр томоохон хууль батлан гаргаж байлаа. Энэ нь сонгуулийн нэгдсэн хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт алхам болсон²⁰ талаар олон улсын байгууллагаас сайшааж байсан хэдий ч 2020 оны сонгуулийн өмнө тус тусдаа бие даасан хууль болж батлагдсан юм.

Тавигдах шаардлага болон хянан шийдвэрлэх ажиллагаанд тус бүрийнх нь онцлогийг тусгах зорилгоор дээрх гурван сонгуулийг тусдаа хуулиар зохицуулжээ. Дээрх сонгуулиуд бүгд зохион байгуулалтын хувьд онцлог шинжтэй тул нэг хуулиар зохицуулахад бэрхшээлтэй тал бий. Хуулийн зүйл заалтыг сонгуулийн харилцаанд оролцогчид өөрийнхөөрөө тайлбарлаж хэрэглэх, үүнээс үүдэн хууль хэрэглээний хувьд хүндрэл үүсэж, сонгуульд оролцогч талуудын хооронд маргаан гарах шалтгаан болсон байна²¹. Тухайлбал, хэрэг маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ тухайн сонгуультай холбоотой нарийвчилсан зохицуулалт байхгүй тохиолдолд өөр сонгуулийн харил-

²⁰ ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны 2016 оны УИХ-ын сонгуулийн тайлан, 5 дахь тал, (2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр нэвтрэв): <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

²¹ Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал, 2020.

цаанд хамаарах Сонгуулийн тухай хуулийн (2015) зохицуулалтыг авч хэрэглэж болох эсэх асуудал маргаан дагуулж байв. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухайлсан маргааныг зохицуулсан зохицуулалт байхгүй тул нэхэмжлэгч (Кэйс 1) УИХ-ын сонгуульд хамаарах хуулийн зүйл заалтыг хэрэглэх талаар шүүхэд хандсан байна. Шүүхээс тухайн асуудлыг нэг хуулиар зохицуулсан тул орон нутгийн Хурлын сонгуулийн маргаанд УИХ-ын сонгуульд хамаарах хуулийн зохицуулалт үйлчилнэ хэмээн үзжээ. Гэвч сонгууль зохион байгуулж буй Сонгуулийн Ерөнхий Хорооны (СЕХ) зүгээс эрх зүйн тусдаа статустай, сонгуулийн зохицуулалт нь өөр өөр байх тул ийнхүү адилтган авч үзэх боломжгүй юм гэж үзсэн байна.

Кэйс 1²².

Нэр дэвшигч Л.А-г Сонгуулийн тухай (2015) хуулийн 158 дугаар зүйлийн 158.1 дэх хэсэгт заасан сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа зөрчил гаргаж, хууль тогтоомж зөрчсөн байх буюу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн хувьд 501-ээс доошгүй дэмжигчийн гарын үсгийг цуглуулсан байхаар хуульд заасан боловч Л.А-н хувьд дээрх хуулийн шаардлагыг хангаагүй зөрчилтэй байсан тул Нийслэлийн Сонгуулийн хорооноос “Бие даан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах” тухай 34 тоот тогтоол гаргажээ. Л.А үүнийг эсэргүүцэн, шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд анхан болон давж заалдах шатны шүүхээс дараах үндэслэлээр сонгуулийн хорооны шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ

Анхан шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл²³

...Сонгуулийн тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.4-

²² <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1493/view>

²³ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 432 тоот шийдвэр, <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1493/view>

т “Бие даан нэр дэвшигчээс сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн өөрийн нэр, эцэг, эхийн нэр регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна” гэж заасан байх бөгөөд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.А-г дэмжин, гарын үсэг зурсан сонгогчдын нэрсийн жагсаалтыг нягтлан шалгаж “хөдөлгөөнт болон суурин утас дутуу, энэ утсан дээр тийм хүн байхгүй зэрэг тайлбарыг зөрчил гэж үзсэн” хэмээн тайлбарлаж байх боловч [сонгогч] “утасгүй” байгаа явдалд нэр дэвшигчийг буруутгах боломжгүй юм. ...Сонгогч “утасгүй” байгаа нь бие даан нэр дэвшигчээс үл хамаарах бөгөөд хаягийг гүйцэд бичээгүй гэсэн зөрчил нь бичиглэлийн алдаа байна. Иймээс Л.А-г бие даан нэр дэвшигчээр бүртгэхгүй байгаа Нийслэлийн Сонгуулийн Хорооны эс үйлдэхүй нь хууль бус байх тул... Л.А-ийг нэр дэвшигчээр бүртгэхийг даалгах нь зүйтэй.

Давж заалдах шатны магадлалын үндэслэл²⁴

Бие даан нэр дэвшигчийг дэмжигч сонгогчийн гарын үсгийг бүрдүүлэх маягтад тухайн сонгогчийн хөдөлгөөнт болон суурин утасны дугаар заавал бичсэн байх ёстой гэсэн шаардлагыг хангаагүй хэмээн үзэж, зөрчилд тооцсоныг шүүх хууль ёсны шаардлага гэж үзэх боломжгүй байна. Хариуцагчийн зүгээс Улсын Их хурлын сонгуулийн харилцаанд хэрэглэгдэх зохицуулалтыг үндэслэж... нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан гэх тайлбар, гомдол үндэслэлгүй байна.

Учир нь *Сонгуулийн хуулийн (2015 он) орон нутгийн Хурлын сонгуулийн харилцааны зохицуулалтад болон*

²⁴ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 221/МА2016/0378 тоот магадлал, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/793/view>

бие даан нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичигт ийм нөхцөл, шаардлага заагаагүй бөгөөд Сонгуулийн хуулийн 156 дугаар зүйлийн 156.2.2-д заасан 501-ээс доошгүй сонгогчдын гарын үсгийг ирүүлсэн байх шаардлагыг нэхэмжлэгч хангасан байна.

Сонгогч хөдөлгөөнт болон суурин утас ашигладаггүй, утсаа бичихийг хүсээгүй болон алдаатай бичсэн нь сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй хэмээн 2015 оны Сонгуулийн тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.4-д буюу УИХ-ын сонгуультай холбоотой хэсгийг эшлэн, анхан шатны шүүхээс дүгнэлт гаргажээ. Сонгуулийн тухай хуулийн орон нутгийн Хурлын сонгуулийн зохицуулалтад бие даан нэр дэвшигч нь гарын үсэг бүрдүүлэх маягтад тухайн сонгогчийн хөдөлгөөнт болон суурин утасны дугаар заавал бичсэн байх шаардлагыг тусгаагүй тул УИХ-ын сонгуулиар шаардсан шаардлагыг орон нутгийн Хурлын сонгуульд баримтлах нь үндэслэлгүй гэж давж заалдах шатны шүүх үзжээ. Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ анхан шатны шүүхийн шийдвэрт тусгагдсан УИХ-ын сонгуультай холбоотой хэсгийн зохицуулалтыг хэрэглэхгүй бөгөөд зөвхөн орон нутгийн Хурлын сонгуулийн хэсэгт тусгасан шаардлагыг баримтлах нь зүйтэй гэсэн үндэслэлээр шийдвэрээ гаргажээ. Энэхүү кэйс нь 2015 оны Сонгуулийн тухай нэгдсэн хуулийг СЕХ болон шүүхээс тус тусын ойлгосноор тайлбарлаж буйг харуулж байна. Түүнчлэн анхан шатны шүүхээс 2015 оны Сонгуулийн хууль нь нэгдмэл хууль тул УИХ-ын сонгуулийн заалт нь орон нутгийн Хурлын сонгуулийн маргаанд үйлчилнэ гэж үзсэн бол давж заалдах шатны шүүхээс тус тусад нь авч үзнэ хэмээн дүгнэсэн байна.

Монгол Улсын хэмжээнд УИХ-ын ээлжит сонгууль 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020 онд найман удаа, аймаг нийслэл, сум дүүргийн ээлжит сонгууль дээрх онд мөн найман

удаа тус тус зохион байгуулагджээ. Энэ хугацаанд сонгуулийн хууль тогтоомж 1992 оноос хойш нийт есөн удаа өөрчлөгдсөн байна (Хавсралт 1). Сонгуулийн хуулийг сонгууль болохоос хэдхэн сарын өмнө батлах практик тогтсон тул хуулийн шинэ зохицуулалт, өөрчлөлтийг оролцогч талууд нэг мөр ойлгож, дагаж мөрдөхөд хүндрэл үүссээр байна. Тухайлбал, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй УИХ-ын Сонгуулийн тухай хууль нь 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан билээ²⁵. Тиймээс дээр дурдсанчлан сонгуулийн хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангах, олон нийтийн ардчилсан сонгуульд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд УИХ-ын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн хугацаанд сонгуулийн хууль, тогтоомжийг шинээр батлах, нэмэлт, өөрчлөлт оруулахыг 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр хориглосон юм.

Хэдийгээр сонгуулийн өмнөхөн хууль өөрчлөгдөх, сонгуулийн системээ өөрчлөх зэрэг сонгуулийн эрх зүйн тогтворгүй байдал нь сонгуулийн маргаан гарах шалтгаан болж байсан ч манай улсын сонгуулийн хууль тогтоомж ерөнхийдөө ардчилсан сонгууль явуулах суурийг хангалттай тавьсан гэж үздэг²⁶. Гэвч хууль хоорондын уялдаа тааруу, хуулийн хэрэгжилт, холбогдох дүрэм журмын талаар олон нийтийн мэдлэг дутмаг байгаа зэрэг нь Монгол Улсад хийгдэж буй сонгуулийн болон улс төрийн шинэчлэлийн нааштай үр дүнг баллах боломжтой гэдгийг НҮБ-аас анхааруулсан билээ²⁷. Сонгуулийн эрх зүйн тогтворгүй байдал нь сонгуулийн маргаан гарах нэг нөхцөл болж, маргааны төрөл, тооны өөрчлөлтөд нөлөө үзүүлж байна. 2012 оны сонгуулийн эрх зүйн шинэтгэл зарим төрлийн сонгуулийн маргааны тоог

²⁵ 2012 оны сонгуулийн хууль 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан бөгөөд сонгуульд оролцогчид талууд хуулийг нэг мөр ойлгон дагаж мөрдөхөд хугацаа бага байгаа талаар НҮБ-ын шинжээч мөн л дурдаж байв.

²⁶ ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон сонгуулийн ажиглах хорооны тайлан, 2017, https://www.osce.org/files/f/documents/1/3/366136.pdf?fbclid=IwAR2KR3SHOqFeCAVS_lyZv_K1t_l1wXsfpZsy6rQMFy-z6BEZh1O_W3llnuw

²⁷ "Монгол Улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж 2008-2012", НҮБ, 7 дахь тал.

бууруулахад нөлөөлсөн бол 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт сонгуулийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн алхам болжээ. Цаашид сонгуулийн тогтолцооны сонголт, сонгуулийн эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдал, сонгуулийн төв байгууллагын бүрэн эрх зэрэг нарийвчилсан эрх зүйн зохицуулалт шаардсан асуудлууд байсаар байна.

1.6. ШҮҮХИЙН ХАРЬАЛАЛ

Сонгуулийн маргааныг захиргааны болон эрүүгийн хэргийн шүүх, түүнчлэн Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байна. Сонгуулийн маргааны шүүхийн харьяаллын асуудлыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019), Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020), Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017) зэрэг хуулиар зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд “Санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан маргааныг Үндсэн хуулийн цэц²⁸ хянан шийдвэрлэх бөгөөд харин үүнээс бусад Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдох маргааныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ”²⁹ гэж заажээ. Захиргааны хэргийн шүүх нь сонгуулийн маргааныг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан³⁰ тусгай журмаар шийдвэрлэж байна. Сонгуу-

²⁸ Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 66.2.2.

²⁹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 81 дүгээр зүйлийн 81.3-81.4.

³⁰ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр бүлэг.

лийн асуудлаарх өргөдөл, гомдлыг тухайн шийдвэр гаргасан сонгуулийн хорооны дээд шатны сонгуулийн байгууллагад гаргана.

Өөрөөр хэлбэл, сум дүүргийн шийдвэрт холбогдуулан, аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргаж³¹, маргааныг шатлан захирах зарчмаар шийдвэрлэнэ. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуультай холбоо бүхий сонгуулийн хорооны шийдвэрийг мөн адил дээд шатны сонгуулийн хороо хянан шийдвэрлэх бөгөөд холбогдох нэхэмжлэлийг ЗХШ хянан шийдвэрлэж³² байна. Харин нэр дэвшигчийн нэр төр, алдар хүнд³³, цахим орчин ашиглан, сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих, сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараахтай холбоотой³⁴ асуудлыг эрүүгийн шүүх хянан шийдвэрлэх харьяалалтай байна.

Дээр дурдсанчлан сонгуулийн маргааныг гурван өөр шүүхэд харьяалан шийдвэрлэхээр хуульчилснаас гадна зарим төрлийн маргааныг эхлээд эрүүгийн шүүхээр, дараа нь захиргааны шүүхээр шийдвэрлэхээр зохицуулжээ. Жишээ нь: Хууль зөрчиж, сонгуулийн сурталчилгаа явуулсан тохиолдолд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-д зааснаар зөрчил гаргасан нь эрүүгийн шүүхээр тогтоогдсоны дараа Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ. Үүний дараа СЕХ-ны шийдвэрийг эс зөвшөөрсөн тал захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл

³¹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 81 дүгээр зүйлийн 81.2; Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 81 дүгээр зүйлийн 81.2.

³² Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 81 дүгээр зүйлийн 81.2-81.3.

³³ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 35 дугаар зүйлийн 35.3.

³⁴ Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 81.6.

гаргах боломжтой байна. Энэ төрлийн маргааныг эцэслэн шийдвэрлэхэд хоёр өөр шүүхээр дамжихаар хуульчлахдаа процессын хуулийн холбогдох зохицуулалтын уялдааг хангаагүйгээс хугацаа алдах, эрх нь зөрчигдсөн этгээдийн эрхийг сэргээх боломжгүй болох, шүүхийн шийдвэр үр нөлөөгүй³⁵ болох нөхцөл үүсэж байна.

УИХ-ын сонгуулийн дүн нэгэнт гарсан бол СЕХ болон захиргааны хэргийн шүүхээс Зөрчлийн тухай хууль зөрчсөн хууль бус сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор эрх нь зөрчигдсөн байж болох этгээдийн эрхийг сэргээх боломжгүй байдлаар хуульчилсан байна. Үүнээс үүдэн захиргааны хэргийн шүүх харьяаллын маргаан биш гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдол 2020 оны сонгуультай холбогдон гарсан юм³⁶. Шүүгчийн захирамжийн агуулгад нэгэнт сонгуулийн дүн гарсан бөгөөд маргаан бүхий захиргааны актын үйлчлэл дуусгавар болсон, нэхэмжлэл хангагдсан ч нэхэмжлэгчийн зөрчигдсөн гэх хууль ёсны ашиг сонирхол нь сэргэхгүй, сонгуулийн дүн өөрчлөгдөх үр дагавар үүсгэхгүй тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д зааснаар тус шүүхийн харьяаллын маргаан биш хэмээн татгалзсан байна³⁷.

Эрүүгийн шүүхээр шийдвэрлэгдэж буй сонгуулийн маргаан нь дотроо хоёр төрөл байна. Энэ нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг болон зөрчлийн хуульд заасан зөрчлийн хэрэг байх бөгөөд гэмт хэргийг гурван шатны шүүхээр, зөрчлийн хэргийг хоёр шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэхээр хуульчилжээ. Нэгэнт сонгогдож, гишүүний тангаргаа өргөсөн гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь шүүхээр эцэслэн тогтоогдсон тохиол-

³⁵ Улсын дээд шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 049/2012/0020/з тоот шийдвэр.

³⁶ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 1382 тоот захирамж.

³⁷ Мөн тэнд.

долд Үндсэн хуулийн 29.3 дугаар зүйлд “...Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна” гэж зааснаар хариуцлага ногдуулах боломжтой.

Санал татах зорилгоор амлалт өгөх, урлагийн тоглолт зохион байгуулах, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, сувилалд амраах, бараа эд зүйл өгөхөөр гэрээ хийх зэргээр Зөрчлийн тухай хууль зөрчсөн³⁸ нэр дэвшигч УИХ-ын гишүүн болсон тохиолдолд торгохоор хуульчилсан боловч гишүүнийг эгүүлэн татах эрх зүйн зохицуулалт байхгүй байна³⁹. Энэ тохиолдолд нэр дэвшигч, сонгуульд оролцогч нам, эвсэл сонгуулийн хууль тогтоомжийг зориуд зөрчөөд ч хамаагүй сонгуульд ялалт байгуулах замыг сонгох явдал түгээмэл байна⁴⁰. Орон нутгийн Хурлын сонгуулийн явцад хууль бус сурталчилгаа явуулж, хууль зөрчсөн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол сонгогдсонд тооцох тухай шийдвэрийг хүчингүй болгож, дахин сонгууль явуулна⁴¹. Харин УИХ-ын сонгуулийн тухай хууль болон Зөрчлийн тухай хууль зөрчиж, сонгогчдын саналыг татах зорилгоор шударга бусаар өрсөлдсөн этгээд нэгэнт УИХ-ын гишүүн болсон бол эгүүлэн татах хуулийн зохицуулалтгүй байгаа тул УИХ-ын сонгуулийн тухай хуульд энэ зохицуулалтыг тусгах нь зүйтэй.

³⁸ Зөрчлийн тухай хууль (2017)-ийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.16.

³⁹ НҮБХХ, Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь, Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл.

⁴⁰ Мөн тэнд, х.33.

⁴¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 74 дүгээр зүйлийн 74.3, 74.6.

1.7. НЭР ДЭВШИГЧИЙН БАТАЛГАА

2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр зургаан нэр дэвшигчийг сонгуулийн сурталчилгаа эхлэхийн өмнөхөн баривчлан, цагдан хорьсон юм. Ийм тохиолдол өмнөх сонгуулиудын үеэр гарч байсангүй. Нэр дэвшигчийн үнэмлэхээ авсан бол СЕХ-ны зөвшөөрөлгүйгээр хэрэг үүсгэх, баривчлах, саатуулах, албадан саатуулах, цагдах хорихыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулиар хориглодог⁴². Ерөнхий сайд асан УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбат нэр дэвшигчийн УИХ-ын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэлгүйгээр баривчлан хорьсон тохиолдолд гарав. Олон улсын Парламентын Холбооноос энэ асуудлаар хэрэг нээж “мөрдөн шалгах ажиллагаа хууль журмын дагуу явагдаагүй, шүүх ажиллагаа шударга явагдаагүй, парламентын гишүүний халдашгүй байдалд халдсан” гэж дүгнэсэн юм⁴³.

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2020 оны 7 дугаар сарын 6-ны өдөр хянан хэлэлцээд, Ж.Эрдэнэбатыг улс төрд нөлөө бүхий этгээд өөртөө болон бусдад давуу байдал бий болгож, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт зохион байгуулагчаар, бүлэглэж хамтран оролцсон гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар нийтийн албанд томилогдох эрхийг зургаан жилийн хугацаагаар хасаж, зургаан жил хорих ял оногдуулсан билээ⁴⁴. Энэхүү шийдвэрийг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр хянан хэлэлцээд, Ж.Эрдэнэбатад холбогдох хэсгийг хэвээр үлдээжээ. Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол,

⁴² УИХ-ын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 35 дугаар зүйлийн 35.2.1.

⁴³ <https://www.ipu.org/sites/default/files/documents/mongolia-162-e.pdf>

⁴⁴ <http://www.supremecourt.mn/news/562>

давж заалдах шатны шүүхийн магадлал хуулийн шаардлага хангаагүй гэсэн үндэслэлээр 2021 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр тус тус хүчингүй болгож, хэргийг прокурорт буцааж шийдвэрлэсэн⁴⁵ юм. Ийнхүү сонгогчдын олонхын саналыг авч, СЕХ-оос түүнийг УИХ-ын гишүүнээс сонгогдсонд тооцох тогтоол гаргасан хэдий ч хорих ял сонсоод байсан Ж.Эрдэнэбат 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр УИХ-ын гишүүний тангараг өргөж, бүрэн эрхээ баталгаажуулжээ.

⁴⁵ <http://www.supremecourt.mn/news/562>

ХОЁР. СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТООН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд www.shuukh.mn цахим хуудаст нийтлэгдсэн 2012-2021 оны 6 дугаар сар хүртэлх Захиргааны хэргийн шүүхэд анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоо бүхий 177 шийдвэр болон шүүгчийн захирамж, давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн 49 магадлал, хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн 20 тогтоол, мөн УИХ-ын сонгуулийн маргаантай холбоотой Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн 12 шийдвэр, давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн 7 магадлал нийтдээ 265 шүүхийн шийдвэрийг⁴⁶ судалж, шинжилгээ хийлээ. Эдгээр маргааныг дээр дурдсан сонгууль тус бүрээр ангилж (Хүснэгт 1) үзүүлэв.

⁴⁶ Эх сурвалж: www.shuukh.mn УИХ-ын сонгуультай холбоотой зарим маргааныг шүүхэд хянан шийдвэрлэсэн шийдвэрийг энэ цахим хуудаст байршуулаагүй байхыг үгүйсгэхгүй.

Хүснэгт 1: УИХ-ын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргаан

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн жил	Анхан шатны журмаар	Давж заалдах шатны журмаар	Хяналтын шатны журмаар	Нийт
2012	101	30	17	148
2016	64	16	3	83
2020	12	3	-	15
Нийт	177	49	20	246
УИХ-ын сонгуулийн жил		Давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар	Хяналтын шатны шүүхэд давж заалдах журмаар	Нийт
2012		2	1	3
2016		3	2	5
2020		7	4	11
Нийт		12	7	19

Дээрх хугацаанд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргааныг шүүхээр шийдвэрлэсэн тоо тогтмол буурч иржээ. Маргааны тоо буурсан шалтгааныг маргааны төрөл бүрээр нь доор тайлбарлалаа.

Хүснэгтээс үзвэл 2012 онд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотой 101 маргаан гарч байсан бол 2020 онд энэ тоо 12 болж буурсан байна. 2012 онд сонгуулийн маргааны тоо их байсан нь санал хураах өдрөөс 61-68 хоногийн өмнө⁴⁷ холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн баталснаас үүдэлтэй. Өөрөөр хэлбэл, сонгууль зохион байгуу-

⁴⁷ Хавсралт 2-ыг үзнэ үү.

лагчид болон нэр дэвшигчид шинэ эрх зүйн зохицуулалттай танилцах хугацаа, түүнчлэн, нарийвчилсан журам баталж хэрэгжүүлэх хангалттай хугацаа байгаагүй. Жишээлбэл, СЕХ нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд зааснаар хязгаарлагдмал хүрээнд буюу хууль тогтоомжид заасан дүрэм, журам, заавар, баримт бичгийн загвар маягтыг батлан гаргадаг⁴⁸ бөгөөд холбогдох аргачлал, зааварчилгааг сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлдэг. Сонгуулийн өмнө сонгуулийн хуулийг шинэчлэн баталсан нь дэмжигчдийн хуудас дээрх дэмжигчийн гарын үсэг үнэн зөв эсэхийг шалган, шийдвэрлэх аргачлал, зааварчилгаагаар аймгийн сонгуулийн хороог хангах хугацаа бага байснаас 2012 онд бие даан нэр дэвшигчийн дэмжигчийн хуудаст тавигдах шаардлагатай холбоотой маргаан зөвхөн Хөвсгөл аймагт гэхэд 18 гарчээ.

2016 оны сонгуулийн хувьд 2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулийн дагуу явагдав. Өмнө нь тус тусдаа бие даасан хуулиар зохицуулж, явуулдаг байсан Ерөнхийлөгч, Улсын Их Хурал болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан бөгөөд энэ хуулийг сонгуулийн нэгдсэн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт алхам болсон талаар олон улсын байгууллагаас сайшааж байсан хэдий ч сонгууль зохион байгуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр, зөв ойлгон хэрэглэхэд бэрхшээл тулгарч байсныг сонгуулийг зохион байгуулж явуулсан бүх шатны сонгуулийн байгууллага, сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцсон нам, эвслээс илэрхийлж байв⁴⁹. Дээрх гурван сонгууль нь зохион байгуулалтын хувьд тус тусын онцлог шинжтэй. Сонгуулийн зарим үйл явц нь тухайн сонгуулийнхаа онцлогт тохирсон хуулийн зохицуулалт шаарддаг тул нэг хуулиар зохицуулахад хүндрэл,

⁴⁸ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (2006)-ийн 7 дугаар зүйлийн 7.1.7.

⁴⁹ Б.Янжиндолгор, Сонгуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал түүнийг боловсронгуй болгох нь, УБ., 2019.

бэрхшээл тулгардаг. Хуулийн зүйл заалтыг сонгуулийн харилцаанд оролцогчид өөр өөрийн өнцгөөс тайлбарлаж хэрэглэх, үүнээс үүдэн хууль хэрэглээний асуудал үүсэж, оролцогч талуудын хооронд маргаан үүсэх шалтгаан болж байжээ⁵⁰.

Харин сонгуулийн дүн гарснаас хойш нэр дэвшигчийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломж хуулиар хязгаарлагдсантай холбоотойгоор 2020 онд иргэд шүүхэд хандах нь багассан⁵¹, сонгуулийн зарим эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой хуульчилсан зэрэг нь 2020 оны сонгуультай холбогдох маргааны тоо буурахад нөлөөлжээ. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон УИХ-ын сонгуулийн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг маргааны төрлөөр нь ангилж үзвэл сонгуулийн бүртгэлтэй холбоо бүхий маргаан 68 хувь, сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбоотой маргаан 16 хувь, санал хураалт дууссаны дараах үйл ажиллагаатай холбоотой маргаан 9 хувь байгаа бол үлдсэн 7 хувь нь саналын хуудас, санал авах ажиллагаа болон сонгуулийн бусад маргаан эзэлж байна (Хүснэгт 2). Бусад маргаан гэдэгт сонгуулийн тойрогт олгогдсон мандат, сонгуулийн хороог татан буулгах, сонгуулийн материал хуулбарлан авах, сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой маргааныг орууллаа.

⁵⁰ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал, 2020.

⁵¹ Энэ талаар удаах бүлгүүдээс дэлгэрүүлж үзнэ үү.

Хүснэгт 2: Анхан шатны журмаар хянан хэлэлцсэн сонгуулийн маргааны төрөл

Маргааны төрөл	2012		2016		2020		Нийт
	ИТХ	УИХ	ИТХ	УИХ	ИТХ	УИХ	
Сонгуулийн бүртгэлтэй холбогдох	65		46	2	9	7	129
Сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбогдох	27		4				31
Саналын хуудас, санал авах ажиллагаатай холбогдох	1		3		1		5
Санал хураалт дууссаны дараах үйл ажиллагаатай холбогдох	5	1	8	1	1		16
Бусад маргаан	3	1	3		1		8
Нийт	101	2	64	3	12	7	189

Сонгуулийн бүртгэл болон сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбоо бүхий маргааны тоо буурсан үзүүлэлттэй байгаа бол саналын хуудас, санал авах ажиллагаа, санал хураалт дууссаны дараах үйл ажиллагаа, бусад маргааны хувьд маргааны тоо төдийлөн их биш, мөн өсөлт бууралт ажиглагдахгүй байна⁵².

2.1 БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН

Сонгуулийн бүртгэлтэй холбоотой маргаан нийт 129 гарснаас бие даан нэр дэвшигчийн дэмжигчийн хуудаст тавигдах

⁵² Дээрх дүгнэлтийг хийхдээ www.shuukh.mn цахим хуудаст нийтэд нээлттэй байршуулсан шүүхийн шийдвэрт тулгуурласан болно. Зарим маргааныг шүүхэд хянан шийдвэрлэсэн шийдвэрийг энэ цахим хуудаст байршуулаагүй байхыг үгүйсгэхгүй.

шаардлагатай холбоотой 36, намын гишүүнчлэл болон намын дотоод зөрчлөөс шалтгаалсан 18, нэр дэвшигч сонгуулийн хороонд хүргүүлэх баримт материалын бүрдэл дутуу, хугацаандаа ирүүлээгүйтэй холбоотой 18, төрийн албан хаагч биш байх гэсэн шаардлагыг хангаагүйтэй холбогдох маргаан 14, нэр дэвшигч өр төлбөргүй байх шаардлагад нийцээгүй 13, мөрийн хөтөлбөр шаардлага хангахгүй байх 7, нэр дэвшигч тухайн орон нутагт байнга оршин суугч байх шаардлагыг хангаагүй 6, бусад маргаан 17 тус тус гарсан байна.

Доорх хүснэгтээс (Хүснэгт 3) харвал энэ төрлийн маргааны 29 хувь нь бие даан нэр дэвшигчийн бүрдүүлбэл зохих дэмжигчийн хуудаст тавигдах шаардлагатай холбоотой маргаан эзэлж байна. Үүнд, дэмжигчийн гарын үсэг, гэрийн хаяг, регистрийн дугаар, утасны дугаар үнэн зөв эсэхтэй холбогдох асуудал голлож байна. Намын гишүүнчлэл болон намын дотоод зөрчлөөс шалтгаалсан маргаан удаах буюу 14 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, нэр дэвшигч өөр намаас нэр дэвших эсхүл нэг намаас хоёр өөр нэр дэвшигчийн жагсаалтыг сонгуулийн хороонд хүргүүлэх гэх мэт маргаан багтаж байна. Улмаар баримт материалын бүрдэл дутуу, хугацаандаа ирүүлээгүй гэдэгт нэр дэвшигчийн зүгээс сонгуулийн хороонд ирүүлбэл зохих материалуудыг бүрэн ирүүлээгүй⁵³, засвар оруулсан материал хүргүүлсэн, эсхүл материалаа хугацаандаа хүргүүлээгүй зэрэг асуудал 12 хувийг эзэлж байна. 11 хувь нь нэр дэвшигч төрийн албан хаагч биш байх болон 10 хувь нь өр төлбөргүй байх хэмээх шаардлагыг хангаагүй гэх маргаан байв.

⁵³ Иргэний үнэмлэхийн хуулбар, татварын газрын тодорхойлолт, хөрөнгө орлогын мэдүүлэг, намтрын хуудас дутуу гэх мэт.

Хүснэгт 3: Бүртгэлтэй холбоотой үүсэж буй маргааны шалтгаанууд

Он	2012	2016	2020	Нийт
Дэмжигчдийн хуудас шаардлага хангаагүй (зөвхөн бие даан нэр дэвшигчийн хувьд)	21	11	4	36
Намын гишүүнчлэл, намын дотоод зөрчлөөс үүдэлтэй	7	8	3	18
Баримт бичгийн бүрдэл дутуу, хугацаандаа ирүүлээгүй	8	10		18
Төрийн албан хаагч нэр дэвшсэн	9	5		14
Өр төлбөргүй байх шаардлагыг хангаагүй	4	7	2	13
Мөрийн хөтөлбөр шаардлага хангаагүй	3	3	1	7
Байнгын оршин суугч биш хүн нэр дэвшсэн	4	2		6
Намаас нэр дэвшүүлэх журмыг зөрчсөн	4	1		5
Гэмт хэрэгт холбогдоогүй байх гэсэн шаардлагыг хангаагүй	1		3	4
Хандивын дансанд аудит хийлгэсэн байх			3	3
Бусад шалтгаан	4	1		5
НИЙТ				129

Бие даан нэр дэвшигчийн хуудаст тавигдах шаардлагатай холбоотой маргааны тоо буурч байгаа шалтгаан нь эрх зүйн зохицуулалттай холбоотой. Өөрөөр хэлбэл 2012 онд бие даан нэр дэвшигчийн дэмжигчийн хуудастай холбоотой 21 маргаан гарснаас 18 маргаан нь Хөвсгөл аймагт бүртгэгдсэн. Хөвсгөл аймгийн сонгуулийн хорооноос дэмжигч-сонгогчдын гарын үсгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол нэр дэвшигчийн жагсаалтаас хасах хуулийн заалт⁵⁴-ыг үндэслэн дэмжигчдийн хуудасны маягт дээр зурагдсан гарын үсэг хуурамч гэж

⁵⁴ Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2012)-ийн 27.4 дүгээр зүйл.

үзэн бие даан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан 14 тохиолдол гарсан байна. Шүүхээс дээрх 14 тохиолдлыг хянан шийдвэрлэхдээ 13-т нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн буюу тус аймгийн сонгуулийн хорооны шийдвэр үндэслэлгүй гэж үзсэн. Үлдсэн маргаан нь хаяг, регистрийн зөрчилтэй холбоотой маргаан байна.

2016 оны сонгуулиар 2015 онд батлагдсан хуульд заасны дагуу орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бие даан нэрээ дэвшүүлэгч нь сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа гарын үсэг хуурамчаар үйлдэх, хүч хэрэглэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах, сонгуулийн эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулах, батлагдсан маягтаас өөр маягтаар гарын үсэг цуглуулах болон энэ хуульд заасан бусад шаардлагыг зөрчсөн бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзана⁵⁵ гэснийг баримтлан сонгуулийн хорооноос нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдол 11 гарсан. Үүнээс 5 тохиолдол нь хуурамч гарын үсэг, 6 тохиолдол нь насан хүрээгүй дэмжигчээр гарын үсэг зуруулсан гэх маргаан байна. Дээрх 11 тохиолдлыг шүүхээс хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн буюу сонгуулийн хороог үндэслэлгүй шийдвэр гаргасан хэмээн дүгнэжээ.

Дэмжигчийн гарын үсэг цуглуулахтай холбоо бүхий маргааныг шүүх ханган шийдвэрлэж буй үндэслэл нь нийт цуглуулсан дэмжигчдийн маягтаас зөрчилтэй маягтыг хасаад, маягтын зөрчилгүй гарын үсгийн тоо нь хуульд заасан буюу орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль бол 201-ээс доошгүй байх, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль бол 501-ээс доошгүй байх шаардлагыг хангаж байгаа бол дээрх зөрчил нь бие даан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй гэсэн зарчмыг баримталсан байна.

⁵⁵ Сонгуулийн тухай хуулийн 158.4.1 дэх зүйл.

Харин УИХ-ын сонгуульд бие даан нэр дэвшигчдийн хувьд сонгогчдын гарын үсэг зуруулсан маягтыг нягтлан шалгахад бие даан нэр дэвшигчээс үл хамаарах, сонгогчийн бичиг баримттай холбоотой зөрчил илэрсэн бөгөөд маягтын зөрчилгүй гарын үсгийн тоо нь 801-ээс доошгүй бол дээрх зөрчил нь бие даан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй⁵⁶ гэсэн зохицуулалт 2015 оны Сонгуулийн тухай хуульд тусгаснаар 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр энэ төрлийн маргаан гараагүй байна.

Сонгогчдын гарын үсэг зуруулсан маягтыг нягтлан шалгахад бие даан нэр дэвшигчээс үл хамаарах, сонгогчийн мэдээлэлтэй холбоо бүхий зөрчил илэрсэн бөгөөд зөрчилгүй гарын үсгийн тоо нь хуульд заасан шаардлагыг хангаж байгаа бол дээрх зөрчил нь бие даан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй⁵⁷ гэсэн зохицуулалтыг хуульчилсан явдал нь 2020 оны орон нутгийн Хурлын сонгуулиар энэ төрлийн маргааны тоо буурахад нөлөөлжээ. 2020 онд орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулиар дэмжигчийн хуудаст тавигдах шаардлагатай холбогдох маргаан хоёр гарсан бол УИХ-ын сонгуулиар мөн хоёр маргаан гарсан байна. Дээрх маргаанууд бүгд дэмжигчийн гарын үсгийн тоо хуульд заасан тоонд хүрээгүй гэх үндэслэлээр нэр дэвшигчийг бүртгээгүй тохиолдлууд байна.

Сонгуулийн бүртгэлтэй холбоо бүхий маргааны удаах төрөлд намын гишүүнчлэл, намын дотоод зөрчлөөс шалтгаалсан маргаан жагсаж байна. Энэ төрлийн маргааны хувьд нийт 18 тохиолдол бүртгэгдсэнээс долоон тохиолдолд нэг намын хорооноос хоёр өөр нэр дэвшигчдийн жагсаалтыг сонгуулийн хороонд хүргүүлсэн, зургаан тохиолдолд нэр дэвшигч өөр намаас нэр

⁵⁶ Сонгуулийн тухай хууль (2015)-ийн 129.3 дугаар зүйл.

⁵⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тухай хуулийн 32.4 дүгээр зүйл.

дэвшсэн эсэх маргаан, үлдсэн таван тохиолдлыг бусад маргаан эзэлж байна. Жишээ нь: МАН болон МАХН 2011 онд салж, тус тусдаа үйл ажиллагаа явуулж эхэлснээр намын гишүүнчлэлд хамаатай маргаан гарах болжээ⁵⁸. Мөн тухайн орон нутгийн намын хорооноос сонгуулийн хороонд хоёр өөр нэр дэвшигчийн нэрсийн жагсаалт хүргүүлэх үед шүүхээс намын ерөнхий нарийн бичгийн даргатай холбогдон, тухайн намын хорооны нэгжийн аль даргынх нь илгээсэн нэрсийн жагсаалт хүчинтэй болохыг тодруулах шаардлага гардаг байна. Дээрх асуудал нь сонгуулийн эрх зүйн зохицуулалтаас илүүтэй нам эвслийн төлөвшил, дотоод зохион байгуулалтаас шалтгаалдаг. 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байх шаардлагыг тусгасан нь улс төрийн намын төлөвшлийг дэмжих, ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн зохицуулалт болсон юм.⁵⁹

Сонгуулийн хороонд ирүүлж буй нэр дэвшигчийн материалд тавигдах шаардлага, хугацаатай холбоотой маргаан 2012 онд найм, 2016 онд арав гарчээ. 2012 оны хувьд нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш 2 хоногийн хугацаанд багтаан нэр дэвшигч нь материалаа сонгуулийн хороонд ирүүлэх; 2016 онд хувьд нэр дэвшүүлэх ажиллагааг дууссан өдрөөс хойш 3 хоногт багтаан, орон нутгийн цагаар 17 цаг 00 минутаас өмнө тухайн шатны сонгуулийн хороонд нэр дэвшигчдийн материалыг биечлэн хүргүүлэх; 2020 оны хувьд нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан тухайн шатны сонгуулийн хороонд материалаа ирүүлнэ гэж хугацааг тодорхой тусгажээ. Харин сонгуулийн хороонд ирүүлсэн материалтай холбоотой маргааны хувьд намтрын хоёр хуудас дутуу, засвар оруулсан материал ирүүлсэн, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлээгүй, хөрөнгө орлогын мэдүүлэгтээ гарын үсгээ зураагүй илгээсэн гэх мэт хуульд

⁵⁸ 2012 оны сонгуулийн маргаан.

⁵⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19.3 дугаар зүйл.

заасан хугацаанд нөхөн ирүүлэх боломжтой багахан зөрчлүүдийг үндэслэн, тухайн шатны сонгуулийн хорооноос нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэрийг гаргасан байна.

2012 болон 2016 онд нэр дэвшигчийг бүртгэхдээ нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичгийн бүрэн гүйцэд болоод үнэн зөвийг шалгаж, нэр дэвшигчээр бүртгэх эсэх шийдвэрийг 2-3 хоногт гаргадаг байсан бол 2020 оны хувьд сонгуулийн хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авахдаа бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгах бөгөөд уг баримт бичгийн бүрдэл дутуу бол энэ хуульд заасан хугацаанд багтаан нөхөн ирүүлж болно⁶⁰ гэсэн зохицуулалт оруулсан юм. Ингэснээр нэр дэвшигч дутуу материалаа нөхөн ирүүлэх боломжийг олгосон тул энэ төрлийн маргаан 2020 онд гараагүй байна.

Сүүлийн гурван сонгуульд нэр дэвшигч нь өр төлбөргүй байх шаардлагад хамаарах 13 маргааныг шүүх шийдвэрлэжээ. 2012 онд банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өр болон хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөргүй байх гэсэн хуулийн шаардлагыг нэр дэвшигчид тавьж байсан бол 2016 онд дээрхээс гадна нэр дэвшигч нь аль нэг компанийн 51 ба түүнээс дээш хувьцааг эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх гэсэн шаардлагыг нэмсэн байна. Өр төлбөртэй нэр дэвшигчийг сонгуулийн хороо нэр дэвшигчээр бүртгэсэн тогтоолыг хүчингүй болгуулах шаардлага бүхий маргаан 2012 онд дөрөв гарсан⁶¹ бол 2016 онд сонгуулийн хорооноос нэр дэвшигчийг өр төлбөртөйд тооцон бүртгэхээс татгалзсан долоон маргаан тэр дундаа нэр дэвшигчийн хувьцаа эзэмшдэг компанийн өр төлбөртэй холбоотой маргаан гурав гарчээ. Харин

⁶⁰ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 35.1 дэх заалт.

⁶¹ 2012 оны маргаанууд өр төлбөртэй нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгуулах нэхэмжлэл бүхий агуулгатай байв.

2020 онд энэ төрлийн маргаан хоёр болж буурсан байна.

Ихэвчлэн орон нутгийн Хурлын сонгуулийн үеэр тохиолддог төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшсэн тухай маргаан сонгуулиас сонгууль хооронд буурсаар 2020 оны сонгуулиар ийм маргаан гарсангүй. 2012 оны Аймаг, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн зохицуулалтаар төрийн жинхэнэ албан хаагч нэр дэвшихээр бол албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байхаар тусгасан ч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байх хугацааг тодорхой заагаагүй. Харин 2015 оны Сонгуулийн тухай хуульд орон нутгийн Хурлын сонгуульд нэр дэвших бол сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн байх бөгөөд нэр дэвшигчээр бүртгүүлсэн өдрөөс хойш ажил, албан үүргээ гүйцэтгээгүй байвал зохино хэмээн хуульчилсан байна. 2020 оны Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч ээлжит сонгуулийн жилийн 8 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байхаар тодорхой зохицуулжээ. УИХ-ын сонгуулийн хувьд ээлжит сонгуулийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байхыг шаарддаг. Төрийн албан хаагч сонгуульд нэр дэвшихэд тавигдах хуулийн шалгуур тодорхой болсон нь сонгуулийн маргааны тоо буурахад нөлөө үзүүлжээ.

Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт хийсэн аудитын нийцлийн дүгнэлтээр зарим зүйл заалт нь шаардлага хангаагүй учир сонгуулийн хороо нэр дэвшигчээр бүртгээгүй тухай маргаан долоо гарсан байна. Нэр дэвшигч мөрийн хөтөлбөрийнхөө хуулийн шаардлага хангаж буй зүйл, заалтыг баримтлан, нэр дэвших эрхтэй гэж шүүх үзээд, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

Орон нутгийн Хурлын сонгуульд байнгын оршин суугч нэр

дэвшихтэй холбоотой маргаан 2020 онд гараагүй бол өмнөх хоёр сонгуульд нийт зургаа гарсан байжээ. 2012 болон 2016 оны орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулиар 180-аас доошгүй хоногийн өмнө шилжин суурьшиж, байнгын оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий иргэн нэр дэвших эрхтэй⁶² байв. 2020 оны хуулиар ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн сонгуулийн эрх бүхий иргэн нэр дэвших эрхтэй байхаар тодорхой, ойлгомжтой зохицуулснаар энэ төрлийн маргаан 2020 оны сонгуулиар гараагүй байна.

2.2 СОНГУУЛИЙН ХУУЛЬ БУС СУРТАЛЧИЛГААТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН

Сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбогдох маргааны хувьд хууль бус сурталчилгааны үйл ажиллагаа явуулсан буюу сурталчилгаа явуулах хуульд заасан хугацаанаас өмнө сурталчилгааг эхлүүлсэн, сонгогчдод мөнгө, эд зүйл төлбөргүй тараах, нийтийг хамарсан уралдаан, тэмцээн, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага зохион байгуулах, гадаад, дотоод аялал зохион байгуулах, амралт, сувилалд амраах, мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт өгөх, сурталчилгаанд шашны зан үйл ашигласан зэрэг маргаан 2012 онд 27, 2016 онд дөрөв гарчээ. Энэ төрлийн маргааныг зөрчлийн хуулиар хянан шийдвэрлэх болсон нь маргааны тоо буурахад нь нөлөөлжээ. Мөн сурталчилгаанд шашны зан үйл ашигласан гэх маргаан 2012 онд тав гарсан бөгөөд энэ заалтыг 2015 болон 2020 оны сонгуулийн хуулиас хассан байна.

⁶² Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухай хууль (2012)-ийн 6.2, Сонгуулийн тухай хууль (2015)-ийн 11.8.

Хугацааны хувьд сонгууль явагдаж дуусаад, сонгуулийн үр дүн гарсны дараа ч сонгуулийн хууль бус сурталчилгаа хийсэн тухай маргаан тасраагүй байна. Тухайлбал, сонгуулийн өмнө хууль бус сурталчилгаа явуулж, сонгуульд ялалт байгуулсан тул нэр дэвшигчийн жагсаалтаас хасуулах, сонгуулийн үр дүнг хүчингүйд тооцуулах, иргэдийн хурлын төлөөлөгчөөс нь эгүүлэн татуулахтай холбогдох маргаан олон байна.

2.3 САНАЛ ХУРААЛТ ДУУССАНЫ ДАРААХ МАРГААН

Санал хураалт дууссаны дараах үйл ажиллагаатай холбоо бүхий маргаан 16 гарчээ. Энэ төрөлд нэр дэвшигчийг сонгогдсон тооцуулах, ялалт байгуулсан нэр дэвшигчид иргэдийн төлөөлөгчийн үнэмлэх олгохгүй байгаа эс үйлдэхүй, бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа эс үйлдэхүй, нэр дэвшигч сонгуулийн хууль зөрчиж ялсан нь тогтоогдсон үед нөхөн сонгууль явуулах шаардлага бүхий маргаанууд зонхилж байна.

2012 онд сонгуулийг хувь тэнцүүлэх системээр явуулснаас улбаатай сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигч намын дотоод зөрчлийн улмаас намын хариуцлага хүлээсэн, намаасаа хөөгдсөн, төрийн албан хаагч болсон, эгүүлэн татсан тохиолдолд намын Б жагсаалтын эрэмбээр дараагийн хүнийг сонгогдсонд тооцуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий маргаан хэд хэд гарсныг шүүх хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Мөн сонгуулиар үнэмлэхгүй ялалт байгуулсан ч нэр дэвшигчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх хурлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс зохион байгуулахгүй байгаа эс үйлдэхүйтэй холбоо бүхий маргааны хувьд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

2.4 САНАЛЫН ХУУДАС, САНАЛ АВАХТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН

2012, 2016, 2020 оны сонгуульд саналын хуудас, санал авах үйл ажиллагаатай холбоотой нийт таван маргаан гарснаас дөрөв нь саналын хуудас дутсанаас шалтгаалан, хуулбарласан саналын хуудсаар санал авсантай, үлдсэн нэг нь саналын хуудсыг шалгах хүсэлтийг хүлээж аваагүйтэй холбогдох маргаан байна. 2012 оноос өмнө саналын хуудсыг гараар тоолдог байсан тул санал тоолох үйл ажиллагаатай холбоо бүхий маргаан их гардаг байжээ. Жишээлбэл, 2008 оны сонгуульд санал тоолох ажиллагаа гараар хийгдэж, сонгуулийн дүнд үл итгэх байдал маш өндөр байсан нь сонгуулийн дараах өдрүүдэд үймээн самуун гарахад нөлөөлжээ. Энэ асуудлыг шийдвэрлэх, будилаан гарах боломжийг хаах зорилгоор 2011 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль батлагдаж, санал тоолох үйл ажиллагаанд автоматжуулсан машин ашиглах болсон билээ. Үүний зэрэгцээ санал тоолох автомат машинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг хангахын тулд 2012 оны сонгуулийн үеэр сонгуулийн тойрог бүрээс хоёр хэсгийг санамсаргүй сонгон авч, хяналтын тооллогыг гараар үйлдэн, машины дүнтэй тулгаж байсан нь сонгуулийн харилцаанд оролцогчдын автомат машинд итгэх итгэлийг нэмэгдүүлж, 2012 оноос хойш явагдсан сонгуулийн хувьд энэ төрлийн маргааны тоо буурсан байна⁶³.

2.5 ШҮҮХЭЭС МАРГААНЫГ АНХАН ШАТНЫ ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Захиргааны хэргийн анхан, давж заалдах болон хяналтын

⁶³ Нэгдсэн Үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Монгол улсад үзүүлсэн сонгуулийн сурталчилгааны тусламж: 2008-2012, 2013.

шатны журмаар сонгуулийн маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг доор (Хүснэгт 4, 5) үзүүлэв. Дээрх маргаан шийдвэрлэсэн байдлаас үзвэл 46 хувь нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бол 33 хувь нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, 14 хувь нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, үлдсэн 7 хувь нь нэхэмжлэлийг хэсэгчлэн хангасан эсхүл хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдлууд эзэлж байна. Сонгуультай холбоотой маргааны бараг тал хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 4: Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдал

Сонгуулийн маргааныг шийдвэрлэсэн байдал	2012		2016		2020		Нийт
	ИТХ	УИХ	ИТХ	УИХ	ИТХ	УИХ	
Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн	45		36		3	3	87
Нэхэмжлэлийн шаардлагыг хэсэгчлэн хангасан	3		2	1			6
Нэхэмжлэлийг шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	33	1	19	2	7	4	66
Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан (шүүгчийн захирамж)	18	1	5		2		26
Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрч шаардлагыг бүхэлд нь хангасан	2		2				4
Нийт	101	3	64	3	12	7	189

Нэхэмжлэлийн шаардлагыг ханган шийдвэрлэж буй 87 шийдвэрээс 72 нь сонгуулийн өмнөх бүртгэлийн маргаан байсан бол 12 нь сонгуулийн сурталчилгааны тухай маргаан байна.

Харин нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 66 шийдвэрээс сонгуулийн өмнөх бүртгэлд хамаарах маргаан 37, сонгуулийн сурталчилгааны талаарх маргаан 13, санал өгсний дараах үйл ажиллагаатай холбоотой маргаан 9 тус тус хянан шийдвэрлэгдсэн байна. Дээрхээс үзвэл шүүхээс нэр дэвшигчийн сонгогдох эрхийг сэргээх тухайд түлхүү ач холбогдол өгч ажиллаж байгаа нь ардчилсан сонгуулийн системтэй манай улсын хувьд эерэг хандлага юм.

Хүснэгт 5. Давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн байдал	Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн				Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн			Нийт тоо
	2012	2016	2020	Нийт	2012	2016	Нийт	
Шийдвэрийг хэвээр үлдээсэн	17	13	4	34	11	2	13	47
Шийдвэрт өөрчлөлт оруулсан	3	3	1	7	5		5	12
Шийдвэрийг хэрэгсэхгүй болгосон	11	2	1	14	2	1	3	17
Нийт	31	18	6	55	18	3	21	76

Сонгуулийн 189 маргаанаас 55 буюу 29 хувьд нь анхан шатны шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй давж заалдах журмаар хянан шийдвэрлүүлэхээр шүүхэд гомдол гаргасан байна. Давж заалдах шатны шүүхэд ирсэн 55 маргааны 37 нь сонгуулийн өмнөх бүртгэл, 9 нь сонгуулийн хууль бус сурталчилгаа, 7 нь санал өгсний дараах үйл ажиллагаанд хамаарах маргаан байсан бол үлдсэн хоёр нь сонгуулийн санал авах үйл ажиллагаатай холбоотой болон бусад төрлийн маргаан

эзэлж байна. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийн 62 хувийг хэвээр үлдээж, 25 хувийг хэрэгсэхгүй болгож, үлдсэн 13 хувьд нь нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хугацааны хувьд 2012 оны сонгуультай холбоо бүхий маргаанд давж заалдах журмаар хянан хэлэлцүүлэхээр гомдол гаргаж буй тохиолдол нь 2016 болон 2020 онтой харьцуулахад олон байна. Жишээ нь: Дархан-Уул аймгийн сонгуулийн хорооноос анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргасан тохиолдол 14 буюу нийт 55 сонгуулийн маргааны 25 хувийг эзэлсэн байна. Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн 55 магадлалд дараагийн шатанд гомдол гаргасан 21 тохиолдол байна. Эдгээр 21 тохиолдлын 13-т нь магадлалыг хэвээр үлдээсэн бол 5 магадлалд өөрчлөлт оруулан, 3 магадлалыг хэрэгсэхгүй болгожээ.

ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР: ХУГАЦАА, ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

3.1. СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА

Шүүхээс сонгуулийн маргааныг шийдвэрлэх хугацаа болон гаргасан шийдвэрийн эрх зүйн үр дагавар нь сонгуулийн үйл явцын чухал хэсэг болдог. Хугацаа нь эрх зүйн үр дагавар үүсгэх боломжийг харуулдаг тул удаан байх нь нэг талаас ардчиллын институт, сонгуулийн тогтолцоонд итгэх сонгогчдын итгэлийг бууруулдаг⁶⁴. Нөгөө талаас хэт богино хугацаанд шийдвэрлэхээр зохицуулах нь маргааныг ул суурьтай, үр нөлөөтэй шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхэд саад учруулна. Тийм учраас олон улсын эрх зүйн шаардлага, зарчмуудад сонгуулийн маргааныг зохистой хугацаанд шуурхай шийдвэрлэхийг чухалчилсан байдаг⁶⁵.

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хугацаа урт байх нь шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагаварт нөлөө үзүүлж байна. ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооноос гаргасан 2016 оны УИХ-ын сонгуулийн тайланд сонгуулийн маргааныг цаг тухайд нь шийдвэрлэхгүй байгаа

⁶⁴ Иргэдийн сонгуульд итгэх итгэлийн нэмэгдүүлэх талаар эндээс үзнэ үү. Dashbalbar Gangabaatar, Jordi Barrat Esteve, 'Electoral reform in Mongolia: E-voting and confidence building', (NUM Law Review), issue 1, 2019.

⁶⁵ OSCE "Resolving Election Disputes", 2000. <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>

талаар дурджээ⁶⁶. Түүнчлэн, “Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” судалгааны тайланд “...анх нэхэмжлэл гаргаснаас хойш бүтэн нэг жил өнгөрөөд байхад дуусаагүй (сонгуулийн маргаан) байгаа нь сонгуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуулиар нарийн тусгах шаардлагатай” бөгөөд “...сонгуулийн холбогдолтой маргааныг захиргааны хэргийн шүүх хүлээн авч шийдвэрлэхээр хуульд заасан боловч нэгэнт сонгууль дуусаад, үр дүн нь гарсны дараа маргаан шийдэгдсэн тохиолдолд хэрхэх вэ гэсэн асуудал тодорхойгүй байна”⁶⁷ хэмээн дүгнэсэн байна.

Сонгуулийн маргаан шийдвэрлэх хугацаатай холбогдох эрх зүйн зохицуулалтаас харвал УИХ-ын болон аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн аль ч хороодын гаргасан шийдвэрийн талаар дээд шатны сонгуулийн байгууллагад⁶⁸ захиргааны акт гарснаас хойш 7 хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах боломжтой байна⁶⁹. Энэ хугацаа 2015 оны Сонгуулийн хуулиар 10 хоног байсныг 2019 онд 7 хоног болгон багасгажээ⁷⁰. Сонгуулийн хороод өргөдөл, гомдол хүлээж авснаас хойш гурав хоногийн дотор шийдвэрлэж, гомдол гаргагчид хариуг бичгээр мэдэгдэнэ.

Иргэдийн өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх СЕХ-ны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой нэхэмжлэлийг Захиргааны хэргийн шүүхэд гаргана. Захиргааны хэргийн

⁶⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны 2016 оны УИХ-ын сонгуулийн тайлан, 26 дахь тал, (2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр нэвтрэв): <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

⁶⁷ Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь, 30 дахь тал.

⁶⁸ Сонгуулийн байгууллага шатлан захирах зохицуулалттай тул аливаа сонгуулийн хорооны шийдвэрт дээд шатны байгууллагад нь гомдол гаргах шаардлагатай.

⁶⁹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 81 дүгээр зүйлийн 81.5; Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 81 дүгээр зүйлийн 81.4.

⁷⁰ Сонгуулийн тухай хууль (2015)-ийн 113 дугаар зүйлийн 113.3.

шүүхээс захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн хугацаа 60 хоног байдаг⁷¹ бол сонгуультай холбоотой өргөдөл, гомдлыг шүүхээр шийдвэрлэх хугацааг тусгай журмаар буюу богино хугацаанд шийдвэрлэхээр зохицуулжээ. Тодруулбал, УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн маргааныг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар 30 хоногийн дотор⁷², аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргааныг анхан шатны шүүхээс 30 хоногийн дотор⁷³ хянан шийдвэрлэх зохицуулалттай байна. Маргааныг хянан шийдвэрлээд гарсан шүүхийн шийдвэрийг тав хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэж албажуулан, хэргийн оролцогчдод гардуулан өгөх, ийнхүү гардан авснаас хойш таван хоногийн дотор давж заалдах журмаар талууд гомдол гаргах, гомдлыг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор хянан шийдвэрлэхээр тусгай хугацааг хуульд тусгажээ. Ийнхүү сонгуулийн маргааныг шүүхээр эцэслэн шийдвэрлэх хугацааг багасгасан нь сонгуулийн кампанит ажлын хугацааг багасгасантай холбоотойгоос гадна сонгуулийн маргааныг шуурхай шийдвэрлэх олон улсын зарчимтай нийцүүлэхэд чиглэжээ.

Давж заалдах шатны журмаар Ерөнхийлөгчийн болон УИХ-ын сонгуультай холбоотой маргааныг УДШ, орон нутгийн Хурлын сонгуультай холбоотой маргааныг давж заалдах шатны шүүхээс тус тус хянан хэлэлцэж байна. Давж заалдах шатны шүүхийн магадлалд⁷⁴ хяналтын журмаар гомдол гаргах хугацааг мөн адил тусгай журмаар буюу магадлалыг тав хоногийн дотор бүрэн эхээр нь бичгээр үйлдэж, хэргийн оролцогчдод гардуулан өгөх, ийнхүү гардан авснаас хойш тав хоногийн дотор хяналтын журмаар гомдол гаргах, гомдлыг

⁷¹ ЗХШХШТХ-ийн 63 дугаар зүйлийн 63.1.


⁷² ЗХШХШТХ-ийн 112 дугаар зүйлийн 112.1.3.

⁷³ ЗХШХШТХ-ийн 112 дугаар зүйлийн 112.4.1.

⁷⁴ Зөвхөн орон нутгийн Хурлын сонгуулийн маргаанд хамаатай.

хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор хянан шийдвэрлэх ёстой (Диаграмм 1).

Диаграмм 1. Сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн шүүхээр хянан хэлэлцэх хугацаа



Эх сурвалж: ЗХШХШТХ

2012-2020 онд Захиргааны хэргийн шүүх УИХ болон орон нутгийн Хурлын сонгуультай холбоотой 265 нэхэмжлэлийг хянан хэлэлцжээ⁷⁵. УИХ-ын сонгуультай холбоо бүхий маргааныг хянан хэлэлцэх хуулийн хугацаа 66 хоног, орон нутгийн Хурлын сонгуультай холбогдох маргааныг хянан хэлэлцэх хугацаа 97 хоног байх зохицуулалттай. Орон нутгийн сонгуультай холбоотой маргааны хувьд дээр дурдсан хугацаанд багтааж шийдвэрлээгүй тохиолдол 7 хувийг эзэлж байна. Шүүх хуралд өмгөөлөгчтэй орох эрхийг хангах болон өвчний улмаас зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаан хойшилбол энэхүү хугацаа сунгагдана.

Сунгагдсан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжлэх хугацаа тодорхойгүй болох төдийгүй сонгууль болоод өнгөрсний дараа гарсан гишүүний бүрэн эрхтэй холбоотой захиргааны шүүхийн шийдвэрийн эрх зүйн үр дагаврын талаар⁷⁶ ч хуульд тодорхой тусгаагүй байна. Тухайлбал, 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр үүссэн сонгогчийн шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой маргаан тухайн УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуустал үргэлжилж байв (Кэйс 2). Сонгуулийн маргаан гэж тодорхойлолгүй ердийн журмаар хянан хэлэлцсэн нь маргааныг дөрвөн жил сунжрахад хүргэжээ. Улмаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаар 2020 оны 9 дүгээр сард уг хэрэг хаагдсан байна.

Кэйс 2.

2016 оны УИХ-ын сонгууль улс орон даяар явагдаж нэр дэвшигч Б.Ч 8358 санал, нэр дэвшигч О.Ц 7737 санал тус тус авч, 621 саналын зөрүүгээр нэр дэвшигч Б.Ч

⁷⁵ Дээрх тоо нь www.shuukh.mn цахим хуудаст нийтэд нээлттэй байршуулсан шүүхийн шийдвэрт тулгуурласан болно. Зарим маргааныг шүүхэд хянан шийдвэрлэсэн шийдвэрийг энэ цахим хуудаст байршуулаагүй байхыг үгүйсгэхгүй.

⁷⁶ Улсын дээд шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 61 тоот шийдвэр, 27 дахь тал.

ялалт байгуулсан байна. ...Уг сонгуулийн үеэр зөвхөн Улаангом сумд гэхэд улсын хэмжээнд хамгийн их сонгогч буюу 2345 сонгогч шилжиж ирсэн нь тус сумын нийт сонгогчдын 30 хувийг эзэлсэн байв. Иймээс нэг талаас Увс аймгийн иргэд, сонгогчдын эрх ашиг ноцтой зөрчигдсөн, нөгөөтээгүүр сонгуульд оролцогч нам, нэр дэвшигчдийн тэгш, шударга, хууль дээдлэх зарчмыг баримтлан, сонгуульд оролцох, сонгогдох эрхийг зөрчсөн хэмээн үзэж, нэр дэвшигч О.Ц нь шүүхэд дараах шаардлагаар нэхэмжлэл гаргасан байна: “Санал авах байруудад ажилласан ...улсын бүртгэлийн хэлтсийн итгэмжлэгдсэн ажилтнууд шилжин ирсэн сонгогчдыг сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэхдээ Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчиж хийсэн бүртгэлүүдийг хүчингүй болгуулах, дээр дурдсан хүчингүй бүртгэл бүхий сонгогчдыг нэрсийн жагсаалтаас хасуулах” гэжээ. Үүнийг 2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хянан хэлэлцэж, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна⁷⁷. Харин Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээр 2017 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр хянан хэлэлцэж, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон, дахин хэлэлцүүлэхээр буцаах магадлал гаргажээ⁷⁸. Энэхүү магадлалыг 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр УДШ-ээс хэвээр үлдээж шийдвэрлэсэн юм⁷⁹. Ийнхүү сунжирсаар эцэст нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсанаар 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс

⁷⁷ Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 35 тоот шийдвэр, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2577/view>

⁷⁸ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 221/МА2017/0039 тоот магадлал, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1018/view>

⁷⁹ Улсын дээд шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 99 тоот тогтоол, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/739/view>

хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүгчийн 018 тоот захирамж гарсан ажээ⁸⁰.

Сонгуультай холбоотой маргааныг шүүхээр хянан хэлэлцэхдээ ийнхүү удаашруулах, мөн олон янзаар авч үзэж шийдвэрлэж байгаа зэрэг нь шүүхээр хамгаалуулах эрхээ эдлэх боломжийг бууруулж байна⁸¹. Иймээс сонгуулийн маргааныг илүү хурдан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт 2019 оны УИХ-ын Сонгуулийн тухай хууль болон 2020 оны орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд шинээр тусгажээ⁸². Уг зохицуулалтаар сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж буй эрх бүхий этгээд тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан, сонгуулийн жилдээ багтаан эцэслэн шийдвэрлэх шаардлага тавьсан юм.

Гэвч 2020 оны УИХ-ын сонгуулийн маргааныг тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлээгүй тохиолдол гарчээ (Кэйс 3). 2020 оны УИХ-ын сонгуульд оролцохоор хүсэлтээ гаргасан нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан шийдвэртэй холбогдох маргааныг⁸³ Давж заалдах шатны шүүхээс сонгуулийн маргаан хэмээн үзэж, богино хугацаанд хянан, 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр шийдвэрлэсэн байна. Харин тус шийдвэрт нэхэмжлэгчээс гомдол гаргаж, Улсын дээд шүүхэд маргаан шийдвэрлэх явцад талуудаас хүсэлт гаргаснаар хэрэг удааширч, 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр шийдвэрлэгджээ. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д “Сонгуулийн гомдол, маргааныг хянан

⁸⁰ Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 018 тоот шүүгчийн захирамж, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/7267/view>

⁸¹ (2021 оны 3 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

⁸² Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 81 дүгээр зүйлийн 81.1; Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 81 дүгээр зүйлийн 81.1.

⁸³ Улсын Дээд Шүүхийн 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 28 тоот шийдвэр, Кэйс 3.

шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд нь тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан, энэ хуульд өөрөөр заагаагүй бол тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ” гэсэн заалт хэрэгжээгүй байна⁸⁴.

Хэрэв шүүхээс нэхэмжлэлийг ханган шийдвэрлэж, нэр дэвшигчийг бүртгэхээс хууль бусаар татгалзсан гэдгийг сонгууль дуусахаас өмнө тогтоож чадаагүй (Кэйс 3) бол тухайн иргэний эрхийг сэргээх хуулийн зохицуулалт холбогдох хууль тогтоомжид тусгагдаагүй байна. Тухайн сонгуулийн жилд багтаан сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлээгүй тохиолдолд хэрхэх болон хуулийн энэ зохицуулалт нь Үндсэн хуулийн цэц, түүнчлэн бусад сонгуулийн маргааныг шийдвэрлэж буй шүүхэд хамаарах эсэх нь тодорхойгүй байна.

Кэйс 3.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 8/1921 тоот тодорхойлолт, 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 8/1967 тоот лавлагааг үндэслэн Н.Э-г авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон хэмээн үзэж, нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 98 дугаартай тогтоол гарчээ.

Н.Э нь дээрх тогтоолыг эсэргүүцэж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд Сонгуулийн ерөнхий хороонд холбогдуулан, Сонгуулийн ерөнхий хорооны 2020

⁸⁴ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд энэ зохицуулалт тусгагдаагүй.

оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 98 дугаартай тогтоолыг хүчингүй болгож, Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхийг Сонгуулийн ерөнхий хороонд даалгах, Цагдаагийн ерөнхий газарт холбогдуулан, 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 8/1921, 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 8/1967 дугаар албан бичгүүдийг тус тус илт хууль бус болохыг тогтоолгож, мэдээллийн санд бүртгэгдсэн байдлаар лавлагаа олгохыг даалгах тухай нэхэмжлэлийг гаргасан байна. Энэхүү маргааныг шүүхээс хянан хэлэлцэж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхээс дараах үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл⁸⁵: Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2012 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 326 дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 3 дахь заалтаар Н.Э-г дангаараа болон бусадтай бүлэглэн, албан тушаалын байдлыг урвуулан ашиглаж, бусдын эд хөрөнгийг завшиж, үрэгдүүлэн онц их хэмжээний хохирол учруулсан, мөн төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан, аж ахуйн нэгж байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцжээ. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхээс Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу түүнд ял оногдуулсан хэсэгт өөрчлөлт оруулан, бусад заалтыг хэвээр үлдээжээ. Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны 2012 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 775 дугаар тогтоол нь эцсийн шийдвэр байх

⁸⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 13 тоот магадлал.

бөгөөд нэхэмжлэгчийн маргаж буй Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар ял шийтгүүлээгүй, шийтгэх тогтоолын уг хэсгийг хэрэгсэхгүй болгосон гэх тайлбар үндэслэлгүй байна. Нэхэмжлэгч Н.Э нь албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хуульд зааснаар энэхүү үндэслэл нь нэр дэвшигчид хориглох зүйл, түүнчлэн нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэлд хамаарч байх тул хариуцагчийн үйлдэл хууль тогтоомжид нийцсэн гэж үзэхээр байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.8, 32 дугаар үйлийн 32.2.9, 33 дугаар зүйлийн 33.1, 33.1.2, Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан, Н.Э-ээс Сонгуулийн ерөнхий хороо, Цагдаагийн ерөнхий газар, тус газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанд тус тус холбогдуулан гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 98 дугаартай тогтоолыг хүчингүй болгож, Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхийг Сонгуулийн ерөнхий хороонд даалгах, Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 8/1921 дугаар, 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 8/1967 дугаар лавлагаануудыг тус тус илт хууль бус болохыг тогтоолгож, мэдээллийн санд бүртгэгдсэн байдлаар лавлагаа олгохыг даалгах тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл⁸⁶:
Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуул-

⁸⁶ Улсын дээд шүүхийн 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 28 тоот тогтоол.

лагаас ирүүлсэн “Ял шийтгэлийн тухай тэмдэглэл”-ийн 3 дахь нүүрэнд “ЭХ-ийн” 263.2, “3 жил”, “Өршөөл” гэж тэмдэглэгдсэн байх тул мэдээллийн санд бүртгэгдсэн эдгээр мэдээллийг үндэслэн, лавлагаа гаргасан хариуцагчийн үйлдэл хууль тогтоомж зөрчөөгүй, өөр байдлаар лавлагаа гаргахыг даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хангах боломжгүй. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн “Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай” 98 дугаар тогтоол хуульд нийцсэн; уг тогтоолыг хүчингүй болгуулж, нэр дэвшигчээр бүртгэхийг даалгах нэхэмжлэлийн шаардлага гаргасныг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр зөв байна.

Дээрх маргаантай холбоотой бас нэг асуудал хөндөгдөж буй нь авлига, албан тушаалыг хэрэгтэй холбогдуулж, тухайн иргэнд шүүх хариуцлага тооцсон хэдий ч сонгох, сонгогдох эрхийг нь дахин хязгаарлах замаар нэг үйлдэлд хоёр хариуцлага оногдуулж байна. Уг зохицуулалттай холбогдуулж, Улсын Дээд Шүүхээс албан ёсны тайлбар гаргах шаардлагатай⁸⁷.

3.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭРХ ЗҮЙН ҮР ДАГАВАР

Шүүхийн шийдвэр нь хууль зүйн нэгдмэл үйл ажиллагааны эцсийн бүрэлдэхүүн хэсэг болдгийн хувьд тодорхой хууль зүйн үр дагавар үүсгэж, зөрчигдсөн буюу маргаантай эрхийг сэргээх, түүнийг зохих ёсоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой байдаг⁸⁸. Иймд түүний тогтоох хэсэгт шийдвэрийн

⁸⁷ УДШ-ийн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбар эрхийг 2021 оны Шүүхийн тухай хуулиар баталгаажуулсан байна.

⁸⁸ Улсын дээд шүүхийн 2006 оны 04 дүгээр сарын 24-ний 21 тоот “Шүүхийн шийдвэрийн тухай” тогтоол, <http://www.supremecourt.mn/act/view/145>

үндэслэх хэсэгт дурдсан дүгнэлтийн үр дагаврыг тусгахаас гадна шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелэгдэх боломжтой байх бүх нөхцөлийг заасан байвал зохино⁸⁹.

Захиргааны хэргийн шүүхээс зарим маргааныг сонгуулийн дүн гарахаас өмнө болон хойно шийдвэрлэсэн эсэхээс шүүхийн шийдвэр хууль зүйн үр дагавартай, зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой эсэх нь хамаарч байна⁹⁰. Жишээ нь: Сонгуулийн дүнг танилцуулахаас өмнө нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрээ хүчингүй болгоогүй Сонгуулийн ерөнхий хорооны эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэхдээ нэгэнт сонгуулийн дүн гарсан бөгөөд маргаан бүхий захиргааны актын үйлчлэл дуусгавар болсон, нэхэмжлэл хангагдсан ч нэхэмжлэгчийн зөрчигдсөн гэх хууль ёсны ашиг сонирхол нь сэргэхгүй, сонгуулийн дүн өөрчлөгдөх үр дагавар үүсгэхгүй гэж дүгнэжээ⁹¹. Зөрчлийн тухай хууль зөрчиж, сонгуулийн сурталчилгаа хийсэн этгээдийг нэрсийн жагсаалтаас хасах эсэх маргааныг захиргааны хэргийн шүүх сонгуулийн дүн гарахаас өмнө⁹² шийдвэрлээгүй тохиолдолд сонгуулийн дүн гарснаас хойш нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргах боломжгүй⁹³ байна.

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 14 дүгээр дүгнэлтэд “...

⁸⁹ Мөн тэнд.

⁹⁰ Улсын дээд шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 61 тоот шийдвэр, 27 дахь тал.

“...Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн дагуу шаталсан тогтолцоотой захиргааны байгууллагын эцсийн шат болох Сонгуулийн төв байгууллагын шийдвэр эцэслэн гарч, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн (2012) 49 дүгээр зүйлийн 49.3-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган, нийтэд мэдээлсэн, улмаар Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн талаар шийдвэр гаргах эрхийг Захиргааны хэргийн шүүхэд хуулиар олгоогүй байна”. Хэдийгээр 2019 онд УИХ-ын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн баталсан боловч дээрх зохицуулалт одоог хүртэл өөрчлөгдөөгүй байна.

⁹¹ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 1382 тоот захирамж.

⁹² УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйл.

⁹³ ЗХДЗШШ-ын 2020 оны 1382 тоот захирамж.

сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгт Орон нутгийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа орон нутгийн хурлын төлөөлөгчийг нэр дэвшигчийнх нь хувьд нэрийн жагсаалтаас хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухайн төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно хэмээн хуульчилсан боловч УИХ-ын сонгуульд нэр дэвшиж сонгогдсон гишүүн тангараг өргөн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсний дараа сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл нь тогтоогдвол ямар нэгэн хариуцлага тооцох талаар Сонгуулийн тухай хуульд тусгаагүй байна” гэж дүгнэжээ.

Ийнхүү сонгуулийн дүнд байгуулагддаг Улсын Их Хурал болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд нь хүлээлгэх хариуцлагыг илтэд ялгавартайгаар, тухайлбал, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшин сонгогдож, тангараг өргөн, бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн Улсын Их Хурлын гишүүнд хүлээлгэх энэ төрлийн хариуцлагыг хуульчлаагүй нь Үндсэн хуулиар баталгаажсан шударга ёс, тэгш байдлын зарчмыг алдагдуулсан, Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалтыг зөрчсөн гэж Цэц дүгнэжээ. Гэвч 2015 оны Сонгуулийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.4 дэх хэсэгтэй ижил агуулга бүхий заалтыг 2019 оны УИХ-ын сонгуулийн тухай хууль, 2020 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан байна.

Сонгуулийн дүн гарахаас өмнө Зөрчлийн тухай хууль зөрчиж, хууль бус сурталчилгаа хийсэн эсэхийг шүүхээр эцэслэн тогтоох боломж бага байна (эйс 4). Учир нь хууль зөрчиж, сонгуулийн сурталчилгаа явуулсан тохиолдолд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т зааснаар

зөрчил гаргасан нь эрүүгийн шүүхээр тогтоогдсоны дараа Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ санал хураалт явуулахаас өмнө хүчингүй болгож, нийтэд мэдээлэх боломжтой. Гэтэл санал хураалт явуулахаас өмнө хууль зөрчиж, сонгуулийн сурталчилгаа явуулсан гэдэг нь эрүүгийн шүүхээр эцэслэн тогтоогдох боломж бага байна. Эрүүгийн шүүхээр хууль бус сурталчилгаа хийсэн эсэхийг тогтоох хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сонгуулийн сурталчилгаа явуулах хугацаатай уялдуулан, богино хугацаатай хуульчлаагүйгээс санал хураалт явуулахаас өмнө зөрчлийн асуудал шүүхээр тогтоогдохгүй байх нөхцөл бүрдсэн байна⁹⁴. Өөрөөр хэлбэл, УИХ-ын сонгуулийн тухай хууль зөрчсөн зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх хугацааг урт тогтоожээ.

Кэйс 4. УИХ-ын сонгуулийн 77 дугаар тойрогт Г намаас нэр дэвшигчид нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр А аймгийн Б сумд Г намаас нэр дэвшигчдийн сонгуулийн нээлтийн арга хэмжээний үеэр Я, О, Э нарыг дуу дуулуулж, иргэдийн санал авах зорилгоор урлагийн тоглолт зохион байгуулсан, хүн хоорондын зай баримтлаагүй, насанд хүрээгүй хүүхэд оролцсон, оролцогчид маск зүүгээгүй гэх гомдлыг 2020 оны 6 дугаар сарын 4-ний өдөр А аймгийн Б сумын цагдаагийн хэлтэст Б намаас гаргажээ.

Цагдаагийн хэлтэс зөрчлийг шалгаж, нэр дэвшигчид бус Д.Ц нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр А аймгийн Б сумд Г намаас нэр дэвшигчдийн сонгуулийн нээлтийн арга хэмжээний үеэр Я, О, Э нарыг дуу дуулуулж, иргэдийн санал авах зорилгоор урлагийн тоглолт зохион байгуулсан хэмээн үзэж, Зөрчлийн тухай хуулийн 17.1, 16.2-т зааснаар зөрчлийн хэрэг нээн, А аймгийн Б сум дахь сум

⁹⁴ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5, 6.8 дугаар зүйл.

дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр шилжүүлсэн байна.

Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн шийтгэврээр (2020.06.25 №2020/ЗШ/256): Д.Ц-ыг “Хүн ...ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор нийтийг хамарсан урлагийн тоглолт зохион байгуулсан” зөрчил үйлдсэнд тооцож, Зөрчлийн тухай хуулийн 17.1, 16.2-т зааснаар 20 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

Өвөрхангай аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 08 дугаар магадлалаар: Гомдол гаргагч нь 2020 оны 6 дугаар сарын 2-ны өдөр А аймгийн Б сумд Г намаас нэр дэвшигчдийн сонгуулийн нээлтийн арга хэмжээний үеэр 1. Урлагийн тоглолт үзүүлсэн; 2. Хүн хоорондын зай 1,5 метрээс бага байсан; 3. Оролцогчид маск зүүгээгүй байсан; 4. Насанд хүрээгүй хүүхэд оролцсон гэжээ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.2-т зааснаар гомдол мэдээлэлд дурдагдсан үйл баримтыг бүгдийг нь хуульд заасан журмын дагуу шалгасны эцэст Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг явуулах үүрэгтэй. Гэтэл гомдол мэдээлэлд дурдагдсан үйл баримтыг бүгдийг шалгаагүй зөвхөн урлагийн тоглолт үзүүлсэн гэх үйлдлийг шалгасан нь эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1.5-д заасныг зөрчсөн байна. Мөрдөгчийн даалгаварт бичигдсэн ажиллагаа хийгдээгүй, хэргийн оролцогчоор тогтоогоогүй этгээдийг оролцуулсан нь

ойлгомжгүй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.4, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3-д зааснаар анхан шатны шүүхийн шийтгэврийг хүчингүй болгож, прокурорын газарт буцаажээ.

2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр цагдаагийн дэслэгч дээрх маргааныг “зөрчлийн шинжгүй” хэмээн үзэж хэрэгсэхгүй болгосон байна. Гомдол гаргагч тус шийдвэрийг эс зөвшөөрч, дээд шатны прокурорт гомдол гаргасан бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр МУ-ын ерөнхий прокурорт гомдол гаргажээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд сонгуулийн маргааны хэрэг бүртгэлтийн ажиллагааг 14 хоног явуулж, шийтгэл ногдуулах саналыг шүүхэд шилжүүлэх, шүүхээс ажлын гурав өдрийн дотор хэргийг шийдвэрлэх, шүүхээс шийтгэврээ 5 хоногийн дотор бичгээр гаргах, 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргахаар зохицуулсан байна. Давж заалдах шатны шүүх 30 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэж, шийдвэр тухайн зөрчлийн хэргийн эцсийн шийдвэр болдог⁹⁵. Сонгуулийн дүн гарахаас өмнө зөрчил шүүхээр эцэслэн тогтоогдоогүйгээс СЕХ Зөрчлийн тухай хууль зөрчиж, сонгуулийн сурталчилгаа хийсэн этгээдэд хариуцлага ногдуулах боломж нь хязгаарлагдаж байна. Зөрчлийн хэрэг шийдвэрлэх хугацаа, сонгуулийн хорооны шийдвэр гаргах хугацаа, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааны уялдааг хангаж, тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэхтэй холбоотой хуулийн зохицуулалт оруулах замаар шүүхийн шийдвэрийн үр нөлөө, иргэдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

⁹⁵ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 14, 9.2 дугаар зүйлийн 2, 10, 12 дахь хэсэг, ЭХШХШ тухай хуулийн 39.2 дугаар зүйлийн 39.2.1.

ДӨРӨВ. СОНГУУЛИЙН МАРГААНЫ ТӨРӨЛ, АГУУЛГА

2012-2020 онд явагдсан УИХ болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотой маргаанаас сонгуулийн бүртгэлтэй холбоо бүхий маргаан 68 хувь, сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбоотой маргаан 16 хувь, санал хураалт дууссаны дараах үйл ажиллагаатай холбоотой маргаан 9 хувь, үлдсэн 7 хувь нь саналын хуудас, санал авах ажиллагаа болон сонгуулийн бусад маргаан эзэлж байна. Эдгээр ангилал тус бүрд холбогдох шүүхийн шийдвэрүүдийг доор авч үзье.

4.1. БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН

Сонгогч бичиг үсэг тайлагдаагүй байх, эсвэл хөдөлгөөнт болон суурин утасгүй, гарын үсэг цуглуулах маягтыг бүрэн бөглөөгүй зэрэг шалтгаанаар нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсантай холбоотой маргаан 2012-2020 онд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн нийт сонгуулийн маргааны 68 хувийг эзэлж байна⁹⁶. Нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоотой маргаан олон

⁹⁶ Ялангуяа, орон нутгийн Хурлын сонгуулийн хувьд нэр дэвшигчийн бүртгэл, тэр дотроо бие даан нэр дэвшигчийн дэмжигчдийн маягт дээрх гарын үсэгтэй холбоотой маргаан олон гарч байна.

байгаа болон энэ төрлийн маргааныг шийдвэрлэх хугацаа сунжирч буй нь ижил тэгш үндсэн дээр сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлаж байна хэмээн олон улсын сонгуулийн ажиглагчид дүгнэсэн байна⁹⁷.

Бүртгэлтэй холбоо бүхий маргааны хувьд бие даан нэр дэвшигчдийн дэмжигчдийн хуудаст тавигдах шаардлагатай холбогдох маргаан хамгийн олон хянан шийдвэрлэгдсэн бол намын харьяалал, дотоод зөрчлөөс шалтгаалсан, нэр дэвшигч өр төлбөргүй байх, төрийн албан хаагч нэр дэвшихгүй байх, мөрийн хөтөлбөр шаардлага хангасан байх, нэр дэвшигчийн бүрдүүлсэн материал бүрэн гүйцэд, хуульд заасан хугацаанд илгээгдсэн байх зэрэг шаардлагатай холбоотойгоор бий болсон маргаан удаалж байна.

Бие даан нэр дэвшигчдийн дэмжигчдийн хуудаст тавигдах шаардлагатай холбоотой маргааны хувьд хуулийн дагуу бие даан нэр дэвшигч нь УИХ-ын сонгуульд 801, нийслэлийн Хурлын сонгуульд 501, аймаг, дүүргийн Хурлын сонгуульд 201-ээс доошгүй дэмжигчдийн гарын үсэг тус тус цуглуулах шаардлагатай⁹⁸. Гарын үсэг цуглуулахдаа СЕХ-оос өгсөн маягтыг сонгогч-дэмжигчдээр бөглүүлдэг. Мөн “бие даан нэр дэвшигч нь сонгуулийн гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг, эхийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байх” шаардлагыг хуульд тусгажээ⁹⁹.

Нөгөөтээгүүр, бүртгэхээс татгалзсан шийдвэртэй холбогдох

⁹⁷ (2021 оны 3 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

⁹⁸ Монгол Улсын УИХ-ын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 31.2 дугаар зүйл; Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 30.2 дугаар зүйл.

⁹⁹ Монгол Улсын УИХ-ын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 31.4 дүгээр зүйл; Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020)-ийн 30.4 дүгээр зүйл.

маргааны 56 хувьд Үндсэн хуульд заасан сонгох сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарласан гэж шүүх үзжээ. Тухайлбал, нэр дэвшигч Ц.А-г Хөвсгөл аймгийн Сонгуулийн хорооноос “Бие даан нэр дэвшигч Ц.А-н ...дэмжигч-сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягтад байгаа мэдээлэл нь хуурамч, учир нь гарын үсэг цуглуулсан маягтад өөр засаг захиргааны нэгжийн харьяалалтай 1, оршин суугаа хаяг регистрийн дугаар зөрүүтэй 12, регистрийн дугаар байхгүй нэр бүхий хэд хэдэн иргэн байгаа талаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс албан бичгээр аймгийн Сонгуулийн хороонд хандсан тул нэрийн жагсаалтаас хасах тухай тогтоол гаргажээ (Кэйс 5). Анхан шатны шүүхээс хэргийг хянан үзээд, нэр дэвшигч нь дэмжигч, сонгогчдын мэдээллийг өөрөө хуурамчаар үйлдээгүй л бол иргэдийн өгсөн мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах үүрэггүй тул энэхүү зөрчлийг баримт бичиг дутуу, эсхүл хуурамчаар үйлдсэн гэдэгт хамаарахгүй хэмээн үзсэн бөгөөд хэдэн дэмжигч-сонгогчийн гарын үсэг зуруулах шаардлагын талаар ямар нэгэн дүгнэлт гаргаагүй. Давж заалдах болон хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн шийдвэрт (i) сонгуулийн хороо нь Улсын бүртгэлийн газраас бүртгэлийн зөрчилтэй гэж үзсэн иргэд сонгогчидтой уулзаж, нягтлан шалгах үүргээ сонгуулийн хороо биелүүлээгүй, үүнийг нягтлан шалгах үүрэг нэр дэвшигчид байхгүй, зөрчилтэй хэмээн үзсэн дэмжигч-сонгогчдын бүртгэлийг нийт тооноос хасахад хуулиар шаардсан тоонд хүрч байгаа тул үүнийг зөрчил гэж үзэхгүй хэмээн дүгнэжээ.

Кэйс 5.**Анхан шатны шүүхийн шийдвэрийн (№0046) үндэслэл¹⁰⁰**

Бие даан нэрээ дэвшүүлэгч Ц.А-г бичиг баримт хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон гэсэн үндэслэлээр нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хассан нь буруу бөгөөд нэр бүхий дэмжигч сонгогчдын регистрийн дугаар болон хаягийг нэр дэвшигч өөрөө хуурамчаар үйлдээгүй болох нь нэр бүхий иргэдээс ирүүлсэн цахим үнэмлэх, багийн засаг даргын тодорхойлолт зэргээр нотлогдож байгаагаас үзэхэд дэмжигч сонгогчдын гарын үсэг цуглуулсан маягтад тэдгээрийн тухай бүртгэлүүдийг бичихдээ бие даан нэрээ дэвшүүлэгч нь тухайн иргэний баримт бичиг, хаягийн бүртгэл, регистрийн дугаарыг үнэн зөв эсэхийг шалгах үүрэггүй бөгөөд хуулийн 28 дугаар зүйлийн 28.9.3-т заасан баримт бичиг дутуу эсхүл хуурамчаар үйлдсэн гэдэгт хамаарахгүй болно.

Давж заалдах шатны магадлалын (№09) үндэслэл¹⁰¹

Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй иргэдээр гарын үсэг зуруулах үед тэдгээрийн гаргаж өгсөн нэрсээс улсын бүртгэлийн хувьд зөрчилтэй гэдгийг нэхэмжлэгч нь мэдэх боломжгүй бөгөөд ийнхүү дэмжигч-сонгогчдын өгсөн мэдээллийг нэгтгэж, сонгуулийн хороонд өгсөн нь түүнийг хуурамч нотлох баримт бүрдүүлсэн гэх үндэслэл болохгүй.

Түүнчлэн тухайн орон нутагт оршин суух хаяггүй иргэний гарын үсгийг зуруулсан боловч Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-д зааснаар

¹⁰⁰ Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 0046 тоот шийдвэр, <http://old.shuukh.mn/zahirgaaanhan/1590/view>

¹⁰¹ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 09 тоот магадлал, <http://old.shuukh.mn/zahirgaadavah/325/view>

аймгийн Хурлын сонгуульд нэрээ дэвшүүлэгч нь 200 дэмжигч-сонгогчдын гарын үсгийг зуруулах байтал Ц.А 300 дэмжигч-сонгогчийнхыг цуглуулсан, үүнээс зөрчилтэй гэх хүмүүсийг хасаж тооцоход хуулийн дээрх шаардлагыг бүрэн хангасан байна.

Хяналтын шатны тогтоолын (№55) үндэслэл ¹⁰²

“...дэмжигч-сонгогчдоос 12 иргэний регистрийн дугаар зөрүүтэй, нэг иргэн тухайн орон нутагт оршин суух хаягийн бүртгэлгүй байсан нь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгаас гаргасан лавлагаагаар тогтоогдсон хэдий ч тэдний гарын үсэг үнэн зөв эсэхийг иргэний бичиг баримт, хаягийн бүртгэлтэй тулгах, дэмжигч-сонгогчтой уулзаж нягтлан шалгах хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, тэдний гарын үсэг нь хуурамч болохыг нотлоогүй атлаа Ц.А-н нэрийг нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хассан тус аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагаа Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 30 дугаар зүйлийн 30.1-д заасанд нийцээгүй байна. Түүнчлэн дэмжигч-сонгогчдын бүртгэлд байгаа 12 иргэн Хөвсгөл аймгийн Рашаант сумын сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэлтэй, тэдний регистрийн дугаар, нэг иргэний хаягийн бүртгэл зөрчилтэй байсанд бие даан нэр дэвшүүлсэн Ц.А-г холбогдуулан буруутгах үндэслэлгүй бөгөөд түүний дэмжигч-сонгогчдын тоо дээрх хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан хэмжээнээс 100 орчим дэмжигч-сонгогчоор илүү байгаа зэрэг нь тогтоогджээ. Маргаан бүхий акт нь ...бие даан нэрээ дэвшүүлсэн иргэн Ц.А сонгогдох эрхийг хөндсөн

¹⁰² Улсын дээд шүүхийн 2013 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 55 тоот тогтоол, <http://old.shuukh.mn/zahirgaahyanalt/381/view>

нь нотлогдсон тул уг тогтоолыг хүчингүй болгож, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн жагсаалтад оруулахыг даалгах тухай түүний нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн ...анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээв.

УИХ-ын сонгуулийн тухай 2019 оны хуульд “Энэ хуульд заасан сонгогчдын гарын үсэг зуруулсан маягтыг нягтлан шалгахад бие даан нэрээ дэвшүүлэгчээс үл хамаарах, сонгогчийн бичиг баримттай холбоотой зөрчил илэрсэн бөгөөд маягтын зөрчилгүй гарын үсгийн тоо нь энэ хуулийн 31.2-т заасан тооноос доошгүй бол дээрх зөрчил нь бие даан нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй”¹⁰³ гэсэн шинэ зохицуулалт оруулсан бөгөөд энэ нь гарын үсэг, дэмжигчдийн бүртгэлтэй холбоо бүхий маргааныг бууруулахыг зорьжээ¹⁰⁴. Бодит байдалд СЕХ сонгогчидтой утсаар болон биечлэн уулзах замаар гарын үсгийн үнэн, зөв эсэхийг шалгаж буй нь одоогоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байна. СЕХ-ны зүгээс сонгогчдын гарын үсэг зуруулсан маягтыг нягтлан шалгах (Кэйс 6) талаар нэгдсэн дүрэм, журам баталж хэрэгжүүлснээр энэхүү асуудлыг шийдвэрлэх боломж бий.

Кэйс 6.

СЕХ-ны 2020 оны 5 дугаар сарын 25 өдрийн нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах тухай тогтоолыг хүчингүй болгож, нэр дэвшигчийг бүртгэхийг даалгах шаардлага бүхий захиргааны хэргийг анхан шатны журмаар Захиргааны хэргийн давж заалдах шатны

¹⁰³ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 33 дугаар зүйлийн 33.4.

¹⁰⁴ 2016 онд бүртгэлтэй холбоотой маргаан 48 гарсан бол 2020 онд 16 гарсан байна. Дэлгэрэнгүйг 3 дугаар бүлгээс үз.

шүүхээс 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хянан хэлэлцэж, 221/ШШ2020/0009 тоот шийдвэрээр нэр дэвшигч Д.А-г бүртгэхийг СЕХ-нд даалгаж шийдвэрлэжээ. Энэхүү шийдвэрт холбогдуулан, СЕХ-оос давж заалдах журмаар гомдол гаргасан бөгөөд үүнийг 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр УДШ-ээс хянан хэлэлцэж, Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Тогтоолын үндэслэлд:

Хариуцагч СЕХ нь Сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж, бие даан нэрээ дэвшүүлэгч Д.А-н ирүүлсэн материалыг нягтлан шалгахад, гарын үсэг зураагүй, регистрийн дугаар бичигдээгүй, сонгогч дэмжиж гарын үсэг зураагүй зэрэг нийт 483 зөрчил илэрсэн, үүнээс шалтгаалж зөрчилгүй гарын үсгийн тоо нь 801-д хүрээгүй тул нэхэмжлэгчийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан нь хууль зөрчөөгүй гэсэн тайлбар гаргажээ. Гэвч хэрэгт нотлох баримтаар авагдсан, Бие даан нэрээ дэвшүүлэгч Д.А-н гарын үсэг зуруулсан маягтыг шалгах хуудас, Сонгогчийн гарын үсэг зуруулах маягт, тус хорооны ажилтан Г.Э-н гаргасан Тайлбар гэх зэрэг баримтуудаас үзэхэд хариуцагчийн тайлбарлаж байгаачлан регистрийн дугаар буруу, хаягтаа байхгүй, тойргийн биш, утасны дугаар буруу, зарим нь өөр нэр дэвшигчийг дэмжиж зурсан, судалгаа авч байгаа, сонгуульд ажиллуулна гэх мэтээр хуурч, гарын үсэг зуруулсан гэсэн тайлбар, үндэслэлийг нотлох баримт хэрэгт байхгүй, өөрөөр хэлбэл, нийт 483 зөрчил илэрсэн гэх үндэслэл нь баримтаар, эргэлзээгүй байдлаар тогтоогдоогүй гэж үзнэ. Хариуцагч СЕХ-ны гаргасан, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан шаардлага хангаагүй буюу зөрчилгүй гарын үсгийн тоо 801-д хүрээгүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэгч Д.А-г нэр

дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэр Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно; 24.2-т Энэ хуулийн 24.1-д заасан бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны байгууллага хүлээнэ гэж тус тус заасантай нийцээгүй, энэ талаар давж заалдах шатны шүүхээс үндэслэл бүхий дүгнэлтийг хийжээ. Иймд давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шийдвэрийг хүчингүй болгон, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгуулахаар гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхих нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоо бүхий эрх зүйн зохицуулалтыг сайжруулснаар СЕХ болон сонгуулийн маргааныг шийдвэрлэх шүүхийн ачаалал багасна. Гарын үсэг цуглуулах шаардлагыг хангасан эсэхийг баталгаажуулах журам боловсруулах эрх хэмжээг СЕХ-д хуулиар олгох, эсхүл хуульд нарийвчлан зохицуулж өгөхийг олон улсын байгууллагаас зөвлөдөг¹⁰⁵. Хуулиар зохицуулаагүйн улмаас зарим нэр дэвшигч болон улс төрийн намын цуглуулсан гарын үсгийг шалгаж, баталгаажуулахдаа хэт өндөр шаардлага тавих, нөгөө хэсэгт нь шалгасан “нэр зүүх” төдийгөөр бүртгэж, нэр дэвшигчдийг ялгаварлан гадуурхах, тэдний эвлэлдэн нэгдэх улс төрийн эрх чөлөөг нь боомилох нөхцөл бүрдэнэ. Мөн үүнээс үүдэн СЕХ болон шүүхийн ачаалал ихсэх хандлагатай байна.

Гадаад улс орнуудад түүвэрлэн шалгах гарын үсгийн

¹⁰⁵ Guidelines for Reviewing a Legal Framework for Elections OSCE, <https://www.osce.org/files/f/documents/f/8/104573.pdf>

тоо, гарын үсгийн түүврийг сонгох аргачлал¹⁰⁶ (компьютерын программаар санамсаргүй түүврийн гэх мэт); Гарын үсэг үнэн, зөв эсэхийг тодорхойлох загвар; Шалгасан гарын үсгээс хэд нь үнэн, зөв байх тохиолдолд нэр дэвшигч болон улс төрийн намыг бүртгэхийг харуулсан томьёо; Шаардлагатай гэж үзвэл нэмж түүвэрлэх нөхцөл байдал зэргийг хууль, журамдаа тусгадаг¹⁰⁷ байна.

Бүртгэлтэй холбоотой дараагийн маргааны төрөл нь мөрийн хөтөлбөрийн шаардлага хангахтай холбоотой маргаан юм. 2004, 2008 оны УИХ-ын сонгуулиар “улс төрийн голлох намуудын мөрийн хөтөлбөрт баялгийн хуваарилалтыг иргэн бүрд түгээх “Эрдэнийн хувь” болон “Эх орны хишиг” зэрэг намын бодлогод популист шинжтэй амлалтууд бий болсон билээ”¹⁰⁸. Үүнийг хязгаарлах үүднээс 2012 оны сонгуулиас эхлэн, намууд мөнгөн амлалт өгч, сонгогчдын саналыг худалдаж авахыг хуулиар хориглон, нам, эвсэл нь ээлжит сонгуулийн жилийн 3 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө, бие даан нэр дэвшигч нь ээлжит сонгуулийн жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэхээр¹⁰⁹ зохицуулсан юм. Аудитын байгууллагаас нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт¹¹⁰ гарвал тав хоногийн дотор

¹⁰⁶ Гарын үсгийн тоо болон тэдгээрийн түүвэрлэн шалгах аргачлалын талаар олон улсын сайн туршлага бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹⁰⁷ Guidelines for Reviewing a Legal Framework for Elections OSCE, 38 дахь тал. <https://www.osce.org/files/f/documents/f/8/104573.pdf>

¹⁰⁸ Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн Хурлын сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь, НҮБ, 56 дахь тал.

¹⁰⁹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 38 дугаар зүйлийн 38.6.

¹¹⁰ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 38 дугаар зүйлийн 38.1: “Төрийн аудитын дээд байгууллага нь бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 33-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ”.

зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулж¹¹¹ байна.

2012-2020 онд мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангасан эсэхтэй холбогдох долоон маргаан гарчээ. Эдгээрт нам, улс төрийн хүчин УИХ-ын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрөөрөө орон нутгийн Хурлын сонгуульд оролцож болох эсэх, намуудаас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэд нь хуульд заасан шаардлага хангавал тухайн нам, бие даан нэр дэвшигч сонгуульд оролцох боломжтой эсэхтэй холбоо бүхий маргаан хамаарч байна. Тухайлбал, 2012 онд УИХ-ын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрөө тэр хэвээр нь ашиглан, орон нутгийн Хурлын сонгуульд оролцохоор бүртгүүлэх хүсэлтээ өгсөн нам, эвслийг шаардлага хангаагүй хэмээн үзэж (Кэйс 7), Сонгуулийн хороо бүртгээгүй билээ. УИХ-ын сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрөөрөө орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нь хуульд заасан шаардлага хангасан гэж шүүх шийдвэрлэсэн байна.

Кэйс 7.

Өвөрхангай аймгийн МАХН-МҮАН-ын Шударга ёс эвслээс Өвөрхангай аймгийн сонгуулийн хороонд холбогдох нэхэмжлэлд “Сонгуулийн хороо нь тус намын мөрийн хөтөлбөрийн заалтууд нь аймаг, орон нутгийн онцлогт нийцээгүй, УИХ, Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд шийдэгдэх асуудлыг дэвшүүлсэн нь орон нутагт хэрэгжих боломжгүй гэж дүгнэсэн нь илт хууль бус байна. ... мөрийн хөтөлбөр нь орон нутгийн онцлогт нийцсэн эсэх асуудлаар ард түмэн үнэлэлт өгч, сонгуулиар санал өгөн, сонголтоо хийдэг болохоос биш, Сонгуулийн хороо намын дотоод асуудлаар санал өгч, хөндлөнгөөс оролцох нь илт хууль бус байна” гэжээ. Харин Хариуцагч буюу

¹¹¹ Мөн тэнд, 38.9 дүгээр зүйл.

Өвөрхангай аймгийн СХ-ны зүгээс “Аймгийн Сонгуулийн хороонд МАХН-ын МҮАН-ын “Шударга ёс” эвслээс ирүүлсэн мөрийн хөтөлбөр нь хуулийн шаардлагыг хангаагүй хэмээн үзжээ. [Учир нь] ...УИХ-ын сонгуульд оролцохоор гаргасан мөрийн хөтөлбөр учир хорооны гишүүд энэхүү хөтөлбөрийг орон нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулах аймгийн ИТХ-ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр гэж үзэхэд учир дутагдалтай” хэмээсэн байна. Үүнийг шүүхээс хууль зүйн үндэслэлгүй байна хэмээн үзэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ. Шүүхээс дүгнэхдээ “Нам, эвсэл чухам ямар мөрийн хөтөлбөр дэвшүүлэх нь тэдэнд Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгээр олгосон бүрэн эрхийн асуудал байх ба гагцхүү нам, эвслээс дэвшүүлэн тавьж байгаа мөрийн хөтөлбөр нь Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлд хуульчлан заасан журамд нийцсэн байх ёстой байхаар зохицуулжээ. Нэхэмжлэгч эвслийн мөрийн хөтөлбөр нь хөндлөнгийн хяналтын байгууллагаар хянуулсан байх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад нийцсэн байх зэрэг хуульд заасан шаардлагуудыг хангасан байгаа болох нь... тогтоогдож байна. Хөндлөнгийн хяналтын байгууллага буюу аудит болон түүнтэй холбоотой харилцаа нь Аудитын тухай хуулиар зохицуулагддаг, тусгай зөвшөөрөл бүхий эрх бүхий этгээд аудитын үйл ажиллагаа эрхэлж, хуулийн дагуу үүрэг хариуцлага хүлээдэг ба аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий эрх бүхий этгээдээс хуулийн дагуу эвслийн мөрийн хөтөлбөрт аудит хийж, дүгнэлтээ гаргасан байх тул шүүх уг аудитын дүгнэлтийг үнэлэх дүгнэх эрх хэмжээгүй байна” гэжээ.

Улс төрийн нам нь мөрийн хөтөлбөртөө Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, үндэсний эрх ашигт нийцсэн өөрийн үзэл баримтлал, үйл ажиллагааны зарчим, эрхэм зорилго, тэдгээрийг хэрэгжүүлэх үндсэн арга замыг тодорхойлох үүрэгтэй¹¹². Харин УИХ-ын болон орон нутгийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар хуульд ялгамжтай зохицуулалт тусгалгүй зөвхөн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлагыг жагсаажээ. Ингэснээр нэг мөрийн хөтөлбөрөөр УИХ болон орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нөхцөл бүрдсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурал нь төрийн эрх барих дээд байгууллага бөгөөд хууль тогтоох эрх мэдэл гагцхүү УИХ-д хадгалагддаг¹¹³. Харин нутгийн өөрөө удирдах байгууллага¹¹⁴ болох аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх эрхтэй бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно гэжээ. Үндсэн хуулиар олгогдсон ялгаатай чиг үүрэг бүхий эдгээр эрх мэдлийн институцийн онцлогийг харгалзан, мөрийн хөтөлбөрийн агуулга, хамрах цар хүрээг ялгаатай байдлаар хуульд тусгах нь эдгээр төрлийн маргаан буурахад нөлөөлнө.

Орон нутгийн Хурлын сонгуулийн үеэр мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ хуульд заасан шаардлагад нийцэхтэй холбогдох маргаан гарсаар байна. 2016 онд орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигчийн 16 зорилт бүхий мөрийн хөтөлбөрийн 15 нь хуульд нийцээгүй, нэг нь хуульд заасан

¹¹² Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйл.

¹¹³ Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйл.

¹¹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйл.

шаардлагад нийцсэн тохиолдолд уг мөрийн хөтөлбөрөөрөө сонгуульд оролцохтой холбоо бүхий маргааныг шүүхээс шийдвэрлэсэн тохиолдолд гаржээ. Нэр дэвшигч Н.Б нь “Мөрийн хөтөлбөртөө нийт 16 арга хэмжээ тусгаснаас 15 арга хэмжээ нь хуульд нийцээгүй зөвхөн нэг арга хэмжээ нь хуульд нийцсэн байна гэж Аймгийн аудитын газраас дүгнэснийг үндэслэн, Сонгуулийн хороо бүртгэхээс татгалзжээ. Нэр дэвшигч Сонгуулийн тухай хуульд нэг хөтөлбөртэй орохыг хориглоогүй учраас ийнхүү татгалзсан нь хууль бус, миний сонгох, сонгогдох эрхийг ноцтойгоор зөрчсөн ” (Кэйс 8) хэмээн маргажээ.

Кэйс 8. Шүүхийн шийдвэрийн үндэслэл:

Хариуцагч Дархан-Уул аймгийн Сонгуулийн хороо нь Аудитын газрын 2016 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 286 тоот “Нийцлийн талаарх дүгнэлт”-ийг үндэслэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Н.Б-ийг бүртгэхээс татгалзсан тогтоол гаргахдаа нэхэмжлэгчийн мөрийн хөтөлбөрөөс нэг арга хэмжээ нь Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5-д заасан “...сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцсэн байдалд болон хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулсан байна” гэх шаардлагыг хангасан эсэхэд үнэлэлт өгөөгүй, мөн Н.Б-ийг хуульд нийцсэн нэг мөрийн хөтөлбөрөөрөө сонгуульд оролцох эрхийг Сонгуулийн тухай хуулиар хориглоогүй байхад нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан нь хууль бус байх бөгөөд нэхэмжлэгчийн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9, Сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Үндэсний Аудитын Газраас (ҮАГ) нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн дэвшүүлж буй мөрийн хөтөлбөрөөс хэд нь хуульд заасан шаардлага хангасан талаар СЕХ-д дүгнэлт гаргадаг. Гэвч мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэдэн хувь нь хуульд заасан шаардлага хангасан тохиолдолд сонгуульд оролцож болох талаар эрх зүйн нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс сонгуулийн маргаан гарч байна. Хуулийн зохицуулалт тодорхойгүй, ойлгомжгүй байгаа нь нэг талаас иргэдийн сонгогдох эрх зөрчигдөх, нөгөө талаас ҮАГ, СЕХ, шүүх зэрэг төрийн байгууллагын ажлын ачааллыг нэмэгдүүлж байна. Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөрийг улс орон болон орон нутгийг хөгжүүлэх амлалт, төлөвлөгөө, сонгогчтой хийж буй гэрээ гэж үзвэл эрх бүхий байгууллагуудын зүгээс мөрийн хөтөлбөр хуульд заасан шалгуурт нийцсэн эсэх талаар хянах аргачлал боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бүртгэлтэй холбоо бүхий дээрх маргаануудаас гадна 2020 оны УИХ-ын сонгуультай холбогдох олон нийтийн анхаарлыг татсан нэг маргааныг¹¹⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс шүүгчийн захирамжаар (Кэйс 9) шийдвэрлэсэн байна. Маргааны агуулга нь УИХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлсэн иргэн давхар харьяалалтай байна хэмээн СЕХ-д хандсан боловч СЕХ гомдол гаргах хугацаа хэтэрсэн гэсэн үндэслэлээр гомдлыг шийдвэрлэхээс татгалзжээ. УИХ-ын гишүүнд нэрээ дэвшүүлсэн иргэн нь УИХ-ын сонгуулийн тухай хууль¹¹⁶ болон Харьяатын тухай хуульд¹¹⁷ зааснаар зөвхөн Монгол Улсын харьяат иргэн байх шаардлагатай. Өөр улсын давхар харьяаллыг хориглосон байна. УИХ-ын гишүүнд нэрээ дэвшүүлсэн иргэний холбогдох баримт бичгийг хүлээн авч,

¹¹⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 1160 тоот захирамж.

¹¹⁶ УИХ-ын сонгуулийн тухай хууль (2019)-ийн 3.1.3 дугаар зүйл.

¹¹⁷ Харьяатын тухай хууль (2003)-ийн 4.1 дүгээр зүйл.

шаардлага хангасан эсэхийг шалган, нэр дэвшигчээр бүртгэх эсэх шийдвэрийг СЕХ гаргадаг. Нэр дэвшигчээр бүртгүүлэхээр баримт бичгээ ирүүлсэн иргэний давхар харьяалалтай эсэхийг Сонгуулийн ерөнхий хороо хэрхэн шалгах талаар нарийвчилсан зохицуулалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид тусгагдаагүй байна.

Кэйс 9.

А намаас Сонгуулийн ерөнхий хороонд холбогдуулан гаргасан “Нэр дэвшигч бүртгэсэн шийдвэр хүчингүй болгуулах тухай” албан тоотод хариу өгөхгүй байгаа Сонгуулийн ерөнхий хорооны эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгож, шаардагдах захиргааны акт гаргахыг Сонгуулийн ерөнхий хороонд даалгах, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 3-2/240 албан тоотыг хүчингүй болгох” нэхэмжлэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргажээ. Нэхэмжлэлийн үндэслэл нь: Нэр дэвшигч Г.А нь Н Улсын иргэншилтэй гэх үндэслэл бүхий мэдээллүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн болно. Харьяатын тухай хуулийн 4.1-д “Монгол Улсын харьяат нэгэн зэрэг гадаад улсын харьяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй” гэж заасан байдаг. Иймд Улсын Их Хурлын сонгуулийн 29 дүгээр тойрогт нэр дэвшигч Г.А нь Н Улсын иргэн мөн бол Харьяатын тухай хуулийн 4.1-д заасны дагуу Монгол Улсын иргэнд тооцогдохгүй юм. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 3.1.3-т “нэр дэвшигч гэж... Монгол Улсын иргэнийг”, 5.2-т “...Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй” гэж тус тус заасан билээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын иргэн биш хүн Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших, Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхгүй юм. Монгол Улсын Их Хурлын

сонгуулийн тухай хуулийн 33.1-д “Нэр дэвшигчээр дараах тохиолдолд бүртгэхээс татгалзана: ...33.1.2. энэ хуульд заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй...”, 75.1-д “Нэр дэвшигч бүртгүүлсний дараа тухайн нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ” хэмээн заажээ. Г.А нэр дэвшигчээр бүртгэх үед Н улсын иргэншилтэй нь мэдэгдээгүй байсан хэдий ч энэ нь бүртгэсний дараа тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо түүнийг бүртгэсэн шийдвэрээ хүчингүй болгох үүрэгтэй гэжээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020.06.18 №1160 захирамжийн үндэслэл:

А нам нь СЕХ-д хандан, 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдөр “...Монгол Улсын Их Хурлын 29 дүгээр тойрогт М намаас нэр дэвшигч Г.А-г бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгуулах”-аар хүсэлт гаргасныг СЕХ-ы Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын 2020 оны 3-2/240 дугаар албан бичгээр “...Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5-д “Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй” хэмээн заасны дагуу гомдлыг буцаан хүргүүлэв” гэсэн хариуг өгсөн байна. Ийнхүү гаргасан гомдлыг хүлээн авч, хариу өгсөн байхад Сонгуулийн ерөнхий хороог өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүй гаргасан гэж үзэх боломжгүй тул А намын албан тоотод СЕХ хариу өгөхгүй байгаа гэх нэхэмжлэлийг хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэх үндэслэлгүй байна.

Түүнчлэн А намаас СЕХ-д гомдол гаргахад Сонгуулийн

төв байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д зааснаар гомдлын хариуг СЕХ-ны ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсээс өгсөн байх тул хариуцагчийг гомдолд хариу өгөөгүй, шийдвэрлээгүй гэж үзэх боломжгүй юм. Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын 2020 оны 3-2/240 дүгээр албан бичиг захиргааны акт биш байх тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус хэмээн үзлээ. Дээрх үндэслэлээр А намын нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Захиргааны хэргийн шүүх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзжээ. Нэхэмжлэл гаргахдаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-д заасан хэлбэрээр нэхэмжлэлээ гаргахаар зохицуулсан байна. Захиргааны шүүхийн хамгаалалт нэхэмжлэлийн шаардлагаар хязгаарлагддаг учир “нэхэмжлэлийн зөвшөөрөгдөхүйц байдал”-ыг¹¹⁸ болон нэхэмжлэлийн төрлийг¹¹⁹ шалгах шаардлагатай¹²⁰. Захиргааны акт гаргахыг даалгах нэхэмжлэлийн зүйл нь зөвхөн эс үйлдэхүйгээр хязгаарлагдахгүй. Үүнийг “...захиргааны акт гаргахаас татгалзсан шийдвэр, эсхүл эс үйлдэхүй нь хууль бус бөгөөд... шаардагдах захиргааны акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах...”¹²¹ гэсэн хуулийн зохицуулалтаас тодорхой харж болно. Даалгах нэхэмжлэлийн зүйл нь захиргааны хууль бус татгалзал байх бөгөөд энэ нь дараах хоёр хэлбэртэй. Үүнд: Захиргааны байгууллагын хууль бус “эс

¹¹⁸ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54.1.1 дүгээр зүйл.

¹¹⁹ Мөн тэнд, 52.5.1-52.5.6.

¹²⁰ Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2019, 132 дахь тал.

¹²¹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.3.4 дүгээр зүйл.

үйлдэхүй”, “татгалзсан шийдвэр” (акт) байна¹²². Нэхэмжлэлийн агуулгаас харвал СЕХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга гаргасан гомдлыг шийдвэрлэхээс татгалзаж, албан бичгээр хариу өгсөн байх бөгөөд үүнийг “татгалзсан шийдвэр” хэмээн үзэх боломжтой байна. Харин нэхэмжлэгчид нэхэмжлэлийн шаардлагаа тодруулах боломж олгож, нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангах хугацаа тогтоож болох юм.

Үүнээс гадна УИХ-ын гишүүнд нэрээ дэвшүүлсэн иргэний харьяалал, давхар харьяалалтай эсэхийг СЕХ хэрхэн шалгах нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс үүдэн, дээрх маргаан гарсан гэж үзэж болохоор байна. Цаашид нэр дэвшигчээр бүртгүүлэхээр материалаа ирүүлсэн иргэний харьяаллыг СЕХ хэрхэн шалгах талаар хуулийн нарийвчилсан зохицуулалт бий болгох нь зүйтэй. Нөгөө талаас сонгуулийн асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагаа¹²³ зөв тодорхойлохгүй бол сонгуулийн маргааны онцлогоос хамаарч, хугацаа алдсанаар эрхээ сэргээлгэх боломжгүй болох эрсдэл байна.

4.2. ХУУЛЬ БУС СУРТАЛЧИЛГААТАЙ ХОЛБООТОЙ МАРГААН

2016 оноос хойш сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбоотой маргааныг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэх болсноор Захиргааны хэргийн шүүхээр энэ төрлийн гомдол маргаан хянан шийдвэрлэгдэх нь буурсан байна¹²⁴. Хуульд заасан сурталчилгаа явуулах

¹²² Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2019, 191 дэх тал.

¹²³ Захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний актаа зөв тодорхойлох гэх мэт.

¹²⁴ 2012 онд хууль бус сурталчилгаатай холбоотой маргаан 27, 2016 онд 4, 2021 оны 6 дугаар сар хүртэл Захиргааны хэргийн шүүхээр хянан хэлэлцэгддэггүй байна.

хугацаанаас өмнө сурталчилгааг эхлүүлсэн, сонгогчдод мөнгө, эд зүйл төлбөргүй тараах, албан тушаалаа ашиглан хүлээн авалт, дайллага, цайллага зохион байгуулах, амралт, сувилалд амраах, мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт өгөх, сурталчилгаанд шашны зан үйл ашигласан зэрэг хууль бус сурталчилгаа явуулсан гэх үндэслэлээр сонгуулийн хорооноос нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тухай маргааныг авч үзье.

Кэйс 10.

“...Сумын Засаг даргын Тамгын газраас 2016 оны цагаан сарын баярын өмнө Засаг даргын Тамгын газар болон иргэдийн хуралд ажиллаж байсан ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн арга хэмжээ нь Монгол Улсын Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу жил бүр зохион байгуулж хэвшсэн ажил байх бөгөөд энэхүү ажиллагаанд Засаг дарга Б.А өөрийн биеэр оролцон, тухайн жилд хийж хэрэгжүүлсэн онцлог ажлуудаа дурдаж, ахмадуудынхаа санаа бодлыг сонсон, хүндэтгэл үзүүлсэн үйлдэл нь өөрийнх нь эрхэлж буй ажил үүрэгтэй нь холбоотой болох нь хэрэгт авагдсан тус сумын Засаг даргын 2015 оны 54 тоот захирамжаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам” сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 13/04 дугаар “Сумын 2016 оны төсөв батлах тухай” тогтоол, урилга, СД бичлэг зэрэг нотлох баримтаар нотлогдож байгаа төдийгүй хуулийн Сонгуулийн тухай хуулийн 70.1-д заасан сонгогчдын саналыг татах зорилго агуулаагүй байна...”.

Албан тушаалаа ашиглаж, санал татах зорилгоор сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулсан гэх үндэслэлээр сонгуулийн хороо Б.А-г нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан байна. Үүнийг шүүхээс сонгогчдын санал татах зорилго

агуулаагүй хэмээн үзжээ. Албан хаагчид сонгуулийн жилийн цагаан сараар ахмадуудад бэлэг сэлт тараах, хүлээн авч дайллага, цайллага хийх уламжлал тогтсон нь ээлжит сонгуулиар нэр дэвших нь тодорхой болсон албан тушаалтнуудад давуу байдал олгож байдаг. Гэвч баяр ёслолын үеэр уламжлал болж тогтсон болон хөдөлмөрийн дотоод журмын дагуу явагдсан энэ төрлийн үйл ажиллагааг хориглосон хуулийн заалт байхгүй тул хууль зөрчөөгүй байна гэж шийдвэрлэжээ.

4.3. САНАЛЫН ХУУДАС, САНАЛ ТООЛОХТОЙ ХОЛБООТой МАРГААН

Саналын хуудас, санал тоолохтой холбоотой маргаан нь сонгуулийн үеэр дутсан саналын хуудсыг хувилан олшруулахтай ихэвчлэн холбоотой байна. Хувилсан саналын хуудсаар өгсөн саналыг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийг нэр дэвшигчид шүүхэд гаргаж байна (Кэйс 12). Санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнг баримтлан, сонгуулийн дүнг гаргах, хуулбарлан олшруулсан саналын хуудсаар сонгогчдоос авсан саналыг дүнг хүчингүйд тооцох шийдвэрийг шүүх гаргажээ. Энэ мэт СЕХ ба сонгуулийн хороодын ажлын уялдаа холбоо сул, сонгуулийн бэлтгэл хангалтгүй байгаа нь иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдөх, сонгуулийн маргаан нэмэгдэх нэг хүчин зүйл болж байна.

Кэйс 12¹²⁵.

“...Сонгуулийн үр дүнд эхний хоёр сонгогдогч үнэмлэхүй олон санал авсан бөгөөд энэ талаар талууд маргаагүй болно. Харин гурав дахь олонхын санал авсан гэх нэр дэвшигчийн тухайд маргаантай байна. Тодруулбал,

¹²⁵ <http://new.shuukh.mn/zahirgaanhan/1675/view>

нэр дэвшигч М намаас нэр дэвшигч Д.У, А намаас нэр дэвшигч Л.Т нарын сонгогчдоос авсан саналын тоог хоёр янзаар нэгтгэсэн дүнг Тосонцэнгэл сумын сонгуулийн хороо аймгийн сонгуулийн хороонд ирүүлжээ. Эхний нэгтгэлийн дүнгээр буюу санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгээр нэхэмжлэгч М намаас нэр дэвшигч Д.У-г 2206 сонгогчдын буюу олонхын санал авснаар гаргасан бол дараагийн өөр нэгтгэлийн дүнгээр буюу санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн дээр саналын хуудас хүрэлцээгүй үндэслэлээр хуулбарлан олшруулсан саналын хуудсаар сонгогчдоос авсан саналын дүнг нэмэн гаргасан дүнгээр гуравдагч этгээд Л.Т нь 2219 сонгогчийн буюу олонхын санал авсан дүнг гаргажээ. Учир нь санал хураалтын явцад саналын хуудас хүрэлцэхгүй болсон үндэслэлээр тус сумын сонгуулийн хороо нь саналын хуудсыг 300 ширхгээр хуулбарлан олшруулж бэлтгэн, тэдгээрийн 28 ширхэг саналын хуудсаар нь сонгогчдоос санал авсан нөхцөл үүсжээ. Иймд аймгийн Сонгуулийн хороо 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хуралдаж, уг хуралдаанаар сумын сонгуулийн хороодоос ирүүлсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал хураалтын дүнг нэгтгэн, Орон нутгийн хуралд сонгогдсонд тооцогдох нэр дэвшигчдэд түр үнэмлэх олгох тухай 15 дугаар тогтоолыг батлан гаргасан...”. Ингэхдээ санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн дээр саналын хуудас хүрэлцээгүй үндэслэлээр хуулбарлан олшруулсан саналын хуудсыг нэмсэн дүнг үндэслэл болгосон байна. Шүүхээс нэхэмжлэгчийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн буюу санал тоолох төхөөрөмжийн дагуу М намаас нэр дэвшигч Д.У-г сонгогдсонд тооцохыг сонгуулийн хороонд даалгасан байна.

ТАВ. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА

Олон улсын гэрээ, конвенц, стандарт, сайн туршлагад тулгуурлан, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх боломжтой. Гэвч сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэхтэй шууд холбоотой нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн баримт бичиг цөөн тул ардчилал, хууль дээдлэх ёс, шударга шүүхээр шүүлгэх эрх, шүүхийн бие даасан байдалтай холбоо бүхий олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон ардчилал төлөвшсөн гадаад улс орнуудын туршлагаас судлах шаардлагатай болдог. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын конвенц болон Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц зэрэг нь сонгуулийн маргаанд хамаарах Монгол Улсын нэгдэн орсон заавал биелэгдэх шинжтэй олон улсын эрх зүйн хэм хэмжээ юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон бүс нутгийн баримт бичгүүдэд сонгуулийн маргааныг шийдвэрлэх механизм, зарчмыг тусгайлан тусгажээ. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 31, 32 дугаар ерөнхий тайлбар, Венецийн комиссоос гаргасан Сонгуулийн шилдэг туршлага, дүрэм журам болон бусад холбогдох эх сурвалжид сонгуулийн бүхий л үйл ажиллагаа нь хууль дээдлэх зарчимд нийцсэн байх, сонгуулийн бүх үе шатанд төрийн зүгээс хүний эрхийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн

байх шаардлагатайг онцолжээ. Сонгуулийн маргааныг шийдвэрлэхэд хуулийн дагуу шударга, нээлттэй, тэгш байдлын зарчмыг удиртгал болгодог¹²⁶. Түүнчлэн Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх Олон улсын хүрээлэнгээс “сонгуулийн зохистой тогтолцоо”-г “сонгуультай холбоотой аливаа үйл ажиллагаа, процедур, шийдвэр нь хуульд нийцэж байх, сонгох сонгогдох эрхийг хамгаалах, сэргээх, эрх нь зөрчигдсөн хэмээн үзэж буй этгээдийн гаргасан гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцэж, цаг хугацаанд нь шийдвэр гаргах боломжоор хангах” гэж тодорхойлжээ¹²⁷.

Гадаад улс орнуудын хувьд сонгуулийн маргаан шийдвэрлэх тогтолцоо нь харилцан адилгүй байдаг. Аль загвар, тогтолцоог авч хэрэглэх нь тухайн улсын улс төрийн соёл, сонгуулийн үйл явц, эрх зүйн тогтолцооноос ихээхэн шалтгаална. Гаднын сайн туршлагаас судлахын тулд эдгээр тогтолцооны аль нь улс төрийн эрхийн хамгаалалт, шударга, үр дүнтэй, бодитой, шуурхай байх зарчимд нийцсэн бөгөөд олон улсын нийтлэг стандартыг¹²⁸ хангаж буйг тодорхойлох нь чухал. Сонгуулийн маргааныг төрийн захиргааны байгууллага¹²⁹, парламентаас байгуулагдсан хороо болон шүүхийн байгууллага¹³⁰ шийдвэрлэдэг загварууд бий. Мөн зарим улсад хуулийн дагуу байгуулагдсан маргаан шийдвэрлэх тусгай байгууллага үүнийг хэрэгжүүлдэг. Энэхүү байгууллага нь шүүхтэй хавсран шийдвэрлэдэг загвар ч бас тохиолддог. Жишээ нь: Бразил, Панам зэрэг улсад дээрх тусгай байгууллагад мөрдөн шалгах эрх

¹²⁶ Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь, НҮБ-ын Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь 13/102 төсөл, 37 дахь тал.

¹²⁷ Зүй ёсны сонгууль гарын авлага, АСДҮОУХ, 17 дахь тал, <https://www.idea.int/sites/default/files/publications/electoral-justice-handbook-MN.pdf>

¹²⁸ OSCE “Resolving Election Disputes” (2000), <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>

¹²⁹ Ихэнх улсад сонгуулийн хороо байдаг.

¹³⁰ Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх шийдвэрлэдэг. Жишээ нь: Их Британи, Герман, Франц, Итали гэх мэт.

олгосон байдаг аж. Гурав дахь загвар нь сонгуулийн шүүх бөгөөд энэ нь Төв Америк, өмнөд Америкийн зарим улс орон, Грек¹³¹ зэрэг улсад хамаарна.

Дээрх байгууллагын аль нь сонгуулийн маргааныг шийдвэрлэж байгаагаас үл хамааран, гадаад улс орнуудад сонгуулийн харилцааг эрүүгийн, сонгуулийн тухай болон захиргааны хуулиар зохицуулж байна. Сонгуулийн тухай хуулийг шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах замаар хариуцлагатай холбоо бүхий эрх зүйн зохицуулалт нь ойр ойрхон өөрчлөгдөх эрсдэлтэй байдаг учир харьцангуй тогтвортой үйлчилдэг хуулиуд, тухайлбал, эрүүгийн хуульд сонгуулийн маргааныг тусгай бүлгээр зохицуулах хандлагатай байна¹³².

5.1. СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

Олон улсын эрх зүйн эх сурвалжуудад улс төрийн эрхийн баталгааны үндсэн зарчмыг тусгасан байдаг. Эдгээрээс сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх талаар илүү тодорхой бөгөөд өргөн цар хүрээнд тусгасан Олон улсын парламентын холбооны “Чөлөөт, шударга сонгуулийн шалгуур үзүүлэлтийн тунхаг”-т (1994) улс төрийн болоод сонгуулийн эрхийн зөрчлийг шийдвэрлэх, эрхийг сэргээх шаардлага, сонгуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх шаардлагыг тус тус дурджээ. Түүнчлэн (i) Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын Хүний эрхийн бага хурлын Копенгагений уулзалтын баримт бичгийн 5.10 дугаар догол мөр, (ii) ЕАБХАБ-ын Венийн баримт бичгийн 13.9 дүгээр догол мөр, (iii) Хүний

¹³¹ OSCE “Resolving Election Disputes” (2000), <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>, p. 5.

¹³² International IDEA “Handbook on Electoral Justice”, 2010, p.70, <https://www.idea.int/sites/default/files/publications/electoral-justice-handbook.pdf>

эрхийн тухай Европын конвенцын 6 дугаар зүйлд сонгуулийн маргааныг шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй холбоотой олон улсын суурь зарчмыг багтаажээ.

Сонгуулийн маргааныг шүүхээр шийдвэрлэхтэй холбоотой олон улсын эрх зүйн шаардлага, зарчмыг нэгтгэн дүгнэвэл¹³³:

Шүүхээр хамгаалуулах эрх: Аливаа иргэн, улс төрийн нам нь улс төрийн болон сонгуулийн эрхээ хуулиар хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд шүүхээр сэргээлгэх эрхтэй байх ёстой. Шүүх эрх мэдлийн хараат бус байдлын баталгааг хангах, сонгуулийн маргааныг хуульд заасан хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг улс орнууд хүлээнэ. Сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актад тусгасан хоёрдмол утга бүхий тодорхойгүй зохицуулалт нь шүүхээс сонгуулийн маргаан шийдвэрлэхэд бэрхшээл учруулж болзошгүй тул нэн даруй засаж сайжруулах үүргийг улс орнууд хүлээдэг. Хараат бус, шударга шүүхээр хамгаалуулах, давж заалдах эрхийг баталгаажуулах шаардлага ч энэ зарчимд хамаарна.

Шуурхай шийдвэрлэх: Сонгуулийн маргааныг сонгуулийн үйл явцад тохирсон хугацааны дотор шуурхай шийдвэрлэхээр хуульчлах шаардлагатай. Ингэснээр сонгуулийн үр дүнг хойшлуулахгүй байх нөхцөл бүрдэнэ. Нөгөө талаас хугацааны хязгаар тогтоохдоо шүүх болон сонгуулийн байгууллагад ирсэн гомдол, давж заалдах хүсэлтийг хянан магадлах, шийдвэрлэх хангалттай хугацаа олгох хэрэгтэй. Зарим гомдол, давж заалдах нэхэмжлэл, ялангуяа сонгуулийн санхүүжилт, сурталчилгаатай холбогдох асуудалд нарийвчилсан мөрдөн шалгалт шаардлагатай байдгийг харгалзан үзэх нь зүйтэй.

Сонгуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх хугацааг

¹³³ Зарчмуудыг дараах холбоосоор орж дэлгэрүүлж үзнэ үү. <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>

сонгуулийн үе шат бүрээр¹³⁴ Сонгуулийн тухай хуульд тодорхой тусгах хэрэгтэй. Сонгогчдын бүртгэл болон нэр дэвшигчдийг батламжлахтай холбоо бүхий гомдол, нэхэмжлэл гаргах сүүлийн хугацааг (нийтлэг журмаас гадна) хуулиар тусгайлан зохицуулна. Энэ нь сонгуулийн санал авах өдрийн өмнөх өдөр дээрх асуудлаар өргөдөл, гомдол гаргахаас сэргийлэх сайн талтай. Ингэснээр өмнө нь шийдвэрлэж болох байсан нэр дэвшигчийн бүртгэл, нэрсийн жагсаалттай холбоо бүхий маргаанд цаг хугацаа зарцуулах бус, харин санал өгөх болон санал тоолохтой холбогдох нэн яаралтай асуудлыг шийдвэрлэхэд анхаарал, цаг хугацаа, нөөц бололцоогоо зарцуулах боломж бүрдэнэ.

Ил тод, тодорхой байх: Сонгуулийн хэрэг, маргаан шийдвэрлэх журам нь ил тод, тодорхой, ойлгомжтой, олон нийтэд хүртээмжтэй байна. Сонгуулийн байгууллагад гомдол гаргах журам, мөн сонгуулийн маргааныг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний талаар мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах, сонгогчдын боловсролын кампанит ажлын хүрээнд гомдол шийдвэрлэх журмын талаар мэдээлэл өгөх нь зүйтэй. Тухайлбал, сонгуулийн үр дүнг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүйд тооцох шийдвэр гаргах эрхийг Дээд шүүх эсхүл Үндсэн хуулийн шүүхэд олгох зэргээр маргаан шийдвэрлэх байгууллагыг хуульд тодорхой тусгах нь шүүхийн ачааллыг бууруулахад эерэг нөлөөтэй. Түүнчлэн, дээд шүүх нь өмнө нь хянан шийдвэрлэгдсэн сонгуулийн хэрэг, маргааны шийдвэрийн талаар мэдээлэл бэлтгэж, бусад шүүхийн шүүгчид танилцуулдаг нь цаашдын сонгуулийн маргааныг шуурхай шийдвэрлэх, эрх зүйн зохицуулалтын талаар нэгдсэн ойлголтод хүрэхэд үр нөлөөтэй байдаг талаар ЕАБХАБ-аас гаргасан судалгаанд тэмдэглэсэн байна¹³⁵.

¹³⁴ Сонгогчдын жагсаалт, нэр дэвшигчдийг батламжлах гэх мэт.

¹³⁵ <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>

Шийдвэр хэрэгждэг байх: Шүүх болон сонгуулийн байгууллагын гаргасан шийдвэр бүрэн дүүрэн хэрэгжсэний үндсэн дээр сонгууль шударга явагдах, иргэдийн сонгох, сонгогдох эрх хамгаалагдах боломжтой. Хэрэгжүүлэх үр дүнтэй арга замыг тодорхойлох, түүндээ нийцүүлэн арга хэмжээ авах үүргийг улс орнууд хүлээдэг.

Хариуцлагын тогтолцоотой байх: Төрийн байгууллага, албан тушаалтанд үйлдэл, эс үйлдлийнх нь төлөө хариуцлага хүлээлгэх талаар сонгуулийн хууль тогтоомж болон бусад хуульд тодорхой зохицуулаагүй улс байдаг. Иймээс сонгуулийн хууль тогтоомж нь тогтворгүй, богино хугацаанд олон удаа өөрчлөгддөг улсад сонгуулийн явцад гарсан хэрэг маргаан, ялангуяа авлигын хэрэгт эрүүгийн хуулийн дагуу хариуцлага ногдуулахаар зохицуулдаг байна.

Шүүхийн болон сонгуулийн байгууллага хамтран, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх стандарт тогтолцооны загварыг бий болгохыг олон улсын байгууллагаас, тухайлбал, Европын Аюулгүй байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагаас¹³⁶ санал болгодог. Ийм стандарт тогтолцоог бүрдүүлэх нь сонгуулийн маргааныг шийдвэрлэх үйл явцын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэхээс гадна тухайн улс дахь сонгуулийн маргаан шийдвэрлэх процесс, түүний үр нөлөөг бүхэлд нь харах боломж олгодог. Түүнчлэн тухайн улсын сонгуулийн хууль тогтоомжид тусгагдсан сонгох, сонгогдох эрхийн хамгаалалт болон холбогдох эрх зүйн зохицуулалтыг үнэлэх боломж олгож, эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад дөхөм болдог.

¹³⁶ OSCE “Resolving Election Disputes” (2000), <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>, p. 16.

5.2. БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ САЙН ТУРШЛАГА

Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсантай холбогдох маргаан 2012-2020 онд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн нийт сонгуулийн маргааны 68 хувийг эзэлж байна. Нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоо бүхий маргаан дийлэнх хувийг эзэлж байгаа болон энэ төрлийн маргааныг шийдвэрлэх хугацаа сунжрах нь тэгш эрхийн үндсэн дээр сонгуульд нэр дэвших эрхийн хязгаарлалт болдог.

Улс төрийн нам болон бие даан нэр дэвшигч сонгуульд оролцох замаар улс төрийн эрхээ эдэлдэг. Бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс эвлэлдэн нэгдэх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын¹³⁷ 22 дугаар зүйлд тодорхойлсон байдаг. Түүнчлэн Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 7 дугаар зүйлийн 3 дугаар мөр, ЕАБХАБ-ын Копенхагений баримт бичгийн 7.9 дэх заалтад Гишүүн улсууд “хувь хүний болон бүлэг хүмүүс улс төрийн нам эсхүл бусад улс төрийн байгууллага байгуулах эрх, эрх чөлөөг хүндэтгэх бөгөөд байгуулагдсан улс төрийн нам, улс төрийн байгууллагууд хуулийн өмнө хоорондоо өрсөлдөх тэгш боломж шаардлагатай хууль, эрх зүйн баталгаагаар хангах” үүрэгтэй гэж заасан байдаг. 1990 оны Копенхагений баримт бичигт эвлэлдэн нэгдэх эрх¹³⁸, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх¹³⁹ болон төрийн болон улс төрийн эрх үүргийн ялгаа, заагийг хамгаалсан заалтууд¹⁴⁰ мөн л улс төрийн суурь эрхийг баталгаажуулсан байдаг.

Сонгогдох эрхийг хамгаалахын тулд нэр дэвшигчийг бүртгэх процесс нь хуульд нийцсэн, ил тод, талуудын оролцоог хангасан байдлаар явагдах учиртай. Бүртгэхээс татгалзах

¹³⁷ <https://www.legalinfo.mn/law/details/1257>

¹³⁸ Копенхагений баримт бичиг (1990)-ийн 9.3 дугаар зүйл.

¹³⁹ Мөн тэнд, 9.1 дүгээр зүйл.

¹⁴⁰ Мөн тэнд, 5.4 дүгээр зүйл.

нөхцөл нь хязгаарлагдмал байх бөгөөд зөвхөн хуульд заасан үндэслэл, шалгуур буюу нэрээ дэвшүүлснээ илэрхийлэх мэдэгдэл, мөрийн хөтөлбөр, сонгогчийн гарын үсэг, зарим нэг эрхэлсэн ажил, албан тушаалаас чөлөөлөгдөх шаардлага, харьяат иргэн байх зэрэг цөөн тооны шаардлагыг ихэнх улс орон хуульчилсан байдаг¹⁴¹. Манай улсад гарч буй сонгуулийн бүртгэлтэй холбоо бүхий маргааны 29 хувийг бие даан нэр дэвшигчийн бүрдүүлбэл зохих дэмжигчийн хуудаст тавигдах шаардлагатай холбогдох маргаан эзэлж байна. Тухайлбал, дэмжигчийн гарын үсэг, гэрийн хаяг, регистрийн дугаар, утасны дугаар үнэн зөв эсэх асуудал голлодог ажээ.

5.3. ГАРЫН ҮСГИЙН ТОО

Бие даан нэр дэвшигч болон өмнөх сонгуулиар тодорхой тооны санал аваагүй улс төрийн нам сонгуульд оролцохоор бүртгүүлэхэд дэмжигч, сонгогчдын гарын үсэг цуглуулах шаардлага тавьдаг жишиг бий. Тухайлбал, ХБНГУ-ын Бундестагийн сонгуульд бие даан нэр дэвшигчид 200 сонгогчийн гарын үсэг цуглуулах шаардлага тавьдаг байна. Мөн парламентад таваас цөөн суудал авсан улс төрийн нам тухайн тойргийн 200-аас доошгүй сонгогчийн гарын үсгийг цуглуулахыг шаарддаг¹⁴². Их Британид 10, Финляндад 100, Австрид 200-500, Энэтхэгт нэг сонгогчийн гарын үсэг цуглуулж, хуулийн энэ шалгуурыг хангадаг байна¹⁴³. Харин Австралийн Шинэ Өмнөд Уэлс мужид бие даан нэр дэвшигч 15 сонгогчийн дэмжлэг авснаар сонгуульд нэрээ дэвшүүлдэг¹⁴⁴. Ерөнхийдөө сонгогч,

¹⁴¹ OSCE, ODIHR, Existing Commitments for Democratic Elections in OSCE Participating States; Daniel Finn, 2003, Part one, 16-17.

¹⁴² <http://aceproject.org/main/english/pc/pcc05.htm>

¹⁴³ <http://aceproject.org/main/english/pc/pcc05.htm>

¹⁴⁴ Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь, Монгол Улсын Их Хурал, НҮБХХ

дэмжигчдийн гарын үсэг цуглуулах хуулийн шаардлага нь тухайн сонгуулийн тойргийн нийт сонгогчдын нэг хувиас илүүгүй байх нь олон улсын сайн туршлага юм¹⁴⁵.

Сонгуулийн тойрог хуваарилахдаа хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг харгалзан үздэг практик түгээмэл бий. Гэвч сонгуулийн тойрог хуваарилах үйл явц нь ил тод бус, олон нийтээр хэлэлцэгдээгүй, тогтоосон шалгуурыг дагаж мөрддөггүйгээс¹⁴⁶ тойргийн сонгогчийн тоо хэт ялгаатай болж, 2016 оны УИХ-ын сонгуулийн хувьд нэг тойрог нөгөөгөөсөө гурав дахин их сонгогчтой болсон билээ. Тойргийн хүн амын тоо ийм их зөрүүтэй манай улсын хувьд гарын үсэг цуглуулах шаардлагыг нийт сонгогчдын тоонд хувьчилж, тухайлбал, нэг хувиас илүүгүй тооны гарын үсэг цуглуулах зарчмаар хуульчлах нь зүйтэй. Сонгуулийн эрх бүхий сонгогчийн нэг хувиар тооцвол 2020 оны УИХ-ын сонгуулийн хамгийн олон хүн амтай тойрогт 1348, цөөн хүн амтай тойрогт 374 гарын үсэг цуглуулахаар байна¹⁴⁷. Харин УИХ-ын сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгогчдоос 801-ээс доошгүй тооны дэмжлэг авсан байхыг хуулиар шаарддаг нь бага хүн амтай тойрогт өрсөлдөж буй бие даан нэр дэвшигчид тавигдаж буй шаардлага хэт өндөр, хүн амтай ихтэй тойрогт өрсөлдөгчийн хувьд харин цөөн гарын үсэг цуглуулах шаардлага юм. Цаашид тойрог хуваарилахдаа энэ мэт тодорхой аргачлал, шалгуурыг дагаж мөрдөн, иргэн бүр сонгуулийн тэгш эрхтэй байдлаар зохион байгуулах шаардлагатай байна.

хамтарсан Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл (2014)-ийн 82 дахь тал.

¹⁴⁵ Guidelines for Reviewing a Legal Framework for Elections OSCE, 39 дэх тал, <https://www.osce.org/files/f/documents/f/8/104573.pdf>

¹⁴⁶ ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны 2016 оны УИХ-ын сонгуулийн тайлан, 7 дахь тал, (2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр нэвтрэв): <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

¹⁴⁷ Баянгол дүүрэг (26 дугаар тойрог)-ийн хувьд 134.872 сонгогчтой бол Говь-Алтай аймаг (5 дугаар тойрог)-т 37.448 сонгогч бүртгүүлжээ.

5.4. ГАРЫН ҮСГИЙН МАЯГТ

Сонгогдох эрхийг хамгаалах зорилгын үүднээс нэр дэвшигчийг бүртгэх процесс нь хуульд нийцсэн, ил тод, талуудын оролцоог хангасан байдлаар явагддаг. Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл нь хязгаарлагдмал байх бөгөөд зөвхөн хуульд заасан үндэслэл, шалгуур буюу нэрээ дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдэл, мөрийн хөтөлбөр, сонгогчийн гарын үсэг, зарим нэг эрхэлсэн ажил, албан тушаалаас чөлөөлөгдөх шаардлага, харьяат иргэн байх зэрэг цөөн тооны шаардлагыг ихэнх улс орон хуульчилсан байдаг¹⁴⁸.

Нэр дэвшигчийг бүртгэхэд шаардлагатай гарын үсэг цуглуулахтай холбогдох эрх зүйн зохицуулалтын талаар Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагын тайланд “Нэр дэвшигчийг дэмжсэн гарын үсгийг нягтлан шалгаж, баталгаажуулах талаар Сонгуулийн хуульд тусгах нь зохилтой”¹⁴⁹ гэжээ. Хуулиар нарийвчлан зохицуулахгүй байх нь зарим нэр дэвшигч болон улс төрийн намын цуглуулсан гарын үсгийг шалгаж, баталгаажуулахад хэт өндөр шаардлага тавих, нөгөө хэсэгт нь шалгасан “нэр зүүх” төдийгөөр бүртгэн, нэр дэвшигчдийг ялгаварлан гадуурхаж, тэдний эвлэлдэн нэгдэх улс төрийн эрх чөлөөг нь боомилох¹⁵⁰ нөхцөл болдог.

Гарын үсэг цуглуулах маягтад дэмжиж буй сонгогчдын нэрс, хаяг, регистрын дугаар, утасны дугаар зэрэг мэдээлэл тусгадаг. Эдгээр шаардлагыг хэт өндөр шалгуур хэмээн шүүхэд маргаан гаргах явдал бусад улсад цөөнгүй гардаг байна. Жишээ нь: АНУ-д гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн гэрийн хаягийг тусгахыг шаардах нь хэт өндөр шалгуур хэмээн

¹⁴⁸ OSCE, ODIHR, Existing Commitments for Democratic Elections in OSCE Participating States; Daniel Finn, 2003, Part one, 16-17.

¹⁴⁹ Сонгуулийн маргааныг шийдвэрлэх нь, ЕАБХАБ-ын тайлан, 12 дахь тал, <https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>

¹⁵⁰ Мөн тэнд.

шүүхэд хандсан тохиолдол гарсан билээ (Кэйс 13)¹⁵¹.

Кэйс 13.

2006 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн бүх нийтийн сонгууль болохоос таван долоо хоногийн өмнө 1305 хүний гарын үсгийг хүчингүйд тооцсонтой холбогдуулан Нью-Йорк дүүргийн Конгресст Либертари намаас нэр дэвшигч болон хоёр сонгогч хамтран, гарын үсгийн шаардлагыг хэт өндөр гэж гомдол гаргажээ. Нэхэмжлэгчид “Энэ бүс нутагт дүүрэг тосгоны хил хязгаар тодорхойгүй, давхцал ихтэй, аль тосгон, дүүрэгт харьяалагдаж буй нь ойлгомжгүй зэрэг нөхцөл байдлаас хамаарч, гарын үсэг цуглуулахад дэмжигчийн тодорхой хаяг бичих нь хүндрэлтэй байна” хэмээн гомдол гаргажээ.

Нэхэмжлэлтэй холбоотойгоор Нью-Йорк хотын сонгуулийн байгууллага сонгогчдын болон хаягийн бүртгэл шаардлагатай эсэх талаар нийтийн сонгогч зохион байгуулсан бөгөөд шүүгч Канн “гарын үсэг цуглуулахад сонгогчдын гэрийн хаягийг бичих нь хэт өндөр шаардлага биш бөгөөд нэр дэвшигчдийн сонгогдох эрхийг хязгаарлаагүй байна” гэж шийдвэрлэжээ.

Дээрх маргааны хувьд гарын үсэг цуглуулахад сонгогчийн нэр, хаяг, утас зэрэг хувийн мэдээллийг тусгах шаардлага нь хэт өндөр шаардлага биш бөгөөд сонгогчид сонгогдох эрхээ эдлэхэд нь саад учруулахгүй хэмээн шүүхээс дүгнэжээ¹⁵². Манай улсын хувьд сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг (эх)-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичдэг¹⁵³.

¹⁵¹ Sundwall v. Kelleher, <https://www.fjc.gov/sites/default/files/2015/EE-NYN-1-06-cv-1191-Sundwall.pdf>

¹⁵² Sundwall v. Kelleher, <https://www.fjc.gov/sites/default/files/2015/EE-NYN-1-06-cv-1191-Sundwall.pdf>

¹⁵³ УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 31.4.

5.5. ГАРЫН ҮСГИЙН МАЯГТ БАТАЛГААЖУУЛАХ

Бие даан нэр дэвшигчийн цуглуулсан гарын үсгийн хэдийг нь шалгаж, хэрхэн баталгаажуулах талаарх аргачлал улс орон бүрд өөр өөр байна. Европын Аюулгүй Байдал, Хамтын ажиллагааны байгууллагаас гарын үсгийн маягтыг баталгаажуулах дараах аргуудыг сайн туршлага хэмээн үздэг байна. Үүнд:

- Түүвэрлэн шалгах гарын үсгийн тоо, түүврийг сонгох аргачлал (Компьютерын программаар санамсаргүй түүврийн аргаар);
- Гарын үсэг үнэн, зөв эсэхийг тодорхойлох загвар;
- Шалгасан гарын үсгээс хэд нь үнэн, зөв байх тохиолдолд нэр дэвшигч болон улс төрийн намыг бүртгэхийг харуулсан томьёо;
- Шаардлагатай гэж үзвэл нэмж түүвэрлэх нөхцөл байдал зэргийг тусгадаг байна¹⁵⁴.

Түгээмэл арга нь цуглуулсан нийт гарын үсгийн гурван хувийг санамсаргүй түүврийн аргаар сонгон шалгах юм¹⁵⁵. Ийм аргаар сонгосон гурван хувьд хамаарах гарын үсгийг тодорхой аргачлалын дагуу нийт цуглуулсан болон шалгасан гарын үсгийн тоотой харьцуулах замаар нийт баталгаажсан гарын үсгийн тоог гаргадаг. Жишээ болгон АНУ-ын Калифорни мужийн сонгогчдын гарын үсгийг баталгаажуулахад хэрэглэсэн аргачлалыг энд оруулав¹⁵⁶.

¹⁵⁴ Guidelines for Reviewing a Legal Framework for Elections OSCE, 38 дахь тал, <https://www.osce.org/files/f/documents/f/8/104573.pdf>

¹⁵⁵ <https://humboldt.gov/>

¹⁵⁶ <https://www.sos.ca.gov/administration/regulations/current-regulations/elections/election-petition-signature-verification-random-sampling-verification-methodology/>

Нийт цуглуулсан гарын үсгийн тоо	24.034
Санамсаргүй түүврээр сонгох тоо (3%)	$24.034 \times 3\% = 722$
Үүнээс үнэн зөв нь батлагдсан гарын үсгийн тоо	516
Баталгаажаагүй гарын үсгийн тоо (үүнээс хуурамчаар үйлдсэн гарын үсэг 1; хоёр удаа зурсан гарын үсгийн тоо 2)	205
Баталгаажсан гарын үсгийн эзлэх хувь	$516 / 722 = 71.47\%$
Баталгаажсан гарын үсгийн хувийг нийт гарын үсэгт харьцуулна.	$24.034 \times 0.7147 = 17.177.0990$ (17.178)
Гарын үсгийн коэффициентыг тооцоолох	$24.034/722 = 33.2881$
Давхардсан гарын үсэг тус бүрд хуваарилагдсан жинг тодорхойлох	$33.2881 - 1.0000 = 32.2881$ $33.2881 \times 32.2881 = 1.074.8095$ $1.074.8095 \times 2 = 2.149.6190$ (2.150)
Үүнээс баталгаажсан гарын үсэг нь санамсаргүй түүврийн аргаар сонгосон гарын үсгийн түүвэртэй харьцуулахад эзлэх хувь	$17.178 - 2.150 = 15.028$
Дүгнэлт	Нийт 24.034 гарын үсэг цуглуулснаас 15.028 гарын үсэг үнэн зөв болох нь санамсаргүй түүврийн аргаар гарын үсэг сонгож шалгаснаар баталгаажив.

Манай улсад цуглуулсан гарын үсгийг хэрхэн нягтлан шалгах талаар хуулийн нарийвчилсан зохицуулалт байхгүй. СЕХ-ны зүгээс сонгогчийн гар утас руу залгаж лавлах, гэрийн хаягаар нь очиж уулзах зэргээр баталгаажуулдаг боловч хуулийн зохицуулалтгүйн улмаас шүүхэд нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхгүй байна. Тиймээс гарын үсгийг шалгаж, баталгаажуулах, цуглуулсан гарын үсэг, мэдээлэл нь үнэн зөв эсэхийг нягтлах аргачлал, журмыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байдаг¹⁵⁷.

¹⁵⁷ Guidelines for Reviewing a Legal Framework for Elections OSCE, 38 дахь тал, <https://www.osce.org/files/f/documents/f/8/104573.pdf>

5.6. СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Гадаад улс орнуудад сонгуулийн мөрийн хөтөлбөрийн агуулгаас хамаарч, дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзахыг зөвшөөрдөг байна. Үүнд: Угсаа гарвал, үндэс язгуураар алагчлах үзэлд суурилсан, улс төрийн хүчирхийлэл, дайнд өдөөн турхирсан, ардчиллын суурь үнэт зүйлсэд харш болон мөрийн хөтөлбөрийн зорилтдоо тайван бус замаар хүрэхийг зорилго болгосон тохиолдлууд багтаж байна¹⁵⁸. Харин улс төрийн шалтгаанаар мөрийн хөтөлбөрийн агуулгаас хамаарч бүртгэхээс татгалзахыг хориглодог.

Манай улсын хуульд тусгагдсан мөрийн хөтөлбөрт тавигдах шаардлагад санал худалдаж авахаас сэргийлэх зорилгоор дараах зүйлсийг тусгахыг хориглосон байдаг¹⁵⁹. Үүнд: Мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбоо бүхий эрх олгох; Уул уурхай, газрын тос, эрдэс баялгийн болон бусад салбарын орлого, түүнчлэн улс, орон нутгийн төсвөөс иргэдэд аливаа хишиг, хувь, тэдгээртэй адилтгах бусад зүйл хүртээх; Зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, хөрвүүлэх; Иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх; Ажлын байранд зуучлах, ажилд оруулах болон улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон асуудлууд багтжээ. Түүнчлэн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж буй эсэх талаар төрийн аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байхыг шаарддаг.

¹⁵⁸ The Carter Center, Guide to Election Dispute Resolution, 2010.

¹⁵⁹ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2019)-ийн 38 дугаар зүйлийн 38.3.

Санал худалдаж авахтай холбоо бүхий маргааныг позитив болон негатив хэмээн ангилж үздэг. Мөнгө, эд хөрөнгө, албан тушаал санал болгох замаар санал худалдан авахыг позитив гэдэг бол дарамт, шахалт, сүрдүүлэг ашиглан, сонгогчийн саналыг татахыг негатив хэлбэр гэнэ. Сүүлийн үед ийм төрлийн санал худалдан авах явдал хөгжиж буй улсад нийтлэг тохиолдох болжээ. Учир нь эдгээр улс оронд алслагдмал хөдөө орон нутгийн оршин суугчид ажил хөдөлмөр эрхлэх, төрийн үйлчилгээ хүртэх зэргээр албан тушаалтнуудаас олон талаар хамааралтай байдаг нь нөлөөнд автан саналаа худалдахад хүргэдэг байна. Санал худалдан авахтай холбогдох сонгуулийн маргаан нь зарим тохиолдолд тухайн улс төрийн намыг тарахад хүргэх нь бий. Тухайлбал, Тайландын дээд шүүх эрх баригч Тай Рак Тай намыг сонгуулиар санал худалдан авсан гэж үзээд тараах шийдвэр гаргаж байв¹⁶⁰.

¹⁶⁰ BBC, TOP THAI COURT OUSTS PM SOMCHAI, 2008.

ДҮГНЭЛТ

Ардчилсан улс оронд аливаа этгээд улс төрийн болон сонгуулийн эрхээ хуулиар хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд сэргээлгэхээр гомдол гаргаж, маргаанаа холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх нэг хэлбэр нь шүүхэд нэхэмжлэл гаргах явдал юм. Гомдол, нэхэмжлэлийн дагуу шүүх үр дүнтэй, шударга, хараат бус шийдвэр гаргаж буй эсэх нь сонгуулийн үйл явцын чухал хэсэг байдаг. Иймээс шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, судалгаанд үндэслэн, олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх нь шүүхийн байгууллагыг илүү хариуцлагажуулах, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх эерэг үр нөлөөтэй.

2012-2020 онд шүүхийн цахим санд бүртгэгдсэн сонгуультай холбоо бүхий анхан шатны шүүхийн 265 шийдвэр, тэдгээртэй холбогдох давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Манай улсын сонгуулийн хууль тогтоомжид “сонгуулийн маргаан” гэсэн нэр томъёоны тодорхойлолт тусгагдаагүй байна. Захиргааны хэргийн шүүхээс зөвхөн Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуулийн хороодтой холбоо бүхий маргааныг сонгуулийн маргаан хэмээн үзээд, тусгай журмаар буюу богиносгосон хугацаанд шийдвэрлэдэг практик тогтжээ. Сонгуулийн хороо хариуцагчаар ороогүй сонгуулийн маргааныг энгийн журмаар шийдвэрлэж, хугацаа алдсанаар уг сонгуулийн маргаан дөрвөн жил хүртэл

үргэлжилсэн тохиолдол байна. Иймд сонгуулийн маргааны тодорхойлолтыг хуульд тодорхой тусгах шаардлагатай.

Судалгааны хүрээнд авч үзсэн шүүхийн шийдвэрийн 68 хувийг нэр дэвшигчийн бүртгэлтэй холбоо бүхий маргаан эзэлж байгаа нь гарын үсэг баталгаажуулах аргачлал байхгүй, холбогдох журам боловсруулах эрх хэмжээг ямар нэг субъектэд олгоогүй зэрэг хуулийн нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаатай холбоотой. Холбогдох дүрэм, журам боловсруулах эрх хэмжээг СЕХ-д хуулиар олгоогүйгээс нэр дэвшигчийн бүртгэлийг нягтлан шалгахад баримтлах нэгдсэн дүрэм, журам одоог хүртэл батлагдаагүй байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуультай холбоо бүхий маргаан 2012 онд 101 гарсан бол 2020 онд 12 болж буурчээ. 2012-2020 онд сонгуулийн өмнөхөн хуулийг шинэчлэн баталсан, сонгуулийн тогтолцоог өөрчилсөн, өөр хувилбарыг сонгосон, гурван сонгуулийг нэг хуулиар зохицуулсан, хуулийн зохицуулалтын хангалтгүй, тодорхойгүй байдаг зэрэг олон шалтгааны улмаас сонгуулийн маргаан гарах нь олонтоо байжээ. 2020 онд сонгуулийн хууль тогтоомжид багагүй дэвшил гарсан болон сонгуулийн дүн гарснаас хойш нэр дэвшигчийн зөрчигдсөн эрхийг сэргээх боломж хуулиар хязгаарлагдсан зэргээс үүдэн, маргааны тоо буурчээ.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон УИХ-ын сонгуулийн маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг маргааны төрлөөр нь ангилж үзвэл сонгуулийн бүртгэлтэй холбоо бүхий маргаан 68 хувь, сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбогдох маргаан 16 хувь, санал хураалт дууссаны дараах үйл ажиллагаатай холбоо бүхий маргаан 9 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 7 хувь нь саналын хуудас, санал авах ажиллагаа болон сонгуулийн бусад маргаан байна. Бүртгэлтэй холбоо бүхий маргаан 2012 онд 65, 2016 онд 48, 2020 онд 16 гарснаас бие даан нэр

дэвшигчийн дэмжигчийн хуудаст тавигдах шаардлага, нэр дэвшигч сонгуулийн хороонд хүргүүлэх баримт материалын бүрдэл, хугацаандаа ирүүлэх, төрийн албан хаагчтай холбогдох маргаан 2012 оноос хойш тогтмол буурч ирсэн нь хууль эрх зүйн зохицуулалт сайжирсантай холбоотой юм.

Сонгуулийн хууль бус сурталчилгаатай холбоо бүхий маргаан 2012 онд 27, 2016 онд дөрөв гарсан бол 2020 онд огт гарсангүй. Энэ төрлийн маргаанд хууль бус сурталчилгааны үйл ажиллагаа явуулсан буюу сонин сэтгүүл хэвлүүлэн, сурталчилгаа хийсэн; шашны эд зүйлс ашигласан; хууль бус амлалт бүхий мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн; санал худалдан авах үйлдэл гаргасан; албан тушаалаа ашиглан, хурал, цуглаан, цайллага зохион байгуулсан; хууль бус амлалт өгсөн зэрэг маргаан багтжээ. Маргааны тоо буурахад энэ төрлийн маргааныг эхний ээлжид Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар хянан шийдвэрлэх болсон нь нөлөөлсөн байна.

Санал хураалт дууссаны дараах маргааны хувьд сонгогдсонд тооцуулах; иргэдийн төлөөлөгчийн үнэмлэх олгохгүй байгаа эс үйлдэхүй; бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа эс үйлдэхүй; нэр дэвшигч сонгуулийн хууль зөрчиж ялсан нь тогтоогдсон үед нөхөн сонгууль явуулах шаардлага бүхий нийт 16 маргаан гарчээ. 2012, 2016, 2020 оны сонгуульд саналын хуудас, санал авах үйл ажиллагаатай холбоотой нийт таван маргаан гарснаас дөрөв нь саналын хуудас дутсанаас шалтгаалан хуулбарласан саналын хуудсаар санал авсантай холбогдох маргаан, үлдсэн нэг нь саналын хуудсыг шалгах хүсэлтийг хүлээж аваагүйтэй холбогдох маргаан байна. Санал тоолох үйл ажиллагаатай холбогдох маргааны хувьд 2012 оноос өмнө саналын хуудсыг гараар тоолдог байсантай холбоотойгоор энэ төрлийн маргаан олонтоо гардаг байсан ч автоматжуулсан машин ашиглаж эхэлсэн нь уг маргааны тоо эрс буурахад нөлөөлжээ.

Сонгуультай холбоо бүхий маргааныг Захиргааны хэргийн шүүхээс анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн байдлаас үзвэл 46 хувь нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн бол 33 хувь нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон; 14 хувь нь нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан; үлдсэн 7 хувь нь нэхэмжлэлийг хэсэгчлэн хангасан эсхүл хариуцагч нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдлууд эзэлж байна. Сонгуультай холбоо бүхий маргааны талаас илүү хувьд нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь нэг талаас шүүх сонгох, сонгогдох эрхийн баталгааг хангаж байгаа, нөгөө талаас эрхийн зөрчил их байгаагийн илрэл юм.

2012 оны сонгуулиас бусад УИХ-ын бүх сонгууль 1992 оны Үндсэн хуулийн дагуу олонхын тогтолцоогоор явагдсан билээ. Олонхын тогтолцоогоор сонгууль явуулахад сонгогчдын санал гээгдэх, эмэгтэйчүүдийн сонгогдох боломж хязгаарлагдах зэрэг сөрөг үр дагавар гардаг. Ийм тогтолцоогоор сонгууль явуулдаг улс орнууд сонгуулийн холимог тогтолцоонд, холимог тогтолцоотой улсууд хувь тэнцүүлсэн тогтолцоонд шилжих чиг хандлага олон улсад ажиглагдаж байгааг хууль тогтоогчид анхаарах нь зүйтэй.

2015 онд УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн тухай хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуультай нэгтгэж баталсан билээ. Энэ нь сонгуулийн эрх зүйн тогтолцоог нэгдмэл болгох, ойлголтын зөрүүг арилгах зэрэг олон давуу талтай байсан хэдий ч шүүхийн практикт хууль хэрэглээний хувьд хүндрэл учруулсан юм. 2019, 2020 онд сонгуулийн харилцааг гурван өөр хуулиар зохицуулсан хэдий ч нэр дэвшигч, мөрийн хөтөлбөрт тавигдах шаардлага болон хянан шийдвэрлэх ажиллагаанд тус бүрийнх нь онцлогийг тодорхой тусгаагүй. Ийнхүү өөр өөр хуулиар зохицуулахдаа сонгууль тус бүрийн онцлогийг тусгасан тусгайлсан шаардлагыг хуульчлах нь зүйтэй. Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тавигдах

шаардлагыг хуулиар ялгаатай зохицуулаагүйгээс нэг мөрийн хөтөлбөрөөр УИХ болон орон нутгийн сонгуульд оролцохтой холбоо бүхий маргаан гарсаар байна. Ийнхүү ард түмнийг төлөөлөх чиг үүрэг бүхий парламентыг бүрдүүлэх УИХ-ын сонгууль болон тухайн орон нутгийн иргэдийг төлөөлөх орон нутгийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрт нэгэн ижил шаардлага тавьсан хэр нь сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь өөр байна.

2019 онд шинээр батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хууль болон 2020 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулинд хууль зөрчиж, сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглосон зохицуулалт нь ижил боловч хүлээлгэх хариуцлага нь ялгаатай байна¹⁶¹. Орон нутгийн сонгуульд өрсөлдсөн нэр дэвшигч хууль бус сурталчилгаа явуулсан бол нэр дэвшигчээр бүртгэсэн шийдвэр, төлөөлөгчөөр сонгогдсон шийдвэрийг тус тус хүчингүй болгож, дахин сонгууль явуулахаар хуульчилжээ. Гэтэл УИХ-ын сонгуульд нэр дэвшиж, сонгогдсон гишүүн тангараг өргөн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлсний дараа сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн¹⁶² үйлдэл нь тогтоогдвол гишүүний бүрэн эрхтэй холбоо бүхий шийдвэр гаргах, дахин сонгууль явуулах эрх сонгуулийн байгууллага болон захиргааны шүүхэд олгогдоогүй юм.

Шүүхийн шийдвэр хууль зүйн үр нөлөөтэй, зөрчигдсэн эрхийг сэргээх боломжтой эсэх нь Захиргааны хэргийн шүүхээс зарим маргааныг сонгуулийн дүн гарахаас өмнө эсхүл хойно шийдвэрлэхээс хамаарч байна. Санал татах зорилгоор амлалт өгөх, урлагийн тоглолт зохион байгуулах, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх, сувилалд амраах, бараа эд зүйл өгөхөөр гэрээ хийх зэргээр Зөрчлийн тухай хууль зөрчсөн нэр дэвшигч

¹⁶¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.1, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 48.1.

¹⁶² Зөрчлийн тухай хууль зөрчсөн бол.

УИХ-ын гишүүн болсон тохиолдолд торгохоор хуульчилсан боловч гишүүнийг эгүүлэн татах эрх зүйн зохицуулалт үгүй байна¹⁶³. Зөрчлийн хэрэг шийдвэрлэх, сонгуулийн хорооны шийдвэр гаргах, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааны уялдааг хангаж, тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэхтэй холбогдох хуулийн зохицуулалт оруулах замаар шүүхийн шийдвэрийн үр нөлөө нэмэгдүүлэх, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх боломжоор хангах шаардлагатай байна.

Шүүхээр маргааныг эцэслэн шийдвэрлэхэд эрүүгийн болон захиргааны шүүхээр дамжин, хэрэг хянан шийдвэрлэхээр хуульчлахдаа процессын хуулийн холбогдох зохицуулалтын уялдааг хангаагүйгээс хугацаа алдах, эрх нь зөрчигдсэн этгээдийн эрхийг сэргээх боломжгүй болох, шүүхийн шийдвэр үр нөлөөгүй болох нөхцөл үүсэж байна. Түүнчлэн сонгуулийн маргааныг олон улсын жишигт нийцүүлж, тусгай журмаар шуурхай шийдвэрлэхээр хуульчлахдаа процессын хуульд холбогдох зохицуулалтыг тусгаагүйгээс сонгуулийн хууль тогтоомжийн шинэчлэлийн үр нөлөө буурах нөхцөл болж буй нь шүүхийн практикаас харагдаж байгаа юм.

Сонгуулийн эрх зүйн тогтворгүй байдал нь сонгуулийн маргаан гарах нэг нөхцөл болж, маргааны төрөл, тооны өөрчлөлтөд нөлөө үзүүлж байна. 2012 оны сонгуулийн эрх зүйн шинэтгэл зарим төрлийн сонгуулийн маргааны тоог бууруулахад нөлөөлсөн бол 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт сонгуулийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн алхам болжээ. Гэвч сонгуулийн тогтолцооны сонголт, сонгуулийн эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдал, сонгуулийн төв байгууллагын бүрэн эрх зэрэг эрх зүйн нарийвчилсан зохицуулалт шаардсан асуудлууд байсаар байна.

¹⁶³ НҮБХХ, Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь, Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл.

ХАВСРАЛТ

УИХ-ЫН БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ХУУЛИУД

- 1. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (1992)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.ges.gov.mn/post/2482?n=%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%B0%D1%80%D1%85%D0%B8%D0%B2>
- 2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хууль (1996)**
- 3. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2005)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.ges.gov.mn/post/2484?n=%D0%A5%D1%83%D1%83%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD%20%D0%B0%D1%80%D1%85%D0%B8%D0%B2>
- 4. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хууль (2007)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.legalinfo.mn/law/details/437>
- 5. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2011)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.legalinfo.mn/law/details/351?lawid=351>

6. **Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2012)**
(2020 оны 07 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.legalinfo.mn/law/details/8700>, <https://www.legalinfo.mn/law/details/8662>
7. **Сонгуулийн тухай хууль (2015)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.legalinfo.mn/law/details/12178?lawid=12178>
8. **Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.legalinfo.mn/law/details/14869>
9. **Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)**
(2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр нэвтрэв): <https://www.legalinfo.mn/law/details/15125?lawid=15125>

**ХАВСРАЛТ 2. СОНГУУЛИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ, ТҮҮНИЙ БАТЛАГДСАН ХУГАЦАА**

Сонгуулийн жил	Сонгуулийн нэр	Батлагдсан огноо	Хуулийн нэр	Сонгууль зохион байгуулагдсан он
2012	Улсын их хурлын сонгууль	2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр	Улсын их хурлын сонгуулийн тухай хууль	2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр
	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль	2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль	2012 оны 6 дугаар сарын 28-ны өдөр
	Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль	2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр	Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль	2012 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр
2016	Улсын их хурал, Нийслэл, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль	2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр	Сонгуулийн тухай хууль	2016 оны 6 дугаар сарын 26-ны өдөр
2020	Улсын их хурлын сонгууль	2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр	Улсын их хурлын сонгуулийн тухай хууль	2020 оны 6 дугаар сарын 24-ны өдөр
	Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль	2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр	Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль	2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

МОНГОЛ ХЭЛЭЭР

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын тогтоол, 2010.
2. Ж.Төртогтох, С.Мөнхбат, Улс төрийн санхүүжилт ба намуудын хөгжлийн хандлага, НҮБХХ, УБ., 2014.
3. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, УБ., 2019.
4. Морис Дюверже, Улс төрийн байгууламж-Үндсэн хуулийн эрх зүй, Монсудар, УБ., 2007.
5. С.Мөнхбат, Улс төрийн санхүүжилт ба намуудын хөгжлийн хандлага, НҮБХХ, УБ., 2014.
6. П.Амаржаргал, Б.Буяндэлгэр нар, Бодлогын судалгаа шинжилгээ, УИХ-ын тамгын газрын хэвлэл, УБ., 2011.
7. Б.Баттуул, Нээлттэй Нийгэм Форум, Улс төрийн намд өгч буй хандивын зарим асуудал, Бодлогын асуудал №16, УБ., 2015.
8. Ж.Ядамсүрэн, Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар, УБ., 2008.
9. Ч. Содномцэрэн, Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь, илтгэл,
<https://www.gec.gov.mn/post/887?n=%D0%9C%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D,%20%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D%D0%BB%D1%8D%D0%BB>
10. Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт, Хүний эрхийн ээлжит

- дүгнэлт хэлэлцүүлэгт зориулсан Монголын төрийн бус байгууллагын форумын илтгэл, 2010.
11. Д. Энхцэцэг, Нээлттэй Нийгэм Форум, Сонгуульд санал автоматаар тоолоход зайлшгүй анхаарах асуудлууд, Бодлогын асуудал №8, УБ., 2011.
 12. Э. Гэрэлт-Од, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо: Сонголт, туршлага, <http://www.academy.edu.mn/content/legislative-election-gereltod/>
 13. УИХ-ын сонгуульд ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийн ажиглах хорооны тайлан, <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>
 14. Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал, 2020.
 15. ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хорооны 2016 оны УИХ-ын сонгуулийн тайлан, <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>
 16. Н.Ариунболд, Б.Энхтөгс нар, Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл, Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь, НҮБХХ, 2013.
 17. Пол Гуэрин, Монгол Улсад үзүүлсэн сонгуулийн туслалцааны сургамж 2008-2012, НҮБХХ, 2013.
 18. Улс төрийн намуудын санхүүжилт, гишүүнчлэл, орон нутгийн Хурлын сонгууль дахь улс төрийн намын оролцоог боловсронгуй болгох нь, НҮБХХ, 2014.

ГАДААД ХЭЛЭЭР

1. Electoral reform in Mongolia: E-voting and confidence building, Dashbalbar Gangabaatar, Jordi Barrat Esteve, NUM Law Review issue 1, 2019.
2. Funding of Political Parties and Election Campaigns: A Handbook on Political Finance, Elin Falguera, Samuel Jones, Stokolm: International IDEA publication, 2014.
3. Financing Politics: Money, elections and political reform, Congressional Quarterly, Herbert Alexander, USA, 1992.
4. <https://www.slideshare.net/gecmongolia/ss-11455921>
5. International IDEA “Handbook on Electoral Justice”, 2010.
<https://www.idea.int/sites/default/files/publications/electoral-justice-handbook.pdf>
6. OSCE “Resolving Election Disputes”, 2000.
<https://www.osce.org/files/f/documents/b/b/17567.pdf>
7. OSCE/ODIHR “Guidelines for reviewing a legal framework for elections”, 2013.
<https://www.osce.org/files/f/documents/f/8/104573.pdf>
8. ACE Encyclopaedia version 1.0
<http://aceproject.org/main/english/pc/pcc05.htm>
9. Election Petition Signature Verification Random Sampling Verification Methodology, California, USA.
<https://www.sos.ca.gov/administration/regulations/current-regulations/elections/election-petition-signature-verification-random-sampling-verification-methodology/>
10. Signature Verification Guide, Colorado Secretary of State, USA, 2018.
<https://www.sos.state.co.us/pubs/elections/docs/SignatureVerificationGuide.pdf>

ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Монгол Улсын Үндсэн Хууль, 1992.
2. Монгол Улсын Улс Төрийн Намын тухай хууль, 2005.
3. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 1992.
4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хууль, 1996.
5. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 2005.
6. Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2007.
7. Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 2011.
8. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай, 2012.
9. Сонгуулийн тухай хууль, 2015.
10. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 2019.
11. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, 2020.
12. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016.
13. Зөрчлийн тухай хууль, 2017.
14. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 35 тоот шийдвэр, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2577/view>
2. Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 018 тоот шүүгчийн захирамж, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/7267/view>
3. Хөвсгөл аймгийн Захиргааны хэргийн шүүхийн 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 0046 тоот шийдвэр, <http://old.shuukh.mn/zahirgaaanhan/1590/view>

4. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 221/МА2017/0039 тоот магадлал, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/1018/view>
5. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 432 тоот шийдвэр, <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/1493/view>
6. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 221/МА2016/0378 тоот магадлал, <http://new.shuukh.mn/zahirgaadavah/793/view>
7. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 1382 тоот захирамж.
8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 1382 тоот захирамж Улсын дээд шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 61 тоот шийдвэр.
9. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 13 тоот магадлал.
10. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 1382 тоот захирамж.
11. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2013 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 09 тоот магадлал, <http://old.shuukh.mn/zahirgaadavah/325/view>
12. Улсын дээд шүүхийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 99 тоот тогтоол, <http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/739/view>
13. Улсын дээд шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 049/2012/0020/з тоот шийдвэр.
14. Улсын дээд шүүхийн 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 61 тоот шийдвэр, 27 дахь тал.
15. Улсын дээд шүүхийн 2006 оны 4 дүгээр сарын 24-ний 21 тоот “Шүүхийн шийдвэрийн тухай” тогтоол, <http://www.supremecourt.mn/act/view/145>
16. Улсын дээд шүүхийн 2013 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 55 тоот тогтоол, <http://old.shuukh.mn/zahirgaahyanalt/381/view>

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M, MBA)

Өмгөөллийн DB>S ХХН-ийн гишүүн хуульч



Өмгөөллийн DB>S ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Билиг” дээд сургуульд хичээл зааж байсан туршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн турш өндрөөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкминий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)



Тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кьюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ISBN 978-9919-9926-0-6



9 789919 992606